ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 1-18 дэх тал

“УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД АРДЧИЛЛЫГ ДИЖИТАЛ ТЕХНОЛОГИЙН ТУСЛАМЖТАЙ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ”

С.Мөнхбат
МУИС, УТСОУХНУС-ийн захирал, профессор

Э.Золбаяр
МУИС, УТСОУХНУС
Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй:

Намын дотоод ардчилал нь гишүүдийн санал бодлыг шийдвэр гаргалтад тусгах замаар намын ил тод байдал, бодлогын чанарыг дээшлүүлж, иргэдийн улс төрийн итгэлцэл, төлөөллийн бодит байдлыг баталгаажуулж байдаг. Гэвч Монгол улсад намуудын дотоод шийдвэр гаргалт төвлөрсөн, ил тод бус, эрх мэдлийн босоо бүтэц давамгай байдаг нь иргэдийн улс төрийн намд итгэх итгэлийг бууруулж, улс төрийн төлөөллийн чанарыг сулруулж байна. Сүүлийн үед дижитал технологид суурилсан улс төрийн намууд бий болж санал боловсруулах систем, цахим санал хураалт, шийдвэр гаргалт, цахим оролцоо зэргийг намын үйл ажиллагаандаа нэвтрүүлж гишүүд дэмжигчдийн оролцоог өргөжүүлж, шийдвэр гаргалтын хүртээмжийг нэмэгдүүлж, намын ил тод байх боломжийг олгож байна. Иймд дижитал технологийг улс төрийн намууд дотоод ардчиллыг нэмэгдүүлэх хэрэгсэл болгон ашиглах боломжийг дижитал намын туршлагаас шинжиллээ.

Түлхүүр үгс: Дижитал нам, намын дотоод арчилал, гишүүдийн оролцоо, ил тод байдал, шийдвэр гаргалт, дижитал технологи.

Удиртгал: XXI зуунд дижитал технологийн хурдацтай хөгжил нь улс төрийн байгууллага, нийгмийн харилцаа, иргэдийн улс төрийн оролцоо, төрийн үйл ажиллагаанд гүнзгий өөрчлөлт авчирч байна. Ялангуяа интернэт, олон нийтийн сүлжээ, цахим платформ, дижитал технологид суурилсан шийдлүүд нь улс төрийн мэдээлэл солилцох, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, улс төрийн оролцооны шинэ орчныг бүрдүүлж, төлөөллийн ардчиллын уламжлалт загварыг дахин тодорхойлох нөхцөлийг бий болгож байна.

Улс төрийн намууд нь ардчилсан тогтолцоонд иргэдийн ашиг сонирхлыг төлөөлөх, улс төрийн хүсэл эрмэлзлийг институцийн хэлбэрт оруулах үндсэн субъект боловч олон оронд тэр дундаа Монгол Улсад намуудын дотоод зохион байгуулалт төвлөрсөн, удирдлагын түвшинд хэт хамааралтай, гишүүдийн бодит оролцоо сул хэвээр байгааг олон судлаачид онцолдог. Намын дотоод ардчилал сул байх нь зөвхөн намын дотоод асуудал бус харин улс төрийн төлөөллийн чанар, иргэдийн улс төрийн итгэлцэл, ардчиллын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх институцийн асуудал болдог (van Biezen, 2004).

Намын дотоод ардчиллыг шинжлэх онолын хүрээнд “intra-party democracy” хэмээх ойлголт нь намын шийдвэр гаргах бүхий л түвшинд гишүүд, дэмжигчдийн оролцоог хэрхэн хангаж байгааг хэмжих оролдлогоор хөгжиж ирсэн. Тухайлбал Гидеон Рахат болон Ассаф Шапира нар намын дотоод ардчиллыг оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, хариу үйлдэл, ил тод байдал гэсэн үндсэн хэмжигдэхүүнээр тодорхойлж, улс төрийн намуудын институцийн чанарыг харьцуулан шинжлэх индексийг боловсруулсан нь улс төр судлалын онол, практикт өргөн хэрэглэгдэж байна (Rahat & Shapira, 2016)

Олон улсын туршлагаас харахад орчин үеийн улс төрийн намууд хоёр үндсэн чиглэлээр хөгжиж байна. Нэгдүгээрт, уламжлалт томоохон намууд өөрийн үйл ажиллагаандаа дижитал технологи, сошиал платформ, гишүүдийн дотоод цахим санал асуулга, цахим сурталчилгаа, онлайн санхүүжилтийн систем зэрэг дижитал шинэчлэлийг үе шаттайгаар нэвтрүүлж байна. Хоёрдугаарт, зөвхөн дижитал орчинд тулгуурласан улс төрийн намууд бий болж, дотоод зохион байгуулалт, бодлого боловсруулах, шийдвэр гаргалтыг онлайн оролцоонд суурилсан хэлбэрээр зохион байгуулж байна. Европын зарим оронд үйл ажиллагаа явуулж буй “Далайн дээрэмчдийн нам”, “Таван од хөдөлгөөн” зэрэг намуудын туршлага нь цахим оролцоо, ялангуяа уламжлалт улс төрийн намуудын дотоод ардчиллыг сайжруулах шинэ загварыг туршсан жишээ болж, олон улсын судлаачдын анхаарлыг ихээхэн татах болсон.

Монгол Улсын хувьд дижитал шилжилт харьцангуй өндөр түвшинд хүрсэн хэдий ч улс төрийн намууд дижитал технологийг дотоод ардчиллаа бэхжүүлэх институцийн хэрэгсэл болгон ашиглах явдал хангалтгүй хэвээр байна. Намууд дижитал орчныг ихэвчлэн мэдээлэл түгээх, сонгуулийн сурталчилгааны хэрэгсэл хэлбэрээр ашиглаж байгаа нь гишүүдийн оролцоо, бодлого боловсруулах, шийдвэр гаргалтад үзүүлэх бодит нөлөөг хязгаарлаж байна.

Хүчирхэг улс төрийн нам нь төрийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ төр–иргэний холбоог бэхжүүлэх чухал үүрэгтэй. Харин намын дотоод зохион байгуулалт сул, дотоод зөрчил ихтэй, бүлэглэлийн өрсөлдөөн давамгайлсан нөхцөлд улс төрийн нам нь нийгэмд хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болдог. Орчин үеийн нийгмийн хөгжлийн түвшин, иргэдийн улс төрийн соёл, ухамсрын өсөлт, эрх зүйн орчны боловсронгуй байдал нь улс төрийн намуудыг илүү тогтвортой, ил тод, оролцоонд суурилсан зохион байгуулалттай байхыг шаардаж байна (С.Мөнхбат, 2023).

Иймд намын дотоод ардчиллыг бэхжүүлэхэд дижитал технологийг ашиглах боломж нь орчин үеийн улс төр судлалын хувьд онцгой сонирхол татах асуудал болж байна. Дижитал технологи нь намын гишүүд, дэмжигчдийн оролцоог өргөжүүлэх, бодлого боловсруулах болон шийдвэр гаргалтын үйл явцыг илүү ил тод, хүртээмжтэй болгох, улмаар намын институцийн чанарыг дээшлүүлэх шинэ механизм болж чадах эсэхийг онолын болон практик түвшинд шинжлэх шаардлагыг бий болгож байна. Энэхүү хүрээнд намын дотоод ардчиллыг хэмжихэд Гидеон Рахат болон Ассаф Шапира нарын боловсруулсан оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, хариу үйлдэл, ил тод байдал зэрэг үндсэн хэмжигдэхүүнүүдийг аналитик хүрээ болгон ашиглаж, дижитал оролцоо эдгээр хэмжигдэхүүнүүдэд хэрхэн нөлөөлж болохыг авч үзэх нь чухал ач холбогдолтой юм.

Намын дотоод ардчилал ба дижитал технологи

Намын дотоод ардчилал буюу “internal democracy within political party”, нам доторх ардчилал буюу “intra-party democracy” хэмээх ойлголт нь намын шийдвэр гаргах бүхий л түвшинд гишүүд, дэмжигчдийг оролцуулах тухай ойлголт юм (De Facto Independent Research Institute, 2020, xy. 10). Намын дотоод ардчилал гэдэг нь гишүүд дотоод төлөөллийн байгууллага болон аливаа сонгууль, төрийн албанд нэр дэвшигчийг сонгоход оролцох, сонгох эрхээ эдлэх явдал юм. Мөн намын дотоод төлөөллийн байгууллагад хүйсийн төлөөллийг боломжит хэлбэрээр хадгалах, санхүүгийн хувьд нээлттэй байх, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон намын үндсэн бодлогын баримт бичигт саналаа тусгах тухай юм. Өөрөөр хэлбэл улс төрийн намын дотоод үйл ажиллагаа бүхэлдээ гишүүдээс эх сурвалжтай байх тухай асуудал юм (Э.Гэрэлт-Од, 2009).

Намын дотоод ардчиллын ач холбогдол нь зөвхөн намын дотоод үйл ажиллагааны үр ашигтай холбоотой бус, харин улс төрийн системийн тогтвортой байдал, хариуцлага, иргэдийн улс төрийн оролцооны чанарт шууд нөлөөлдөгт оршино. Дотоод ардчилал өндөртэй намууд гишүүдийн

оролцоог өргөн хүрээнд хангаж, дотоод өрсөлдөөнийг дэмжиж, удирдлагын шийдвэрийг хянах механизмыг бий болгосноор улс төрийн төлөөллийг илүү бодитой, итгэл даахуйц болгодог байна. Харин дотоод ардчилал сул намуудын хувьд улс төрийн шийдвэр цөөн удирдагч, элит бүлгийн хүрээнд гарч, намын жирийн гишүүдийн оролцоо ёс төдий шинжтэй болж хувирдаг нь ардчиллын чанарт сөргөөр нөлөөлдөг. Иймд улс төр судлалын хүрээнд намын дотоод ардчиллыг системтэйгээр шинжлэх, хэмжих оролдлогууд өргөжин хөгжсөн бөгөөд энэ нь намын институцийн чанарыг харьцуулан үнэлэх онолын болон практик ач холбогдолтой болсон юм (С.Мөнхбат, 2023).

Намын дотоод ардчиллыг хэмжих оролдлогын хүрээнд хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй загвар бол Гидеон Рахат, Ассаф Шапира нарын боловсруулсан намын дотоод ардчиллын индекс юм. Уг индекс нь намын дотоод ардчиллыг нэг хэмжигдэхүүнээр бус, харин харилцан уялдаа бүхий хэд хэдэн институцийн хэмжигдэхүүнээр тодорхойлохыг зорьдгоороо онцлогтой. Судлаачид намын дотоод ардчиллыг оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, хариу үйлдэл, ил тод байдал гэсэн үндсэн хэмжигдэхүүнүүдээр задлан шинжилж, улс төрийн намуудыг дотоод ардчилалтай эсэхээр хоёр туйлд ангилах бус, харин ардчиллын чанарын түвшинг харьцуулан үнэлэх боломжийг олгодог. Түүнчлэн энэхүү индекс нь намын дотоод ардчиллын хэмжигдэхүүнүүд хоорондоо зөрчилдөх эсвэл харилцан бэхжих боломжтойг харуулснаар дотоод ардчиллыг нэг шугаман бус, олон талт институцийн үзэгдэл болохыг онолын түвшинд нотолдог (Rahat & Shapira, 2016).

Оролцоо нь намын гишүүд, дэмжигчид шийдвэр гаргах үйл явцад бодитоор оролцох боломж хэр зэрэг нээлттэй байгааг илэрхийлдэг бол өрсөлдөөн нь намын удирдлага, нэр дэвшигчдийг тодруулах үйл явц дахь сонголтын бодит боломж, чөлөөт өрсөлдөөнийг илтгэнэ. Төлөөлөл нь намын дотоод бүтэц, удирдлага нийгмийн олон янз бүлгүүдийн ашиг сонирхлыг хэр зэрэг тусгаж байгааг харуулдаг бол хариу үйлдэл нь намын удирдлага гишүүдийн санал, шаардлагад хэр хурдан, бодитоор хариу өгч байгааг илэрхийлдэг. Харин ил тод байдал нь намын шийдвэр гаргалт, санхүүжилт, дотоод үйл ажиллагаа гишүүд болон олон нийтэд хэр нээлттэй, хянах боломжтой байгааг илтгэдэг хэмжигдэхүүн юм (Rahat & Shapira, 2016).

Энэхүү индексийн онолын ач холбогдол нь намын дотоод ардчиллыг зөвхөн норматив зарчим бус, бодит институцийн механизмын түвшинд авч үзэх боломжийг олгосонд оршино. Уг индекст дижитал технологийн

нөлөөллийг шууд тусгаагүй нь орчин үеийн улс төрийн намуудын хувьд судалгааны шинэ орон зайг нээж байна. Иймд дижитал технологийн нөлөөг үнэлэх оновчтой арга нь эдгээр хэмжигдэхүүн тус бүрийн хүрээнд ямар институцийн сул тал ажиглагдаж байгааг тодорхойлж, түүнд дижитал шийдлүүд институцийн түвшинд ямар механизмаар нөлөөлж болохыг шинжлэх явдал юм.

1. *Оролцоо (participation)*

Гидеон Рахат болон Ассаф Шапира нарын үзүүлэлтээр оролцоо гэдэг нь намын голлох шийдвэрүүдэд хэн оролцож, хэн бодит нөлөө үзүүлж чадаж байгааг тодорхойлно. Тухайлбал намын дарга болон удирдах байгууллагын гишүүд, парламентын сонгуульд нэр дэвшигчдийг хэн тодруулдаг, намын бодлого, мөрийн хөтөлбөр боловсруулахад хэн оролцдог, үзэл санааны хэлэлцүүлэгт хэн оролцох боломжтой зэрэг нь оролцооны бодит цар хүрээг тодорхойлдог (Rahat & Shapira, 2016).

Орчин үеийн улс төрийн намуудын хөгжлийн чиг хандлага нь технологийн дэвшил, иргэдийн оролцооны өөрчлөлттэй нягт уялдаж байна. Дижитал технологийн нөлөөгөөр намуудын бүтэц, стратеги, оролцооны механизм шинэчлэгдэж, улам бүр ил тод, өгөгдөл, сүлжээнд суурилсан, иргэдийн цахим оролцоог дэмжсэн байгууллагын хэлбэр рүү шилжиж буй нь ажиглагдаж байна. Энэ нь зөвхөн сонгуулийн кампанит ажил төдийгүй улс төрийн тогтолцооны бүхэл бүтэн шинэчлэлийн урьтал нөхцөл болж буй юм. Улс төрийн намд итгэх иргэдийн итгэл илт унаж буй нь нам зохион байгуулалт болон бусад олон зүйлсэд өөрчлөлт оруулах шаардлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл тухайн цаг үе, нийгмийн байдал, улс төрийн зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан улс төрийн намууд хүртэл хөгжиж, улам боловсронгуй болох шаардлагатай тулгарч байна. Энэ нь улс төрийн намыг үеэ өнгөрөөсөн гэж үзэхээс илүүтэйгээр улс төрийн намын хэв маяг шинэчлэгдэж, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан дэвшилтэт бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэрийг сонгон ажиллах бодит шаардлага бий болсонтой холбон үзэх ёстой (С.Мөнхбат, Н.Батсүмбэрэл, 2023).

Барууны улс орнуудад дижитал хэлбэрийн улс төрийн намууд шинээр байгуулагдан, зарим уламжлалт улс төрийн намууд дижитал хэлбэрлүү шилжиж иргэд, гишүүдийн оролцоог илүүтэй хангаж, зардал, цаг хугацаа хэмнэж чадахуйц зохион байгуулалтын хэлбэрийг сонгож, нүсэр зохион байгуулалт, зардал ихтэй бүтцээс татгалзаж эхлээд байна.

Швед улсад “Далайн дээрэмчдийн нам” (Pirate Party), Итал улсад “Таван од хөдөлгөөн” (Five Star Movement) зэрэг дижитал намууд бий болж эдгээр намууд төвлөрсөн бус, уян хатан байдалд суурилсан, намын дотоод зохион байгуулалт, шийдвэр гаргах процессыг ил тод, нээлттэй, олон талын оролцоонд тулгуурласан байдаг. Цаашлаад, дижитал орчин дахь харилцаа холбоо нь намын гишүүд, дэмжигчид, тэр ч байтугай улс төрийн хүрээнээс гадна орших иргэдтэй харилцах шинэ суваг болж, тэдний санал бодлыг улс төрийн бодлого боловсруулах үйл явцад нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж байна (Gerbaudo, 2019). Ингэснээр дижитал технологи зөвхөн технологийн дэвшил төдий бус, улс төрийн соёл, оролцоо, намын байгуулалтын шинэ шатанд шилжих нөхцөлийг бүрдүүлж байна.

2. *Өрсөлдөөн (competition)*

Намын дотоод ардчиллыг хэмжих дараагийн гол шалгуур бол өрсөлдөөн (competition) юм. Өрсөлдөөн нь намын удирдлага болон нэр дэвшигчдийг тодруулах үйл явц олон сонголттой, чөлөөт өрсөлдөөнд суурилсан байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл сонгогч (намын гишүүд болон төлөөлөл) нь олон хувилбар дундаас сонголт хийх бодит боломжтой эсэх нь дотоод ардчиллын үндсэн шалгуур мөн гэж үзсэн (Rahat & Shapira, 2017).

Дижитал технологи нь өрсөлдөөний хүртээмжийг нэмэгдүүлэх хоёр үндсэн суваг нээж буйг Европын дижитал намуудын туршлагаас харж болно (Gerbaudo, 2019). Нэгдүгээрт, цахим сунгаа буюу санал хураалтын систем нь гишүүдийн байршил, цаг хугацааны хязгаарлалттай холбоотой саадыг бууруулж, илүү олон гишүүн өрсөлдөх, оролцох боломж олгож байна. Хоёрдугаарт, нэр дэвшигчийн талаарх мэдээллийг илүү нээлттэй, харьцуулж болохуйц хэлбэрээр түгээх боломж олгосноор намын удирдлагын мэдээллийн давуу байдлаас шалтгаалсан хаалттай өрсөлдөөнийг сулруулах нөхцөл бүрдэнэ.

Дижитал технологийн тусламжтайгаар намын удирдлага болон сонгуульд нэр дэвших хүсэлтэй гишүүд хүсэлтээ цахим хэлбэрээр ил тод гаргаж, намын гишүүдийн дунд нээлттэй өрсөлдөх аргыг Швед улсын дижитал намууд ашиглаж байна (Piratpartiet, 2024). Ингэснээр уламжлалт улс төрийн намуудад ажиглагддаг цөөн бүлгийн эрх мэдэл, удирдлагын төвлөрлийг тодорхой хэмжээнд сааруулах, илүү олон гишүүн нэр дэвших, өрсөлдөх институцийн нөхцөл бий болдог. Паоло Гербуадо (2019) “Дижитал нам” хэмээх бүтээлдээ дижитал платформд суурилсан ийм зохион байгуулалт нь гишүүдийн хэлэлцүүлэг, санал хураалтад оролцоог дэмжих

замаар намын дотоод өрсөлдөөнийг илүү нээлттэй, хүртээмжтэй хэлбэрт шилжүүлэх боломжтой гэж дүгнэсэн байдаг (Gerbaudo, 2019).

3. Төлөөлөл (representation)

Намын дотоод ардчиллыг хэмжих бас нэг чухал хэмжигдэхүүн бол төлөөлөл (representation) буюу намын дотоод бүтэц, шийдвэр гаргалт нийгмийн олон янз бүлгүүдийн ашиг сонирхлыг хэр зэрэг тусгаж буйг илэрхийлнэ (Rahat & Shapira, 2016). Дижитал технологи энэ хэмжигдэхүүнд шууд квот шиг нөлөөлөхгүй ч төлөөллийн саадыг бууруулах нөхцөл бүрдүүлж чадна. Тухайлбал алслагдсан бүс нутгийн гишүүд, залуучууд болон эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нь уламжлалт танхимд суурилсан хурал, биечлэн оролцох механизмаар дамжин хэрэгжиж ирсэн нь орон зайн байршил, цаг хугацаа, эдийн засаг болон нийгмийн капиталын ялгаанаас үүдэн бодит хязгаарлалтад орж ирсэн (НҮБХХ, 2014). Энэхүү нөхцөл байдал нь улс төрийн оролцооны тэгш бус байдлыг гүнзгийрүүлж, тодорхой бүлгүүдийн дуу хоолой шийдвэр гаргалтын түвшинд хангалттай тусгагдахгүй байх эрсдэлийг бий болгож байна. Харин дижитал технологид суурилсан онлайн оролцооны хэлбэрүүд нэвтэрснээр эдгээр саад бэрхшээлийг бууруулж, гишүүдийн тэгш боломжид суурилсан, хамрах хүрээ, оролцоог тэлэх нөхцөл бүрдүүлэх боломжтой. Үүний үр дүнд эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бүс нутгийн төлөөллүүд газарзүйн байршлаас үл хамааран цахимаар бодлогын хэлэлцүүлэгт оролцох, санал санаачилга гаргах, улмаар намын дотоод шийдвэр гаргалтад шууд оролцох, нөлөөлөх нөхцөл бүрдэж байгаа нь дижитал технологийн чухал нөлөө юм.

4. Хариу үйлдэл (responsiveness)

Хариу үйлдэл нь намын удирдлага гишүүдийн санал, шаардлага, гомдолд хэр хурдан, бодитоор хариу өгч, бодлого, шийдвэрт тусгаж байгааг илэрхийлнэ (Rahat & Shapira, 2016). Дижитал технологи энэ хэмжигдэхүүнд нөлөөлөх хамгийн тодорхой боломжтой. Учир нь онлайн санал, санал асуулга, хэлэлцүүлгийн өгөгдөл нь гишүүдийн хүсэл, чиг хандлагыг хурдан нэгтгэж, намын удирдлагад болон гишүүдийн эргэх холбоог сайжруулдаг байна. Намын дотоод ардчилал ба хариу үйлдлийн уялдаа холбоог эмпирик түвшинд судалсан судалгаанууд дотооддоо ардчилсан механизмтай намууд улс төрийн орчин дахь өөрчлөлт, сонгогчдын хандлагад илүү мэдрэмжтэй, хариуцлагатайгаар хариу үйлдэл үзүүлэх хандлагатайг харуулдаг (Lehrer, Ezrow, & Ward, 2017). Өөрөөр хэлбэл гишүүдийн оролцоо бодитой

хангагдсан намуудад гишүүдийн байр суурь, шаардлага удирдлагын шийдвэр гаргалтад тогтмол тусч, намын бодлого орчны өөрчлөлттэй илүү уялдан шинэчлэгдэх нөхцөл бүрддэг байна.

Энэхүү дүгнэлтийг намын дотоод орчинд авч үзвэл дижитал технологи нь гишүүдийн санал бодол, чиг хандлагыг тогтмол, хэмжигдэхүйц хэлбэрээр илэрхийлүүлэх боломж олгож, удирдлагын шийдвэрийг гишүүдийн бодит байр суурьтай ойртуулах институцийн нөхцөлийг бүрдүүлж чадна. Харин уламжлалт төвлөрсөн зохион байгуулалттай, дотоод ардчилал сул намуудад гишүүдийн санал хүсэлт удирдлагын түвшинд хүрэхгүй саатах, эсвэл шийдвэр гаргалтад бодитоор тусахгүй байх хандлага давамгайлдаг бөгөөд энэ нь намын хариу үйлдлийн чанарыг сулруулдаг (Lehrer, Ezrow, & Ward, 2017).

5. *Ил тод байдал (transparency)*

Хамгийн сүүлийн намын дотоод ардчиллын чухал хэмжүүр бол ил тод байдал (transparency) юм. Ил тод байдал нь намын дотоод шийдвэр гаргалт, санхүүгийн бүрдүүлэлт, зарцуулалт, олон нийтэд ойлгомжтой, хянах боломжтой, нээлттэй байхыг хэлдэг. Дотоод ардчилал өндөртэй намууд гишүүдийн хяналтын механизмыг өргөн хэрэглэж, мэдээллийн нээлттэй байдлыг хангах замаар гишүүдийн итгэл, оролцоо, хариуцлагын тогтолцоог бэхжүүлдэг байна (Rahat & Shapira, 2016). Харин уламжлалт намуудад ил тод байдал нь ихэвчлэн удирдлагын түвшинд хязгаарлагдаж, шийдвэр гаргалтын процессын дотоод мэдээлэл гишүүдэд хүрдэггүй, эсвэл хэт төвлөрсөн нууцлагдмал байдаг нь өнөөгийн намуудаас ажиглагддаг. Ялангуяа улс төрийн намууд сонгуулийн болон улс төрийн санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд ил тавьдаггүй, хяналт тавих хууль эрх зүйн орчин сул байдаг нь өнөөгийн улс төрийн намуудын дотоод ардчиллыг доройтуулж буй нэг шалтгаан юм (Ж.Төртогтох, Б.Эрдэнэдалай, 2023). Дижитал хэлбэрийн улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг хангахын тулд блокчэйн технологи ашигладаг. Энэ нь тухайн намд өгч буй хандивыг өөрчлөх боломжгүй байдлаар бүртгэлжүүлэх, гүйлгээний эх үүсвэрийг тодорхой болгох, гишүүд болон олон нийтэд хяналт тавих боломжийг бий болгож байна. Энэ нь намын санхүүжилтын хаалттай, хяналтгүй байх эрсдлийг бууруулах эерэг үр дүнтэй технологийг нэгэн шинэлэг арга юм (Deseriis, 2020).

Европын дижитал улс төрийн намууд намын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн хүртээмжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлж байна. Эдгээр намууд нь бодлого боловсруулах, дотоод шийдвэр гаргах, санал

хураалт явуулах үйл явцыг цахим орчинд зохион байгуулж, санал хураалтын үр дүнг ил тод нийтэлснээр хяналт, хариуцлагын механизмын мөрдөх боломжийг сайжруулж байгаа нь онцлог юм. Түүнчлэн намын үйл ажиллагаанд зарцуулах зардал, намын болон улс төрийн санхүүжилтийн урсгалыг цахим системээр бүртгэн тайлагнаж, хөндлөнгийн хяналтын байгууллагуудын оролцоог хангах замаар ил тод байдлыг институцийн түвшинд бэхжүүлж байна. Ингэснээр дижитал платформд суурилсан намууд нь ил тод байдал, хариуцлагын шинэ стандартыг тогтоож, уламжлалт намын зохион байгуулалттай харьцуулахад нээлттэй байдлын түвшинг дээшлүүлэх хандлага ажиглагдаж байна.

Дээрх таван хэмжигдэхүүний хүрээнд авч үзвэл дижитал технологи нь намын дотоод ардчиллыг дангаараа, автоматаар сайжруулах шийдэл бус харин намуудын шинэчлэлийг дэмжих, оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал, хариу үйлдлийн сул талыг бууруулахад ашиглаж болох үр ашигтай хэрэгсэл байж болохоор байна.

Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын өнөөгийн байдал

Ардчилал бол иргэнд үзэл бодлоо илэрхийлэх улс төрийн эрх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх, боломжийг олгосон үнэт зүйл, үнэлэмжийн цогц бөгөөд улс төрийн нам нь дээрх үнэт зүйлсийг бодитойгоор ашиглах боломжийг олгодог. Ардчилал өндөр хөгжсөн болон ардчилал хөгжиж буй улс орнууд бүхэлдээ гишүүд болон сонгогчдын үзэл бодлыг илэрхийлж чадах, хүчтэй, төлөвшсөн, ардчиллын суурь зарчмуудыг дотоод үйл ажиллагаандаа дагаж мөрддөг улс төрийн намуудтай байхыг хүсдэг. Харамсалтай нь зарим ардчилсан улсад улс төрийн намууд сонгогчид болон жирийн гишүүдийн санаа бодлыг илэрхийлэх, тэдний үзэл бодол, байр суурийг зуучлах үнэт хэрэгсэл болж чадахгүй байна (Э.Гэрэлт-Од, 2009) .

Намын дотоод ардчиллыг улс төрийн намын оршин тогтнох, ардчилсан шинжийг тодорхойлох суурь нөхцөл хэмээн үздэг. Р. Гибсон, Р. Гармель нар намын дотоод ардчиллыг “намын шийдвэр гаргах бүхий л үйл ажиллагаанд намын гишүүд, дэмжигчид оролцох боломж” хэмээн тодорхойлсон байдаг (Gibson & Harmel, 1998). Ардчилсан нийгэмд намын дотоод ардчиллыг гишүүдийн намын бодлого, мөрийн хөтөлбөр, дүрэм журам боловсруулах, сонгуульд оролцох, нэр дэвшигч тодруулах зэрэг шийдвэр гаргалтын үйл явц дахь бодит оролцооны боломжоор хэмждэг


бөгөөд энэ нь тухайн нам хэр зэрэг ардчилсан шинжтэй болохыг илэрхийлдэг чухал шалгуур болдог (С. Мөнхбат, 2023).

Монгол Улсын Улс төрийн намын тухай хуульд намуудын дотоод зохион байгуулалт, гишүүдийн оролцоо, санхүүгийн тайлагнал, ил тод байдлыг хангах тодорхой шаардлагууд тусгагдсан боловч эдгээр зохицуулалтыг бодитой хэрэгжүүлэх, зөрчилд хариуцлага тооцох механизм сул хэвээр байгааг судлаачид онцолдог.

Намын дотоод ардчиллыг хангах эрх зүйн шаардлага болон тэдгээрийн хэрэгжилтийн хооронд үүсч буй зөрүүг Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын бодит байдлыг хэмжсэн эмпирик судалгааны үр дүн тодорхой харуулж байна. Дефакто Институт нь 2018–2020 онуудад Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийн судалгааг Рахат, Шапира нарын боловсруулсан онолын загварт тулгуурлан гүйцэтгэж, оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал гэсэн дөрвөн үндсэн хэмжигдэхүүнээр үнэлгээ хийсэн байна. Судалгаанд тухайн үед УИХ-д суудалтай МАН, АН, МАХН, ХҮН зэрэг дөрвөн намыг хамруулсан бөгөөд эдгээр намуудын дундаж оноо 100 онооноос 59.7-д хүрсэн нь Монголын намуудын дотоод ардчилал “хагас ардчилсан” ангилалд багтаж байгааг харуулж байна (De Facto Independent Research Institute, 2020).

Индексийн ангиллаар авч үзвэл 30-аас доош оноо авсан намыг “ардчилалгүй”, 31–60 оноог “хагас ардчилсан”, 61–100 оноог “ардчилсан” гэж ангилдаг байна. Энэ хүрээнд МАН, АН, МАХН намууд “хагас ардчилсан” ангилалд багтсан бол ХҮН нам дотоод ардчиллын хувьд “ардчилсан” ангиллын доод заагт дөнгөж хүрсэн байна. Энэ нь намуудын дотоод дүрэм, гишүүдийн оролцооны механизм, шийдвэр гаргалтын ил тод байдал, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгааг илтгэж байна.

Зураг №1: Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс 2018-2020 он




Зураг №1-д харуулсан энэхүү индексийн үр дүнгээс харахад Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын асуудал нь зөвхөн нэг намын сул тал бус, харин тогтолцооны шинжтэй, нийтлэг институцийн сорилт болох нь харагдаж байна. Хэдийгээр эрх зүйн орчинд намуудын дотоод ардчиллыг хангах шаардлагууд тусгагдсан ч тэдгээрийн хэрэгжилтийг хянах хяналт, хариуцлага тооцох тогтолцоо сул хэвээр байгаа нь намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд саад болж байгааг энэхүү судалгааны үр дүн харуулж байна.

Судлаач Э. Гэрэлт-Од Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллыг бэхжүүлэхэд саад болж буй хүчин зүйлсийг шууд болон шууд бус гэж ангилж, шууд хүчин зүйлд нэр дэвших эрх, нэр дэвшигчийг тодруулах механизм, эмэгтэй гишүүдийг дэмжих бодлого, орон нутгийн намын бие даасан байдал, санхүүжилтийн ил тод байдлыг, харин шууд бус хүчин зүйлсд олигархжих хандлага, хатуу төвлөрсөн зохион байгуулалт, гишүүдийн сул оролцоо, уламжлалт сэтгэлгээ, соёлын хандлага, ядуурал зэрэг олон хүчин зүйлийг дурдсан байдаг (Э. Гэрэлт-Од, 2009). Энэ нь намын шийдвэр гаргалт цөөн тооны удирдах түвшинд төвлөрөх хандлага давамгайлж, жирийн гишүүд бодлого, стратеги, нэр дэвшигч тодруулах зэрэг гол шийдвэрүүдэд тогтмол, бодит нөлөө үзүүлэх боломж манай улсад хязгаарлагдмал хэвээр байна гэж дүгнэсэн байдаг.

Дефакто Институтын 2019–2020 оны судалгаагаар намын гишүүдийн оролцооны хэмжигдэхүүнд хамрагдсан дөрвөн нам дунджаар 25 онооноос 15.5 оноо авсан нь оролцоо дунд түвшинд байгааг харуулж байна. Судалгааны үр дүнгээс харахад АН нь намын даргаа бүх гишүүдийн саналаар сонгодог хамгийн хүртээмжтэй механизмыг хэвээр хадгалж байгаа бол МАН 2020 онд оролцооны оноогоо тодорхой хэмжээнд ахиулсан байна. Гэсэн хэдий ч нийтлэг дүр зураг нь гишүүдийн оролцоо нэр дэвшигч тодруулах, бодлого боловсруулах зэрэг гол шийдвэрүүдэд тогтвортой, бодитой хангагдахгүй байгааг харуулж байна (De Facto Independent Research Institute, 2020). Гишүүдийн оролцоо ихэвчлэн сонгуулийн мөчлөгт хязгаарлагдаж, бодлого боловсруулах болон шийдвэр гаргалтад тогтмол, нөлөө бүхий байдлаар тусч чадахгүй байгаа нь намын дотоод ардчиллыг формаль шинжтэй болгох гол хүчин зүйл болж байна.

Зураг №2: Улс төрийн намын гишүүдийн оролцоо, 2019-2020 он (25 оноо)




Эх сурвалж: (De Facto Independent Research Institute, 2020)

Дотоод өрсөлдөөний хувьд намын удирдлага болон сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах үйл явц дүрмийн хүрээнд явагддаг ч бодит байдал дээр санхүү, зохион байгуулалт, дотоод нөлөөллийн хүчин зүйлс өрсөлдөөнийг жигд бус болгож, нээлттэй сунгааны зарчим бүрэн хэрэгжихэд саад болж байна. Ингэснээр нэр дэвших, өрсөлдөх боломж гишүүдийн дунд тэгш хуваарилагдахгүй, тодорхой бүлгүүдийн давуу байдал хадгалагдах нөхцөл бүрдэж байна.

Төлөөллийн хэмжигдэхүүний хүрээнд эмэгтэйчүүд, залуучууд, орон нутгийн гишүүдийн намын удирдах түвшинд оролцох боломж харьцангуй сул хэвээр байгаа нь намын дотоод ардчиллын чанарт нөлөөлөх чухал асуудал болж байна (НҮБХХ,2014). Хэдийгээр квот, бодлогын зорилт зэрэг зохицуулалтууд тусгагдсан ч тэдгээр нь бодит оролцооны механизм болон бүрэн төлөвшөөгүй байгаагаас төлөөллийн чанар тогтвортой сайжрахгүй байна. Мөн гишүүдийн санал, байр суурь намын бодлого, шийдвэрт хэрхэн тусч буй талаар ил тод, тогтмол мэдээлэх тогтолцоо сул байгаа нь дотоод ардчиллын хариу үйлдлийн чанарыг бууруулж байна.

Шийдвэр гарсны дараах хэрэгжилт, тайлагнал тодорхой бус байх нь гишүүдийн улс төрийн намд итгэх итгэлцэлд сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 1: Намын талаарх иргэдийн санал бодол



Эх сурвалж: Сант Марал судалгааны төв.(2022) *2010-2022 онд хийсэн судалгааны дата.*

Ил тод байдлын хувьд санхүүжилт, шийдвэр гаргалт, дотоод тайлан мэдээлэл нам бүрт жигд бус, системтэй бус хэлбэрээр нийтлэгдэж байгаа нь намын дотоод хяналт, хариуцлагын механизм бүрэн ажиллахад саад болж байна (Transparency International Mongolia, 2019). Энэ нь намын дотоод ардчиллыг институцийн хувьд сулруулж, олон нийтийн итгэлцлийг тогтвортой хадгалах боломжийг хязгаарлаж буй хүчин зүйл болж байна. Ялангуяа манай улсын хувьд ил тод болгодог тогтолцоо нь боловсронгуй биш учраас хамгийн их авилга авдаг хамгийн их мөнгө ордог төв бол улс төрийн нам болчихоод байна. (НҮБХХ, 2014 ху 13) Өнөөгийн байдлаар Улсын Дээд Шүүхэд албан ёсоор 37 улс төрийн нам бүртгэлтэй байгаа хэдий ч дотоод ардчилал өндөртэй, сонгогчидтойгоо байнгын харилцаатай нам цөөхөн байна (Нээлттэй нийгэм форум, 2024).

Дефакто Институтын индексийн судалгааны үр дүн болон улс төрийн намуудын бодит үйл ажиллагаанд тулгуурлан үзвэл Монголын улс төрийн намуудын дотоод ардчилал нь хууль, дүрэмд тусгагдсан шаардлагууд бодит амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй хэвээр байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, намын дотоод ардчиллыг хангах зохицуулалт байгаа ч гишүүдийн оролцоо, дотоод өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдлыг тогтмол, бодитой хэрэгжүүлэх түвшинд хараахан хүрээгүй байна.

Иймээс цаашид намын дотоод ардчиллыг улам бэхжүүлэхийн тулд зөвхөн хууль, дүрэмд заасан зохицуулалтад найдах бус, харин гишүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтыг илүү нээлттэй болгох,

дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог бодит ажил болгох шинэчлэлийн арга, механизм зайлшгүй шаардлагатай байна.

Дээрх дүн шинжилгээ болон Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын чанарыг сулруулж буй хүчин зүйлсийг харгалзан үзвэл эдгээр сул талыг дижитал технологийн тусламжтайгаар тодорхой хэмжээнд бууруулах боломжтой. Гэхдээ дижитал технологийг намын дотоод ардчиллыг автоматаар сайжруулах шийдэл хэмээн үзэх нь оновчтой биш бөгөөд харин гишүүдийн оролцоог өргөжүүлэх, дотоод өрсөлдөөнийг идэвхижүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалт, ил тод байдлыг нэмэгдүүлэх, илүү хариуцлагатай болгоход дэмжлэг үзүүлэх хэрэгсэл, зохион байгуулалтын механизм гэж ойлгох нь зүйтэй.

Хэрэв Монголын улс төрийн намууд дижитал технологи, цахим оролцоог зөвхөн мэдээлэл түгээх, эсвэл аль хэдийн гарсан шийдвэрийг дамжуулах хэрэгсэл хэлбэрээр ашиглавал гишүүдийн оролцоо бодит нөлөөгүй, хэлбэр төдий хэвээр үлдэх эрсдэлтэй. Монголын нөхцөлд намууд цахим орчныг ихэвчлэн зар сурталчилгаа, нэг чиглэлийн мэдээлэл дамжуулахад ашиглаж ирсэн нь гишүүдийн бодлого боловсруулах үйл явц дахь бодит оролцоог нэмэгдүүлж чадаагүйг судалгаанууд онцолдог (Нээлттэй нийгэм форум, 2018). Иймээс дижитал оролцоо нь дан ганц технологийн шийдэл бус, харин гишүүдийн санал бодол бодлого, шийдвэр гаргалтад ямар үе шатанд, ямар жинтэйгээр тусахыг тодорхойлсон институцийн дүрэм, зохион байгуулалттай уялдсан тохиолдолд л дотоод ардчиллыг бэхжүүлэх бодит механизм болж чадна.

Дижитал технологи нь намын дотоод өрсөлдөөнийг илүү хүртээмжтэй болгох боломжийг хоёр чиглэлээр нэмэгдүүлэх хандлагатай. Нэгдүгээрт, нэр дэвших болон өрсөлдөх боломжийг мэдээлэл, сүлжээ, хөрөнгө нөөцөөр хязгаарлагддаг уламжлалт хаалттай хүрээнээс тодорхой хэмжээнд салгаж, илүү олон гишүүн нэр дэвших, өөрийгөө таниулах, дэмжлэг цуглуулах боломжийг нээдэг. Хоёрдугаарт, нэр дэвшигч тодруулах, удирдлага сонгох үйл явцыг илүү ил тод, мөрдөх боломжтой процедур болгон хувиргаж, намын төв байгууллага болон дотоод элит бүлгийн нөлөөллийг институцийн хувьд хязгаарлах боломж бүрдүүлдэг (Gerbaudo, 2019).

Манай улс төрийн намуудын дотоод өрсөлдөөний тэгш бус байдал нь ихэвчлэн санхүүжилт, зохион байгуулалтын нөөц, дотоод нөлөөллийн сүлжээний ялгаанаас үүдэлтэй байдаг. Иймээс дижитал технологийг зөвхөн цахим санал хураалт хийх хэрэгсэл бус, харин нэр дэвшигчийн бүртгэл, шалгуур, сонгон шалгаруулалтын үе шат, мэдээлэл түгээх хэлбэрийг

стандартчилах институцийн шийдэл болгон ашиглах нь чухал. Нэр дэвшигчдийн мэдээллийг ижил формат, ижил нөхцөлөөр гишүүдэд хүргэх нь мэдээлэлтэй сонголт хийх боломжийг нэмэгдүүлж, танил тал, дотоод бүлэглэлийн давуу байдлыг сулруулахад дэмжлэг үзүүлэх боломжтой.

Түүнчлэн дижитал технологи нь дотоод өрсөлдөөнийг хувь хүн хоорондын бус, бодлого, үзэл санааны өрсөлдөөн болгон чиглүүлэх боломж олгож буйг Европын дижитал намын туршлагаас харж болно. Бодлогын санал, санаачилгыг цахимаар бүртгэх, хэлэлцэх, саналаар эрэмбэлэх тогтолцоо нь гишүүдийн оролцоог чанарын хувьд нэмэгдүүлэхийн зэрэгцээ өрсөлдөөнийг "хэн бэ" гэдгээс илүү "ямар бодлого дэвшүүлж байна вэ" гэсэн шалгуурт шилжүүлж байна.

Гэсэн хэдий ч дижитал технологи нь өрсөлдөөнийг автоматаар тэгшитгэнэ гэж үзэх боломжгүй. Платформын зохион байгуулалт, дүрэм, хандалтын тэгш байдал, мэдээллийн аюулгүй байдал хангагдаагүй тохиолдолд дижитал орчинд ч шинэ төрлийн давуу байдал үүсэх эрсдэл бий. Иймээс дижитал шийдлийг уламжлалт институцийг орлуулах бус, харин дотоод дүрэм, хяналт, шалгалт, аудит, маргаан шийдвэрлэх механизмтай уялдуулан нэвтрүүлж, Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг хэлбэр төдий байдлаас бодит хэрэгжилттэй, илүү хариуцлагатай байдалруу шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Уламжлалт улс төрийн намуудын дотоод ардчиллын чанарыг тогтоох таван үзүүлэлт хоорондоо харилцан уялдаатай болохыг Гидеон Рахат болон Ассаф Шапира нарын боловсруулсан индекс харуулж байна. Тэдгээрийн үзсэнээр оролцоо өргөжихийн хирээр дотоод өрсөлдөөн бодитой болж, дотоод өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр төлөөллийн чанар сайжирч, төлөөлөл сайжрах нь гишүүдийн дуу хоолой бодлогын түвшинд бодитой тусгагдах нөхцөлийг бүрдүүлж, үүний үр дүнд намын дотоод шийдвэр гаргах үйл явц улам ил тод болохын намын дотоод ардчилал хөгжиж, намын институтийн чанар өсдөг.

Хамгийн сүүлд хийсэн судалгаагаар Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын түвшин "хагас ардчилсан" ангилалд багтаж байна. Энэ нь манай намуудад оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, хариу үйлдэл, ил тод байдал зэрэг институтийн таван хэмжигдэхүүн аль аль нь хангалтгүй түвшинд байгааг илэрхийлж байна. Ялангуяа намуудад гишүүдийн оролцоо сул, дотоод өрсөлдөөн хязгаарлагдмал, шийдвэр гаргах эрх намын

удирдлагад төвлөрөх хандлагатай, намын санхүүжилт ил тод бус, мэдээлэл хаалттай зэрэг асуудлууд нь Монголын намуудыг “хагас ардчилсан” ангилалд үлдэхэд нөлөөлж байна.

Иймд Европын улс орнуудад дижитал технологийг намын үйл ажиллагаанд системтэйгээр нэвтрүүлэх, цаашлаад дижитал хэлбэрийн улс төрийн нам байгуулах туршлага эрчимтэй хөгжиж байгаа нь намын дотоод ардчиллыг бэхжүүлэх шинэ боломж, гарц болж байна. Тухайлбал Испанийн Подемос, Италийн Таван од хөдөлгөөн, Шведийн Далайн дээрэмчдийн нам зэрэг намууд гишүүдийн цахим оролцоонд суурилсан платформуудыг хөгжүүлж, санал хураалт, нэр дэвшигч болон намын удирдлага сонгох, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх, мөрийн хөтөлбөр боловсруулах, батлах зэрэг голлох шийдвэрүүдэд намын нийт гишүүдийг өргөн хүрээтэй, илүү тэгш байдлаар оролцуулах механизмыг ашиглаж байна.

Эдгээр туршлагаас харахад Монголын улс төрийн намуудын хувьд дижитал технологийг дотоод болон гадаад үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь зөвхөн техникийн шинэчлэл бус харин гишүүдийн оролцоог бодитой нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтыг илүү нээлттэй болгох замаар намын дотоод ардчиллыг бэхжүүлэх институцийн ач холбогдолтой байж болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол эх сурвалж

1. De Facto Independent Research Institute. (2020). Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2020. Улаанбаатар хот. Монгол улс. 10 дахь тал
2. Мөнхбат, С., & Батсүмбэрэл, Н. (2023). Онлайн ардчиллын бэхжилт ба Монголын улс төрийн намын гишүүнчлэлд тулгарч буй сорилтууд. *ПОЛИТОЛОГИ XXI. Эрдэм шинжилгээний бичиг*, (21[579]), 172–179.
3. Мөнхбат, С. (2023). Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын хөгжил: Онол, практик. Улаанбаатар: Соёмбо Принтинг
4. Мөнхбат, С. (2025). “Дижитал улс төрийн нам ба үзэл баримтлалын зарим асуудал”, Политологи сэтгүүл №23 (619), ху-173
5. Гэрэлт-Од, Э. (2009). “Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал” УБ.
6. НҮБХХ. (2014). “Улс төрийн намуудын санхүүжилт, гишүүнчлэл, орон нутгийн сонгууль дахь улс төрийн намын оролцоог боловсронгуй болгох нь” Retrieved from Судалгаа1_UNDP.pdf

7. Ж.Төртогтох, & Б.Эрдэнэдалай. (2023). Монголын Улс Төрийн Намуудын Санхүүжилтын Өнөөгийн Байдал, Тулгамдсан Асуудал: Улс Төр- Эрх Зүйн Шинжилгээ. *Politology*, *5*(325 (51), 130–139. Retrieved from https://journal.num.edu.mn/ps/article/view/3743
8. Нээлттэй нийгэм форум. (2024). Бодлогын асуудал: Намын дотоод ардчилал, нэр дэвшүүлэх процесс.
9. Transparency International Mongolia. (2019). Улс төрийн намын санхүүжилт ба ил тод байдал.
10. Эрдэнэдалай, Б. (2023). Улс төрийн санхүүжилт: *Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал.* Улаанбаатар хот: Мөнхийн үсэг
    Гадаад эх сурвалж
11. van Biezen, I. (2004). HOW POLITICAL PARTIES SHAPE DEMOCRACY. *UC Irvine: Center for the Study of Democracy*. Retrieved from https://escholarship.org/uc/item/17p1m0dx
12. Rahat, G., & Shapira, A. (2016). An Intra-Party Democracy Index: Theory, Design and A Demonstration. Parliamentary Affairs, 70 (1), 84–110.
13. Gerbaudo, P. (2019). *The Digital Party: Political Organisation and Online Democracy*. Pluto Press.
14. Pirate partiet. (2025). Policy areas: Administrative policy. Retrieved from Policy areas – Piratpartiet
15. Lehrer, R., Ezrow, L., & Ward, H. (2017). *Intra-Party Democracy and Responsiveness*.
16. Deseriis, M. (2020). *Direct Democracy and Digital Politics: The Pirate Party Model.* New Media & Society, 22(1), 152–170.
17. Richard Hofferbert. (1998). Parties and Democracy. PSA. Blackwell Publishers.

STRENGTHENING INTERNAL DEMOCRACY WITHIN POLITICAL PARTIES THROUGH DIGITAL TECHNOLOGIES

Abstract: Internal party democracy plays an essential role in enhancing transparency, improving the quality of policy formulation, and strengthening citizens' trust in political institutions by ensuring that members' preferences are meaningfully reflected in decision-making processes. In Mongolia, however, political parties remain characterized by highly centralized and non-transparent decision-making structures dominated by hierarchical power relations. Such organizational characteristics weaken public confidence in political parties and undermine the representativeness and accountability of the political system. Given these circumstances, this paper examines the topic in depth.

This paper aims to define the concept of intra-party democracy and to examine the five key indices proposed by scholars Gideon Rahat and Assaf Shapira. It also further explores how traditional parties can leverage digital technology to enhance each of these dimensions. Finally, the study identifies a few key challenges to internal democracy within Mongolian political parties and proposes recommendations to address them.

Key words: Digital political party, intra-party democracy, member participation, transparency, decision-making, digital technology.

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 19-29 дахь тал

УИХ ДАХЬ НАМЫН БҮЛГҮҮД АЖЛЫН ХЭСГИЙН МЭДЭЭЛЛЭЭ ЮУТҮБ СУВГААР ТҮГЭЭЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Б.Эрдэнэдалай
МУИС, УТСОУХНУС
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

А.Минжинсор
МУИС, УТСОУХНУС
Улс төрийн мэдээлэл харилцааны магистрант

Хураангуй:

Цахим мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн үр дүнд улс төрийн институцүүд олон нийттэй харилцах шинэ сувгуудыг идэвхтэй ашиглах болсон. Ялангуяа видео контентод суурилсан юутүб платформ нь улс төрийн мэдээллийг шууд түгээх, иргэдийн мэдээлэл авах боломжийг өргөжүүлэх чухал хэрэгсэл болж байна. Энэхүү судалгаанд Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүдийн ажлын хэсгүүдийн юутүб сувгаар түгээж буй мэдээллийн агуулга, хүртээмж, редакцийн шинж чанарыг шинжилж, тухайн мэдээлэл сэтгүүлчдээр дамжин олон нийтэд хүрэх үйл явц хэрхэн явагдаж байгааг тодорхойлохыг зорив. Судалгаанд контентын шинжилгээ, ажиглалт, гүнзгийрүүлсэн ярилцлага зэрэг чанарын болон тоон хосолсон арга зүйг ашиглав. Судалгааны үр дүнгээс харахад намын бүлгүүд юутүб сувгийг мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх хэрэгсэл болгон ашиглаж байгаа боловч бодит байдалд мэдээллийн агуулгад редакцийн шүүлтүүр тодорхой хэмжээнд ажиллаж байгаа нь ажиглагдсан.

Түлхүүр үгс: Улс төрийн коммуникаци, намын бүлэг, юутүб суваг, нээлттэй мэдээлэл, хэвлэл мэдээлэл, хоёр шатлалын мэдээллийн урсгал

Удиртгал: Сүүлийн жилүүдэд цахим орчин, сошиал медиа платформууд улс төрийн коммуникацийн үндсэн суваг болж өөрчлөгдөж байна. Интернэт хэрэглээний өсөлт нь улс төрийн байгууллагууд олон нийттэй харилцах уламжлалт хэлбэрийг өөрчилж, шууд харилцааны шинэ механизмыг бий болгож байна (Chadwick, 2017). Ялангуяа видео контентод

суурилсан платформууд нь улс төрийн мэдээллийг илүү хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар түгээх боломжийг нэмэгдүүлж байна.

Монгол Улсад парламентын үйл ажиллагааны талаарх мэдээллийг уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээдэг байсан бол сүүлийн жилүүдэд улс төрийн намын бүлгүүд өөрсдийн албан ёсны сошиал медиа сувгуудыг идэвхтэй ашиглах болсон. Тухайлбал, УИХ дахь намын бүлгүүд ажлын хэсгийн үйл ажиллагаа, гишүүдийн байр суурь, хуралдааны үйл явцын талаарх мэдээллийг юутүб сувгаар дамжуулан нийтэлж байна.

Ковид-19 цар тахлын үед төрийн ордонд ажиллах хэвлэл мэдээллийн байгууллагуудад тодорхой хязгаарлалт тавигдсан нь улс төрийн мэдээлэл авах эх сурвалжийн бүтэц өөрчлөгдөхөд нөлөөлсөн. Үүний үр дүнд сэтгүүлчид улс төрийн мэдээллийг намын бүлгүүдийн сошиал медиа сувгаас авах хандлага нэмэгдсэн. Энэ нь улс төрийн мэдээлэл түгэх механизмд шинэ зуучлагч бий болгож байгаа бөгөөд тухайн мэдээллийн үнэн зөв байдал, бүрэн бүтэн байдалд нөлөөлөх боломжтой. Иймд энэхүү судалгааны зорилго нь УИХ дахь намын бүлгүүдийн юутүб сувгаар түгээж буй мэдээллийн онцлогийг шинжилж, тухайн мэдээлэл олон нийтэд хүрэх процесс улс төрийн коммуникацийн онолын үүднээс хэрхэн тайлбарлагдах боломжтойг тодорхойлоход оршино.

Судалгааны онол, арга зүй

Улс төрийн мэдээлэл олон нийтэд хэрхэн түгдэг талаар судлахад коммуникацийн сонгодог онолууд чухал ач холбогдолтой. Тэдгээрийн дотор хоёр шатлалын харилцаа холбооны онол (Two Step Flow Theory) нь масс харилцаа холбоо, мэдээлэл түгэх болон нийгмийн нөлөөллийн талаар анхны цогц ойлголтуудыг өгсөн онол юм. Энэ онолыг анх 1940-өөд оны дундуур Пол Лазарсфельд, Бернард Берельсон, Хэзел Гаудет нар (Lazarsfeld, Berelson & Gaudet, 1944) судалгаагаар гаргаж ирсэн. Тэд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр (1940) сонгогчдын зан төлөвийг судалж, мэдээлэл түгэх арга барилыг шинжилсэн байдаг. Ингэхдээ масс мэдээллийн хэрэгслээр дамжсан мэдээлэл шууд олон нийтэд нөлөөлдөг гэсэн үзэл санааг үгүйсгэж, мэдээлэл дараах байдлаар түгдэг гэж үздэг. Эхний шат нь масс мэдээллийн хэрэгслээр (сонин, радио, телевиз гэх мэт) мэдээлэл "үзэл бодлын манлайлагчид" (opinion leaders) буюу нийгэмд нөлөөтэй хүмүүсийн анхааралд хүрдэг. Хоёр дахь шат нь эдгээр манлайлагчид тухайн мэдээллийг хүлээн авч, боловсруулан өөрсдийн найз нөхөд, гэр бүл, хамт олон зэрэг нийгмийн бүлгүүдэд дамжуулдаг юм. Лазарсфельд болон түүний

хамтрагчид Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр сонгогчдын мэдээлэл авах үйл явц, сонголтод юу нөлөөлдөг талаар судлахдаа дараах зүйлийг илрүүлсэн. Сонгогчдын шийдвэрт масс мэдээллийн хэрэгслээс илүү ойрын харилцаа, ялангуяа итгэмжит хүмүүсийн санал чухал нөлөөтэй байдаг. Хүмүүс мэдээллийг бусадтай харилцах явцдаа илүү их ойлгож, итгэл үнэмшлээ өөрчилдөг. Иймд мэдээлэл бүх нийтэд шууд хүрэхийн оронд тодорхой нийгмийн сүлжээ, хүмүүсийн харилцааны суваг дамжин түгдэг гэх дүгнэлтэд хүрсэн байдаг.

Судалгааны арга зүйг төлөвлөхдөө анхдагч болон хоёрдогч эх сурвалж болж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон намын бүлгүүдийн юутүб сувагт ажиглалт хийв. Мөн тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төлөөлж байгаа улс төрийн мэдээ, мэдээллээр дагнан мэдээлэл бэлтгэн ажилладаг сэтгүүлчидтэй уулзаж ярилцлага хийв. Мөн мэдээллийн анхдагч эх сурвалж болоод байгаа намын бүлгүүдийн албан ёсны юутүб сувгуудын хандалт болон бусад тоон мэдээллийг сүүлийн нэг жилийн хугацаанд тооцоолох юм.

Судлагдсан байдал

Улс төрийн намуудын мэдээлэл түгээх арга барилын тухай олон улсад хийгдсэн зарим судалгаанд намын бүлгүүдийн мэдээлэл түгээх стратеги, олон нийтийн харилцаа, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оролцоо, нийгмийн сүлжээ ашиглах байдал зэргийг судалдаг. Үүний гол зорилго нь улс төрийн намуудыг олон нийтэд ил тод байлгах, үнэн зөв мэдээлэл дамжуулах, нийгэмд нөлөөлөх чадварыг бий болгох явдал юм.

Дэлхийн бусад улс оронд улс төрийн нам, бүлгүүдийн сошиал медиа ашиглах байдлыг судалсан олон жишээ байдаг. АНУ-ын улс төрийн намуудын фэйсбүүк, юутүб зэрэг платформ ашиглалтыг судалсан ажлуудад кампанит ажлын үеэрх видео контентын үр нөлөө, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд хэрхэн нөлөөлсөн талаар дүн шинжилгээ хийсэн байдаг. 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Дональд Трамп болон Жо Байден нарын юутүб ашиглалтыг харьцуулсан судалгаа байна. Энэтхэгийн улс төрийн намуудын цахим платформ ашиглалт дэлхий дахинд онцлог болж байна. Тухайлбал, Моди Ерөнхий сайдын "Digital India" кампанит ажилд юутүб гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ талаар олон судалгаа хийгдсэн. Мөн Английн парламентийн юутүб сувгаа хэрхэн ашиглаж байгаа тухай судалгаа цөөнгүй байна. “Sage Journals” байгууллагаас хийсэн 2018 оны судалгаагаар Английн парламентын юутүб суваг нь олон нийтэд хууль

тогтоох үйл явц болон парламентын хуралдаан, хэлэлцүүлгүүдийг үзэх боломжийг олгодог. Энэ суваг нь ил тод байдлыг дэмжих зорилгоор парламентын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг тавьдаг. Тухайн юутүб суваг нь парламентын хуралдаануудыг шууд дамжуулдаг бөгөөд ингэснээр иргэд бодит цаг хугацаанд хуралдааныг үзэж, хууль тогтоох үйл явцыг дагаж мөрдөх боломжтой. Мөн хуралдаан болон хэлэлцүүлгийн дараа бүрэн бичлэгүүдийг нийтэлдэг тул хүмүүст тухайн хуралдааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломж олгодог. Зарим чухал асуудлуудыг тоймлон хураангуй бичлэгүүдээр үзүүлдэг бөгөөд энэ нь сонгогчдод тухайн асуудлыг хурдан, ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл авах боломжийг өгдөг. Юутүб суваг нь парламентын үйл ажиллагаа, хууль тогтоох үйл явцын талаарх мэдээллийг олон нийтэд хялбархан хүргэх гол үүрэгтэй бөгөөд энэ нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоогчдын үйл ажиллагааг ил тод болгоход чухал ач холбогдолтой. Энэ бүх үйл явдал нь парламентын ажлыг олон нийтэд нээлттэй, ойлгомжтой болгох зорилготой бөгөөд иргэдийн оролцоо, мэдээллийн ил тод байдалд онцгой ач холбогдол өгч байна гэсэн дүгнэлтийг гаргаж байжээ.

Монгол Улсад хийгдсэн судалгааны нэг жишээ бол IRIM судалгааны хүрээлэнгийн 2019 оны "Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс" юм. Энэхүү судалгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлыг үнэлж, тэдгээрийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн. Судалгааны үр дүнд Монгол Улсын төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс 0.612 буюу сул түвшинд байгааг харуулсан байна. Энэ нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.


Судалгааны үр дүн

Судалгааны хүрээнд УИХ-д суудалтай МАН, АН, ХҮН нам, ИЗНН-ын албан ёсны юутүб суваг дахь 2024.01.01-ээс 2024.10.31 хүртэлх хугацаанд нийтлэгдсэн видеонд дараах агуулгаар харьцуулалт хийсэн. Энэ хугацаа нь сонгуулийн өмнөх үе, сонгуулийн үе, сонгуулийн дараах үе гэсэн улс төрийн өндөр идэвхтэй байдлыг харгалзсан болно.

- Контентын хандалт, сошиал медиа судалгааны аргачлалаар видео үзэлтийн тоо, лайк, сэтгэгдэл, хуваалцах зэрэг харилцааны үзүүлэлтүүдийг шинжлэв.
- Бодлого, хууль тогтоомж, намын бүлгийн үйл ажиллагааны агуулгатай холбоотой видеонуудыг ангилсны үндсэн дээр тухайн

видео формат, урт, тайлбар мессежийн тодорхой байдал, дүрслэлийн чанарыг харьцуулав.

- УИХ дахь намын бүлгүүдийн юутүб сувгуудын идэвх, хүртээмжийг хооронд нь харьцуулж, давуу болон сул талуудыг тодорхойлов.
- Дээрх агуулгаар монголын хэвлэл мэдээллийн салбарт улс төрийн чиглэлээр дагнан ажилладаг сэтгүүлчидтэй ганцаарчилсан ярилцлага хийв.

Монгол Ардын нам	Ардчилсан нам	Хүн нам
		
- 266.000 дагагчтай - 13.000 видеотой Намын бүлгийн гишүүдийн: - чуулган болон байнгын хорооны хуралдаанд хэлсэн үг, - асуусан асуултыг дагнан нийтэлдэг. - Мөн бүлгээс зарласан хэвлэлийн хурал, - нэвтрүүлэг зэргийг нийтэлдэг.	- 196.000 дагагчтай - 7.900 видеотой Намын бүлгийн гишүүдийн: - чуулган болон байнгын хорооны хуралдаанд хэлсэн үг, - хуралдаанд оролцож буй дүрс, - хэвлэлийн хурал зэргийг нийтэлдэг.	- 271 дагагчтай - 62 видеотой - Сонгуулийн сурталчилгааны уед нэр дэвшигчдийн танилцуулгыг нийтлэдэг. - Гишүүдийн чуулганд хэлсэн үг болон байнгын хорооны хуралдаанд ямар байр суурьтай оролцож байгаа тухай онцолж нийтэлдэггүй.

Хүснэгт 1. Намын бүлгүүдийн юутүб хуудсын нэр, харагдах байдал

УИХ-д суудалтай улс төрийн 4 намын бүлгийн албан ёсны юутүб хуудасны идэвхтэй байдал, өдөр тутмын мэдээлэл түгээхдээ энэ сувгаа ашигладгийг үндэслэн МАН, АН-ын хувьд мэдээллийг нягталлаа. Ингэхдээ 2024 оны 1-р сараас 2024 оны 10-р сарыг дуустал хугацаанд нийтлэгдсэн

бичлэгүүдийг хамруулав. Энэ цаг хугацаа нь УИХ-ын сонгуулийн өмнөх үе, сонгуулийн үе, сонгуулийн дараах үе гэсэн онцлох хугацааг хамарч байгаа юм.

МАН, АН-ын сошиал хөтлөлтийн тухай судалгааг хийхдээ тухайн сувгийг хариуцан ажиллаж байгаа хүнээс мэдээлэл авах гэж хэд хэдэн удаа холбогдсон ч энэ талын мэдээллийг өгөхөөс татгалзсан. Доорх хүснэгтэд хоёр намын суваг хөтлөлтийн харьцуулсан байдлыг хураангуйлан нэгтгэлээ.

Хүснэгт 2. Намын бүлгийн юутүб хуудсын онцлог

Үзүүлэлт	МАН	АН
Шуурхай дамжуулах байдал	Чуулганы хуралдаан үргэлжилж байх явцад онцлох ярианууудыг 10-20 минутын зайтайгаар тогтмол нийтэлдэг.	Тухайн өдрийн чуулганы хуралдаан дууссаны дараа тасалсан яриаг нийтэлдэг.
Видеонд өгсөн гарчиг ойлгомжтой байдал	Гарчиг өгөхдөө УИХ-ын гишүүний овог, нэр болон ярьсан зүйлээс онцлох агуулга, өгүүлбэрийг ашигладаг.	Ихэнх тохиолдолд зөвхөн байр суурь илэрхийлсэн тухайн УИХ-ын гишүүний нэрээр видеоны гарчигаа өгдөг.
Видео бүрэн агуулгаараа байдаг эсэх	Тухайн видеонд гарах яриа, байр суурийг таслан оруулахдаа асуулт болон хариултыг бүтэн багтаадаг.	Тухайн видеонд гарах яриа, байр суурийг таслан оруулахдаа зөвхөн хариултыг эсвэл зөвхөн асуултыг нь оруулдаг.
Видео тасралтгүй үргэлжилдэг эсэх	Оруулсан видео ямар нэгэн засвартай, сул үг, жижиг хэсгүүдийг тасдсан байдаг.	Оруулсан видео ямар нэгэн засваргүй, шууд бүтнээрээ байдаг.
Дүрсний чанар	480p	1080p

Дээрх хүснэгтээс, МАН-ын бүлгийн юутүб хуудаст нийтлэгдэж буй мэдээллүүд сэтгүүлчдэд хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байгаа нь харагдаж байна. Гэхдээ нөгөө талаар УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдааны үеэр болж буй үйл явдал, мэдээллийг ямар нэгэн хяналт, шүүлтүүргүйгээр иргэдэд шууд дамжуулах нь чухал. Хэдийгээр намын бүлгүүд мэдээллээ ил тод мэдээлж буй мэт боловч тухайн намын болон УИХ-ын гишүүний нэр хүндийг унагасан үг, яриа, хэлэлцүүлгийг иргэдэд хүргэхгүй.

Зураг 1. Видео дээр, УИХ-ын гишүүний үйлдэл



Дээрх зурагт, орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хуралдааны үеэр УИХ-ын гишүүн П.Батчимэгийг үг хэлэх үед УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан инээж байгаа дүрс харагдаж байна. Энэ видеог АН-ын бүлгийн сошиал сувгуудаар нийтэлсний дараагаар “Ардчилсан намын дотоод хагарал дуусаагүй” гэх гарчиг агуулгатай нийтлэлүүд гарах болсон. Тус намын хувьд намын дотоод асуудлаа цэгцэлсэн, шинэ парламентад хүчтэй сөрөг хүчин байна гэсэн имижийг бүрдүүлэхийг хичээсэн ч энэ мэт хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өөрсдөд нь халтай бичлэгийг хянахгүй оруулсан нь харагдаж байна. Гэхдээ энэ бичлэг бол үнэн бодит байдал юм. Харин МАН-ын хувьд бичлэг бүрийн яриаг ажиглахад сул үг болон бусад хэсгийг таслаж оруулсан нь видеоны дүрс дундаа үсрэлттэй байгаагаас харж болох юм. Энэ хоёр жишээнээс харахад угтаа бол мэдээллээ нээлттэй ил тод байлгахаар энэхүү сувгийг өдөр тутмын мэдээллээ түгээхдээ ашиглаж байгаа гэж тайлбарлаж байгаа ч энэ нь мэдээллийн агуулгыг хэд дахин шүүж, өөрсдийнхөө үзүүлэхийг хүссэн зүйлээ үзүүлж, олон нийт мэдэх ёстой ч мэдүүлэхгүй байх нь намын бүлэгт ашигтай байх мэдээллийг сувагтаа оруулж байгаа нь ажиглагдаж байна.

Дараах хэсэгт, хэвлэл мэдээллийн салбарт хоёроос дээш жил улс төрийн мэдээлэл дагнан бэлтгэдэг сэтгүүлчидтэй ганцаарчилсан ярилцага хийн, УИХ-д суудалтай намын бүлгүүдийн мэдээллээ түгээж буй байдал, тухайн мэдээллийн ач холбогдлын талаар харьцуулалт хийсэн болно.

- ***Цаг хугацааны хувьд**:* УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдааны сигналыг аваад бүтэн бичлэгийг нь рекорд хийгээд авчихдаг ч гэсэн дараа эвлүүлгийн программд оруулаад хэдэн цагийн видеог татна,

таслана зэргээр их ажиллагаатай байдаг. Тийм учраас намын бүлгүүдийн юүтүб хуудаснаас дүрс авч ашиглах хялбар байдаг байна. Мөн хуралдааны дүрс, үйл явдлын дэлгэрэнгүй яриа, байр суурийг өөрийн биеэр очиж авах нь их хугацаа шаарддаг тул мэдээллийг намын бүлгийн хуудсаас авч цаг хэмнэдэг.

- ***Мэдээлэл бэлтгэх хүний нөөцийн хувьд***: Монголд үйл ажиллагаа явуулж буй бүх хэвлэл мэдээллийн хэрэгслүүд УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдаанд сэтгүүлч болон зураглаачаа бүтэн ажиллуулах боломж хомс. Иймээс хүний нөөцийн хувьд боломжгүй, үйл ажиллагаа нь жигдрээгүй, эсвэл орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагууд юутүб сувгаас мэдээллийг авах нь хялбар, хүртээмжтэй.
- ***Мэдээлэл авах нээлттэй эсэх***: Ковид-19 цар тахлын үеэр төрийн ордонд ажиллаж байгаа сэтгүүлчдэд тодорхой хэмжээний хязгаарлалт тогтоосон. Гэхдээ одоо болтол шалтгаангүйгээр сэтгүүлчдийг УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдаанд оролцуулахгүй, эсвэл камер оруулахгүй гэдэг болсон. Зарим хуралдаанд зөвхөн сэтгүүлч нь ороод асуултаа асуу, харин зураглаачийг оруулахгүй гэх мэтээр хязгаарлаж байгаа.
- ***Мэдээллийг шууд авахад намын бүлгээс хандаж буй байдал***: УИХ-ын чуулганы болон байнгын хорооны зарим хурал, чуулганыг сурвалжилж асуулт асууж, дотор уур амьсгалын дүрсийг авах гэхэд юутүб хуудас дээр мэдээлэл бичлэг оруулчих болохоор тэндээс аваарай гээд мэдээлэл бэлтгэхийг зөвшөөрдөггүй.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар УИХ дахь намын бүлгүүдийн юутүб сувгаар түгээгдэж буй мэдээллийн агуулга, бүтэц, редакцийн шинж чанарыг шинжилж, уг мэдээлэл сэтгүүлчдээр дамжин олон нийтэд хүрэх үйл явцыг хоёр шатлалын мэдээллийн урсгалын онолын хүрээнд тайлбарлахыг зорьсон болно. Судалгааны үр дүнгээс харахад парламентын орчинд мэдээлэл түгэх механизм институцийн түвшинд шинэ бүтцийг бүрэлдүүлж байна. Намын бүлгүүдийн юутүб сувгаар нийтлэгдэж буй контент нь анхдагч эх сурвалж болж байгаа боловч бодит байдалд уг мэдээлэл олон нийтэд шууд бус, сэтгүүлчдийн зуучлалаар дамжин хүрч байна. Энэ нь П.Лазарсфельд болон П.Катз нарын тодорхойлсон хоёр шатлалын мэдээллийн урсгалын загварт нийцэж байгаа бөгөөд сэтгүүлчид орчин үеийн “үзэл бодлын манлайлагч”-ийн үүргийг гүйцэтгэж байгааг харуулж байна.

Контентын шинжилгээнээс харахад намын бүлгүүд мэдээллийг ил тод байлгах зорилгоор видео хэлбэрээр түгээж байгаа боловч редакцийн тодорхой шүүлтүүр, сонгон үзүүлэх байдлаар ажиллаж байна. Зарим тохиолдолд ярианы хэсгийг таслах, гарчгийг тодорхой фреймээр өгөх, агуулгын бүтэн байдлыг өөрчлөх зэрэг редакцийн шийдвэрүүд ажиглагдсан нь мэдээллийн анхдагч шатанд аль хэдийн тодорхой фрейминг явагдаж байгааг илтгэнэ. Иймм нөхцөлд сэтгүүлчид уг мэдээллийг дахин боловсруулж олон нийтэд хүргэхдээ хоёр дахь шатны фреймингийг үүсгэж байгаа нь мэдээллийн давхар шүүлтүүрийн орчин бүрэлдэж байгааг харуулж байна.

Ярилцлагын үр дүнгээс харахад цаг хугацаа, хүний нөөцийн хязгаарлалт, институцийн хандалтын асуудлууд нь сэтгүүлчдийг намын бүлгүүдийн юутүб сувгийг идэвхтэй ашиглахад хүргэж байгаа бөгөөд энэ нь хоёр шатлалын механизмыг улам бэхжүүлж байна. Иймд парламентын мэдээллийн хүртээмж нь формаль байдлаар нээлттэй боловч бодит байдалд намын редакцийн бодлогоор тодорхой хэмжээгээр зохицуулагдаж буй байдал ажиглагдаж байна.

Онолын хувь нэмрийн хувьд энэхүү судалгаа нь хоёр шатлалын мэдээллийн урсгалын онолыг Монголын парламентын институцийн орчинд туршин баталгаажуулсан бөгөөд сошиал медиа орчинд институцийн мэдээлэл хэрхэн зуучлагдан дамжиж буйг эмпирик түвшинд харуулснаараа шинэлэг ач холбогдолтой юм. Улс төрийн намуудын сошиал медиа ашиглалт нь зөвхөн шууд коммуникаци бус, харин зуучлагчийн үүргийг дахин бүтэцжүүлж буй институцийн процесс болох нь харагдаж байна.

Практик ач холбогдлын хувьд парламент дахь намын бүлгийн үйл ажиллагааны ил тод байдлыг зөвхөн мэдээлэл нийтэлсэн тоо, давтамжаар хэмжих бус, харин мэдээллийн бүрэн бүтэн байдал, редакцийн ил тод байдал, анхдагч эх сурвалжийн шууд хүртээмжээр үнэлэх шаардлагатайг энэхүү судалгаа харуулж байна. Хэрэв парламентын институци мэдээллийг шууд, бүтэн хэлбэрээр хүртээмжтэй байлгах бодлого хэрэгжүүлэхгүй бол хоёр шатлалын механизм нь намын стратегийн коммуникацид давуу тал олгож, олон нийтийн ойлголтод нөлөөлөх эрсдэлтэй байна. Цаашид энэхүү судалгааг сошиал медиа алгоритмын нөлөө, контентын үзэлт, хэрэглэгчдийн хүлээн авах байдлыг хамтатган судалснаар парламентын коммуникацийн ил тод байдлын асуудлыг илүү өргөн хүрээнд тайлбарлах боломжтой болно.

НОМ ЗҮЙ

Батболд, Ц. (2018). *Улс төрийн социологийн онолын үндэс*. Улаанбаатар.

МУИС. (2021). *Улс төрийн мэдээлэл харилцаа: Гарын авлага* (Ред. Ж. Төртогтох). Улаанбаатар.

IRIM судалгааны хүрээлэн. (2019). *Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс*. Улаанбаатар.

Улс төрийн намуудын төлөвшил, өнөөгийн нөхцөл байдлын судалгааны тайлан. (2019). Улаанбаатар.

Chadwick, A. (2017). *The hybrid media system: Politics and power* (2nd ed.). Oxford University Press.

Gonçalves, G. (2018). *Political communication*. In Oxford Research Encyclopedia of Communication. Oxford University Press.

Katz, E. (1957). The two-step flow of communication: An up-to-date report on an hypothesis. *Public Opinion Quarterly, 21*(1), 61-78. https://doi.org/10.1086/266687

Lazarsfeld, P. F., Berelson, B., & Gaudet, H. (1944). *The people's choice: How the voter makes up his mind in a presidential campaign*. Duell, Sloan & Pearce.

Weimann, G. (1982). On the importance of marginality: One more step into the two-step flow of communication. *American Sociological Review, 47*(6), 764-773.

Ардчилсан намын бүлэг. (2024). *YouTube сувag*. https://www.youtube.com/@anbuleg3257

Иргэний зориг ногоон нам. (2024). *YouTube сувag*. https://www.youtube.com/@ИЗННПАРЛАМЕНТ

Монгол Ардын намын бүлэг. (2024). *YouTube сувag*. https://www.youtube.com/@МАНБүлэгАжлыналба

ХҮН нам. (2024). *YouTube сувag*. https://www.youtube.com/@hunnam_mn

AN ANALYSIS OF THE DISSEMINATION OF WORKING GROUP INFORMATION VIA YOUTUBE BY PARLIAMENTARY PARTY GROUPS IN THE STATE GREAT KHURAL

Abstract: With the rapid development of digital communication technologies, political institutions have increasingly adopted new channels to communicate with the public. Video-based platforms, particularly YouTube, have become important tools for directly disseminating political information and expanding citizens' access to parliamentary activities.

This study examines the content, accessibility, and editorial characteristics of information disseminated through the official YouTube channels of party groups in the State Great Khural of Mongolia. It further analyzes how such information reaches the public through journalists, drawing on the Two-Step Flow Theory of communication.

The research employs a mixed-methods approach combining content analysis, observation, and in-depth interviews. The findings indicate that although party groups utilize YouTube as a mechanism to promote transparency and public access to parliamentary proceedings, editorial filtering and selective presentation are evident in the published content. The study demonstrates that parliamentary information is often mediated by journalists who function as contemporary opinion leaders, thereby reinforcing a two-step flow of communication in Mongolia's parliamentary context.

Key words: Political communication; parliamentary party groups; YouTube; transparency; media mediation; Two-Step Flow Theory

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 30-54 дахь тал

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Насанбат
МУИС, УТСОУХНУС
Улс төр судлалын тэнхимийн докторант

С.Мөнхбат
МУИС, УТСОУХНУС-ийн захирал,профессор

Хураангуй:

Ардчилсан тогтолцоонд улс төрийн нам нь нийгэм ба төрийг холбох үндсэн институц бөгөөд намын хүний нөөцийн бодлого нь ардчиллын чанарыг тодорхойлох чухал үзүүлэлт болдог. Гэвч Монгол улсад улс төрийн намын хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, томилгоо хийх, нэр дэвшүүлэх үйл явцад системтэй анхаарал хандуулж ирээгүй нь мэргэшил, туршлага, ур чадварын хувьд дутагдалтай хүмүүс төрийн удирдах албанд томилогдох, намын төлөөллийн чанар сулрах, дотоод ардчилал алдагдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Энэхүү судалгааны зорилго нь Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлогыг тайлбарлах онолын үндэслэлийг тодорхойлох, хүний нөөцийн бодлогод шууд холбогдох субъектүүдийн үүрэг, харилцааг шинжлэх, намын хүний нөөцийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхэд оршино. Судалгаанд хоёрдогч эх сурвалжид тулгуурласан институцийн болон харьцуулсан шинжилгээ, холбогдох хууль тогтоомж, улс төрийн намуудын дүрэмд баримт бичгийн шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүнгээс харахад Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлогыг тайлбарлахад нэг онол дангаараа хангалтгүй бөгөөд элитийн болон неоинституционал онолыг хослуулан ашиглах нь илүү оновчтой байв. Элитийн онол нь намын удирдлагын төвлөрөл, фракцын нөлөө, танил талд суурилсан томилгоо давамгайлах шалтгааныг тайлбарлах боломж олгож байгаа бол институциональ онол нь хүний нөөцийн бодлогод нөлөөлж буй албан ба албан бус зохицуулалт, дотоод соёл, уламжлал болон институцийн сул талыг тодорхойлох боломжийг бүрдүүлж байна.

Түлхүүр үгс: дотоод ардчилал, гишүүд, удирдлага, нэр дэвшигчид, улс төрийн ажилтнууд, дэмжигчид, дэргэдэх байгууллагууд, элитийн онол, институциональ онол

Оршил: Улс төрийн намууд нь нийгмийн олон бүлгийн эрх ашгийг төлөөлж, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад оролцдог үндсэн институцийн хувьд ардчилсан тогтолцооны тулгуур багана болдог. Иймд улс төрийн намын хүний нөөцийн асуудал нь зөвхөн намын дотоод бүтэц, зохион байгуулалтын хүрээнд хязгаарлагдах бус, улс орны засаглалын чанар, ардчиллын тогтвортой байдалд шууд нөлөөлөх стратегийн ач холбогдолтой асуудал юм. Судлаач Л.Даймонд улс төрийн намын хүний нөөцийн бодлогыг ардчиллын чанарыг тодорхойлох чухал хэмжүүрүүдийн нэг хэмээн тодорхойлсон нь (Diamond, 2019) уг асуудлын онол, практикийн ач холбогдлыг илэрхийлж байна.

Улс төрийн намын хүний нөөц хэмээх ойлголт нь намын зорилго, үзэл баримтлал, бодлого, манлайлал, төлөөллийг хэрэгжүүлэхэд оролцож буй гишүүд, лидерүүд, томилогдсон албан тушаалтнууд, намын ажилтнууд болон тэдгээрийн дэмжигчдийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм.

Монгол Улсын улс төрийн тогтолцооны хөгжлийн явцад намын хүний нөөцийн бодлого нь өөр өөр онцлогтойгоор төлөвшиж ирсэн. Нэг намын тогтолцооны үед МАХН-ын боловсон хүчний бодлого нь төрийн хүний нөөцийн бодлоготой шууд уялдаж, ёс суртахуун, ажил хэрэгч чанарт суурилсан сонгон шалгаруулалт хийгддэг байсан (УА, 2021, х.18). Харин 1990 оноос хойш олон намын тогтолцоо бүрэлдэн тогтсоноор улс төрийн намуудад хүний нөөцөө бэхжүүлэх, засаглалын харилцаанд байр сууриа тогтоох, улс төрийн үйл ажиллагааны соёл, мэргэжлийн ур чадварыг төлөвшүүлэх, олон нийтийн итгэл, дэмжлэгийг хүлээх зэрэг шинэ бөгөөд илүү төвөгтэй сорилтууд тулгарсан байна (Болд-Эрдэнэ. Д, 2020).

Өнөө цагт улс төрийн намууд нь төлөөллийн байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж буй боловч (Чулуунбаатар. Г, Батсүх. Ш нар, 2021, х.214), намын хүний нөөцийн бодлоготой холбоотой анхаарал татсан, шийдэл шаарсан олон асуудал байсаар байна. Тухайлбал, улс төрийн болон төрийн захиргааны хүний нөөцийг системтэйгээр бэлтгэх ажил сул, харин албан тушаал, эрх мэдэл, эдийн засгийн ашиг сонирхолд тулгуурласан томилгоо давамгайлах хандлага ажиглагдсаар байна (Чулуунбаатар. Г, Батсүх. Ш нар, 2021,х.109). Үүний зэрэгцээ улс төрийн намууд мэргэшсэн улс төрч, хүний нөөцийг төлөвшүүлэх, нийгмийг төртэй холбох институцийн үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн оронд клиентелист

шинжтэй ардчиллын хэлбэрт хэвийх хандлага нэмэгдэж байгааг судлаачид онцолж байна (Төртогтох. Ж, 2019, х.31).

Мөн Монголын улс төрийн намуудын хүний нөөцийн чадавх сул байгаа нь популист улс төрчид олноороо тодрон гарах, улмаар тэд нийгмийн дунд "төрийг удирдах хошуучлагчид" мэтээр хүлээн зөвшөөрөгдөх хандлагыг нэмэгдүүлж байна. Энэ байдал нь цаашид сонгуулийн мөчлөг бүрд популизм хүчээ авах, ардчилал, төрийн удирдлага, засаглалын тогтолцоо доройтох нөхцөл бүрдэх эрсдэлийг үгүйсгэхгүй (Төртогтох. Ж, 2019, х.33).

Эмпирик судалгааны дүнгүүд ч дээрх дүгнэлтийг бататгаж байна. Тухайлбал, Монголын улс төрийн намуудын 70 хувь нь намын гишүүдэд зориулсан тогтмол сургалтын хөтөлбөргүй байгаа (UNDP Mongolia, 2020) бол иргэдийн 68 хувь нь улс төрийн албан тушаалд томилогдоход боловсрол, туршлагаас илүү танил тал, хамаарал чухал нөлөөтэй гэж үзсэн байна (Сант Марал, 2021). Түүнчлэн судалгаанд оролцсон намын гишүүдийн 71 хувь нь намын дотоод албан тушаалд хэн томилогдох нь тодорхой бус хэмээн хариулсан (Open Society Forum, 2022) бөгөөд улс төрийн нөлөөгөөр томилогдсон боловсон хүчний 32 хувь нь тодорхой мэргэжлийн шаардлага хангаагүй байсан нь тогтоогдсон байна (Төрийн албаны зөвлөл, 2022). Үүнээс гадна намаас томилогдсон албан тушаалтнуудад ёс зүйн хариуцлага тооцох зохицуулалт сул хэвээр байгаа нь бодлогын ноцтой цоорхойг илтгэнэ.

Иймд намын хүний нөөц болон санхүүгийн ил тод байдал, албан тушаалд дэвшүүлэх журмын шударга, нээлттэй байдал нь намын дотоод ардчиллыг бэхжүүлэх үндсэн шалгуурын нэг болохын хувьд эдгээрийг шударга ёсны зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна (Чулуунбаатар. Г, Батсүх. Ш нар, 2021, х.112).

Дээр дурдсан онолын дүгнэлт, бодит судалгааны үр дүнгүүд нь Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлогын асуудлыг онолын үүднээс нарийвчлан судлах бодит хэрэгцээ, шаардлага байгааг нотолж байна.

Арга зүй: Чанарын судалгааны арга зүйд тулгуурлан улс төрийн хүний нөөцийн бодлогыг асуудлаар судлаачдын нэг сэдэвт бүтээл, илтгэл, өгүүлэл, судалгааны тайлан зэрэг хоёрдогч эх сурвалжуудад институцийн болон харьцуулсан шинжилгээ хийв. Институцийн шинжилгээг хийхдээ институциональ болон неоинституционал арга зүйг баримталж, улс төрийн намын хүний нөөцийн бодлого дахь албан ба албан бус ёсны зохицуулалтын нөлөөг тодорхойлон тайлбарлав. Неоинституционал онолын хувьд улс төрийн нам нь улс төрийн тогтолцоо, төрийн үйл ажиллагаанд оролцогч идэвхтэй субъект, төрийн бодлогод голлох нөлөөтэй институц (Болд-Эрдэнэ. Д, 2016. хуудас 12) мөн. Институционалист онол нь улс төрийн намыг "үндсэн хууль,

парламент, төрийн байгууллагын бүтцийн хувьд авч үздэг" бол неоинституционализм нь нам хэмээх институц хэрхэн ажилладаг болохыг "албан ба албан бус зохицуулалт, дотоод соёл, уламжлал, институцийн дарамт" зэрэг ойлголтуудаар дамжуулан тайлбарладгаараа онцлог юм. Харин харьцуулсан шинжилгээний аргыг ашиглан улс төрийн намын хүний нөөцийн бодлогын субъектүүд, тэдгээрийн үүргийг Монгол болон бусад улс орны туршлагад тулгуурлан авч үзэв. Түүнчлэн улс төрийн намын талаарх бодлогын баримт бичиг, намын дүрэм, журмуудад баримт бичгийн шинжилгээ хийж судалгааны ажлын практик ач холбогдлыг нэмэгдүүлсэн болно.

Үндсэн хэсэг: Энэхүү судалгааны ажилд нам судлалын неоинституционал онолын үндэслэлд тулгуурлан Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлоготой холбоотой зарим асуудлыг тайлбарлах зорилго тавив. Энэ хүрээнд судалгааг дараах үндсэн асуултын дарааллаар авч үзсэн болно. Үүнд:

1. Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлогын асуудлыг тайлбарлахад аль онол илүү тохиромжтой вэ?
2. Монголын улс төрийн намын хүний нөөцийн гол субъектүүд, тэдгээрийн үүрэг, харилцан хамаарал юу вэ?
3. Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлогын эрх зүйн үндсэн зохицуулалт нь юу вэ? гэсэн дарааллаар авч үзэв.

Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлогын асуудлыг тайлбарлах тохиромжтой онол юу вэ?: Намын хүний нөөцийн бодлогыг тайлбарлахад элит, институциональ, патронажийн онолын үндэслэлүүд илүү тохиромжтой байна. Элитийн онолын хувьд намаас нэр дэвших, томилогдох үйл явц, намын дотоод шийдвэр гаргалтад удирдлага, фракцуудын нөлөөнөөс хамаардаг тул намын хүний нөөцийн бодлого нь цөөн хэдэн элитүүдийн сонирхолд үндэслэгддэг. Харин институциональ онолоор бол хууль, дүрэм журам дахь нэр дэвшилт, томилгоо, дотоод ардчиллын үйл явц, ёс зүйн хяналтын талаарх зохицуулалтууд нь хүний нөөцийн бодлогыг тодорхойлж байдаг. Институциональ онолын хувьд хүний нөөцийн бодлого ямар байх нь намын дотоод дүрэм, журмын зохицуулалтаас шууд хамаардаг. Эдгээр онолуудын гол ялгааг товч илэрхийлвэл:

Хүснэгт №1 Элитийн болон институциональ онолын гол ялгаа

Элитийн онол:	Институциональ онол:
Улс төрийн намын хүний нөөцийн	Улс төрийн намын хүний нөөцийн бодлого

бодлогод хэн нөлөө үзүүлдэг вэ? гэдгийг тайлбарладаг. Намын лидерийн эрх мэдэл хэрхэн төвлөрдөг, фракцын нөлөө шийдвэр гаргалтыг хэрхэн хаалттай болгодог, мерит зарчим бус танил тал, итгэлцэлд суурилсан бодлого хэрэгждэгийн шалтгааныг тайлбарладаг.	хэр оновчтой вэ? гэдэг асуултад төвлөрнө. Энэ нь тухайн намын дотоодод хэрэгждэг дүрэм, журамд намын хүний нөөцийн бодлогын ил тод байдал, хариуцлагын механизмыг хэр зэрэг нарийвчлан зохицуулсан бэ? гэдгээс шалтгаална.

Эх сурвалж: Katz, R. S., & Mair, P. (1995). "Changing Models of Party Organization and Party Democracy." Party Politics.

Элитийн онолын хувьд удирдлагын бүлэг, фракцын нөлөө нь шийдвэр гаргах эрх мэдлийн төвлөрлийг хэрхэн бий болгодог талаар, неоинституционал онолын логикоор дүрэм, журамд нэн тэргүүнд тусгах агуулга болон дүрэм, журмаас ангид байдлаар хүний нөөцийн бодлогод нөлөөлдөг хүчин зүйл юу байдаг вэ? гэдгийг товч тайлбарлая.

Хүснэгт №2 Улс төрийн намын үндсэн асуудлуудад холбогдох онолын тайлбарууд

№	Онол	Асуудал	Тайлбар
1	Элит онол	Намд яагаад удирдлагын төвлөрөл бий болдог вэ?	Нийгмийн аль ч байгууллагад цөөнхийн удирдлага давамгайлж энгийн олонх тэднийг дагана. Үүний нэгэн адил намд элит бүлгийн манлайлал дор бусад энгийн гишүүд зохион байгуулагддаг. Удирдлагын зүгээс босоо бүтцээр шийдвэр гаргахын тулд төвлөрлийг бий болгодог. Боловсрол өндөртэй, илтгэх чадвар сайтай хүмүүс нь танил тал, гэр бүл, холбоо хамаарлаараа нэгдэж эрх ашгаа хамгаалдаг. Улс төрийн намын удирдлагууд нь ямагт эдийн засаг, цэргийн элитүүдтэй холбогдсон байдаг. Ингэснээр тэд аливаа бодлогоо өөрсдийн ашиг сонирхолд тулгуурлан дээрх холбоо сүлбээгээрээ дэмжүүлж, хамгаалуулж байдаг. Судлаачдын үзэж буйгаар намын удирдлагын эрх мэдлийн төвлөрөл хүний нөөцийн бодлогод шууд нөлөөлдөг. Төвлөрөл их байх тусам хаалттай,

			мерит зарчим сул, ил тод бус хүний нөөцийн бодлого хэрэгждэг.
		Шинэ удирдлага гэж хэн бэ?	Удирдлага өөрийн эрх мэдлээ хадгалах зорилгоор өөрийн залгамжлагчдыг бэлтгэнэ. Улс төрийн намд элитүүд солигдож буй мэт харагдах боловч өмнөх удирдлагын төвлөрөл ямар нэг хэмжээгээр хадгалагдан үлддэг. Энэ утгаар улс төрд хэзээ ч “шинэ хүн” төрдөггүй бөгөөд зөвхөн хуучин элитийн нуугдмал дүр л байдаг. Элит шинэчлэгдэх биш харин нуугдмал дүрээр дахин төрж байдаг.
2	Институционал онол	Намын хүний нөөцийн асуудлыг хэрхэн оновчтой зохицуулах вэ?	Институциональ онолын хувьд намын хүний нөөцийн бодлого нь намын удирдлагын үнэлэмжийн асуудал бус харин албан ба албан бус дүрэм, хэм хэмжээ, соёлын илрэл юм. Тиймээс нэгдүгээрт, Улс төрийн намын хүний нөөцийн тогтолцоог бүрдүүлдэг хууль, дүрэм, журамд уг асуудлыг оновчтой тусгах ёстой. Үүнд: ● Үндсэн хууль дахь намын зохицуулалт ● Тусгайлсан хууль дахь намын зохицуулалт ● Сонгуулийн хууль дахь намын зохицуулалт ● Намын дүрэм, журмын зохицуулалтууд зэрэг нь хоорондоо болон дотооддоо зөрчилгүй байх ёстой. Намын дотоод дүрэм, журамд тусгайлан хэн гишүүн болох, хэн нэр дэвших, хэн удирдах албан тушаалд томилогдох, хэн хэнийг сургах, хэн төлөөлөх эрхтэй байх вэ? зэргийг зохицуулна. Харин намын бүтэц, үйл ажиллагаа, жендерийн квот, санхүүгийн ил тод байдал, хүний эрх, сонгуулийн үеийн үүрэг зэргийг тусгайлсан хуулиар зохицуулна. Хэрэв ийм зохицуулалт хангалтгүй, институц сул

			байх тусам патронаж давамгайлдаг болохыг судлаачид дурддаг.
		Намын дотоодод уламжлагдан ирсэн албан бус үнэт зүйл нь хүний нөөцийн бодлогод нөлөөлдөг үү?	Аль нэг хүйсийн төлөөлөлд илүү их итгэл хүлээлгэх, насны ялгааг туршлага, чадвартай дүйцүүлэх, танил талдаа давуу байдал үүсгэх, тэдний алдаа дутагдлыг хаацайлах, ахмад гишүүдийн нөлөө их байх зэргээр уламжлагдсан үнэт зүйл нь намын хүний нөөцийн бодлогод нөлөө үзүүлэх боломжтой. Мөн түүнчлэн фракцын нөлөө /нэг эрх ашигтай бүлгүүд, нэг сургууль төгсөгчдийн бүлэг, нэг нутаг усны бүлэг гэх мэт/ намын бодлого, шийдвэрт туссанаар хүний нөөцийн бодлого ч тэдний эрх ашгийн нэг хэрэгсэл болдог. Энэ мэт албан бус үнэт зүйлийн нөлөө нь нам доторх карьер өсөх замыг тодорхойгүй болгох, аль нэг фракцад багтахаас өөр аргагүй байдалд оруулах, уламжлагдсан үнэт зүйлтэй эвлэрэх зэргээр институцийн дотоод соёл болтлоо бэхэждэг.
		Намын хүний нөөцийн бодлогод нөлөөлдөг гадаад хүчин зүйл юу вэ?	Гурван төрлийн нөлөөлөгч /дарамт/ байна. Үүнд: ● Тухайн намын үйл ажиллагаанд нөлөөлж буй хуулийн шинэчлэл, аудитын тайлан, ИНБ-ын хяналтын үйл ажиллагаа ● Нийгмийн зүгээс тавьж буй хүлээлт, жендерийн эрх тэгш байдлыг хангах шахалтууд, ёс зүйн шаардлагууд ● Амжилттай намуудын туршлага, загвар, олон улсын практик зэрэг нь тухайн намд үзүүлж буй хүчин зүйл /дарамт/ юм.
		Улс төрийн томилгоо хэрхэн хийгддэг вэ?	Хэрэв институтийн хөгжил хангалтгүй бол патронажийн зарчим хэрэгжинэ. Намын томилгоо нь удирдлагууд өөртөө үнэнч хүмүүст олгож буй боломж байдлаар хийгддэг. Ялангуяа сонгуулийн үед өөрийнх нь төлөө

			ажилласан, цаашид ч үнэнч байхаа илэрхийлсэн ойрын хүнээ боломжит албан тушаалд байршуулдаг. Энэхүү боломж нь тухайн томилгоог хүртэж буй хүний хувьд үнэнчээр тогтвортой ажилласан, сонгуулийн үеийн хөдөлмөрөө үнэлүүлсэн явдал бол томилгоо хийгчийн хувьд өөрийн эрх мэдлээ баталгаажуулах, хянах арга хэрэгсэл нь юм. Энэ хандлага нь намын дотоодод шударгаар карьер өсөх боломжийг алдагдуулдаг.
		Намын томилгоонд мерит зарчим яагаад хэрэгждэггүй вэ?	Намын удирдлага нь томилгоо хийхдээ өөрт нь үнэнч байхад тулгуурлах бөгөөд мөн цаашид харилцан ашигтай байхыг чухалчилдаг. Ингэснээр өөрт нь үнэнч байсан, цаашид ч үнэнч байх боломжтой гэж үзсэн өөрийн хүнээ томилж уг хүнээрээ дамжуулан эрх ашгаа хамгаалж байдаг. Мерит зарчмыг бус үнэнч байдлыг чухалчлах энэхүү хандлага нь чадварлаг хүн намд тогтохгүй байх үр дагаврыг төрүүлдэг.

Эх сурвалж:Michels, R. (1911). Political Parties: A Sociological Study of the Oligarchical Tendencies of Modern Democracy, North, D. C. (1990). Institutions, Institutional Change and Economic Performance.

Онолын дээрх тайлбаруудаас гадна намын хүний нөөцийн бодлогын макро хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:

- Эрх зүйн зохицуулалтаас үүдэлтэй асуудал: Монгол улсын улс төрийн тогтолцоонд парламентад суудалтай улс төрийн намуудад төрөөс санхүүжилт олгодог зохицуулалт үйлчилдэг (*Улс төрийн намын тухай хууль*, 2023, 26.1.1). Сонгуулийн үр дүнгээр хамгийн олон суудал авсан нам хамгийн өндөр хэмжээний санхүүжилт авах эрх үүсдэг. Үүний үр дүнд тухайн нам нь бусад намуудаас харьцангуй давуугаар боловсон хүчнээ сургах, чадваржуулах, мөн судалгаанд суурилсан бодлого боловсруулах, урт хугацааны төлөвлөлт хийх боломж нь илүү өргөждөг.
- Сонгуулийн цикл: Манай улсын хувьд УИХ-ын болон орон нутгийн сонгууль 4, ерөнхийлөгчийн сонгууль 6 жил тутамд зохион байгуулагдах эрх зүйн зохицуулалттай (Монгол улсын

үндсэн хууль 30.2). Сонгуулийн мөчлөг бүрийн үр дүн нь тухайн намын хүний нөөцийн хөгжилд шууд нөлөө үзүүлдэг. Удаа дараалан ялалт байгуулах, парламент дахь төлөөллөө хадгалж чадсан намын хувьд хүний нөөцөө тогтвортой хөгжүүлэх боломж нэмэгддэг. Харин сонгуулиар ялалт байгуулж чадахгүй байх, парламентад төлөөллөө удаа дараа бүрдүүлж чадахгүй байх зэрэг нь намын хүний нөөцийн тогтворгүй, чадамжгүй байдлыг үүсгэх талтай.

- Улс төрийн соёлын гажуудал: Манай улсын хувьд улс төрийн хүрээнд хийгддэг томилгоо нь мэргэшил, туршлагаас илүү "үнэнч байдал"-д суурилсан байх хандлагатай. Энэ үнэнч байдлыг баталгаажуулах хүрээлэл нь ихэвчлэн ах дүү, төрөл садан, нутаг ус, танил тал дээр тулгуурладаг. Ийм тогтолцоо нь мэргэжил, чадварын шаардлага хангаагүй хүмүүс албан тушаалд томилогдох нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн нам болон төрийн хүний нөөцөд багтаж буй мэргэшил, туршлагын шаардлага хангасан иргэдэд боломж олдохгүй байх, шударга бус байдлыг бий болгох зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулдаг.

Монголын улс төрийн намын хүний нөөцийн гол субъектүүд, тэдгээрийн үүрэг юу вэ?: Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд оролцдог субъектүүдийн үүрэг, харилцан хамаарлыг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

Монгол улсын Сонгуулийн тухай хууль (2019) болон Улс төрийн намын тухай хууль (2023)-д зааснаар намын хүний нөөцөд хамаарах гол субъектүүд нь намын удирдлага, гишүүд, нэр дэвшигчид, менежерүүд, дэмжигчид мөн.

Хүснэгт №3. Улс төрийн намын хүний нөөцийн бүрэлдэхүүн

Хүний нөөц	**Субъектүүд**	**Тайлбар**	**Зохицуулдаг эрх зүйн акт**
Гишүүд	Энгийн, Идэвхтэн, Фракц	Албан ёсны намын батлахтай иргэд	Намын дүрэм
Удирдлага	Дарга, Дэд дарга, ЕНБД, УЗ	Шийдвэр гаргах эрх мэдэл бүхий бодлого тодорхойлогч гишүүд	Намын дүрэм

Нэр дэвшигчид болон сонгогдсон төлөөлөгчид	УИХ, ИТХ, ЗГ-ын гишүүд, ИТХ-ын дарга, Засаг дарга	Намын нэрийн өмнөөс шат шатны сонгуульд оролцож буй, төрийн тодорхой албан тушаал хашиж буй гишүүд	Намын дүрэм, журам
Намын ажилтнууд	Намын төв болон салбар бүтцийн ажилтнууд	Намын бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн төлөө цалин авч ажиллаж буй гишүүд	Журам
Намын дэргэдэх байгууллагу удын гишүүд	Оюутан, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын холбоо, судалгааны хүрээлэн, сайн дурынхан г.м	Намын бодлого үйл ажиллагаанд бүлгийн төлөөллийн тэнцвэртэй оролцоог хангах, дараагийн лидерүүдийг бэлтгэх, зорилгоор ажиллаж буй бүлэг гишүүд	Намын дүрэм, журам
Албан бус боловсон хүчин	Зөвлөхүүд, дэмжигчид	Намын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн оролцдог намын гишүүн биш иргэд	Намын дүрэм

Эх сурвалж: Докторантын боловсруулалт



2.а Дараах дүрслэл нь намын хүний нөөцийн дотоод байр суурь, статусыг заагаагүй зөвхөн намын хүний нөөцийн бүрэлдэхүүн хоорондын эзлэх жинг илэрхийлэв. Үүнээс харахад жирийн гишүүд хүний нөөцийн дийлэнх хэсгийг бүрдүүлж буй тул тэдэнд зориулсан бодлого, үйл ажиллагаанд онцгой анхаарах хэрэгтэй гэсэн үг. Жирийн гишүүд нь намын хүний нөөцийн гол бүрэлдэхүүн бөгөөд намын гишүүний татвар, хураамж төлөх, хандив өргөх, намын нэрийн өмнөөс бүх шатны сонгуульд нэр дэвшигч нарын төлөө саналаа өгөх, сонгуулийн үеэр өөрийн итгэл үнэмшлээрээ намын үйл ажиллагаанд идэвхийлэн оролцох зэрэг олон талын эерэг нөлөөтэй. Тиймээс тэдгээр гишүүдийнхээ итгэл үнэмшлийг

хадгалж үлдэхэд чиглэсэн үйл ажиллагаанд анхаарал хандуулах нь чухал. Тухайлбал: Намын үйл ажиллагааг жирийн гишүүддээ таниулах олон талт үйл ажиллагааг тогтмол зохиож гишүүдийн идэвх оролцоог үнэлэх, урамшуулах, шагнах гэх олон хэлбэрээр ажиллах хэрэгтэй. Гишүүддээ "нам дуудаж байна, намын үйл ажиллагаанд оролцохыг хүсэж байна, нам та бүхний энэ санаачилгыг дэмжиж байна" гэсэн мэдээллийг байнга өгч байх нь чухал.

2.б Намын харьяа байгууллага: Намын дэргэдэх байгууллагууд нь намын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй бөгөөд улс төрийн манлайлагчдыг шат дараатайгаар бэлтгэх үр дүнтэй арга зам юм (Diamond, L. & Gunther, R., 2001). Тэдгээр байгууллагууд нь нийгмийн тодорхой бүлгүүдийг төлөөлдөг төдийгүй нам ба иргэдийг холбож байдаг (Scarrow, S., 2005). Тийм учраас намууд дэргэдээ харьяа байгууллагыг зохион байгуулах сонирхолтой байдаг.

Манай улсын хувьд Улс төрийн намын тухай хуулийн 19.1-д нам нь дэргэдээ бодлогын судалгааны байгууллагатай байна, 8.5-д "нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана" гэж заасны хүрээнд дээрх төлөөллийг хамарсан холбоо, сан болон төрийн бус байгууллагууд намын харьяанд ажиллах боломжтой. Энэ талаар тус хуулийн 3.1.6-д "намын харьяа байгууллага" гэж намын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд намын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл намын үйл ажиллагааны хүрээнд үүсгэн байгуулагдсан, намтай холбоотой сан, холбоо, төрийн бус байгууллагыг хэлнэ хэмээн заасан байдаг.

Дэлхий нийтийн жишгээс харахад намын дэргэдэх байгууллагууд нь хүний нөөцийг хөгжүүлэх, оролцоог хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, эмэгтэй гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах, удирдагчдыг бэлтгэх зорилгоор эмэгтэйчүүд холбоо, намд шинэ гишүүдийг элсүүлэх, улс төрийн боловсрол олгох, залуу лидерүүдийг бэлтгэх зорилгоор залуучуудын холбоо, оюутны холбоо, намын түүхэн уламжлал, туршлагыг хадгалах, залуу үеийг дэмжих зорилгоор ахмадын холбоо, нийгэмд тулгамдсан аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдийн санаачилгын бүлэг гэх мэт хэлбэрээр ажилладаг. Мөн Герман улсад нам бүр өөрийн нэртэй сантай бол АНУ-д намын үзэл баримтлалыг дэмждэг хандивын болон бодлогын сангууд өргөн тархсан байдаг.

Намын дэргэдэх байгууллагууд нь намын үзэл санаа, хөтөлбөрийг олон нийтэд ойлгуулах, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг стратегийн нэгж

(Цогтбаатар, Д.2019) учраас аль ч намын хувьд үнэ цэнтэй. Тухайн нам нь эдгээр байгууллагаараа дамжуулан иргэдийн улс төрийн оролцоог өргөжүүлж, шинэ үеийн гишүүдийг бэлтгэх зорилгоо хэрэгжүүлдэг. (International IDEA, 2020). Дэлхий дахинаа намын дэргэдэх байгууллагаа дараах байдлаар зохион байгуулж байна.

Хүснэгт №4 Дэлхийн улс орнуудын улс төрийн намуудын дэргэдэх байгууллагуудын жишээ

№	Улс	Нам	Холбоо, бүлэг, сан
1	Их Британи	Хөдөлмөрийн нам Labour Party	Labour Women's Network (эмэгтэйчүүдийн сүлжээ) Labour Young's Network (залуучуудын сүлжээ) Labour Training and Development Labour Friends of Palestine (дэмжих бүлэг)
		Консерватив нам Conservative Party	Conservative Senior Forum (ахмад)
2	Герман	SPD (Социал Демократ нам)	Arbeitsgemeinschaft Sozialdemokratischer Frauen (эмэгтэйчүүдийн холбоо) AG 60plus (60-аас дээш насныхны бүлэг) Willy Brandt School of Public policy SPD Queer (ЛГБТ дэмжих бүлэг)
		CDU	Junge Union Deutschlands (залуучууд)
3	АНУ	Ардчилсан нам Democratic Party	Democratic Women's Caucus (эмэгтэйчүүд)
		Бүгд найрамдах нам Republican Party	Young Republicans (залуучууд) Republicans Overseas (дэмжих бүлэг)
4	Япон	Либерал Ардчилсан Нам, Liberal Democratic Party	Women's Affairs Division (эмэгтэйчүүд) Senior Members Association (ахмад)

5	БНСУ	БНСУ-ын Ардчилсан Нам, Democratic Party of Korea	Women's Committee (эмэгтэйчүүд) Democtatic Leadership Academy (ахмад)
6	Монгол	Монгол ардын нам Mongolian People's Party	Нийгмийн ардчилал Монголын эмэгтэйчүүдийн холбоо Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбоо МАН-ын ахмадын холбоо Стратеги академи
		Ардчилсан нам Democratic Party	Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо Ардчилсан залуучуудын холбоо Ардчилсан оюутны холбоо АН-ын ахмадын холбоо Хүний нөөцийн хөгжлийн төв
		Иргэний Зориг ногоон нам	Иргэдийн бүлэг, Иргэдийн зөвлөл
7	Энэтхэг	Энэтхэгийн Үндэсний Конгресс Нам Indian National Congress	Indian Youth Congress (залуучууд)

Эх сурвалж: Докторантын боловсруулалт

2.в Намын улс төрийн ажилтнууд: Намын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, гишүүдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, намын өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах үүрэгтэй, намын байгууллагад ажиллаж буй мэргэшсэн хүмүүсийг хэлнэ. Энэ утгаар намын улс төрийн ажилтан бол "намын амьд механизм" (Э.Төмөрхуяг, 2020, х.87) бөгөөд нийгмийн дэмжлэгийг бий болгох, намын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх гол үүрэгтнүүд мөн. Үүнд, намын төв аппарат, аймаг, нийслэлийн намын хороо, намын дэргэдэх байгууллагад байнгын цалин авч ажилладаг хүмүүс мөн. Герман улсад эдгээр хүмүүсийг Politischer Referent, АНУ-д Political staff, campaign manager, policy advisor гэх мэтээр нэрлэж намын дотоод бодлого, сонгуулийн стратегийг хэрэгжүүлдэг бол Солонгос улсад party policy professional хэмээн нэрлэж ихэвчлэн магистр, доктор зэрэгтэй хүмүүсээр бүрдүүлдэг. Судлаачдын дүгнэлтээр "Намын бодлого бодитоор хэрэгжих, иргэдийн итгэлийг бий болгох нь улс төрийн ажилтнуудын ур чадвар, ёс зүй, мэдээлэл түгээх чадамжаас хамаардаг." (Katz.R, Mair.P, 1995). Тиймээс намын улс төрийн ажилтныг сонгох, чадваржуулах нь намын хүний нөөцийн

бодлогын нэг чухал шийдэл мөн. Хэрэв улс төрийн ажилтан нь хариуцсан ажилдаа мэргэшээгүй, тэднийг мэргэшүүлэх тогтолцоо бүрэлдээгүй бол намын бодлогын хэрэгжилт хангалтгүй байх болно. (Хаш-Эрдэнэ.Б. 2022, х.54)

Намын улс төрийн ажилтнуудын гүйцэтгэдэг ажлуудыг товчоор илэрхийлвэл:

- Намын хөтөлбөр, мөрийн хөтөлбөр, сонгуулийн стратегийг сайжруулах, хэрэгжүүлэх
- Гишүүд, дэмжигчид, олон нийтэд намын бодлого, үйл ажиллагааг таниулах
- Намын гишүүдийн сургаж чадваржуулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Улс төрийн нөхцөл байдал, иргэдийн санаа бодлыг судлах, үр дүнг удирдах түвшинд танилцуулах
- Гишүүдийн санаа, бодлыг сонсох, нэгтгэх, тэдний оролцоог хангах, удирдлагуудад уламжлах зэрэг мөн.

2.г Намаас нэр дэвшигчид: Нэр дэвшигч гэж төрийн сонгуульд өрсөлдөхөөр сонгууль зохион байгуулах бүтцэд бүртгүүлсэн хүнийг хэлнэ. Ихэнх улс оронд candidate гэж нэрлэдэг. Нэр дэвшигч нь өөрийгөө нэр дэвшүүлэх эсвэл нам, эвслээс нэрийг нь дэвшүүлж сонгуульд оролцоно. Хэрэв нам, эвслээс нэр дэвших бол эхлээд намын дотоод primaries буюу нэр дэвшигчийн урьдчилсан шалгаруулалтаар олонхын дэмжлэг авсан байх ёстой.

“Сонгуульд нэр дэвших гэдэг бол шагнал бус, намын өмнө, нийгмийн өмнө хүлээж буй хариуцлага юм” (Оюунчимэг.Д 2010). Тиймээс хууль бус сурталчилгаа хийх, мөрийн хөтөлбөрт байхгүй асуудлаар амлалтын шинжтэй байр суурь илэрхийлэх, сонгуульд өрсөлдөх бус санал хуваах зорилготой нэр дэвших зэрэг зохисгүй үйлдлүүд нь нэр дэвшигчийн хариуцлагагүйг илэрхийлдэг. Нэр дэвшигчид нь намын болон нийгмийн хариуцлагыг илэрхийлэгчид тул тэдэнд тодорхой шалгуур тавигддаг. Нэр дэвшигчдэд тавигдах шаардлага нь хууль, эрх зүйн шаардлагаас гадна ёс зүйн зарчимд тулгуурласан шинжтэй байдаг. Дэлхий дахинаа сонгуульд нэр дэвшигчдэд дараах нийтлэг шаардлагыг тавьж байна.

Хүснэгт №5 Нэр дэвшигчдэд тавьдаг нийтлэг шаардлага

№	Шаардлагууд	Тайлбар	Монгол улсын хуульд туссан эсэх
		Нэр дэвшигч нь тухайн улсын иргэн байх ёстой	

1	Иргэншил	бөгөөд сүүлийн жилүүдэд эх орондоо тогтвортой амьдарсан байх ёстой. Энэхүү шалгуур нь эх орны нийтлэг эрх ашгийг хамгаалах, тулгамдаж буй асуудлыг бодитойгоор мэддэг зэргийн илэрхийлэл юм.	Туссан
2	Нас	Парламент, Ерөнхийлөгчийн сонгуульд оролцогчдод насны доод хязгаарыг тогтоодог. Тухайн нэр дэвшигчийн хувьд нас нь шаардлагатай бодлогыг хэрэгжүүлэх туршлага, шийдвэр гаргах чадварыг нотлох нэг илэрхийлэл юм.	Туссан
3	Сонгуулийн эрх	Сонгуулийн эрхээ хязгаарлуулаагүй байх ёстой. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэгт холбогдож ял сонссон болон ял эдэлж байгаа, шүүхээс эрх зүйн чадамжгүй гэж тогтоосон /сэтгэцийн өвчтэй/ бол нэр дэвших эрх эдлэхгүй.	Туссан
4	Ёс зүй	Авлига, албан тушаалын хэрэгт холбогдоогүй, ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой.	Туссан

Эх сурвалж:Norris, S. & Curtice, J., Political Participation and Candidate Selection, 2015, p.45

Нэр дэвшигчдэд дээрх шаардлагыг тавьж буйн гол зорилго нь сонгуулийн өрсөлдөөнийг шударга байлгах, иргэдийн итгэлийг төрүүлэх, улс төрийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэнэ.

2.д Намын удирдлагын баг: “Party Leadership team” буюу намын удирдлага хэмээх ойлголт 1930-аад оны үед анх намын төв байгууллагын бүтэц, гүйцэтгэх үүргийг тайлбарлахад хэрэглэгдсэн (Katz, R. S. & Mair, P., 1995. p.5–28.) бөгөөд 1950-иад оноос Ж.Дювержийн намын байгуулалтын тухай онолоор дамжин АНУ, Европын ардчилсан улс орнуудад намын зохион байгуулалтын судалгаанд түлхүү ашиглагдаж байна.

Намын удирдлагын баг нь намын стратегийн шийдвэр гаргах, бодлого тодорхойлох, зохион байгуулалтын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий гол гишүүдээс бүрддэг. (Heywood, A., 2013.) Бүрэлдэхүүний хувьд намын дарга, дэд дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, намын удирдах зөвлөлийн гишүүд багтана. (Norris, P., 2005) Монгол Улсын хувьд улс төрийн намын удирдлагын багт намын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, орон нутгийн салбар хорооны

төлөөлөгчид болон бодлого, хяналтын зөвлөлийн гишүүд ордог. (Б.Энхтүвшин, 2020)

Намын удирдлагын баг нь намын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сонгуулийн стратегийг боловсруулах, намын дотоод нөөцийг хуваарилах гол үүрэг хүлээдэг (Katz, R. S. & Mair, P., 2002) тул чадварлаг хүмүүсээр бүрдэх шаардлагатай.

Намын удирдлагын баг нь чадваргүй, туршлагагүй хүмүүсээс бүрдвэл намын дотоод үйл ажиллагаа доголдож, оновчгүй шийдвэр гаргалт давамгайлах, бодлогын үр нөлөө буурах (Katz, R. S. & Mair, P., 1995, 5–28.) зэрэг эрсдэлтэй. Намын үйл ажиллагаанд энэ мэт хүндрэл үүсэх бол сонгуулийн үед нам улам их алдагдал хүлээдэг. Сонгуульд өрсөлдөх чадвар султай нэр дэвшигчид бий болох, нэр дэвшигчдийн бэлтгэл тааруу хангагдах, дэмжигчдийг өөртөө татаж чадахгүй байх зэргээр явсаар сонгуульд ялагдал хүлээх магадлалтай. (Dalton, R. J., 2014)

Удирдлага нь манлайлах болон харилцааны чадваргүй байх тохиолдолд гишүүдийн намдаа итгэх итгэл, намын үйл ажиллагаанаас авах сэтгэл ханамж буурдаг (Scarrow, S., 2005). Тиймээс намын удирдлагууд нь бусдад ур чадвараараа хүлээн зөвшөөрөгдөж, ёс суртахууны манлайлал үзүүлж, хууль ёсны дагуу эрх мэдлээ хэрэгжүүлдэг байх нь чухал. Намын удирдлага нь чадваргүй байх нь тухайн намын асуудал болохоос гадна гишүүд, дэмжигчдийн улс төрийн оролцоог идэвхгүй болоход нөлөөлж улмаар ардчиллын чанарыг бууруулах эрсдэлтэй. (Heywood, A., 2013.)

2.е Намын дэмжигчид: 1950-иад оны үеэс сонгуулийн оролцоо, намын нийгмийн дэмжлэгийн суурийг тайлбарлах зорилгоор судлаачид намын дэмжигч (party supporter) хэмээх ойлголтыг хэрэглэх болсон (Campbell, A.,etc, 1960). Намын дэмжигч гэж намын үзэл баримтлал, үнэт зүйл, бодлогыг дэмждэг боловч албан ёсоор гишүүнчлэлгүй иргэдийг хэлнэ (Heywood, A., 2013). Намын дэмжигч нь тухайн намын нэр дэвшигчдийг дэмжиж санал өгдөг, намын кампанит ажилд сайн дураар оролцдог (Norris, P., 2005) тул намуудад маш чухал бүлэг юм. Намын дэмжигчдийн ихэнх нь улс төрийн мэдээ мэдээлэлд мэдрэг, нийгмийн амьдралд идэвхтэй оролцдог, өөрийн итгэл үнэмшлийг чөлөөтэй өөрчилдөг, аль нэг намд хамаатахаас татгалздаг иргэд юм.

Дэмжигчид нь сонгуулийн амжилтад голлох нөлөө үзүүлэгчид бөгөөд тэдний идэвх нь нийгмийн дэмжлэгийг илэрхийлдэг. (Dalton, R. J., 2014) Учир нь нэг талаас яг бодит амьдралд тухайн намын гишүүн нь намдаа санал өгөх эсэх нь баталгаатай биш, нөгөө талаас нийт сонгогчдын дийлэх хувийг намын гишүүн болгох боломжгүй зэргээс үүдэн дэмжигчид сонгуулийн үр дүнд

голлох нөлөө үзүүлэгч болдог.

Тухайн нам хүчтэй лидертэй, оновчтой бодлоготой байх тусам дэмжигчдийн хүрээ нэмэгддэг. Дэмжигчдэд тухайн намын үзэл баримтлал, үнэт зүйл, бодлого нь итгэл үнэмшил төрүүлэх гол өдөөлт болдог хэдий ч хүчтэй лидер тэдний сонголтод хамгийн их нөлөө үзүүлдэг. Намын дэмжигчид нь голдуу намын лидерийн үзэл санаа, илтгэл төрүүлэх чадвар, кампанит ажлын нөлөөнд автдаг (Aldrich, J. H., 1995) Мөн зарим тохиолдолд "Дэмжигчид нь лидерийн харизматик зан чанар, амлалтад автах хандлагатай байдаг тул намын бодлогоос илүү удирдагчийн дүр төрх, нэр хүндийг чухалчлах тохиолдол байдаг" (Norris, P., 2005) Тиймээс намууд дэмжигчдээ нэмье гэвэл намын лидерийн харизматик чанар, бусдад хүлээн зөвшөөрөгдөх, нөлөөлөх чадварыг чухалчлах хэрэгтэй байдаг. Хэрэв тухайн нам сул лидертэй байвал дэмжигчдийн тоо шууд буурдаг бол маш богино хугацаанд дэмжигчдийн тоо нэмэгдэх нь лидертэй шууд холбоотой байх тохиолдол байдаг. (Dalton, R. J., 2014) Улс төрийн нам дэмжигчгүй бол сонгуульд ялалт байгуулахгүй, ялалт байгуулаагүй тул төрийн бодлого хэрэгжүүлэх боломжгүй үлдэнэ гэсэн үг. Дэмжигч нь сонгуулийн амжилтын гол нөлөөлөгч төдийгүй лидерийн нөлөөнд хамгийн их өртдөг бүлэг юм.

Өөр нэг анхаарах асуудал нь улс төрийн намын хүний нөөцийн бэлэн байдал мөн. Хүний нөөцийн бэлэн байдал (human resources readiness) хэмээх ойлголт 2000-аад оноос илүү түгээмэл хэрэглэгдэх болсон. Уг ойлголт нь Organizational readiness буюу тухайн байгууллага нь дотооддоо шинэчлэл хийх тодорхой санаачилгаа амжилттай хэрэгжүүлээд шаардлагатай ментал, соёл, үйл ажиллагаа хэр зэрэг бэлтгэгдсэнийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллага шинэ бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн мэдлэг, ур чадвар хангалттай юу гэдгийг тодорхойлоход ашиглаж байна. Байгууллагын талаас "тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц (чадвар, мэдлэг, сэтгэл зүйн бэлтгэл, нөөц боломж) байгаа эсэхийг, харин хувь хүн талаас шинэ үүрэг, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, мотиваци, сэтгэлзүйн дэмжлэг байгаа эсэхийг илэрхийлэхэд хэрэглэнэ.

Улс төрийн намын хувьд ээлжид сонгуульд оролцоход хүний нөөцийн бэлэн байдал (нэр дэвшигчид, кампанит ажлыг зохион байгуулах болон хэрэгжүүлэх баг, дэмжигчид гэх мэт) яригдана. Түүнчлэн тухайн нам сонгуульд ялалт байгуулвал тодорхой албан тушаалтнуудыг томилох, сэлгэх шаардлагатай. Энэ тохиолдолд томилгоог оновчтой хийх замаар нэг талаас мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх, нөгөө талаас төрийн ажлын залгамж халааг алдагдуулахгүй байж чадна. Сонгуулийн өмнөх нэр дэвшүүлэлт болон

сонгуулийн дараах томилгоог тухайн албан тушаалын шалгуурт нийцсэн хүнээр уян хатан байдлаар хийх хэрэгтэй.

Улс төрийн намын хүний нөөцийн бэлэн байдалд уян хатан байдал олон эерэг үр дагавартай. Жишээ нь: Улс төрийн сонгуульд нэр дэвшүүлэх үед хатуу гишүүнчлэлийг баримтлах нь улс төрд шинээр орж ирэх боловсон хүчнийг хязгаарладаг тул аль болох чадалтай, боловсролтой залуучуудад нэр дэвшүүлэх боломж олгох замаар хүний нөөцөө бүрдүүлэх нь улс орны хөгжилд эерэг нөлөөтэй. Нам залуу боловсон хүчнээр эгнээгээ тэлэх энэхүү аргыг орчин үед түгээмэл ашигладаг болсон. Өөр нэг арга нь залуу боловсон хүчнээ намын дэргэдэх байгууллагаараа дамжуулан бэлтгэж чадваржуулах байдлаар хэрэгждэг. Хэрэв энэ мэтээр нам нь боловсон хүчний бэлтгэж чадахгүй бол хүний нөөцийн дутагдалд аажмаар ордог.

Мөн тухайн нам хүний нөөцөө оновчтой томилж чадахгүй тохиолдлыг “хүний нөөцийн бэлэн байдал” хангагдахгүй байгаа гэж үздэг. Жишээ нь 1: Дунд болон түүнээс дээд шатанд нэгэн зэрэг халаа сэлгээ хийх үедээ зөвхөн тухайн сонгуулиар ажилласан хэн нэгнийг буюу шалгуур хангаагүй хүн томилогдох нь намын гишүүдийн дотоод дахь шударга байдлыг алдагдуулдаг. Жишээ нь 2: Төрийн нарийн бичгийн дарга, улсын төсөвт байгууллагын дарга зэрэг мэргэжлийн болон туршлага шаардлагатай албан тушаалд томилохдоо мерит зарчмыг үл баримтлах нь намын дотоод шударга байдлыг алдагдуулахаас гадна салбарын хөгжил, үйл ажиллагааг алдагдуулдаг. Тиймээс улс төрийн намын хүний нөөцийн томилгоог анхаарч үзэх хэрэгтэй.

Монголын улс төрийн намын хүний нөөцийн бодлогын эрх зүйн гол зохицуулалт нь юу вэ?: Улс төрийн намын хүний нөөцийн бодлогын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажил ардчилсан орнуудын хувьд чухал ач холбогдолтой. Манай улсын хувьд Үндсэн хууль, тусгайлсан хууль (Улс төрийн намын тухай хууль), шууд холбогдох бусад хууль (Сонгуулийн тухай хууль), намын дүрэм, журмуудад тусгагдсан байна. Үүнд:

Хүснэгт №6 Монголын улс төрийн намуудын хүний нөөцийн бодлогын эрх зүйн гол зохицуулалтууд

№	Эрх зүйн актууд	Зохицуулалтын жишээ
1	Монгол Улсын Үндсэн хууль (1992)	Монгол Улсын Үндсэн хууль (1992)-д намын хүний нөөц бүрдүүлэх эрх зүйн суурь үндсийг тодорхойлсон. Тус хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол

		Улсын иргэн эвлэлдэн нэгдэх эрхтэй. Энэ утгаар иргэн бүрд намын хүний нөөцөд багтах эрх бий.
2	Улс төрийн намын тухай хууль (2023)-д намын хүний нөөцийн бодлогын шууд зохицуулалтыг тусгасан.	Намын бүтэц, зохион байгуулалтын тулгуур зохицуулалтыг тусгасан. 20 дугаар зүйл: Улс төрийн намын гишүүний эрх, үүрэг, баталгаа, 15.3.2 дугаар зүйл: намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, 16 дугаар зүйл: Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалт, 18 дугаар зүйл: Улс төрийн намын хяналтын байгууллага, 8.4, 19.5 дахь заалт: Нэр дэвшигчийг тодруулах, сонгуулийн үйл ажиллагаанд оролцох журам
3	Сонгуулийн тухай хууль (2019)-д нэр дэвшилттэй холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгасан.	Нэр дэвшигчид тавигдах шаардлагыг голчлон тусгасан. 3.1.3 дугаар зүйл: "25 нас хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг; Бусад холбогдох зохицуулалтууд: 4.3.2, 7.4, 10.1.2, 14.12, 14.15, 20.21, 24.2, 26.3.8, 26.4.8, 29.3, 29.4, 29.6, 30.1, 30.2, 32.1, 32.2.1, 32.2.2, 32.2.4, 32.2.5, 32.2.6, 32.2.7, 32.3.4, 32.3.5, 32.3.6, 32.3.7, 32.3.8, 32.4, 32.5, 32.6, 32.7, 32.8, 32.9, 32.11, 32.12, 32.13, 32.14, 32.15, 33.1, 33.1.2, 33.1.4, 33.1.9, 33.1.10, 33.2, 33.4, 34.1.2, 34.1.3, 35.1, 35.2, 35.3
4	Намын дүрэм, журам /Жишээ: МАН/	Энэ чиглэлийн гол зохицуулалтыг тусгах эрх зүйн гол акт нь “журам” мөн. Тухай нам өөрийн үзэл баримтлал, стратегидаа төвлөрсөн журмыг батлахдаа хүний нөөцийн бодлогоо тодорхойлдог. Жишээ нь, МАН-ын дүрмийн зохицуулалтаас: **Бүрдүүлэх:** 18 насанд хүрсэн иргэний сайн дурын оролцоонд тулгуурлах, ялгаварлан гадуурхахгүй байх, залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжих, **Хөгжүүлэх:** Сонгуульд бэлтгэх, бодлого, мөрийн хөтөлбөрийг таниулахад чиглэсэн сургалт, судалгааг хийх, **Шилж сонгох:** Намын даргыг намын их хурлаас дараагийн их хурал хүртэл, сум, дүүргийн намын дарга,

		тэргүүлэгчдийг 2 жилийн хугацаанд сонгох бөгөөд тусгайлсан шалгуур тавиагүй. Намын даргад нэр дэвших боломж гишүүдэд нээлттэй. **Дэвшүүлэх:** Нэр дэвшүүлэх журмыг намын бага хурлаас баталж түүний хүрээнд ажилладаг. Сонгуульд нэр дэвшигч нь ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх ёстой. **Хариуцлага тооцох:** Намын хяналтын ерөнхий хороо ажиллах, уг хороо намын дүрэм, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих, намын боловсон хүчний бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, намын гишүүдээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх, гишүүдийн нэр төрийг хамгаалах, намын гишүүнд хариуцлага тооцохдоо улс төрийн дэмжлэг үзүүлэхгүй байх, гишүүнээс хугацаатай болон хугацаатай түдгэлзүүлэх, намаас гарсанд тооцох гэсэн хэлбэрээр хэрэгжүүлэх зэргээр зохицуулсан.

Эх сурвалж: Докторантын боловсруулалт

Институциональ онолын үүднээс улс төрийн намын хүний нөөцийн бодлогыг эрх зүйн зохицуулалттай болгох нь нэн чухал бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг “дүрэм, журам”-д тусгадаг тул намууд дүрэм, журмаа боловсруулах, сайжруулахад онцгой анхаарах хэрэгтэй байдаг. Судлаач Күүлийн үзэж буйгаар “Намуудын дотоод дүрэм, процедурын өөрчлөлт нь элитийн сонгон шалгаруулалт, хүний нөөцийн бүтэц, карьерын тогтолцоонд шууд нөлөөлдөг” (Koole 1996).

Намын үзэл баримтлалын онцлогоос үл хамааран дараах агуулгыг намын дүрэм, журмаар зохицуулах ёстой. Үүнд:

Хүснэгт №7 Улс төрийн намын хүний нөөцийн бодлогын гол шалгуурууд ба зохицуулалтууд

№	Байх ёстой гол зохицуулалтууд	Дүрэм	Журам
1	Хүний нөөцийн бодлогыг албан ёсоор тодорхойлох		*
2	Хүний эрхийг хангах, хамгаалах	*	
3	Жендерийн квотыг албажуулах	*	
4	Нэр дэвшигчийг тодруулах албан ёсны шалгуурыг албажуулах	*	*
5	Албан тушаалд томилох шалгуурыг албажуулах	*	*

6	Ёс зүйн хариуцлага тооцох асуудлыг албажуулах	*	*
7	Залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах	*	
8	Намын гишүүдийг сургах, чадваржуулах сургалтын тогтолцоог бүрдүүлэх	*	
9	Хүний нөөцөө бүрдүүлэх /элсүүлэх/хөгжүүлэх асуудлыг зохицуулах	*	
10	Карьер өсөх боломжийг нээлттэй зохицуулах		*
11	Анхан шатны бүтцийн оролцоог хангах	*	

Эх сурвалж: Докторантын боловсруулалт

Манай улсын хувьд дээрх агуулгаас дүрэм, журамд "карьер өсөх боломжийг нээлттэй зохицуулах" талаар маш сул зохицуулалттай. Улс төрийн нийтлэг соёлын хувьд ч танил талдаа карьер өсөх боломж олгох хандлагатай. Уг хандлагыг элитийн онолын зарим үндэслэлээр тайлбарлаж болох авч намын дотоод ардчилал, төлөвшилд уг процесс нь харшилдаг.

ДҮГНЭЛТ

Улс төрийн намууд нь төлөөллийн болон төрийн байгууллагыг хүний нөөцөөр хангадаг гол институц мөн. Энэ утгаар хүний нөөцөө бүрдүүлэх, шилж сонгох, томилох, сургаж хөгжүүлэх зэрэгт онцгой анхаарах хэрэгтэй. Тиймээс уг өгүүлэлд Монголын улс төрийн намуудын хүний нөөцийн бодлогыг тайлбарлах онолын үндэслэгээ, хүний нөөцийн бодлогод хамаарах субъектүүдийн үүрэг, хүний нөөцийн бодлогын эрх зүйн зохицуулалтын гол агуулга зэргийг авч үзэв. Энэ хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол улсад улс төрийн намын хүний нөөцийн бодлогын асуудлыг тайлбарлахад нэг онол дангаараа хангалтгүй байна. Иймээс намын удирдлагын халаа сэлгээ болон дотоод шийдвэр гаргалтад фракц, "танил тал"-ын нөлөө яагаад хүчтэй байдгийг элитийн онолоор, хүний нөөцийн бодлогын албан ба албан бус зохицуулалтуудын нөлөөгөөр улс төрийн намаас албан тушаалын томилгоо хэрхэн хийгддэг болохыг неоинституционал онолоор тус тус тайлбарлах нь илүү оновчтой гэж үзэв.

2. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд оролцдог субъектүүд (гишүүн, удирдлага, улс төрийн ажилтан, дэмжигч, нэр дэвшигчид, албан бус боловсон хүчин)-ийн үүрэг нь үргэлж харилцан хамаарал, нэгдмэл агуулгатай гэдгийг анхаарах шаардлагатай байна. Намын хүний нөөцийн бүрэлдэхүүний ихэнх хувийг гишүүд эзлэх бөгөөд гишүүдийг тогтоон барих, хөгжүүлэх, шинээр элсүүлэх нь намын хүний нөөцийн бодлогын нэн чухал бүрдэл мөн. Намын үйл ажиллагааг жирийн гишүүддээ таниулах олон талт үйл ажиллагааг тогтмол зохиож “нам дуудаж байна, намын үйл ажиллагаанд оролцохыг хүсэж байна, нам та бүхний энэ санаачилгыг дэмжиж байна“ гэсэн мэдээллийг байнга өгч байх нь чухал. Түүнчлэн намын хүний нөөцийг шат дараатай бэлтгэхэд намын дэргэдэх байгууллагууд чухал үүрэгтэй тул намын үзэл санаа, хөтөлбөрийг олон нийтэд ойлгуулах, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг стратегийн нэгж хэмээн үзэж хөгжүүлэх хэрэгтэй болох нь олон улсын туршлагаар нотлогдож байна.
3. Институциональ онолын үүднээс улс төрийн намын хүний нөөцийн бодлогыг эрх зүйн нарийвчилсан зохицуулалттай болгох нь нэн чухал. Монгол улсын хувьд Улс төрийн намын тухай хуульд намын хүний нөөцийн бодлогод хамаарах ерөнхий зохицуулалтыг, харин нарийвчилсан зохицуулалтыг тухайн нам нь намын дүрэм, журамд тусгагдах ёстой. Гэвч бодит байдал дээр намын дүрэм, журмаа тогтвортой хэрэгжүүлдэг, шинэчилж сайжруулах үйл явц хангалтгүй байна.
4. Өөрөөр хэлбэл, элитийн онол нь намын хүний нөөцийн бодлогын хэн шийдвэр гаргаж байгааг тайлбарладаг бол, неоинституционал онол нь уг шийдвэр яагаад тогтвортой давтагдаж буйг институцийн зохицуулалт, соёл, дарамтаар дамжуулан тайлбарлах боломж олгодог. Элитийн онол нь улс төрийн намын хүний нөөцийн бодлогын эрх мэдлийн бодит хуваарилалт, нөлөөллийн механизмыг тайлбарлахад тохиромжтой, институциональ онол нь уг бодлогын зохицуулалтын чанар, тогтвортой байдал, хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд илүү оновчтой онолын суурь болж байна.

Мөн судалгаагаар намын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд оролцдог гишүүд, удирдлага, улс төрийн ажилтнууд, нэр дэвшигчид, дэмжигчид болон намын дэргэдэх байгууллагуудын үүрэг харилцан

хамааралтай, нэгдмэл шинжтэй болохыг тогтоов. Хүний нөөцийн бодлогын эрх зүйн зохицуулалт нь Монгол улсын үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хуульд ерөнхий байдлаар туссан боловч нарийвчилсан зохицуулалт, ялангуяа карьер өсөлт, мерит зарчим, ил тод байдлыг хангах механизм намын дүрэм, журамд тодорхой тусгагдаагүй хэвээр байна. Дүгнэж хэлбэл, Монголын улс төрийн намууд хүний нөөцийн бодлогоо институциональ түвшинд боловсронгуй болгох, мерит зарчимд суурилсан ил тод шалгуур тогтоох, гишүүдийг шат дараатай сургаж хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх нь намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, улмаар ардчиллын чанарыг дээшлүүлэх чухал нөхцөл болохыг энэхүү судалгаа харуулж байна.

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

- Болд-Эрдэнэ, Д. (2008). Монголын намуудын төлөвшилтийн зарим асуудал. Шинэ толь.
- Мөнхбат, С. (2023). Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын хөгжил: Онол, практик .
- Мөнхбат, С. (2009). Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшилтийн асуудал. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.
- Мөнхбат, С. Монголын улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын шинжилгээ Политологи (сэтгүүл). № 12 (419), 2015.
- Оюунчимэг, Д. (2010) Сонгуулийн кампанийн үе дэх улс төрийн намууд, нэр дэвшигчдийн хариуцлага. Политологи VI эрдэм шинжилгээний бичиг. №58 (332).
- Төмөрхуяг, Э (2020) “Монголын улс төрийн намын шинэчлэлийн асуудал”.
- Төртогтох, Ж, Ганзаяа, С. (2019). Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990–2019). Конрад-Аденаур Сангийн дэмжлэгтэйгээр хэвлэв. Улаанбаатар: Адмон принт.
- Удирдлагын академи. (2021). Төрийн албаны хүний нөөцийн бодлого, зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ: Судалгааны тайлан (Судалгааны баг: Санжмятав, Ч [багийн ахлагч], Зүмбэрэллхам, Д [зөвлөх], Хэрлэн, Б. Цэдэвсүрэн, Н. Ууганцэцэг, Б. Нарантуяа, С). Улаанбаатар: Мөнхийн Үсэг. .
- Хаш-Эрдэнэ, Б. (2022), “Намын хүний нөөцийн бодлогын шинжилгээ”.
- Цогтбаатар, Д. (2019), “Улс төрийн намын зохион байгуулалтын хэлбэр

ба түүний үр нөлөө”.

- Чулуунбаатар, Г., Батсүх, Ш., Ганцоож, Б. (2021). Монголын ардчилал: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж. Улаанбаатар: Конрад-Аденауэр Сангийн Суурин төлөөлөгчийн газар.
- Энхтүвшин, Б (2020). “Монгол Улсын улс төрийн намуудын төлөвшлийн асуудал”, УТИС-ийн эрдэм шинжилгээний бичиг.
- Монгол улсын үндсэн хууль (1992). Улаанбаатар.
- Улс төрийн намын тухай хууль (2023). Улаанбаатар.
- МАН-ын үндсэн дүрэм. (2021). Улаанбаатар.
- Ардчилсан намын үндсэн дүрэм. (2020). Улаанбаатар.
- Aldrich, J. H., (1995). Why Parties? The Origin and Transformation of Political Parties in America, University of Chicago Press.
- Campbell, A., Converse, P. E., Miller, W. E., & Stokes, D. E., (1960). The American Voter, University of Chicago Press.
- Dalton, R. J., (2014). Citizen Politics: Public Opinion and Political Parties in Advanced Industrial Democracies, CQ Press.
- Diamond, L. (2019). Developing democracy: Toward consolidation. Johns Hopkins University Press.
- Diamond, L. & Gunther, R., 2001, Political Parties and Democracy
- International IDEA, 2020, Political Party Organization and Women’s Wings Report
- Katz, R. S. & Mair, P., (1995). Changing Models of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party, Party Politics, Vol.1(1).
- Katz, R. S. & Mair, P., (2002). Party Organization, Party Democracy, and the Emergence of the Cartel Party, Oxford University Press.
- Koole, R. (1996). Cadre, Catch-all or Cartel? A Comment on the Notion of the Cartel Party. Party Politics, 2(4).
- Khan, M. (2018). *Political patronage and institutional development*. Oxford University Press.
- Heywood, A., (2013). Politics, Palgrave Macmillan.
- Mills, C. W. (1956). *The power elite*. Oxford University Press.
- Norris, S. & Curtice, J., (2015) Political Participation and Candidate Selection.
- Norris, P., (2005). Political Parties and Democracy in Theoretical and Practical Perspectives, NDI.
- Scarrow, S., (2005), Political Parties and Civil Society.
- Scarrow, S., (2005). Political Parties and Democracy, ECPR Press.

HUMAN RESOURCE POLICY IN MONGOLIAN POLITICAL PARTIES: THEORETICAL AND PRACTICAL ISSUES

Abstract: In democratic countries, political parties play a crucial role in linking society with the state; therefore, they pay special attention to the recruitment, appointment, training, and development of human resources. However, in our country, the lack of focus on this issue has resulted in the appointment of individuals with inadequate experience and skills to public administration positions, and representatives elected from the party do not meet societal expectations. Consequently, the purpose of the presentation is to clarify the main theories explaining party human resource issues, outline the roles and interactions of key participants in human resource policy, and specify the major legal regulations governing human resource policies. To achieve this goal, institutional and comparative analyses of secondary sources, including relevant policy documents, party regulations, single-topic works by researchers, and previously conducted research reports, were conducted, leading to the following conclu*sions.*

Key words*:* internal democracy, party members, leadership, candidates, political staff, party supporters, party-affiliated organizations, elite theory, institutional theory

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 55-68 дэх тал

УЛС ТӨРИЙН НАМЫН ОРЧИН ҮЕИЙН ОНОЛЫН ХАНДЛАГУУД

Н.Отгонбаяр
Этүгэн их сургууль, Хүмүүнлэгийн сургууль, Эдийн засаг, менежментийн тэнхим, Доктор

Д.Одмаа
ШУТИС, Нийгэм, хүмүүнлэгийн сургууль, Нийгмийн ухааны тэнхим, Доктор, дэд профессор

Ц.Бямбачулуун
МУИС, Баруун бүсийн сургууль, Нийгэм-Хүмүүнлэгийн ухааны тэнхим, Доктор

Хураангуй: Тус өгүүлэлд улс төрийн намын орчин үеийн онолын хандлагуудыг харьцуулан судалж, намын институцийн хувьсал өөрчлөлт, үйл ажиллагааны учир шалтгаан, улс төрийн өрсөлдөөний үүргийг шинжлэв. Нам судлал дахь гол онолууд болох олигархижилтын онол**,** бүхнийг шүүрдэгч нам**,** картель намын онол**,** мөн дижиталчлал ба сүлжээний онол зэрэг үзэл баримтлалуудыг авч үзсэн. Өнөөгийн ардчилсан нийгэмд намууд улам бүр улс төрийн зах зээл дээрх өрсөлдөх чадвараар**,** мэдээллийн орчны өөрчлөлтөөр**,** сонгогчдын хуваагдмал бүтцээр тодорхойлогдох болсон нь намын бүтэц, дотоод зохион байгуулалт, стратегид хүчтэй нөлөө үзүүлж байна. Судалгааны дүнд улс төрийн намууд уламжлалт үзэл сурталд суурилсан байгууллагаас аялаг багатай, мэргэжлийн чиг баримжаатай, нам-төрийн холбоолсон бүтцийн шинэ хэлбэр рүү шилжиж буйг харуулж, тухайн шилжилт төлөөллийн чанар, ардчиллын тогтвортой байдалд ямар үр дагавар авчирч буйг дүгнэсэн болно.

Түлхүүр үгс: Улс төрийн нам; намын онол; бүхнийг шүүрдэгч нам; картель нам; цахим нам

I.Удиртгал

Улс төрийн нам орчин үеийн ардчиллын үндсэн институцийн нэг бөгөөд төр, иргэний хоорондын холбоог хангах төлөөллийн тогтолцоог бүрдүүлэхэд голлох байр суурь эзэлдэг байна (Sartori, 2005; Dalton, Farrell, & McAllister, 2011). XIX зууны сүүл үеэс эхлэн нийгмийн бүтэц, сонгогчдын

орчин, технологийн өөрчлөлттэй уялдан намуудын шинж чанар, үйл ажиллагаа, бүтэц, үүрэг хувьсан өөрчлөгдөж, үүнийг дагаад онолын судалгаа тасралтгүй хийгдсээр иржээ (Duverger, 1954). Орчин үед улс төрийн намын тухай уламжлалт тайлбар нийгмийн практикт нийцэхгүй болж, намын хэлбэр, стратеги, бүтэц, зохион байгуулалтыг тайлбарласан онолын шинэ хандлагууд хүч түрж байна.

Орчин үеийн онолууд дотоод бүтэц, зохион байгуулалт, удирдлагын төвлөрөл, сонгогчидтой харилцах арга барил, төрийн институцтэй тогтоох харилцаа, мэдээллийн технологийн нөлөө зэрэг олон талт хүчин зүйлсийг хамарч, намууд хэрхэн өөрчлөгдөж байгааг судлах болсон. Роберт Михельсийн олигархийн онолоос эхлээд бүхнийг шүүрдэгч нам, картель намын онол, дижитал болон клиентелист намын тухай ойлголт нь улс төрийн талбарт гарч буй хувьслыг тайлбарлах үндсэн хандлагууд болж байна. Түүнчлэн намуудын институцийн орчин, улс төрийн зах зээлийн учир шалтгаан, сонгогчдын ялгаварт байдал зэрэг үзэгдэл орчин үеийн судалгаанд гол байр суурийг эзлэх болсон.

Улс төрийн намын орчин үеийн онолын гол хандлагыг нэгтгэн дүгнэхийн зэрэгцээ үндсэн санаа, онцлог шинж, улс төрийн практикт үзүүлэх ач холбогдлыг тодорхойлоход тус өгүүллийн зорилго оршино. Намуудын хувьсал өөрчлөлтийг ухан ойлгох нь төлөөллийн ардчиллын чанар, иргэдийн оролцоо, улс төрийн тогтолцооны тогтвортой байдлыг үнэлэхэд онцгой ач холбогдолтой юм.

II. Онолын судалгаа

Улс төрийн нам орчин үеийн ардчиллын гол институц бөгөөд сонгогчдын оролцоо, төлөөллийн тогтолцоог бий болгоход голлох үүрэг гүйцэтгэдэг. Өнөөгийн улс төрийн судалгаанд намуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, стратеги, улс төрийн орчны нөлөөг тодорхойлох онолын олон чиглэл хөгжиж байна. Эдгээрийг тус өгүүлэлд дараах байдлаар ангилж үзлээ.

II.1 Робэрт Михельсийн олигархийн онол

Роберт Михельсийн боловсруулсан уг онол ямар ч байгууллага, тэр дундаа улс төрийн нам дотоод зохион байгуулалтын хувьд удирдлагын хэт төвлөрсөн хандлагыг бий болгодог. Ингэснээр нам олон түмнийг төлөөлөх чадвараа алдаж, цөөн тооны мэргэшсэн хүмүүсийн гарт шилждэг хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл, олигархижилтын онол нь намын дотоод ардчилал

хумигдаж, гишүүдийн үүрэг, оролцоо багасах үйл явцыг тайлбарлахыг оролддог байна (Michels, 1915; Panebianco, 1988). Уг онол намын дотоод зохион байгуулалт, лидерийн эрх мэдлийн төвлөрөл, тогтвортой удирдлагын системийг ойлгоход чухал үүрэгтэй.

Михельсийн судалгааны гол ололт нь “олигархийн төмөр хууль, зүй тогтол”-ыг нээсэнд оршино. Нам, хөдөлгөөн гэх мэт нийгэм, улс төрийн аливаа зохион байгуулалтын хэлбэр өөртөө олигархичлагдах хандлагыг тээж байдаг. Эрх мэдлийн цөм удирдлага, мэргэшсэн аппаратын гарт төвлөрөх, олон түмний болон байгуулагын энгийн гишүүдийн эрх, үүрэг хумигдах, удирдлага, удирдлагын бүтцээ хянах боломж алдагдах, байгууллагын үйл ажиллагааны анхдагч зорилго сарних зэрэг нь тухайн зохион байгуулалт олигархи шинжтэй болж буйн илрэл юм. Намын зохион байгуулалт олигархи шинжид орох үйл явц нь дараах үе шаттай. Үүнд:

1. Манлайлал бий болно;

2. Манлайлал мэргэшиж, төлөвшинө;

3. Удирдлагын бюрократ бүтэц үүснэ;

4. Эрх мэдэл төвлөрнө;

5. Үзэл суртал удирдлага, удирдлагын бүтцийн зорилгодоо хүрэх арга хэрэгсэл болж хувирна;

6. Үзэл суртал, нийгмийн бодит байдлын хооронд зөрчил бий болж, үзэл суртлаа шинэчлэх санал, санаачлагууд гарч эхэлнэ;

7. Энгийн гишүүд, удирдлагын хоорондын харилцаа алсарч эхэлнэ;

8. Намын шийдвэр гаргах үйл явцад энгийн гишүүдийн нөлөөлөх боломж хумигдаж эхэлнэ;

9. Удирдлагын бүтцэд сөрөг байр суурьтай бүлэглэлүүдийн удирдлагыг элсүүлж эхэлнэ (кооптац) гэх мэт шинжийг багтаасан байна. Хувьсгалт намууд хүртэл гишүүнчлэлээ өргөжүүлэх бодлогоос татгалзаж сонгогчдынхоо хүрээг тэлэх бодлогод шилждэг байна (Michels, 1915, pp. 3-137).

Ямар үзэл баримтлалыг дэмждэг нам байх нь хамаагүй бүгд олигархи шинжтэй болж эхэлдэг. Оршин буй нийгмийн байгууллаа өөрчлөх зорилго бүхий хэт зүүний намуудад хүртэл хөгжлийн явцад олигархи шинж бүрэлдэж, үйл ажиллагааны анхдагч зорилгоо гээх явдал байдгийг Михельс онцолсон.

Намын удирдлагын ярианд хэт зүүний үг хэллэг хадгалагдах ч үнэн чанартаа анхдагч зорилгоосоо аль хэдийн хазаасан байдаг. Энэ бол зохион байгуулалтын хөгжлийн зүй ёсны үр дүн юм. Удирдлага нь энгийн ажилчдаас бүрдэх социалист намд хүртэл мэдлэг чадвар хуримтлагдаж, улс төрийн тэмцэлд татагдан орохын зэрэгцээ хууль тогтоох хуралд сонгогдсон тохиолдолд удирдлага, жирийн гишүүдийн дунд харилцаа алсардаг талаар Михельс онцолсон (Michels, 1915, хууд. 135). Энэ нөхцөлд намын удирдлагын байр суурь зохион байгуулалтаас хамаарах бөгөөд улмаар анги, нийгмийн давхаргын бус, намын зохион байгуулалтын ашиг сонирхлыг илэрхийлэгч, хамгаалагч болж хувирдаг байна. Үүнээс гадна, намын удирдлага намын үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлж, нөөц, шийдвэр гаргах үйл явцад хяналтаа тогтоох замаар бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн хэрээр улс төрийн зүүний радикал шинжээ алддаг талаар Михельс дурдсан. Өнөөгийн олон түмний намууд зохион байгуулалтын хэлбэрт шилжих нь зайлшгүй. Гэтэл зохион байгуулалтын гарцаагүй үр дүн олигархи хандлага болно. Ингэхлээр, оршин буй нийгмийн байгууллаа өөрчлөхийг хүсэгч зүүний намууд хүртэл олигархийн төмөр хуулиас ангид байж чаддаггүй гэсэн үг юм (Michels, 1915, хууд. 128).

II.2 Бүхнийг шүүрдэгч намын онол

Герман-Америкийн эрдэмтэн Отто Хиркхаймэр (1905-1965 он) өнөө үед улс төр судлаачид болон улс төрийг сонирхон судлагчдын зүгээс ихээр ишлэх болсон бүхнийг шүүрдэгч намын хөгжлийн тухай асуудлыг анхлан хөндсөн гэдгээрээ нэр цолгорчээ. Үнэндээ, баруун Европын улс төрийн хувьсал өөрчлөлтийн талаарх Хиркхаймэрийн өргөн цар хүрээтэй үзэл санаа бүхнийг шүүрдэгч намын тухай ойлголттой нягт уялдаатайгаар бий болсон байдаг. Хиркхаймэр 1950, 60-аад оны үеийн намуудын, ялангуяа Социал ардчилсан болон Христийн ардчилсан намын чиг үүргийн хувьсал өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, нам иргэний нийгмээс алсарч, гишүүнчлэлийн түвшин буурсан, үр дүнд нь нам, төрийн картель бий болж байна гэдгийг онцолжээ. Үүнээс гадна, нам, сонгогчдын дундах холбоо суларч, улс төрийн намуудын үзэл суртлын чиг баримжаа өөрчлөгдсөн, үүнээс улбаалан Баруун Европын орнуудын улс төрийн бодлогын үндсэн бүтцэд эрс хувирал бий болсон шалтгаан, үр дагаврыг судалсан байна (Krouwel , The catch-all party in Western Europe,1945-1990. A study in arrested development, 1999, pp. 23-25; Krouwel, Otto Kirchheimer and the catch-all party, 2003).

Бүхнийг шүүрдэгч намын онолоо 1954 онд анх боловсруулсан байх бөгөөд 1954-1966 оны хооронд хэд хэдэн удаа шинэтгэн сайжруулсан байна.

Баруун Германы улс төрийн тогтолцоог судлах явцдаа Хиркхаймэр бүхнийг шүүрдэгч намын үзэл баримтлалаа хөгжүүлсэн юм. Уг судалгаандаа Германы сонгогчид консерватив бүхнийг шүүрдэгч намыг дэмжих болсноос гадна холбоотнууд үзэл баримтлалын чигийг нь өөрчлүүлэх зорилгоор ГСДН-д шахалт үзүүлж эхэлсэн гэж бичжээ. ГСДН болон Христийн ардчилсан намын хооронд бодлогын санал зөрөлдөөн эрс багассан байна. Мөн тэрээр Германы ардчилсан нам нэгдмэл бүхнийг шүүрдэгч нам болсноор засаг барих бололцоотой болсон гэсэн дүгнэлтэд хүрчээ. 1950-аад оны эхэн үеэр Хиркхаймэр төвийн намуудын картель бий болж, улс төрийн сөрөг хүчний үүрэг суларсан, эрх мэдлийн тэнцвэр хууль тогтоох хурлаас гүйцэтгэх эрх мэдэлд шилжсэнээр төрийн хүчинд суурилсан намуудын картель үүссэн гэдгийг ажигласан байна. Олон түмний нам байсан Христийн ардчилсан нам бүхнийг шүүрдэгч нам болж хувирсан талаар бичжээ. Гэвч Хиркхаймэр нэг ч бүтээлдээ шинэ хэв шинжийн улс төрийн намыг бүрэн тодорхойлоогүй юм. Анхны санаа гарснаас хойш 12 жилийн дараа сая өөр хооронд холбоо бүхий дараах таван шинжийг ашиглан зуурам байдлаар тодорхойлохыг оролджээ: а) намын үзэл суртлын үүрэг эрс буурсан. ... б) Намын дээд удирдлагын чиг үүрэг илүү мэргэшсэн с) намын ердийн гишүүдийн чиг үүрэг багассан г) сонгогчдыг ангийн, нийгмийн шинж чанарт тулгуурлан ялгаварт байдлаар ангилах, дэмжлэг горилох явдал буурсан. д) Нийгмийн янз бүрийн бүлгээс намд хандах байдал нэмэгдсэн (Kirchheimer, The Transformation of Western European Party Systems, 1966; Kirchheimer, Party structure and mass democracy in Europe, 1969). Өөрөөр хэлбэл, 1966 онд бий болсон бүхнийг шүүрдэгч намын талаарх тодорхойлолт хамгийн багадаа 12 жилийн туршид хувьсан өөрчлөгдсөөр ирсэн байна. Энэ бүх хугацаанд Хиркхаймэр бүхнийг шүүрдэгч намыг тодорхойлохуйц нэг ч хэмжүүр гаргаж байсангүй (Kirchheimer, Party structure and mass democracy in Europe, 1969).

Бүхнийг шүүрдэгч намын үүсэл бүх нийтийн хангалуун төрийн үзэл санаагаар дамжсан баялгийн дахин хуваарилалт, эдийн засгийн сайн сайхан байдлын улс төрийн үр дагавар мөн гэх үзэл санаа улс төрийн намуудын чиг үүргийн өөрчлөлтийг зохион байгуулалт, үзэл суртал, сонгогчдын түвшинд авч үзэх ерөнхий онол болно. Бүхнийг шүүрдэгч намын ойлголт нь уг ерөнхий онолын бүрэлдэхүүн хэсэг юм. Товчоор хэлбэл, уг ерөнхий онол дараах үндсэн дөрвөн асуудалд төвлөрдөг байна. Үүнд:

1. Улс төрийн антагонизм, сөрөг хүчин үгүй болсноор фашист, коммунист төдийгүй ардчиллыг сэргээн тогтоосон орнуудад хүртэл парламентын ардчилал доройтож байна:

2. Өөрийн улс төрийн зорилгод хууль ёсны арга хэрэгсэл ашиглан хүрэхийг эрмэлзсэн мэргэшсэн улс төрчдийн төрийг удирдах бодлого нийгмээс алсарч, төртэй холбогдож эхэлснээр нам-төрийн картель бүрэлдэн бий болсон:
3. Нийгмээс хөндийрч төрийн нөөцөд тулгуурлах болсон нам зохион байгуулалтын хувьд мэргэшин, сонгогчидтой хувь шинжид тулгуурлах харилцах болсон:
4. Эдгээрийн үр дүнд олон түмэн улс төрөөс залхах, хүнийсэх байдал үүсэж, төрийн эрх мэдэл хуваарилалтын сонгодог зарчим алдагдсан (Kirchheimer, The Transformation of Western European Party Systems, 1966).

Хиркхаймэр харилцан уялдаа бүхий эдгээр асуудал намуудын чиг үүргийн өөрчлөлтөд суурь нөлөө үзүүлсэн хэмээн үзжээ. Хууль тогтоох хурлын нэр хүнд унахтай зэрэгцээд нам үзэл суртлын чиг баримжаагаа алдаж, нам, төр, сонирхлын бүлэгт суурилсан гурван талт эрх мэдлийн картель үүсэж байна гэдгийг онцолсон. Нам нийгмээс алсарч, төртэй илүү ойр болсон нь нийгмийн янз бүрийн давхаргын улс төрийн идэвх сулрахад хүргэжээ. Намын гишүүдийн чиг үүрэг буурч, намын гишүүд, удирдлагын дундах харилцаа хөндийрч байна. Үүнээс гадна, сонгогдсон төлөөлөгчдийн улс төрийн чиг баримжаа өөрчлөгдөн, намын зохион байгуулалт, намын доторх шийдвэр гаргах механизмд нөлөөлөх болсон. Ардчилсан улс төрийн дэглэмд иргэдийг улс төрийн хүч гэдэг утгаар авч үзэхээ больж, улс төрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд шаардлагатай хэрэглэгч төдийд ойлгох болжээ (Kirchheimer, The Transformation of Western European Party Systems, 1966).

Хиркхаймэр ард түмний төлөөллийн байгууллага болох хууль тогтоох хурал доройтож байгааг эрх мэдлийн хуваарилалт алдагдсантай холбон тайлбарлажээ. Төрийн бодлогын үлэмжхэн хэсэг хууль тогтоох хурлаас гадуур ил, далд зөвшилцлийн хэлбэрээр шийдэгдэж, яамдын эрх, үүрэг өсөхийн зэрэгцээ парламент хүчгүйдэх болжээ. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл засгийн газрын түвшинд төвлөрч, хууль санаачлах байдал хууль тогтоох хурлаас бус, кабинет дотроос гарах болсон. Ардчилсан үзэл, онолын үүднээс авч үзвэл нийт ард түмнээс сонгогдсон хууль тогтоох хурлын гишүүн улс төрийн шийдвэр гаргах ёстой ч өнөөгийн улс төрийн тогтолцоонд бюрократиуд улс төрийн шийдвэр гаргаж (Nyamaa et al., 2025), парламент ердөө техникийн асуудалд анхаарч байна.

Өндөр хөгжилтэй аж үйлдвэрийн нийгэм дэх элитийн асуудалд зориулагдсан өөр нэг навтарга бүтээлдээ Хиркхаймэр улс төрийн институт

өсөн нэмэгдэж, үзэл суртлын ач холбогдол буурахын зэрэгцээ улс төрийн хүрээнд өрсөлдөөн сарниж байгааг заасан байна. Шинэ гишүүд элитийн бүлэгт нэгдэх ч засаглагч элитээ солих сонирхолгүй байна гэдгийг гаргасан. Үүнээс гадна, олон түмний нам өргөн хүрээний нам болж хувирснаар төлөөллийн чиг үүрэг багасаж, парламентын сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа төдийгөөр олон түмний оролцоог аргацааж байна. Энгийн иргэд, тэр дундаа нийгмийн доод хэсгийнхэн улс төрийн үйл явцаас хөндийрч, засаглал илэрхий зөрчилгүй болж байна. Үүнтэй холбоотойгоор Өрнөдийн улс төрийн тогтолцоо хяналтын чиг үүргээ алдсан. Хяналт алдагдсан уг байдал олноос цолгорсон хошуучлагчдын гарт эрх мэдэл төвлөрөхөд хүргэжээ. Тухайн тохиолдолд хошуучлагч иргэд, тогтолцоог хооронд нь холбогчийн үүрэг гүйцэтгэдэг байна. Эрх мэдэл хувь хүний түвшинд төвлөрөх болсноор уг эрх мэдлээ урвуулан ашиглах байдалд хүргэж байна. Шарл де Голлын санаанд тулгуурлан Хиркхаймэр олонд нэр түгсэн лидерүүд оршин буй улс төрийн бүтцийг үгүй хийхийн тулд нэр хүндээ ашиглаж байна. Шийдвэр гаргах үйл явцыг хувь хүний улс төрийн зорилгод ашиглах болсон гэжээ. Вэймарын төдийгүй нацист Герман, дайны дараах Европын улс орнууд, Америк ч мөн ийм байна гэдгийг Хиркхаймэр өөрийн туршлагад тулгуурлан гаргажээ (Kirchheimer, The Transformation of Western European Party Systems, 1966; Мөнхбат С. , 2023, хуудсд. 80, 81).

Хиркхаймэрийн дэвшүүлсэн бүхнийг шүүрдэгч намын онол улс төрийн нам, төлөөллийн ардчилал, төр, иргэний хоорондын харилцааг судлахад томоохон түлхэц үзүүлснийг онцлон тэмдэглэх байна.

II.3 Картель намын онол

Улс төрийн намуудын орчин үеийн хувьсал, институцийн өөрчлөлтийг тайлбарлах онолын гол загварын нэг нь **картель намын онол** юм. Уг онолыг Америкийн улс төр судлаач **Ричард С. Кац Питер Майр** нар хамтран 1990-ээд оны дунд үеэс системтэйгээр дэвшүүлж, улмаар намуудын санхүүжилт, улс төрийн өрсөлдөөн, нам– төрийн харилцаа, улс төрийн зах зээл дэх байр суурийг шинээр тайлбарлах онолын загвар хэлбэрээр боловсруулсан (Katz & Mair, 1995; Баярбаатар & Бумдарь , Ардчиллын хөгжилд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг, 2023). Картель намын онол намын хөгжлийн орчин үеийн үе шатын тайлбар бөгөөд өмнөх олон түмний болон бүхнийг шүүрдэгч намын загварыг орчин цагийн институцийн нөхцөлд үргэлжлүүлэн тайлбарлах онолын залгамж холбоо хэмээн тооцож болох юм (Krouwel, Party Models, 2006, p. 251; Баярбаатар & Бумдарь, "Картель нам" ба "намын картелжилт"-ийн тухай ойлголт, 2025, хууд. 178).

Кац ба Майрын үзсэнээр, намуудын санхүүжилтийн эх үүсвэр иргэд, гишүүдээс татагддаг олон түмний намтай харьцуулахад орчин үеийн намууд **төрийн санхүүжилтэд** илүүтэйгээр **түшиглэх болж,** улмаар сонгогчидтой тогтоосон харилцаа суларч, төрийн нөөцийг хуваарилж ашиглах **элит төвтэй бүтэц** рүү шилждэг (Katz & Mair, 2009). Ийм байдлаар намууд улс төрийн өрсөлдөөнд бүрэн ялгарах бус, эсрэгээрээ, эрх мэдлийн тогтолцоог хамгаалах зорилгоор **хоорондоо стратегийн хамтын ажиллагаа** бий болгодог бөгөөд үүнийг эдийн засгийн картелийн үзэгдэлтэй адилтган тайлбарласан байдаг (Баярбаатар & Бумдарь, "Картель нам" ба "намын картелжилт"-ийн тухай ойлголт, 2025, хуудсд. 179, 80).

Картель нам оршин тогтнох үйл явц дараах гурван урьдач нөхцөлтэй шууд холбогддог байна.

Хүснэгт 1. Картель нам үүсэх урьдач нөхцөл

№	**Нийгэм-улс төрийн өөрчлөлт /Хуучин нөхцөлд/**	**Шинэ нөхцөлд**
1	Сонгогчдын давхаргын уламжлалт хуваагдал суларсан	Намууын үзэл суртлын ялгаа бүдгэрсэн
2	Улс төрийн гишүүнчлэл буурсан, иргэдийн оролцоо сул	Нам–төрийн институцийн уялдаа бэхжсэн
3	Мэдээллийн болон сонгуулийн технологи мэргэжлийн түвшин рүү шилжсэн	Нам мэргэжлийн улс төрийн аппарат болж хувирсан

Эх сурвалж: Судлаачид боловсруулав.

Кац ба Майр картель намыг дараах институцийн шинжээр тодорхойлогдоно хэмээн (Katz & Mair, 1995; Katz & Mair, 2009) үзсэн. Үүнд:

1) Төрийн санхүүжилтийн ноёрхол: Намуудын санхүүгийн эх үүсвэрийн томоохон хэсгийг улс орнуудын төрөөс олгодог санхүүжилт бүрдүүлдэг болсноор намууд сонгогчдоос хамаарал багатай, улмаар иргэдийн оролцоо, гишүүнчлэлийн ач холбогдол буурдаг.
2) Хуваагдсан атлаа хамтын өрсөлдөөн: Намууд сонгуулиар өрсөлдөж буй мэт боловч эрх мэдлийг хуваалцах, улс төрийн тогтолцоог хадгалах ашиг сонирхол өрсөлдөөнөөс илүү чухал байр суурь эзлэх болсон. Үүнийг **“олон намын хамтарсан элитийн захиргаа”** хэмээн нэрлэдэг (Mair, 2013).

3) Хууль, журам, институцийн давуу эрхийн тогтолцоо: Сонгуулийн болон намын санхүүжилтийн хууль тогтоомжийг намууд өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн боловсруулдаг тул **шинэ улс төрийн хүчний оролцох боломж хязгаарлагддаг**.
4) Намын дотоод ардчилал суларсан, мэргэжлийн удирдлагын бүтэц бий болсон: Намын лидерүүд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, нөөц хуваарилах гол шийдвэрийг гаргадаг бол гишүүдийн оролцоо хэлбэрийн төдий, бэлгэ тэмдэгийн шинжтэй болж хувирсан (Баасансүрэн , 2017; Katz & Mair, 1995; Katz & Mair, 2009; Баярбаатар & Бумдарь, "Картель нам" ба "намын картелжилт"-ийн тухай ойлголт, 2025).

Дүгнэн үзэхэд, картел намын онол ардчиллын чанартай холбоотой дараах хэд хэдэн шүүмжлэлийг дагуулдаг. Үүнд:

1) Сонгогчдын улс төрийн итгэл буурах;
2) Популизм, системийн гадуурх хүчний сэргэлт;
3) Бодлогын ялгаа бүдгэрэх;
4) Ардчиллын төлөөллийн шинж багасах зэрэг болно.

Майрын тодорхойлсноор, орчин үеийн ардчилал **"улс төрийн хоосон орон зай"** (ruling the void) руу шилжиж, намууд ардчиллын төлөөллийн шинж, зорилгоос хөндийрөх болсон нь улс төрийн шинэ хөдөлгөөн, эсэргүүцлийн хэлбэр үүсэх нөхцөл болж өгчээ (Mair, 2013). Хэдийгээр картель намын онол бүтэц, байгууламжийн хувьд судлаачдын зүгээс ихээхэн шүүмжлэлтэй тулгарч хэд хэдэн удаа үзэл баримтлалын түвшинд шинэчлэгдсэн боловч улс төрийн нам, нам-төрийн харилцаа, бүтэц, зохион байгуулалтыг тайлбарлах нөлөө бүхий онолд тооцогдсон хэвээр байна (Мөнхбат С. , 2023, хуудсд. 81-89; Katz & Mair, 1995; Katz & Mair, 2009; Dalton, Farrell, & McAllister, 2011).

II.4 Дижитал намын онол

XXI зууны улс төрийн орчин мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн нөлөөгөөр эрчимтэй өөрчлөгдөж байна (Мөнхбат & Золбаяр, 2025). Дижитал орчин, нийгмийн сүлжээ, өгөгдөлд суурилсан PR, хиймэл оюун ухааны нөлөө улс төрийн намын бүтэц, зохион байгуулалт, харилцаа, төлөөллийн ардчиллын уламжлалт механизмд шинэчлэл авчирч, улс төрийн намын тухай онолын судалгаанд “**дижитал намын онол**” хэмээх шинэ чиг хандлага бий болоход хүргэв. Энэ хүрээнд Итали гаралтай улс төр судлаач Паоло Гербаудо (Paolo Gerbaudo) **“дижитал нам” (digital party)** хэмээх улс төрийн намын шинэ хэв шинжийг онолын түвшинд тодорхойлж, улс төрийн

оролцооны шинэ парадигм гарч ирж буйг тэмдэглэсэн (Chadwick & Stromer-Galley, 2016; Vaccari, 2015; Мөнхбат & Золбаяр, 2025). Түүний 2019 онд хэвлэгдсэн *The Digital Party: Political Organization and Online Democracy* бүтээл намуудад тавигдах уламжлалт асуултад шинэ хариулт санал болгодог: Ардчиллыг техник технологийн хөгжил сайжруулах уу, эсхүл шинэ хэлбэрийн авторитар төвлөрөлд хүргэх үү? Дижитал улс төрийн намын онол төлөөллийн ардчиллыг технологийн эрин үед дахин тодорхойлох чухал боломжийг нээж байна. Нам зөвхөн сонгуульд оролцогч институц биш, **өгөгдөлд суурилсан, платформд дасан зохицсон, иргэдийн тасралтгүй оролцоог хангагч улс төрийн экосистем** болж хувирсан (Chadwick & Stromer-Galley, 2016).

Дижитал намын онолын эхлэлийг 2000-аад оноос улс төрийн намууд вэбсайт, имэйл, онлайн мэдээллийн сувгийг ашиглан кампанит ажил явуулж эхэлсэн үеэс харж болно. Харин 2010 оноос хойш социал медиа–суурьтай улс төрийн оролцоо, big data, алгоритмын PR өргөжсөнөөр тус онол бүхэл бүтэн судалгааны чиглэл болон төлөвшив.

Дижитал намын анхны түүхэн хэлбэр 2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын үеэр бий болсон. Улс төрийн оролцоо, ардчилсан шийдвэр гаргах шинэ хэлбэрийг бий болгохдоо дижитал технологид суурилж үйл ажиллагаа явуулах тул уг намыг дижитал хэмээн нэрлэдэг байна. Улс төрийн дижитал нам гадаад, дотоод чиг үүргээ цахим хэрэгслээр гүйцэтгэх ба төрөл бүрийн апплейкшн, програм хангамжийг ашигладаг байна. Гербаудогийн тодорхойлолтоор дижитал нам гэдэг нь **сошиал медиа болон дижитал платформ дээр үндэслэн гишүүнчлэл, шийдвэр гаргалт, кампанит ажиллагаа, дотоод засаглалаа зохион байгуулдаг улс төрийн шинэ бүтэцтэй нам** юм (Vaccari, 2015).

Өөрөөр хэлбэл, дижитал нам:

- Онлайн гишүүнчлэлтэй;
- Дижитал шууд ардчиллын хэлбэрүүдийг ашигладаг (онлайн сонголт, санал асуулга);
- Сошиал медиа кампанит ажиллагаанд тулгуурладаг;
- Өгөгдөл, алгоритм ашиглан иргэдийн оролцоог зохион байгуулдаг;
- Хэдийгээр оролцоо өргөн атлаа шийдвэр гаргалт нь төвлөрсөн байдаг;

Энэ нь Гербаудогийн тодорхойлсон **“participation without power”** буюу эрх мэдэлгүй оролцоог бий болгож ардчиллын зөрчилд хүргэдэг.

Гербаудогийн үзэж буйгаар **дижитал нам** картель намын дараагийн хөгжлийн үе шат бөгөөд сошиал медиа түрэлт, онлайн хөдөлгөөний үр дүнд бий болдог байна. Үүний зэрэгцээ, түүний үзсэнээр, дижитал нам платформ нам, холбон зуучлагч нам, хүчтэй удирдагч бүхий сүлжээний нам гэсэн гурван төрөлтэй байдаг гэжээ (Vaccari, 2015; Gerbaudo, 2019). Хэдийгээр дижитал нам иргэдийн өндөр түвшний оролцоо, хямд өртөг, үр ашигтай харилцаа, ил тод байдал, хурдан зохион байгуулалтыг бий болгодог ч эцсийн дүндээ улс төрийн талбарт популизм тархах аятай хөрс болдгийг судлаачид онцолдог (Bavel, Rathje, Harris, Robertson, & Sternisko, 2021).

III. ДҮГНЭЛТ

Орчин үеийн улс төрийн намын онолын хандлагууд улс төрийн төлөөлөл, сонгуулийн өрсөлдөөн, төр–иргэний харилцаанд намуудын гүйцэтгэх үүргийг олон талт өнцгөөс шинээр тайлбарлах боломжийг олгож байна. XIX зууны сүүл үеэс нийгмийн бүтэц, сонгогчдын давхарга, улс төрийн зах зээл, мэдээллийн технологийн хөгжилтэй уялдан намуудын шинж чанар, зохион байгуулалт, стратеги тасралтгүй хувьсан өөрчлөгдсөөр иржээ. Үүнтэй зэрэгцэн улс төрийн намуудыг тайлбарлах онолын үзэл баримтлал улам бүр баяжиж, уламжлалт институцийн тайлбар хүчгүйдэхийн зэрэгцээ шинэ парадигмууд хүч түрж байна.

Р.Михельсийн олигархийн хууль, М.Дювергерийн институцийн нөлөөний тайлбар, Кирххаймерийн бүхнийг шүүрдэгч намын загвар, Кац, Мэйр нарын картель намын онол, дижитал намын тухай хандлагууд орчин үеийн судалгааны үндсэн суурийг бүрдүүлж байна. Эдгээр хандлагад улс төрийн нам зөвхөн сонгогчдыг төлөөлөх байгууллага бус, төрийн бодлого боловсруулах, улс төрийн капитал хуримтлуулах, мэдээллийн орон зайг удирдах, нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлыг хэлэлцүүлэгт оруулах төв механизм болж хувирсныг харуулдаг.

Сонгогчдын улам бүр олон хүчний хооронд хуваагдах байдал, улс төрийн медиа орчны өөрчлөлт болон цахим мэдээллийн технологийн хурдац намуудын стратеги, гишүүнчлэл, бодлогын байр суурь, санхүүжилтийн эх үүсвэрт шинэ сорилтыг бий болгож байна. Ийм нөхцөлд нам судлалын орчин үеийн онолууд ардчиллын төлөөллийн чанар, улс төрийн өрсөлдөөний шударга байдал, төрийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хэрхэн хангах талаар онол-арга зүйн шинэ чиглэлийг нээж өгч байгаагаараа онцлог юм.

Иймээс улс төрийн намын орчин үеийн онолын судалгаа зөвхөн академик ач холбогдолтой төдийгүй ардчиллын институцийн тогтвортой байдлыг үнэлэх, улс төрийн бодлого боловсруулахад шинжлэх ухааны суурь болохуйц онолын болон практик үнэ цэнийг агуулж байна. Цаашдын судалгаанд намуудын дотоод ардчилал, популизмын өсөлт, платформжсан болон алгоритмын улс төр, мөн соёл-үнэт зүйлийн шинэ зөрчил улс төрийн намын системд ямар өөрчлөлт үүсгэж буйг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэж үзлээ.

НОМ ЗҮЙ

Bavel, J., Rathje, S., Harris, E., Robertson, C., & Sternisko, A. (2021). How social media shapes. *Trends in Cognitive Sciences, 25*(11), 913-916.

Bayarbaatar, B., & Bumdari, D.-O. (2024). Reasons for Increasing the Number of Members of the Great Khural of Mongolia and Its Impact Over the Next 10 Years. *Technium Social Sciences Journal, Vol. 6*, 205-216.

Chadwick, A., & Stromer-Galley, J. (2016). *Digital Media, Power, and Democracy in Parties and Elections.* Routledge.

Dalton, R., Farrell, D., & McAllister, I. (2011). *Political Parties and Democratic Linkage: How Parties Organize Democracy.* Oxford: Oxford University Press.

Duverger, M. (1954). *Political Parties: Their Organization and Activity in the Modern State.* London: Methuen & Co. Ltd.

Gerbaudo, P. (2019). *The Digital Party: Political Organisation and Online Democracy.* London: Pluto Press.

Katz, R., & Mair, P. (1995). Changing Models of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party. *Party Politics, 1*(1), 5-28.

Katz, R., & Mair, P. (2009). The Cartel Party Thesis: A Restatement. *Perspectives on Politics, 7*(4), 753–766.

Kirchheimer, O. (1966). The Transformation of Western European Party Systems. In J. LaPalombara, M. Weiner, & L. Binder (Eds.), *Political Parties and Political Development* (pp. 177-200). Princeton, NJ: Princeton Univ. Press.

Kirchheimer, O. (1969). Party Structure and Mass Democracy in Europe. In F. Burin & K. Shell (Eds.), *Politics, law and social change: selected essays of Otto Kirchheimer* (pp. 245–68). New York: Columbia University Press.

Kitschelt, H., & Wilkinson, S. (2007). *Patrons, Clients, and Policies: Patterns of Democratic Accountability and Political Competition.* Cambridge U: Cambridge University Press.

Krouwel , A. (1999). *The catch-all party in Western Europe,1945-1990. A study in arrested development.* PhD dissertation, Amsterdam: Vrije Universiteit Amsterdam.

Krouwel, A. (2003). Otto Kirchheimer and the catch-all party. *West European Politics, 26*(2), 23-40.

Krouwel, A. (2006). Party Models. In R. Dalton, & H.-D. Klingemann (Eds.), *The Oxford Handbook of Political Science* (pp. 249-269). Oxford: Oxford University Press.

Mainwaring, S., & Scully, T. (1995). *Building Democratic Institutions: Party Systems in Latin America.* Stanford University Press.

Mair, P. (2013). *Ruling the Void: The Hollowing of Western Democracy.* Verso.

March, J., & Olsen, J. (1989). *Rediscovering Institutions: The Organizational Basis of Politics.* Free Press.

Michels, R. (1915). *Political Parties: A Sociological Study of the Oligarchical Tendencies of Modern Democracy.* New York: HEARST'S INTERNATIONAL LIBRARY CO.

Nyamaa, Dr. O., Dangaasuren, Dr. O., Tseden, Dr. B., & Davaadorj, Dr. U. (2025). The Impact of Patronage-Based Appointments on Administrative Capacity in Mongolia. *International Journal of Advanced Multidisciplinary Research and Studies*, *5*(6), 1014–1025. https://doi.org/10.62225/2583049X.2025.5.6.5305

Panebianco, A. (1988). *Political Parties: Organization and Power.* Cambridge: Cambridge University Press.

Sartori, G. (2005). *Parties and party systems: a framework for analysis.* ECPR Press.

Vaccari, C. (2015). *Digital Politics in Western Democracies: A Comparative Study.* Johns Hopkins University Press.

Баасансүрэн , Д. (2017). Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага: Бүхнийг шүүрэгч өргөн хүрээний намаас картель загварт. *Политологи сэтгүүл, 15*(476), 33-40.

Баярбаатар , Б., & Бумдарь, Д. (2025). "Картель нам" ба "намын картелжилт"-ийн тухай ойлголт. *Политологи сэтгүүл, 23*(619), 178-190.

Баярбаатар, Б., & Бумдарь , Д. (2023). Ардчиллын хөгжилд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг. *Политологи сэтгүүл, 21*(571), 180-192.

Мөнхбат , С. (2023). *Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын хөгжил: Онол, практик.* Улаанбаатар хот: Соёмбо Принтинг ХХК.

Мөнхбат, С., & Золбаяр, Э. (2025). Дижитал улс төрийн нам ба үзэл баримтлалын зарим асуудал: Улс төрийн намын шинэ хэлбэр. *Политологи сэтгүүл, 23*(619), 167-177.

CONTEMPORARY THEORETICAL APPROACHES TO POLITICAL PARTIES

Abstract:This article examines contemporary theoretical approaches to political parties, comparing how party institutions evolve, the logic of their operations, and their role in political competition. It explores major theories in party studies, including the iron law of oligarchy, the catch-all party model, the cartel party theory, programmatic versus clientelistic approaches, new institutionalist perspectives, and the influence of digitalization and network theories. In modern democracies, political parties are increasingly shaped by their competitiveness in the political marketplace, transformations in the information environment, and the growing fragmentation of the electorate, all of which have profound effects on party structure, internal organization, and strategic behavior. The study finds that parties are shifting from traditionally ideology-based organizations toward more professionalized, less ideological, and state-embedded forms. It discusses how this transformation affects the quality of representation and the stability of democratic systems.

Key words*:* Political party; party theory; catch-all parties; cartel party; digital party.

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 69-82 дахь тал

МОНГОЛ УЛСАД УС ЦЭВЭРШҮҮЛЭХ ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

С.Мөнхбат
МУИС, УТСОУХНУС-ийн захирал, профессор

Jirimutu Ying
МУИС, УТСОУХНУС
Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй:

Аж үйлдвэржилт, хотжилт хурдацтай нэмэгдэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө эрчимжиж буй энэ үед Монгол Улс усны хомсдол болон усны бохирдолтой холбоотой сорилтуудтай тулгарч байна. Ус цэвэршүүлэх технологийг хөгжүүлэх нь үндэсний усны аюулгүй байдлыг хангах, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах бодлогын нэг гол чиглэл болж байна. Энэхүү өгүүллийн зорилго нь ус цэвэршүүлэх технологийн хөгжлийг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн бодлогыг системтэйгээр хянан шинжилж, үнэлэхэд оршино.

Үндэсний хөгжлийн бодлого, хууль тогтоомж, салбарын дүрэм журам болон эдийн засгийн урамшууллын арга хэрэгслүүдийг шинжилснээр хууль эрх зүйн баталгаажуулалт, захиргааны удирдлага, санхүүгийн дэмжлэг, технологийн инноваци зэрэг олон талт хэмжээсүүдэд түшиглэсэн бодлогын тогтолцооны бүтэц, онцлогийг тодорхойлсон. Судалгааны үр дүнд Монгол Улс зорилт тодорхойлох түвшнээс эхлээд зарим бодлогын хэрэгслүүдийг хэрэгжүүлэх хүртэл олон түвшнийг хамарсан эхний шатны бодлогын хүрээ, тогтолцоог бүрдүүлж эхэлсэн нь харагдаж байна. Гэвч тогтолцоо нь бодлогын уялдаа хангалтгүй байх, салбар хоорондын зохицуулалт сул, хэрэгжилтийн үр ашиг төдийлөн хангалтгүй зэрэг сорилтуудтай тулгарсаар байна. Ялангуяа санхүүжилтийн тогтвортой байдал, технологийн судалгааг зах зээлд нэвтрүүлэх холбоос механизмыг бэхжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Энэхүү судалгаа нь Монгол Улсын усны салбар дахь ус цэвэршүүлэх технологийн бодлогын орчныг оновчтой болгох онол болон практикийн ач холбогдолтой санал, дүгнэлт гаргах зорилготой.

Түлхүүр үгс: Усны бодлого, ус цэвэршүүлэх технологи, бодлогын дэмжлэгийн тогтолцоо, усны нөөцийн менежмент, байгаль орчны бодлого.

Усны нөөцийг тогтвортой ашиглах нь Монгол Улсад ногоон хөгжлийг дэмжих, нийгэм-эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үндсэн тулгуурын нэг юм. Хуурай, гандуу уур амьсгал зонхилдог Монгол Улс нь нийт усны нөөц хомс төдийгүй газар нутгийн хувьд маш жигд бус тархалттай байдаг. Үүнээс гадна уул уурхайн үйл ажиллагаа болон хот суурин газрын бохир усны нийлүүлэлт нь усан орчны бохирдлын эрсдэлийг улам нэмэгдүүлж байна. Ийм нөхцөлд ус цэвэршүүлэх технологийн шинэчлэл, практик хэрэглээг дэмжих, усны нөөцийг дахин ашиглах үр ашгийг дээшлүүлэх нь улсын хөгжлийн стратегийн чухал зорилтууд болж байна. Технологийн хөгжилд чиглэсэн бодлогын зохицуулалт, дэмжлэг нь хөгжлийг хөтлөх гол хүчин зүйл бөгөөд бүрэн боловсруулсан бодлогын тогтолцоо нь нийгмийн нөөцийг үр дүнтэй дайчлах, зах зээлийн чиг хандлагыг тодорхойлох, технологийн судалгаа, хөгжүүлэлт, нэвтрүүлэх үйл явцад тулгарч буй саадыг даван туулахад чухал ач холбогдолтой. Иймээс энэхүү судалгаа нь Монгол Улсад ус цэвэршүүлэх технологийн хөгжлийг дэмжих бодлогын дэмжлэгийн тогтолцоог оновчтой, системтэйгээр авч үзэхэд чиглэнэ. Бодлогын хүрээ, гол бүрэлдэхүүн хэсгүүд, хэрэгжилтийн механизм зэргийг шинжилснээр одоо хэрэгжиж буй бодлогын үр нөлөө, сул талыг тодорхойлохын зэрэгцээ цаашдын бодлогын оновчлол, шинэчлэлд онол-арга зүйн үндэслэл өгөхийг зорьж байна.

Нэг. Монгол Улсад ус цэвэршүүлэх технологийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээний хувьсал

Монгол Улсад ус цэвэршүүлэх технологийн хөгжлийг дэмжих бодлогын дэмжлэгийн тогтолцоо нь нэг өдөрт бий болоогүй бөгөөд усны нөөцийн хомсдол, түүний менежментийн асуудал улам гүнзгийрэхийн хэрээр аажимдаа бүрэлдэн тогтож, хөгжиж ирсэн. Энэ хөгжлийн явц нь улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд болон байгаль орчныг хамгаалах шаардлага өсөн нэмэгдэж буй хэрэгцээ хоёрын динамик уялдаа холбоог харуулдаг.

(1) Үндэсний стратегийн түвшинд: Монгол Улсын Засгийн газраас баталсан хэд хэдэн бодлогын баримт бичигт ус цэвэршүүлэх технологийн хөгжлийн чиглэлийг тодорхойлон тусгасан байна. 2020 онд Улсын Их Хурлаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны

хөгжлийн бодлого (Засгийн газар, 2020) нь “экологийн аюулгүй байдал, ногоон хөгжил”-ийг гол зарчмын нэг хэмээн тодорхойлсон. Түүнчлэн иргэдийг цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах эрхийг баталгаажуулахын зэрэгцээ усны нөөцийг тогтвортой ашиглахын тулд шинэ, дэвшилтэт технологи нэвтрүүлэх шаардлагатайг тусгасан. Ногоон хөгжлийн бодлого (2030) (Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2019) нь “усны хэмнэлт болон бохирдлыг бууруулах” зорилтыг гол шалгуур үзүүлэлтүүдийн нэг болгон тодотгож, ус цэвэршүүлэх технологийн судалгаа, хөгжил, хэрэглээг дэмжих өндөр түвшний бодлогын суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Эдгээр стратегийн баримт бичгүүдэд тодорхой технологийн шийдлийг нарийвчлан заагаагүй ч тэдгээрт дэвшүүлсэн макро зорилтууд нь холбогдох яам, агентлагууд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг боловсруулахад үндсэн чиглүүлэх баримт болдог.

(2) Хууль эрхзүйн зохицуулалтын хувьд: Усны тухай хууль (Улсын Их Хурал, 2012), Байгаль орчныг хамгаалах тухай хууль (Улсын Их Хурал, 2021), болон Эрүүл мэндийн тухай хуулийг тулгуур багана болгон нэгэн суурь удирдлагын тогтолцоо бүрдсэн байдаг. 2012 онд шинэчлэн батлагдсан Усны тухай хууль нь усны нөөцийн төрийн өмчлөлийг болон нэгдсэн удирдлагын зарчмыг тодорхой болгохын зэрэгцээ ус ашиглах зөвшөөрөл, бохир ус зайлуулах журам зэрэг үндсэн тогтолцоог баталгаажуулж, усны бохирдлыг бууруулах эрхзүйн суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Харин 2021 оны Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-ний механизмыг улам бэхжүүлж, шинээр байгуулагдаж буй аж үйлдвэр болон уул уурхайн нэгжүүдийг бохир ус цэвэрлэх тохирох байгууламжаар заавал хангахыг тусгасан нь эх үүсвэр дээр ус цэвэршүүлэх технологийн эрэлтийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн Эрүүл мэндийн тухай хууль нь ундны усны эрүүл ахуйн стандартыг нарийвчлан тогтоосноор ундны ус хангамжийн байгууллагуудад технологийн шинэчлэл зайлшгүй хийх шаардлага үүсэж байна. Эдгээр хуулийн тогтолцооны хөгжил нь өргөн хүрээтэй, зарчмын шинжтэй зохицуулалтаас илүү нарийвчилсан, хатуу шаардлагатай болгох чиглэлд хөгжиж, усны хэт хэрэглээ болон бохир усыг шууд зайлуулах боломжийг улам багасган, ус цэвэршүүлэх технологийн зах зээлд тогтвортой эрэлт, хөгжлийн түлхэц өгч буйг харуулж байна.

(3) Үүнээс гадна бодлогын тогтолцооны үйл ажиллагааны түвшинг төлөөлдөг стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн цогц систем бий. Жишээлбэл, “Үндэсний усны хөтөлбөр (2021-2030)” (Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2021) нь хот, хөдөөгийн ундны усны аюулгүй

байдал, сав газрын менежмент, бохир ус цэвэршүүлэх зэрэг тодорхой асуудлын тоон зорилтыг тогтоодог. Эдгээр төлөвлөгөөнүүд нь макро түвшний бодлогын стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ, зорилтуудыг задлан, холбогдох төсвийн санхүүжилттэй хамт хэрэгжүүлэхээр тусгадаг. Иймээс тэдгээр нь үндэсний бодлогын зорилтыг технологийн хэрэгжилтийн нэн тэргүүний практиктай холбох чухал гүүр болж өгдөг.

Хоёр. Бодлогын тогтолцооны үндсэн бүрдэл хэсгүүд ба шинжилгээ

Монгол Улсад ус цэвэршүүлэх технологийн хөгжлийг дэмжих зорилгоор бүрдүүлсэн бодлогын тогтолцоо нь олон төрлийн бодлогын хэрэгслүүдийг уялдуулан нэгтгэсэн цогц бүтэц юм. Энэхүү тогтолцоо нь дөрвөн үндсэн чиглэлд хамаарна. Үүнд: хууль эрх зүйн зохицуулалт, захиргааны удирдлага, эдийн засгийн урамшууллын механизм, шинжлэх ухаан-технологийн инноваци зэрэг орно. Эдгээр чиглэлүүд нь харилцан бэхжүүлэх шинжтэй боловч хоорондоо тодорхой зөрчил, тэнцвэрийн асуудлыг мөн агуулдаг.

(1) Хууль эрх зүйн болон зохицуулалтын бодлого

Хууль эрх зүйн болон зохицуулалтын бодлого нь ус цэвэршүүлэх технологийн дэмжлэгийн тогтолцооны тулгуур, зайлшгүй биелүүлэх шинжтэй үндэс суурийг бүрдүүлдэг бөгөөд түүний гол зорилго нь хууль, стандартын хүрээнд ус цэвэршүүлэх технологийн зах зээлд нэн чухал эрэлт хэрэгцээг бий болгоход оршдог. Энэ тогтолцоо нь 2012 оны Усны тухай хууль, 2021 оны Байгаль орчныг хамгаалах тухай хууль зэрэг үндсэн хуулиудаар гол зарчмуудаа тодорхойлдог бол Гадаргын усны чанарын ангилал, Ариутгах татуургын бохир ус цэвэршүүлэх стандарт (MNS 6561) зэрэг тодорхой техникийн стандартаар салбар бүрийн бохирдлын түвшнийг тогтоож, ус цэвэршүүлэх технологи хүрэх ёстой гүйцэтгэлийн түвшинг тодорхойлдог. Ус хэрэглээний зөвшөөрөл олгох болон бохирдуулах бодисын ялгаруулалтын зөвшөөрлийн хатуу тогтолцоо эдгээр стандартыг байгууллага бүрийн түвшинд хэрэгжүүлж, ялангуяа уул уурхай зэрэг ихээхэн бохирдол үүсгэдэг салбарын аж ахуй нэгжүүдийг стандартад нийцсэн цэвэршүүлэх технологид хөрөнгө оруулах, ашиглахыг шаарддаг. Энэ нь технологийн зах зээлд хамгийн тогтвортой анхны хөдөлгөгч зүйл болдог. Гэвч энэхүү тогтолцоонд дотоод зөрчилдөөнүүд бий. Жишээлбэл, Ашигт малтмалын тухай хуульд тусгасан нөөц ашиглалтыг дэмжих урамшууллын бодлого нь заримдаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагаж мөрдөх зүйл заалттай зөрчилдөх тохиолдол гардаг. Ийм төрлийн эрх зүйн түвшний зөрчил нь орон нутгийн хэрэгжилтэд

бэрхшээл үүсгэж, компаниуд ямар төрлийн технологийн шийдлийг сонгох нь тодорхойгүй байх нөхцөл байдлыг бий болгодог.

(2) Захиргаа, удирдлагын бодлого

Захиргаа болон удирдлагын бодлого нь дээд түвшний үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх боломжийг тодорхойлдог бөгөөд бодлого хэрэгжилтийн гол холбоосын үүрэг гүйцэтгэдэг. Энэ хүрээнд Монгол Улс олон байгууллагын мэргэжил-онцлогт тулгуурласан зохицуулалтын тогтолцоог баримталдаг. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах үндсэн зохицуулагчийн үүргийг гүйцэтгэдэг бол Барилга, хот байгуулалтын яам нь хот суурины усан хангамж, бохир ус зайлуулалтын дэд бүтцийг төлөвлөх, барих ажлыг хариуцдаг. Эрүүл мэндийн яам нь хэрэглэгчийн түвшний ундны усны аюулгүй байдлыг хянах чиг үүрэгтэй. Эдгээр хэрэгслийн дундаас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-ний тогтолцоо нь урьдчилсан зөвшөөрлийн гол механизм болж үйлчилдэг. Энэ нь бүх шинэ төслөөс ТЭЗҮ-гийн шатанд бохир ус цэвэрлэгээний процесс болон холбогдох шаардлагуудыг хангах чадавхаа үндэслэлтэй нотлохыг шаарддаг бөгөөд зөвшөөрөл авах зэргээр технологийн хэрэгжилтийн эхний үе шатнаас л зохицуулалтын шаардлагыг хангахад чиглэгддэг. Гэвч энэхүү үүрэг хуваарилалт нь бодит хэрэгжилтийн явцад тодорхой захиргааны хүндрэл дагуулдаг. Тухайлбал, нэг төсөл нь төслийн санаачилга, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үйл ажиллагааны зөвшөөрөл гэх мэт олон шатны, бие даасан, харилцан уялдаагүй зөвшөөрлийн үйл явцыг дамжих шаардлагатай болдог. Үүнээс гадна эдгээр процессыг өөр өөр яам, байгууллагууд тус тусдаа хариуцдаг тул хугацаа удаашрах, мэдээллийн солилцоо тасалдах, бодлогын тэргүүлэх чиглэл зөрөх зэрэг нөхцөлүүд үүсч, уялдаа холбоо алдагдах нь элбэг. Эдгээр хүндрэл нь шинэ технологи нэвтрүүлэх далд зардлыг нэмэгдүүлээд зогсохгүй, хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээнд бий болгох ёстой зах зээлийн идэвхжлийг тодорхой хэмжээгээр сааруулах үр дагавартай.

(3) Эдийн засаг, санхүүгийн бодлого

Эдийн засаг, санхүүгийн бодлого нь зах зээлийн үндэслэлтэй хөшүүргийг ашиглан ус цэвэршүүлэх технологийг нэвтрүүлэхэд оролцогч талуудыг идэвхжүүлэх, урамшуулах зорилготой. Засгийн газар улсын төсөв болон олон улсын зээлээр дамжуулан хотын төвлөрсөн бохир ус цэвэрлэх байгууламж зэрэг нийтийн дэд бүтцийн томоохон объектуудад шууд хөрөнгө оруулалт хийдэг нь дэмжлэгийн уламжлалт, үндсэн хэлбэр хэвээр байна. Үүний нэг

жишээ нь, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн төсөл юм. Үүнтэй зэрэгцэн 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Татварын хуульд үндэслэн дэвшилтэт тоног төхөөрөмж импортлоход тарифын хөнгөлөлт үзүүлэх, байгаль орчинд ээлтэй төслүүдэд орлогын албан татварын урамшуулал олгох зэрэг бодлогын арга хэмжээг нэвтрүүлэх оролдлогууд хийгдсэн. Гэвч санхүүжилтийн ихээхэн тасалдалтай тулгарах нөхцөлд хувийн хэвшлийн хөрөнгө татах зорилгоор төр-хувийн хэвшлийн түншлэл зэрэг шинэлэг санхүүжилтийн хэлбэрүүдийг эрэлхийлж эхэлсэн. Гэсэн хэдий ч энэ чиглэлийн бодлогын хэрэгслүүд ерөнхийдөө хүрэлцээ багатай, дутмаг байна. Засгийн газрын хөрөнгө оруулалт төсвийн орлогын хэлбэлзлээс шалтгаалан тогтвортой бус; зах зээл дэх оролцоог идэвхжүүлэх зорилготой татварын урамшууллууд хамрах хүрээ, үр нөлөө багатай; түүнээс гадна усны салбарын төр-хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин, эрсдэлийг хуваалцах механизм, урт хугацааны төлбөрийн баталгааны тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. Үүний улмаас хувийн хэвшил хүлээлтийн байр суурь баримтлах хандлагатай байна. Нөгөө талаас, усны технологийн инновацийг дэмжихэд зориулагдсан ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн бараг байхгүй тул санхүүжилтийн хязгаарлалт нь технологи нэвтрүүлэх үйл явцын хамгийн эхний, хатуу саад болж байна.

(4) Шинжлэх ухаан, технологийн инновацийн бодлого

Шинжлэх ухаан, технологийн инновацийн бодлого нь ус цэвэршүүлэх салбарт урт хугацааны технологийн өрсөлдөх чадварыг төлөвшүүлж, тогтвортой дотоод хөдөлгөгч хүчийг бий болгохыг зорьдог. 2019 оны Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн удирдамжийн дагуу Засгийн газар Шинжлэх ухаан, технологийн сан зэрэг механизмаар дамжуулан холбогдох суурь болон хэрэглээний судалгаанд өрсөлдөөнт санхүүжилт олгодог нь технологийн инновацийн ач холбогдлыг төрөөс хүлээн зөвшөөрч буй илэрхийлэл юм. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA) зэрэг байгууллагуудтай хэрэгжүүлж буй техникийн туршилт, загвар төслүүд нь дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, удирдлагын туршлага нэвтрүүлэх хамгийн идэвхтэй сувгуудын нэг болж байна. Гэсэн хэдий ч өнөөгийн инновацийн бодлогын тогтолцоо нь хэд хэдэн ноцтой бүтцийн сул талтай. Нэгдүгээрт, Судалгаа ба хөгжлийн нийт санхүүжилт хангалтгүй хэвээр байгаа бөгөөд үнэлгээний механизм нь зах зээлд чиглэсэн технологийн нэвтрэх чадварыг бус, академик бүтээлийг илүү үнэлэх хандлагатай. Хоёрдугаарт, хамгийн чухал нь “судалгаа-туршилт-хэрэглээ” гэсэн сүлжээний уялдаа холбоо тун сул байна.

Их дээд сургуулиуд, судалгааны байгууллагуудын хийж буй судалгаа нь үйлдвэрлэлийн салбарын бодит хэрэгцээтэй зохих хэмжээнд нийцдэггүй. Туршилт-шинжилгээний дундын лаборатори, турших бааз, нийтэд нээлттэй туршилтын платформ дутмаг байдаг нь лабораторийн түвшний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх “үхлийн хөндий”-г даван туулах боломжийг хязгаарлаж байна. Эцэст нь, бодлогын ерөнхий чиг баримжаа нь “технологи импортлох”-ыг түлхүү онцолдог бөгөөд дотоод инновацийн чадавх бий болгоход системтэй дэмжлэг хангалтгүй байна. Усны технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих бодлого сул, мэргэжлийн ур чадвартай боловсон хүчний гадаад урсгал ч асуудлыг улам хүндрүүлж байна. Үүний улмаас Монгол Улс тус салбарт технологийн бүтээгч бус, дагагчийн байр сууринд хэвээр байна.

3. Одоогийн бодлогын тогтолцоонд тулгарч буй сорилт ба хязгаарлалтууд

Хэдийгээр Монгол Улс ус цэвэршүүлэх технологийн хөгжлийг дэмжих бодлогын тогтолцооны анхдагч нөхцөлийг бүрдүүлсэн ч түүний үр нөлөө, бүрэн бүтэн байдал нь харилцан холбоотой, олон талын сорилттой тулгарч байна. Эдгээр сорилтууд нь зөвхөн бодлогын загвар, бүтэцтэй холбоотой төдийгүй улсын эдийн засгийн бүтэц, засаглалын чадавхи, мөн онцгой байршил, газар зүйн нөхцөлтэй гүнзгий холбоотой юм.

(1) Бодлогын тогтолцооны салангад байдал ба зохицуулалтын хангалтгүй байдал

Одоогийн бодлогын хүрээ “салбар хоорондын тусгаарлагдсан” бүтэцтэй бөгөөд нэгдсэн уялдаа холбоо дутагдалтай байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам усны чанарын стандартыг нэмэгдүүлэхийг зорьдог ч түүний хатуу шаардлагуудыг Барилга, хот байгуулалтын яам нэмэлт зардал бий болгох эсвэл дэд бүтцийн төслийн хугацаанд саад учруулах хүчин зүйл гэж үзэх тохиолдол байдаг. Харин Сангийн яам санхүүгийн тогтвортой байдлын үүднээс ус цэвэршүүлэх технологийн томоохон төслүүдэд болгоомжтой хандах шаардлагатай болдог. Эдгээр зөрчилдөөнтэй зорилтууд нь бодлогын чиглэлийг зөрчилтэй болгож, зарим тохиолдолд бодлогын “харилцан саармагжилт” бий болгодог. Өөрөөр хэлбэл, нэг яамны хүчин чармайлт нөгөө яамны удаашрал, эсвэл хойрго байдлаас шалтгаалан сулрах тохиолдол гардаг. Жишээлбэл, ус цэвэршүүлэх дэвшилтэт технологийг дэмжих санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ олон шат дамжлагатай, төвөгтэй хэлцэл шаарддаг тул цаг хугацаа алдаж, улмаар хувийн хэвшлийн оролцоог бууруулах нь бий. Ийм төрлийн зохицуулалтын алдаа нь зөвхөн төвийн яамд

хооронд төдийгүй төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хооронд ч ажиглагддаг бөгөөд үндэсний бодлого доод шатны байгууллагуудад дамжин хэрэгжих явцдаа үр нөлөө нь буурахад хүргэдэг байна.

(2) Санхүүгийн нөөцийн хязгаарлалт ба тогтворгүй хөрөнгө оруулалт

Санхүүжилтийн хүрэлцээгүй байдал нь ус цэвэршүүлэх технологийг өргөн хэрэглэхэд тулгарч буй хамгийн шууд бөгөөд хатуу, хязгаарлалт юм. Монгол Улс эрдэс баялгийн экспортоос их хэмжээнд хамаардаг тул улсын төсвийн орлого дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хүчтэй хамаардаг. Үүний улмаас усны технологийн чиглэлийн улсын хөрөнгө оруулалт тогтвортой, урьдчилан тооцоолох боломжгүй болдог. Хязгаарлагдмал төсвийн нөөцийг ихэвчлэн Улаанбаатар зэрэг томоохон хотуудын дэд бүтцийн том төсөлд төвлөрүүлдэг бол хөдөө орон нутаг, бэлчээрийн бүс нутаг, олон тооны сумдад ус хангамж, бохир ус цэвэрлэгээний байгууламжийн санхүүжилт урт хугацаанд дутагдаж ирсэн. Эдгээр бүс нутагт дэд бүтэц хангалтгүй, бөгөөд эвдрэл, доройтолд орсон хэвээр байна. Мөн эдийн засгийн урамшууллын бодлогууд, татварын хөнгөлөлт зэрэг нь зорилтот бүлгийг хангалттай чиглэж чаддаггүй бөгөөд хувийн хэвшлийн өргөн оролцоог бодитоор татахад сул нөлөөтэй байна. Усны чиглэлийн төсөл нь ихэвчлэн урт хугацааны хөрөнгө оруулалтын үр ашигтай, эрсдэл өндөртэй байдаг. Засгийн газрын найдвартай баталгаа, оновчтой эрсдэл хуваалцах механизм байхгүй тохиолдолд хувийн хэвшил, ялангуяа жижиг дунд компаниуд ус цэвэршүүлэх технологид хөрөнгө оруулах сонирхол бага байдаг. Үүний улмаас төр-хувийн хэвшлийн түншлэл зэрэг шинэлэг загварууд төлөвлөсөн хэмжээнд суурьшиж, үр ашигтай ажиллахад хүндрэлтэй хэвээр байна.

(3) Технологийн инновацын сүлжээний тасалдал ба мэргэжилтнүүдийн сорилт

Лабораторийн судалгаанаас зах зээлийн хэрэглээ хүртэлх технологийн инновацын сүлжээнд ноцтой зай завсар, тасалдал үүссэн байна. Улсын их, дээд сургууль болон эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгаа ихэвчлэн зах зээлийн бодит хэрэгцээтэй уялддаггүй бөгөөд тэдгээрийн үр дүн нь ихэвчлэн эрдэм шинжилгээний бүтээлд төвлөрдөг. Харин Монгол Улсад өндөр хатуулагтай, их тунгалагжилттай, эсвэл маш бага температуртай ус боловсруулах зэрэг бодит асуудлуудыг шийдвэрлэх технологийн хэрэгцээ хангалттай тусгагддаггүй. Үүний үр дүнд олон судалгааны үр үр дүн бодит амьдралд нэвтэрч ашиглагдалгүй үлддэг. Нөгөө талаас, аж ахуйн нэгжүүд

хуулийн шаардлага хангуулах дарамтаас үүдэн зардлын хязгаарлалтад орсон нөхцөлд дотоодын байгууллагуудтай хамтран судалгаа, туршилт хийхээсээ илүүтэйгээр гадаадаас “бэлэн”, боловсронгуй технологи, тоног төхөөрөмж худалдаж авахыг илүүд үздэг. “Импортод түшиглэсэн, дотоодын шингээлт ба дахин инновацид сул анхаарсан” энэ бодлого нь Монгол Улсад ус цэвэршүүлэх технологийн дотоодын үйлдвэрлэлийн кластер хөгжихөд саад болж байна. Үүнээс ч илүү ноцтой асуудал нь ус боловсруулах болон хүрээлэн буй орчны инженерчлэлийн чиглэлийн өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн дотоодын ажлын байр, судалгаа-хөгжлийн нөхцөл боломж хязгаарлагдмал тул гадагш чиглэсэн шилжилт тогтвортой үргэлжилж байна. Энэ нь Монгол Улсын бие даасан инновац хийх чадамжийг улам сулруулж, технологийн хамаарал болон хүний нөөцийн алдагдлыг давхар нэмэгдүүлдэг “сөрөг мөчлөг”-ийг бий болгож байна.

(4) Хяналт шалгалтын чадавх сул, бодлогын хэрэгжилтийн дутмаг байдал

Эрх зүйн орчин төгс бүрдсэн ч түүнийг бодитой хэрэгжүүлэхгүй бол үр нөлөөгүй болдог. Монгол Улсын байгаль орчны хяналт, зохицуулалтын байгууллагууд хуучирсан тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцийн хомсдол, төсөв санхүүгийн хязгаарлалттай тулгарсаар байна. Улсын хэмжээний мониторингийн сүлжээний хамрах хүрээ хангалтгүй тул улс орон даяарх үйлдвэрлэл, уул уурхайн, ялангуяа алслагдсан бүсийн жижиг уурхайн бохир усны хяналтыг цаг тухайд нь үр дүнтэй хийх боломж хомс хэвээр байна. Үүний улмаас хууль, журамд тусгасан шаардлагууд бодит хэрэгжилтийн чадавхаас давсан “биелэлт дутмаг” нөхцөл байдлыг үүсгэдэг. Стандартын дагуу бохир ус цэвэрлэж нийлүүлэхгүй байгаа аж ахуйн нэгжүүдэд тооцох хариуцлага сул, зөрчил илэрсэн ч хүлээлгэдэг шийтгэл нь харьцангуй зөөлөн хэвээр байна. Ийм байдал нь бохирдлыг үргэлжлүүлэн үүсгэх нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй, шаардлагаа мөрдөж, байгаль орчны технологид хөрөнгө оруулж буй байгууллагуудад шударга бус өрсөлдөөн бий болгодог. Энэ мэт гажуудсан зах зээлийн дохио нь ус цэвэршүүлэх технологи нэвтрүүлэх эдийн засгийн урамшууллыг улам сулруулж байна.

(5) Байгаль, газарзүйн онцлог, нийгмийн нөхцөл байдал нь технологийн хэрэглээний саадыг нэмэгдүүлдэг.

Монгол Улсын өвөрмөц газарзүйн болон нийгмийн орчин нь ус цэвэршүүлэх технологийг өргөнөөр нэвтрүүлэхэд төрөөс үл хамаарах дотоод бэрхшээлүүдийг бий болгодог. Улс орны нутаг дэвсгэр уудам, хүн амын суурьшил, нягтшил бага бөгөөд тархай байрладаг тул төвлөрсөн, том

хэмжээний ус хангамж болон бохир ус цэвэрлэх систем барих нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байдаг. Гэвч модульчлагдсан, контейнер хэлбэрийн зэрэг децентрализсан, бага хүчин чадлын ус цэвэршүүлэх технологийг хөгжүүлэх, нутагшуулах, түгээхэд чиглэсэн бодлогын дэмжлэг харьцангуй сул байна. Мөн Монголын эрс тэс уур амьсгал, урт хугацаанд үргэлжилдэг хүйтэн өвөл нь ус цэвэршүүлэх байгууламжид тусгай техникийн шаардлага бий болгодог. Үүнд хөлдөлтөөс хамгаалах, дулаан алдагдлыг бууруулах, бага температурт найдвартай ажиллах зэрэг орно. Бага температуртай орчинд тохиромжгүй, зөвхөн дулаан уур амьсгалд үр дүнтэй технологи олон байдаг. Ийм байгалийн нөхцөл нь илүү нарийвчилсан, уян хатан бодлого шаарддаг ч одоогийн "нэг загвараар бүхнийг шийдэх" хандлагатай бодлого энэ хэрэгцээг хангаж чадахгүй байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын ус цэвэршүүлэх технологийн бодлогын хэрэгжилтийн тогтолцоонд хийсэн энэхүү шинжилгээ нь улс орон технологийн хөгжлийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, үндэсний стратеги, хууль эрх зүйн зохицуулалт, эдийн засгийн бодлогын хэрэгслээр дамжуулан дэмжих орчныг бүрдүүлэхийг зорьж байгааг харуулж байна. Гэвч энэхүү тогтолцоо хөгжлийнхөө анхан шатанд байгаа бөгөөд бодлогын зохион байгуулалтын сул тал, хэрэгжилтийн чадавх сул, төсөв болон нөөцийн бүтцийн хязгаарлалтаас болж үр нөлөө нь хязгаарлагдсаар байна. Системийн нэгдмэл байдал хангалтгүй байх, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул, санхүүжилт болон технологийг зах зээлд нэвтрүүлэх үйл явцад тулгарч буй хүндрэл зэрэг гол саад бэрхшээлүүд нь ус цэвэршүүлэх технологийг өргөн хүрээнд нэвтрүүлэх, үйлдвэрлэлжүүлэх үйл явцыг удаашруулсаар байна. Цаашид Монгол Улсын ус цэвэршүүлэх технологийн салбарын хөгжил нь бодлогын дэмжлэгийн тогтолцоог цогц байдлаар нэгтгэн бэхжүүлж, илүү уялдаа холбоотой, хүртээмжтэй, инновацид суурилсан удирдлагын тогтолцоог бүрдүүлж чадах эсэхээс ихээхэн хамаарсаар байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад ус цэвэршүүлэх технологийн хөгжлийг дэмжих бодлогын тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг нарийвчлан шинжилсний үндсэн дээр энэхүү судалгаанд дараах дөрвөн бодлогын зөвлөмжийг дэвшүүлж байна. Эдгээр зөвлөмж нь бодлогын тогтолцооны нийт үр ашиг, үр нөлөөг дээшлүүлж, ус цэвэршүүлэх технологийн инноваци болон хэрэглээг хурдасгах зорилготой.

1. Дээд түвшний төлөвлөлт, тогтолцооны уялдааг бэхжүүлж, хамтын засаглалын хүрээ бий болгох.

Монгол Улсын Засгийн газар ус цэвэршүүлэх технологийн хөгжлийн чиглэлийг тодорхойлсон, ирэх арван жилд хэрэгжүүлэх тэргүүлэх салбар, технологийн замын зураглал, шат дараалсан зорилтуудыг тусгасан “Ус Цэвэршүүлэх Технологийн Хөгжлийн Үндэсний Хөтөлбөр”-ийг боловсруулахыг санал болгож байна. Үүнээс чухал нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Боловсролын яам, Эдийн засаг, хөгжлийн яамны шийдвэр гаргагчид оролцсон, өндөр түвшний албан тушаалтнуудын удирдлага дор ажиллах Усны Технологийн Хөгжлийг Зохицуулах Хороог байгуулах шаардлагатай. Энэхүү хороо нь томоохон төслүүдийг болон төсөв, хөрөнгө оруулалтыг батлах бүрэн эрхтэй байх бөгөөд бодлогын чиглэлүүдийг нэг мөр болгох, байгуулдлагуудын хоорондын давхардсан чиг үүрэг болон зөрчилдөөнүүдийг шийдвэрлэх зохицуулалтын механизмыг бүрдүүлнэ. Ийнхүү одоогийн салангид, уялдаа хангалтгүй байгаа захиргааны нөөц бололцоог нэгтгэснээр бодлого төлөвлөлтийн тархай бутархай байдал, зохицуулалтын сул холбоос зэрэг асуудлыг үндсээр нь шийдвэрлэх боломжтой болно.

2. Санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахын тулд төсвийн хөрөнгө оруулалт болон шинэлэг санхүүжилтийн механизмыг оновчтой болгох.

Төсвийн санхүүжилтийн хувьд, жил бүрийн төсвийг хуульчлан баталгаажуулсан, тогтвортой бөгөөд ил тод ажиллагаатай “Усны технологи ба дэд бүтцийн сан” байгуулахыг санал болгож байна. Энэхүү сан нь Засгийн газрын хөрөнгө оруулалтын тасралтгүй байдал, урьдчилан тооцоолох боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Үүнтэй зэрэгцэн, санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэхийн тулд санхүүжилтийн шинэлэг загваруудыг нэн шаардлагатайгаар нэвтрүүлэх хэрэгтэй. Тухайлбал, усны цэвэрлэгээний төслүүдэд тохирсон төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварыг боловсруулж, Засгийн газрын баталгаа болон эрсдэлийг хуваалцах механизмаар дамжуулан хувийн хөрөнгийг татан оролцуулах нь зүйтэй. Мөн Монгол Улс ногоон усан хангамж, ариутгах татуурга (УХАТ)-ын бонд гарган, орлоготой усан хангамж болон бохир ус цэвэрлэх төслүүдэд өргөн хүрээний олон нийтийн хөрөнгийг татах боломжтой. Нэмж дурдахад, гүйцэтгэлд суурилсан татаасын механизм нэвтрүүлэхийг авч үзэж болно. Энэ нь бохир ус цэвэрлэх байгууламжийн бодит цэвэршүүлэлтийн чанар, үйл ажиллагааны үр ашигт үндэслэн татаас олгох бөгөөд ингэснээр зөвхөн барилгын өртгийг

дэмжихээс гадна технологийн шинэчлэл, үр ашигтай ажиллагааг урамшуулах давуу талтай.

3. Аж үйлдвэр, их сургууль, судалгаа-шинжилгээ болон хэрэглээний нэгдсэн уялдаа холбоог дэмжиж, технологийн инновац ба хамтын ажиллагааны сүлжээг бэхжүүлэх.

Судалгаа болон зах зээлийн хоорондын зөрүүг арилгахын тулд одоо хэрэгжиж буй шинжлэх ухаан, технологийн санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, "Усны технологийн хамтарсан инновацийн сан" байгуулахыг санал болгож байна. Сангийн төслүүдэд заавал аж ахуйн нэгж, судалгааны байгууллага, эцсийн хэрэглэгч оролцсон байх бөгөөд технологийн практик хэрэглээ, зах зээлийн төлөв нь үнэлгээний гол шалгуур болох ёстой. Мөн гол хотууд болон аж үйлдвэрийн паркуудад "Усны технологийн үзүүлэн болон аж үйлдвэржилтийн бүс" байгуулж, шинэ технологийг бодит орчинд турших нөхцөл болон туршилтын-үйлдвэрлэлийн орчин бүрдүүлснээр зах зээлд нэвтрүүлэхтэй холбоотой эрсдэл, зардлыг бууруулах боломжтой. Түүнчлэн улсын судалгааны байгууллагын эрдэмтэн, судлаачдыг аж ахуйн нэгжүүдтэй богино хугацааны солилцоо, хамтарсан судалгаа ба хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд оролцохыг дэмжиж, харин аж ахуйн нэгжийн техникийн ажилтнуудад их дээд сургуульд сургалт, чадавх бэхжүүлэх боломж олгох нь зүйтэй. Ийм хоёр талын шилжилт хөдөлгөөн нь мэдлэг, практик хэрэгцээ хоорондын урсгалыг сайжруулж, инновациас хэрэглээнд хүрэх цогц замналын үр нөлөөг нэмэгдүүлэх болно.

4. Хяналтын үр нөлөөг сайжруулж, олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн, нээлттэй бөгөөд инновацид ээлтэй орчныг бүрдүүлэх.

Хяналт, шалгалтын чиглэлд байгаль орчны мониторингийн тогтолцоонд хийж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, автомат хяналтын станцуудын хамрах хүрээг өргөжүүлэх, мөн зөрчил илрүүлэх болон нотлох баримт цуглуулах чадварыг сайжруулахын тулд их өгөгдөлд суурилсан зайнаас хяналтын технологи нэвтрүүлэхийг зөвлөж байна. Үүний зэрэгцээ, аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны гүйцэтгэлийн ил тод үнэлгээний тогтолцоог бий болгож, нийгмийн хяналт болон зах зээлийн нэр хүндийн механизмыг ашиглан аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны зохицуулалтыг дагаж мөрдөх дотоод сэдлийг бэхжүүлэх шаардлагатай. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс технологийг дан төслөөр импортлодог уламжлалт загвараас татгалзаж, "технологийн хамтын ажиллагаа + чадамжийн хөгжил" хосолсон илүү гүнзгий хэлбэрүүд рүү шилжих хэрэгтэй. Гадаадын дэвшилтэт

технологи, санхүүжилтийг нэвтрүүлэх үед технологи дамжуулалт, ажилтнуудын сургалт, нутгийн нөхцөлд нийцсэн дасан зохицох судалгаа-туршилт зэрэг гол заалтуудыг гэрээнд тусгах ёстой. Үүний зорилго нь технологи ашиглалт, засвар үйлчилгээ, судалгаа-хөгжил, менежментийн чадвартай дотоодын багуудыг бэлтгэж, технологийг "дамжуулан авах"-аас "шингээж эзэмших, өөриймшүүлж хөгжүүлэх, дахин шинэчлэх" шат руу шилжих боломжийг бүрдүүлэхэд оршино. Ингэснээр Монгол Улсад ус цэвэршүүлэх технологийн урт хугацааны хөгжилд шаардлагатай мэргэжилтэн, технологийн бат бөх үндэс суурийг тавих юм.

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Их Хур. (2020). Монгол Улсын "Урсгал 2050" хөгжлийн үзэл баримтлал. Улаанбаатар: МУИХ.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2021). *Үндэсний усны хөтөлбөр (2021-2030)*. Улаанбаатар: БОАЖ.

3. Монгол Улсын Их Хур. (2012). Усны тухай хууль. Улаанбаатар: МУИХ.

4. Монгол Улсын Их Хур. (2021). Байгаль орчны тухай хууль. Улаанбаатар: МУИХ.

5. Батмөнх, Д., & Төмөрбаатар, С. (2021). Монгол Улсын усны нөөцийн менежментийн сорилтууд. Байгаль орчин судлалын үйл явц, 25(3), 45-60.

6. Asian Development Bank (ADB). (2020). Mongolia: Urban Water and Wastewater Sector Assessment. Mandaluyong City, Philippines: Asian Development Bank.

7. World Bank. (2022). Mongolia - Strengthening Integrated Water Resource Management in Mongolia. Washington, DC: World Bank Group.

8. Government of Mongolia. (2019). Green Development Policy of Mongolia. Ulaanbaatar: Parliament of Mongolia.

9. JICA. (2023). Project for Improvement of Water Supply System in Ulaanbaatar City: Completion Report. Tokyo: Japan International Cooperation Agency.

10. Dore,J,&Yu, W. (2021). Water Security in Mongolia: Perspectives and Prospects. In A. B. Gupta & R. H. Moores (Eds.), Water Security and Sustainability (pp. 123-140). Springer, Cham.

RESEARCH ON THE POLICY SUPPORT SYSTEM FOR THE DEVELOPMENT OF WATER PURIFICATION TECHNOLOGY IN MONGOLIA

Abstract: With rapid industrialization and urbanization, alongside the intensifying impacts of climate change, Mongolia faces challenges related to water scarcity and water pollution. Developing water purification technologies has become a key policy direction for ensuring national water security and protecting public health. This article aims to systematically review, analyze, and evaluate the policies implemented by the Government of Mongolia to support the development of water purification technologies.

By examining national development policies, laws and regulations, sectoral guidelines, and economic incentive mechanisms, the study identifies the structure and characteristics of a policy framework grounded in multiple dimensions, including legal assurance, administrative governance, financial support, and technological innovation. The findings indicate that Mongolia has begun establishing an initial stage policy framework covering multiple levels, from goal-setting to the implementation of certain policy instruments. However, the system still faces challenges such as insufficient policy coherence, weak intersectoral coordination, and limited implementation efficiency. In particular, there is a need to strengthen the sustainability of financing, enhance mechanisms linking technological research to market adoption, and improve cross-sectoral collaboration.

This study provides theoretically and practically relevant recommendations for optimizing the policy environment for water purification technologies in Mongolia's water sector.

Keywords: Water Purification Technology; Policy Support System; Water Resources Management; Environmental Policy

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 83-94 дахь тал

ДЭД БҮТЦИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ БА УЛС ТӨРИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ

Э.Сувдаа
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй:

Энэхүү өгүүлэлд дэд бүтцийн тэгш бус байдал болон улс төрийн шийдвэр гаргалт, хүчин зүйлсийн харилцан уялдааг онолын түвшинд судалсан. Дэд бүтцийн хүртээмж, чанар, хөрөнгө оруулалт нь эдийн засгийн, нийгмийн, институтийн болон дижитал дэд бүтцийн хүрээнд бүс нутгийн хөгжлийн тэнцвэр, нийгмийн шударга ёс, төрийн чадавхтай нягт холбоотой болохыг онцолсон. Дэд бүтцийн тэгш бус байдал нь орон зайн, нийгмийн бүлгийн, чанарын ялгаа, хөрөнгө оруулалт ба бодлогын хэрэгжилтийн зөрүүгээр илэрч институтийн сул дорой байдал, эрх мэдлийн төвлөрөл, улс төрийн ашиг сонирхлоос шууд шалтгаалдаг. Улс төрийн шийдвэр гаргалт нь хөрөнгө оруулалтын чиглэл, хүртээмж, чанарт нөлөөлж, захын болон эмзэг бүс нутгийн боломжийг хязгаарлаж нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг үүсгэдэг. Дэд бүтцийн тэгш бус байдлыг зөвхөн эдийн засгийн үзэгдлийн хувьд бус, улс төр, институтийн орчин, бодлогын шийдвэр гаргалтын динамикт хамтад нь шинжлэх нь хөгжлийн тэнцвэрт байдлыг дэмжих онол, бодлогын чухал үндэс болохыг харуулж байна.

Түлхүүр үгс: дэд бүтэц, тэгш бус байдал, шийдвэр гаргалт, институтийн чадавх, бүс нутгийн ялгаа

Удиртгал:

Дэд бүтэц нь эдийн засаг, нийгэм, улс төрийн үйл ажиллагаа хэвийн хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлэгч биет болон институтийн системүүдийн нийлбэр (World Bank, 1994). Дэд бүтцийг үйлдвэрлэл, зах зээлийн солилцоог дэмжих нийтийн капитал хэмээн авч үздэг ба тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, усан хангамж зэрэг эдийн засгийн буюу биет дэд бүтцэд хамааруулж тайлбарладаг байв (Aschauer, D. A., 1989). Гэвч 1990-ээд оноос эхлэн хөгжлийн эдийн засаг болон улс төрийн эдийн засгийн онолуудад инфраструктур буюу дэд бүтцийн ойлголтыг илүү өргөн хүрээнд авч үзэх

хандлага давамгайлж хүний капитал болон нийгмийн сайн сайхан байдлыг дэмжих нийгмийн дэд бүтэц мөн эдийн засаг, улс төрийн харилцааг тогтвортой болгох институтийн дэд бүтэц гэсэн бүрэлдэхүүнээр авч үзэх болсон (North, D. C., 1990) (UNDP, 2019).

Иймд энэхүү өгүүлэлд эдийн засгийн буюу биет дэд бүтцээс гадна нийгмийн, институтийн, дижиталчлалын гэсэн олон улсад түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн хүрээгээр авч үзнэ. Дэд бүтцийг зөвхөн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих төдийгүй нийгмийн интеграци, төрийн чадавх, зах зээлийн институтийн үйл ажиллагааг хангах суурь систем гэж тодорхойлсон. Үүний зэрэгцээ институтийн эдийн засгийн онолд (North, D. C., 1990) зах зээлийн үр ашигтай ажиллагаа нь зөвхөн биет дэд бүтцээс бус түүнийг дэмжих дүрэм, байгууллага, хэрэгжилтийн механизмаас хамаарна гэдгийг онцолдог.

Дэд бүтцийн тэгш бус байдал нь хүртээмж, чанар, хөрөнгө оруулалтын хэмжээ орон зай, нийгмийн бүлэг, бүс нутгийн түвшинд жигд бус хуваарилагдсаныг илэрхийлнэ (Calderón, C., & Servén, L. , 2010). Неоклассик эдийн засгийн хандлагад энэхүү ялгааг үр ашиг, зах зээлийн эрэлт, өртгийн тооцоогоор тайлбарлахыг оролддог (Barro, R. J., 1990). Гэвч бодит нөхцөлд дэд бүтцийн байршил, хөрөнгө оруулалтын шийдвэр нь цэвэр эдийн засгийн логикоос гадна улс төрийн хүчин зүйлстэй нягт уялддаг. Улс төрийн эдийн засгийн онолд дэд бүтцийн тэгш бус байдал нь эрх мэдэл, ашиг сонирхлын зөрчил, институтийн бүтэцтэй шууд холбоотой хэмээн тайлбарлагддаг (Acemoglu, D., & Robinson, J. A. , 2012). Тухайлбал, улс төрийн төлөөлөл сул бүс нутагт дэд бүтцийн хөрөнгө оруулалт дутмаг байх хандлага ажиглагддаг нь тэгш бус байдлыг тогтвортой болгож улмаар бүс нутгийн хөгжлийн ялгааг гүнзгийрүүлдэг.

Дэд бүтцийн тэгш бус байдлыг тайлбарлах онолын суурь хандлагууд:

Дэд бүтцийн тэгш бус байдал (*infrastructure inequality*) нь бие даасан нэг нэртэй онол хэлбэрээр бүрэн институтжээгүй боловч бүс нутгийн хөгжил, улс төрийн эдийн засаг, институтийн онол, орон зайн шударга ёсны онолын хүрээнд онолын түвшинд судлагдсан ойлголт. Энэхүү ойлголт нь зам, эрчим хүч, ус хангамж, харилцаа холбоо, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанар, хөрөнгө оруулалт бүс нутаг, нийгмийн бүлэг, орон зайн хувьд жигд бус байгааг илэрхийлдэг (Estache, A., Foster, V., & Wodon, Q., 2002)

Бүс нутгийн тэгш бус хөгжлийн онол (Regional Inequality Theory / Uneven Development Theory)

Дэд бүтцийн тэгш бус байдлыг тайлбарлах онолын суурь нь бүс нутгийн тэгш бус хөгжлийн онол юм. Энэхүү онолын үндсэн санаа нь эдийн засгийн хөгжил орон зайд жигд тархдаггүй, харин тодорхой "төв" бүсүүдэд хуримтлагдан хөгждөгт оршино. Гуннар Мюрдал "хуримтлагдсан шалтгаант холбоо" (*Cumulative Causation*)-ны онолоороо хөгжлийн давуу байдал нь өөрөө өөрийгөө дахин бэхжүүлж, хөгжингүй бүс нутгууд илүү их хөрөнгө, дэд бүтцийг татах хандлагатайг тайлбарласан (Myrdal, G. , 1957).

Үүнтэй адилаар Альберт Хиршман "тэнцвэргүй өсөлт"-ийн онолоор (*Unbalanced Growth Theory*) хөгжиж буй орнуудад дэд бүтцийн хөрөнгө оруулалт эхний шатанд эдийн засгийн өгөөж өндөртэй салбар, бүс нутагт төвлөрөх нь зайлшгүй гэж үзсэн (Hirschman, A. O., 1958). Энэ нь төв болон захын бүс нутгийн дэд бүтцийн ялгааг гүнзгийрүүлэх онолын үндэслэл болдог.

Улс төрийн эдийн засгийн онол (Political Economy of Infrastructure)

Улс төрийн эдийн засгийн хандлага нь дэд бүтцийг техникийн асуудал бус, харин эрх мэдэл, ашиг сонирхол, улс төрийн шийдвэрийн үр дүн гэж үздэг. Харолд Лассвеллийн "хэн юу, хэзээ, яаж авдаг вэ?" (*who gets what, when, and how*) гэсэн сонгодог тодорхойлолт нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтын улс төрийн шинж чанарыг тайлбарлах онолын суурь болдог (Lasswell, H. D. , 1936).

Орчин үеийн судлаачид дэд бүтцийн шийдвэр гаргалт нь сонгуулийн мөчлөг, нөлөө бүхий бүлгүүдийн ашиг сонирхол, стратегийн бүс нутгийн ач холбогдолтой уялддаг болохыг онцолдог (Henisz, W. J., 2002). Иймээс дэд бүтцийн тэгш бус байдал нь зах зээлийн хүчин зүйлээс гадна улс төрийн сонголтын шууд үр дагавар гэж үзэх онолын үндэслэлтэй.

Төрийн чадавх ба институтийн онол (State Capacity and Institutional Theory)

Төрийн чадавх, институтийн онолын хүрээнд дэд бүтцийн тэгш бус байдал нь төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадавхтай нягт холбоотой гэж тайлбарлагддаг. Дуглас Норт институтийг "нийгмийн харилцааг зохицуулах албан ёсны болон албан бус дүрэм" хэмээн тодорхойлж, институтийн чанар нь эдийн засгийн болон нийгмийн үр дүнд шууд нөлөөлдөг болохыг онолын түвшинд нотолсон (North, D. C., 1990).

Сул институт, авлига, төсвийн хуваарилалтын ил тод бус байдал нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг тодорхой бүс нутагт төвлөрүүлж, бусдыг орхигдуулах нөхцөл бүрдүүлдэг (Acemoglu, D., & Robinson, J. A. , 2012) .

Иймээс дэд бүтцийн тэгш бус байдал нь институтийн сул дорой байдлын илрэл гэж үзэх боломжтой.

Орон зайн шударга ёсны онол (Spatial Justice / Infrastructure Justice)

Орон зайн шударга ёсны онол нь дэд бүтцийн тэгш бус байдлыг нийгмийн шударга ёсны хүрээнд авч үздэг харьцангуй шинэ хандлага юм. Анри Лефевр "орон зайн үйлдвэрлэл" (*The Production of Space*)-ээрээ орон зай нь улс төр, эдийн засгийн харилцааны үр дүн гэдгийг онолын хувьд дэвшүүлсэн (Lefebvre, H. , 1991). Үүнийг үргэлжлүүлэн Эдвард Сожа орон зайн шударга ёсыг нийгмийн шударга ёсны салшгүй бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлсон (Soja, E. W. , 2010).

Энэхүү онолын хүрээнд дэд бүтэц нь зөвхөн эдийн засгийн өсөлтийг дэмжих хэрэгсэл бус харин иргэдийн суурь эрхийг хангах механизм гэж үзэгддэг. Тиймээс дэд бүтцийн хүртээмжийн тэгш бус байдал нь тодорхой бүлгүүдийг системтэйгээр нийгмийн боломж, оролцооноос хасах шударга бус байдлыг бий болгодог.

Дэд бүтцийн үндсэн ангилал, хамаарах хүрээ:

Дэд бүтэц нь хөгжлийн гол хөдөлгөгч хүчний нэг бөгөөд эдийн засаг, нийгэм, улс төрийн салбаруудад нөлөөлдөг системтэй бүтэц юм (Calderón, C., & Servén, L. , 2010). Олон улсын судалгаанд дэд бүтцийг хэд хэдэн үндсэн ангиллаар авч үздэг. Үүнд эдийн засгийн буюу биет дэд бүтэц (зам, төмөр зам, цахилгаан хангамж), нийгмийн дэд бүтэц (эрүүл мэнд, боловсрол, усан хангамж) болон институтийн дэд бүтэц (засаглал, хууль эрх зүйн орчин, төрийн үйлчилгээ), дижиталчлалын буюу мэдээллийн дэд бүтэц (World Bank, 1994) (UNDP, 2019). Энэхүү ангилал нь дэд бүтцийн чанар, хүртээмжийн тэгш бус байдлыг судлахад суурь хүрээ болдог.

Хүснэгт 1: Дэд бүтцийн ангилал

Үндсэн ангилал	**Гол ойлголт**	**Хамаарах хүрээ**	**Сэтгэгчид**
Эдийн засгийн дэд бүтэц *(Economic Infrastructure)*	Зах зээлийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, эрчим хүчний тогтвортой байдлыг хангадаг физик болон логистик бүтэц.	-Тээврийн дэд бүтэц (зам, төмөр зам, боомт) -Эрчим хүчний дэд бүтэц (цахилгаан, хийн хоолой) -Логистик төвүүд	John Meyer, John Kain, Michael Porter

Нийгмийн дэд бүтэц *(Social Infrastructure)*	Хүмүүнлэг, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмж, амьдралын чанарыг дэмждэг бүтэц.	-Эрүүл мэндийн дэд бүтэц (эмнэлэг, эмийн сүлжээ) -Боловсролын дэд бүтэц (сургууль, их сургууль) -Нийгмийн үйлчилгээний төвүүд	Amartya Sen
Институтийн дэд бүтэц *(Institutional Infrastructure)*	Улс төр, хууль эрх зүй, засаглал, тогтвортой хөгжлийн институтийн бүтэц.	-Засаглалын бүтэц -Хууль эрх зүйн тогтолцоо -Татвар, санхүүгийн институтүүд	Douglass North
Дижиталчлалын /мэдээллийн дэд бүтэц/ *(Digital ICT Infrastructure)*	Мэдээлэл, технологи, дижитал сүлжээний хүртээмж, инновацын дэмжлэгийг хангадаг бүтэц.	-Мэдээллийн технологи (Интернэт, дата төв) -Харилцаа холбоо (утас, сүлжээ) -Цахим засаглал	Manuel Castells

Эх сурвалж: (Meyer, J. R., & Kain, J. F. , 1962) (Porter, M. E. , 1990) (Sen, A. , 1999) (North, D. C., 1990) (Castells, M. , 1996)

Энэ ангилал нь:

- Эдийн засгийн дэд бүтэц нь биет болон логистик суурийг хангана.
- Нийгмийн дэд бүтэц нь илүү хүн төвтэй хөгжлийг дэмждэг.
- Институтийн дэд бүтэц нь тогтвортой засаглал, хууль эрх зүйг баталгаажуулна.
- Дижиталчлалын дэд бүтэц нь мэдээллийн хүртээмж, инновац, технологийн хөгжилд гол үүрэгтэй.

Дэд бүтцийн хөгжил нь зөвхөн эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх бус нийгмийн тэгш байдал, улс төрийн тогтвортой байдалд ч шууд хамааралтай гэж үздэг (Acemoglu, D., & Robinson, J. A. , 2012). Дэд бүтцийн хүртээмжийн тэгш бус байдал нь ихэвчлэн институтийн сул бүтэц, улс төрийн шийдвэр гаргалтын доголдол, санхүүжилтийн төвлөрөл зэрэг хүчин зүйлстэй холбогддог. Дэд бүтэц нь нийтлэг, олон талт систем бөгөөд эдийн засаг, нийгэм, институт, технологийн хөгжлийг уялдуулж улс орны тогтвортой өсөлт, нийгмийн хөгжилд суурь үүрэг гүйцэтгэдэг.

Дэд бүтцийн тэгш бус байдлын илрэх хэлбэр ба хэмжих үзүүлэлтүүд:

Дэд бүтцийн тэгш бус байдал нь зөвхөн биет байгууламж, тоног төхөөрөмжийн байршлаар хэмжигдэхгүй бөгөөд хүртээмж, чанар, хөрөнгө оруулалт болон бодлогын хэрэгжилтийн ялгаатай байдлаар илэрдэг цогц үзэгдэл юм (Estache, A., & Garsous, G. , 2012). Тэгш бус байдлыг илрэх хэлбэрээр нь ангилж үзэх нь чухал бөгөөд энэ нь дэд бүтцийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг системтэйгээр ойлгох үндэс болдог.

Хүснэгт 2: Тэгш бус байдлын илрэх хэлбэр, хэмжих үзүүлэлтүүд

Илрэх хэлбэр	Хэмжих үзүүлэлт
Орон зайн тэгш бус байдал Дэд бүтцийн хүртээмж төв-зах, хот-хөдөө, бүс нутгийн хооронд жигд бус байгаагаар илэрдэг. Төв бүсэд төвлөрсөн дэд бүтэц захын бүсэд хүртээмж багатай гэх мэт.	➢ Дэд бүтцийн сүлжээний нягтаршил (зам, цахилгаан дамжуулах сүлжээний урт) ➢ Үйлчилгээний хүртээмжийн зай, тээвэрлэх хугацаа ➢ Хот-хөдөө болон бүс нутгийн харьцуулсан индекс
Нийгмийн бүлгийн тэгш бус байдал Дэд бүтцийн хүртээмж орлого, боловсрол, нийгмийн статусын ялгаатай бүлгүүдийн хооронд өөр өөр байдаг. Энэ нь иргэдийн амьдралын чанар, боломжид шууд нөлөөлдөг.	➢ Орлогын бүлэг тус бүрийн хүртээмж ➢ Үйлчилгээний чанарын ялгаа (сургууль, эмнэлэг...) ➢ Харьцуулсан хүртээмжийн индекс
Чанарын тэгш бус байдал Дэд бүтцийн үйлчилгээ хүртээмжтэй мэт боловч чанар, найдвартай байдал нь бүс нутгийн болон нийгмийн бүлгүүдийн хооронд ялгаатай байж болно.	➢ Үйлчилгээ тасалдах давтамж ➢ Эрчим хүч, ус, интернэтийн найдвартай байдал ➢ Хэрэглэгчийн сэтгэл ханамж
Хөрөнгө оруулалт ба бодлогын хэрэгжилтийн ялгаа Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төсөв, бодлогын хэрэгжилт институтийн чадавх, улс төрийн хүчин зүйлсээс хамааран тэгш бус байдлыг үүсгэдэг.	➢ Нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ ➢ Төсвийн хуваарилалтын бүс нутгийн ялгаа ➢ Төслийн хэрэгжилтийн үр ашгийн үзүүлэлт

Эх сурвалж: (Soja, E. W. , 2010) (Estache, A., Foster, V., & Wodon, Q., 2002) (North, D. C., 1990) (Rondinelli, D. A. , 1983) (World Bank, 1994)

Улс төрийн шийдвэр гаргалт ба дэд бүтцийн бодлого:

Дэд бүтцийн хүртээмж ба чанарт нөлөөлдөг томоохон хүчин зүйлсийн нэг нь улс төрийн шийдвэр гаргалт бөгөөд энэ нь дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төсөв, стратегийн бодлого, хэрэгжилтийн процессоор илэрдэг. Улс төрийн орчин, институтийн чадавх, эрх мэдлийн төвлөрөл нь хөрөнгө оруулалтын чиглэл, хүртээмж, чанарыг тодорхойлдог бөгөөд улмаар дэд бүтцийн тэгш бус байдлыг бий болгодог.

Улс төрийн шийдвэр гаргалт нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг зөвхөн эдийн засгийн шаардлагад үндэслэн бус, улс төрийн ашиг сонирхол, эрх мэдлийн төвлөрөл, сонгуулийн мөчлөг зэрэг хүчин зүйлстэй уялдан шийдэгддэг (Keefer, P., & Khemani, S. , 2005). Жишээлбэл, эрх мэдэл төвлөрсөн орнуудад хөрөнгө оруулалт төв, нийслэл хот руу төвлөрөх хандлагатай байдаг бол алслагдсан бүс нутгийн хүртээмж буурч тэгш бус байдал тогтдог. Иймд улс төрийн ашиг сонирхол нь дэд бүтцийн хүртээмжийг тодорхойлох гол механизм болдог.

Институтийн тогтвортой байдал, засаглалын чадавх нь дэд бүтцийн бодлогын үр нөлөөг тодорхойлдог. Хүчтэй институттэй орнуудад хөрөнгө оруулалт илүү тэгш хуваарилагдаж, дэд бүтцийн хүртээмжийн ялгаа харьцангуй бага байдаг. Харин сул институтийн орчинтой улс орнуудад улс төрийн ашиг сонирхол давамгайлах, хөрөнгө оруулалтын шийдвэр улс төрийн эрэлтэд нийцсэн байдлаар төвлөрөх, дэд бүтцийн хүртээмжийн тэгш бус байдал тогтворжих эрсдэлтэй.

Дэд бүтцийн бодлого, төсөв, хөрөнгө оруулалтын шийдвэрийн улс төрийн нөлөө нь тэгш бус байдлын механизмд шууд нөлөөлдөг. Бодлого батлах, хэрэгжүүлэх явцад эрх мэдлийн төвлөрөл, сонгуулийн дараах эрэлт, эрх мэдэлтний ашиг сонирхол хөрөнгө оруулалтын чиглэл, хүртээмжийг тодорхойлдог. Үүний үр дүнд дэд бүтцийн төвлөрөл, чанарын ялгаа, орон нутгийн хүртээмжийн зөрүү үүсдэг (Rondinelli, D. A. , 1983).

Энэхүү уялдаа нь зөвхөн эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахын тулд дэд бүтцийн бодлого боловсруулдаггүйг харуулж байна. Харин улс төрийн хүчин зүйлс дэд бүтцийн хүртээмж, чанар, бүс нутгийн ялгааг тодорхойлж, тэгш бус байдлыг тогтворжуулах гол хүчин зүйл болдог. Иймд улс төрийн шийдвэр гаргалт ба дэд бүтцийн бодлогын уялдаа нь дэд бүтцийн тэгш бус байдлыг системтэй ойлгох онолын суурь, бодлогын дүн шинжилгээ хийх үндэс болдог (Estache, A., & Fay, M., 2007)

Улс төрийн хүчин зүйлс ба дэд бүтцийн тэгш бус байдлын уялдаа:

Дэд бүтцийн тэгш бус байдал нь өргөн цар хүрээтэй улс төр-эдийн засгийн үр дүнгийн нэг хэлбэр бөгөөд хөрөнгө оруулалтын шийдвэр, институтийн орчин, эрх мэдлийн хуваарилалт зэрэг улс төрийн хүчин зүйлстэй нягт холбогддог (Moszoro, Araya, Ruiz-Nuñez & Schwartz, 2014; Wiechman, Anderies & Garcia, 2025). Улс төрийн шийдвэр гаргалт нь дэд бүтцийн төсөв, бодлого, стратегийн төлөвлөлтийг тодорхойлдог чухал механизм бөгөөд энэ нь улс төрийн хүрээнд эрх мэдэл, ашиг сонирхлын төвлөрөл, сонгууль, намын бодлогын чиглэлээр тодорхойлогддог.

Улс төрийн хүчин зүйлүүдийн дэд бүтцийн бодлогод үзүүлэх нөлөө нь хэд хэдэн механизмаар илэрдэг.

Нэгдүгээрт: Эрх мэдлийн төвлөрөл, нь хөрөнгө оруулалтын сонголтыг тодорхойлж, төв болон томоохон хотууд руу төсөв илүү төвлөрөх нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь алслагдсан, захын бүс нутгийн хүртээмж буурахад хүргэнэ (Moszoro et al., 2014). Үүнийг улс төрийн эдийн засгийн загварууд илэрхийлэн харуулдаг тул зарим судалгаанд дэд бүтцийн тэгш бус байдал нь улс төрийн процесс, ялангуяа тухайн орны засаглалын бүтэц, шийдвэр гаргалтын тогтолцоотой салшгүй холбоотой гэж үздэг (Wiechman et al., 2025).

Хоёрдугаарт: Институтийн хүчин зүйлс, нь дэд бүтцийн төсөл, хөрөнгө оруулалтын шийдвэрийг хэрэгжилтэд шилжүүлэх чадварт нөлөөлдөг. OECD-ийн тайлангаар институт, засаглал, улс төрийн тогтвортой байдал нь хувийн болон төрийн дэд бүтцийн оролцоог тодорхойлох чухал хүчин зүйлсийн нэг гэж тэмдэглэсэн бөгөөд эдгээр хүчин зүйлс сул байх тохиолдолд хөрөнгө оруулалтын шийдвэр төсвийн тэгш бус хуваарилалт, хүртээмжийн ялгааг нэмэгдүүлдэг (Moszoro, M., Araya, G., Ruiz-Nuñez, F., & Schwartz, J. , 2014).

Гуравдугаарт: Политик динамик, буюу улс төрийн оролцоо, сонгуулийн цикл зэрэг нь хөрөнгө оруулалтын чиг шугам, бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлдог. Жишээлбэл, шинэ бүтээн байгуулалтын төслүүд нь олон нийтэд илүү харагдахуйц, богино хугацаанд ашиг хүртээх боломжтой бүсүүдэд төвлөрөх хандлагатай байдаг бөгөөд энэ нь улс төрчдийг саналыг татах нөхцөл болдог. Ийм явцад захын, алслагдсан буюу нийгмийн хувьд эмзэг бүлгүүдийн дэд бүтцэд хүртэх боломж хойшлогддог. Үүний үр дүнд дэд бүтцийн тэгш бус байдал улс төрийн шийдвэрийн шууд үр дагавар болж хувирдаг (Wiechman, A., Anderies, J. M., & Garcia, M. , 2025).

Эдгээр улс төрийн хүчин зүйлсийн үр дүнд дэд бүтцийн хүртээмж, чанарын ялгаа улс орны бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, нийгмийн болон эдийн засгийн боломжуудын ялгааг улам өргөжүүлдэг.

Иймээс дэд бүтцийн тэгш бус байдлыг судлахдаа зөвхөн эдийн засгийн үзэгдлийн хувьд авч үзэхгүй, харин улс төрийн байгууллага, засаглалын тогтолцоо, институтийн чадавх, шийдвэр гаргалтын динамикийг нарийвчлан шинжлэх нь ач холбогдолтой байна.

ДҮГНЭЛТ

Дэд бүтцийн тэгш бус байдал нь зөвхөн эдийн засгийн үзэгдэл төдийгүй улс төр, институтийн орчин, нийгмийн бүтэцтэй салшгүй холбоотой цогц феномен бөгөөд дэд бүтцийн хүртээмж, чанар, хөрөнгө оруулалт нь эдийн засгийн, нийгмийн, институтийн болон дижитал дэд бүтцийн хүрээнд бүс нутгийн хөгжлийн тэнцвэр, нийгмийн шударга ёс, төрийн чадавхтай шууд уялддаг байна. Дэд бүтцийн тэгш бус байдал нь орон зайн ялгаа, нийгмийн бүлгийн боломж, үйлчилгээний чанарын ялгаа, хөрөнгө оруулалт болон бодлогын хэрэгжилтийн зөрүүгээр илэрч, институтийн сул дорой байдал, эрх мэдлийн төвлөрөл, улс төрийн ашиг сонирхлын шууд үр дагавар болдог.

Улс төрийн шийдвэр гаргалт нь хөрөнгө оруулалтын чиглэл, хүртээмж, чанарт нөлөөлж, эмзэг болон захын бүс нутгийн боломжийг хязгаарлах замаар нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг тогтворжуулдаг. Иймд дэд бүтцийн тэгш бус байдлыг зөвхөн эдийн засгийн үзэгдлийн хэмжүүрээр бус, улс төрийн институтийн бүтэц, бодлогын шийдвэр гаргалтын динамиктай хамт судлах шаардлагатай. Энэ хандлага нь бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг дэмжих, нийгмийн шударга ёс, төрийн чадавхыг сайжруулах онол, бодлогын үндэс суурийг бүрдүүлдэг.

Улс төрийн институтийн чанар, бодлогын хэрэгжилт, эрх мэдлийн төвлөрөл зэрэг хүчин зүйлс нь дэд бүтцийн хүртээмж, чанарын ялгаанд нөлөөлдөг тул хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд эдгээр хүчин зүйлсийг системтэйгээр харгалзан үзэх нь чухал. Иймд дэд бүтцийн тэгш бус байдлыг судлах нь зөвхөн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх төдийгүй нийгмийн шударга ёс, төрийн чадавх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах бодлогын үндэс суурь болдог бөгөөд улс орны урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжих чухал стратеги болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

A, B. (1996). *Intellectual Capital: Core Asset for the Third Millennium Enterprise.* London: International Thomson Business press.

Acemoglu, D., & Robinson, J. A. . (2012). *Why nations fail: The origins of power, prosperity, and poverty.* Crown Publishing.

Andersen P, &. P. (1993). A procedure for ranking efficient units in data envelopment analysis. . *Manag Sci*, 1261–1264.

Aschauer, D. A. (1989). Is public expenditure productive? . *Monetary Economics*, 177-200.

Asoh, H. &. (1994). On the mean convergence time of evolutionary algorithms without selection and mutation. *Lecture Notes in Computer Science*, 98–107.

Asparouhov, T., Hamaker, E. L., & Muthén, B. (2018). Dynamic structural equation models. . *Structural Equation Modeling*, 359-388.

Barro, R. J. (1990). Government spending in a simple model of endogenous growth . *Political Economy*, 103-125.

Calderón, C., & Servén, L. . (2010). nfrastructure and economic development in Sub-Saharan Africa. . *Journal of African Economies*, 13-87.

Castells, M. . (1996). *The rise of the network society.* . Blackwell.

Estache, A., & Fay, M. (2007). Current debates on infrastructure policy. *World Bank Policy Research Working* , No 4410.

Estache, A., & Garsous, G. . (2012). The impact of infrastructure on growth in developing countries. *World Bank.* , Paper No. 6051 .

Estache, A., Foster, V., & Wodon, Q. (2002). *Infrastructure reform and poverty reduction in Africa.* . World Bank.

Garvin, D.A. . (1993). Building a Learning Organization. . *Harvard Business Review*, 78-91.

Henisz, W. J. (2002). The institutional environment for infrastructure investment. *Industrial and Corporate Change*, 355-389.

Hirschman, A. O. (1958). *The strategy of economic developmen.* Yale University Press.

Keefer, P., & Khemani, S. . (2005). Democracy, public expenditures, and the poor: Understanding political incentives for providing public services. *The World Bank Research Observer*, 1-27.

Lasswell, H. D. . (1936). *Politics: Who gets what, when, how.* McGraw-Hill.

Lefebvre, H. . (1991). *The production of space.* Blackwell.

Lyu H, Z. Z. (2016). Measuring knowledge management performance in organizations: an integrative framework of balanced scorecard and fuzzy evaluation. *Inf.Man*, 11-21.

Meyer, J. R., & Kain, J. F. . (1962). *The urban transportation problem.* Harvard University Press.

Moszoro, M., Araya, G., Ruiz-Nuñez, F., & Schwartz, J. . (2014). *Institutional and political determinants of private participation in infrastructure.* OECD Publishing.

Myrdal, G. . (1957). *Economic theory and under-developed regions.* Duckworth.

North, D. C. (1990). *institutional change and economic performance.* Cambridge University Press.

Peter F. Drucker. (1998). *Managing in a Time of Great Change.* New York: Plume.

Porter, M. E. . (1990). *The competitive advantage of nations.* Free Press.

R.S. Kaplan, D. N. (1992). The balanced scorecard measures that drive performance. *Harvard Business Review*, 71-80.

Rondinelli, D. A. . (1983). *Development projects as policy experiments: An adaptive approach to development administration.* Routledge.

Sen, A. . (1999). *Development as freedom.* Oxford University Press.

Soja, E. W. . (2010). *Seeking spatial justice.* University of Minnesota Press.

Sterman, John. (2000). *Business Dynamics: Systems Thinking and Modeling for a Complex World with CD-ROM.* New York: McGraw-Hill/Irwin.

Sveiby.K.E. (1998). Intellectual Capital: Thinking Ahead, Australian CPA.

UNDP. (2019). *Human development report 2019: Beyond income, beyond averages, beyond today.* United Nations Development Programme.

Wiechman, A., Anderies, J. M., & Garcia, M. . (2025). *Politics, inequality, and the robustness of shared infrastructure systems.* Preprint.

World Bank. (1994). *World development report 1994: Infrastructure for development.* World Bank.

INFRASTRUCTURE INEQUALITY AND POLITICAL DECISION-MAKING

Absract: This article examines infrastructure inequality and the interrelation between political decision-making and influencing factors from a theoretical perspective. It emphasizes that the accessibility, quality, and investment in infrastructure spanning economic, social, institutional, and digital dimensions are closely linked to regional development balance, social justice, and state capacity. Infrastructure inequality manifests through spatial, social group, and quality disparities, as well as differences in investment and policy implementation, and is directly influenced by weak institutions, the concentration of power, and political interests. Political decision-making affects the direction, accessibility, and quality of infrastructure investment, limiting opportunities in peripheral and vulnerable regions and generating socio-economic disparities. Analyzing infrastructure inequality not only as an economic phenomenon but also in conjunction with political context, institutional environment, and policy decision-making dynamics provides a critical theoretical and policy foundation for promoting balanced development.

Key words: Infrastructure, Inequality, Decision-making, Institutional Capacity Regional Disparities

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 95-112 дахь тал

МЕГА ТӨСЛИЙГ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛД ТУЛГУУРЛАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ч.Баатар
Удирдлагын академи, Улсын
салбарын удирдлагын тэнхимийн Ахлах багш, Магистр

Хураангуй:

Мега төслүүдийг хэрэгжүүлэх нь тухайн улсын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хурдасгах, үйлдвэрлэл, экспортын шинэ салбар бий болгох, технологи дамжуулах, хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлэх, бүс нутгийн интеграцийг гүнзгийрүүлэх зэрэг олон талын үр өгөөжтэй бөгөөд дэд бүтцийн чанар, логистик, эрчим хүчний найдвартай байдлыг сайжруулж улсын өрсөлдөх чадварыг бодитоор нэмэгдүүлдэг байна. Оксфордын их сургуулийн профессор Бент Флювбьергийн тодорхойлсноор нь ихэвчлэн нэг тэрбум ам.доллараас дээш өртөгтэй, олон жил үргэлжилдэг, улс орны хөгжлийн бодлоготой нягт уялдсан бүтээн байгуулалтын төслүүдийг мега гэсэн ангилалд оруулдаг. Ийм төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд төрийн бодлогын тогтвортой байдал, эрх зүйн шинэчлэл, ил тод байдал, ур чадвартай хүний нөөц, оролцогч талуудын харилцан уялдаа чухал байдаг. Энэхүү шаардлагыг хангахын тулд мега төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг бөгөөд энэ нь санхүүжилтийн дарамтыг бууруулах, эрсдэлийг оновчтой хуваарилах, менежмент болон технологийн давуу талыг хувийн хэвшлээс ашиглах боломжийг олгодог. Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүч, уул уурхай, төмөр зам, хот байгуулалт, ус хангамж, аж үйлдвэржилтийн чиглэлд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд хууль эрх зүйн орчин, засаглалын уялдаа, төсөл сонгон шалгаруулалтын ил тод байдал, мэргэшсэн хүний нөөцийн хомсдолыг даван туулах шаардлага үүсээд байгаа бөгөөд эдгээр сорилтуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан амжилттай даван туулах боломжтой юм. Энэхүү өгүүллийн хүрээнд мега төслийг төр,

хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг онол, арга зүйн талаас нь авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Засгийн газар; Хувийн хэвшил; хөрөнгө оруулалт, эрсдэлийг оновчтой хуваарилах; бүтээн байгуулалт; менежмент; технологи шилжүүлэх.

Оршил

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт (legalinfo.mn, 2025) тусгагдсан бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн үндсэн дөрвөн бодлогын хүрээнд 16 чиглэлийн 620 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд сүүлийн 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын шинэчлэлийг цаг алдалгүй эхлүүлж дотоодын үйлдвэрлэлийг зохистой түвшинд хүргэх, аж үйлдвэржилтийг нэмэгдүүлэх, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх 14 мега төслийг багтаажээ.

Эдгээр нь “Гашуунсухайт - Ганцмод”, “Ханги - Мандал”, “Шивээхүрэн - Сэхээ” хилийн боомтуудын хил дамнасан холболтын хийгээд Эрээнцав - Чойбалсан -Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам, Тавантолгойн дулааны цахилгаан станц, Эгийн гол болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх, Хэрлэн - Тоонот, Орхон - Онги ус дамжуулах хоолой, нүүрс-хими, кокс-хими, зэс, ган боловсруулах цогцолбор, Монгол, Францын хамтарсан ураны уурхай болон газрын тос боловсруулах, алт цэвэршүүлэх үйлдвэр, үндэсний хиймэл дагуулын төсөл зэрэг юм.

Мега төсөл бол зөвхөн дэд бүтэц, барилга байгууламжын бүтээн байгуулалт биш улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн илэрхийлэл болдог бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд зөвхөн инженерийн шийдэл хангалтгүй бөгөөд улс төр, эдийн засаг, нийгмийн орчны нарийн уялдааг хослуулсан менежмент, хариуцлагын тогтолцоог шаарддаг. Иймд Монгол Улсад тухайн мега төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бодлого, эрх зүйн шинэчлэл хийх, гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, ил тод байдлыг хангах, олон талт оролцогчдыг тэнцвэртэй хамруулахын тулд тухайн төслүүдийг хэрэгжүүлэхэд ашиглах оновчтой арга замыг судлах шаардлага үүсээд байгаа юм.

Нэг. Мега төслийн ач холбогдол, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх үйл явц

Мега төсөл нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг, олон оролцогчтой, урт хугацаатай, хэрэгжилт нь ихэвчлэн тодорхойгүй орчинтой байдаг тул түүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд институцийн болон эдийн засгийн онолын суурь ойлголт зайлшгүй шаардлагатай бөгөөд шинэ институцийн онол (New institutional theory), гэрээний онол (Contract theory), эрсдэлийн хуваарилалтын онол (Risk allocation theory), нийгмийн өгөөжийн онол (Social return theory) нь мега төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд чухал үүрэг гүйцэтгэдэг юм.

Шинэ институцийн онол нь мега төслийг хэрэгжүүлэх орчныг тодорхойлж, хууль эрх зүй, дүрэм журам, төрийн байгууллагын чадавхи, итгэлцэл зэрэг институцийн хүчин зүйлс эдийн засгийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлдөгийг тайлбарладаг. Тогтвортой, ил тод институцийн орчин бүрдээгүй нөхцөлд гүйлгээний зардал өсөж, хөрөнгө оруулалтын эрсдэл нэмэгддэг бол харин сайн институци нь мега төслийн урт хугацааны амжилтын суурь нь болдог байна (North, 1990). Харин гэрээний онол нь мега төслийн оролцогч талуудын хоорондын эрх, үүрэг, урамшууллыг хэрхэн зохион байгуулахыг тайлбарладаг. Мега төсөлд ирээдүйн бүх нөхцөлийг урьдчилан тодорхойлох боломжгүй тул бүрэн бус гэрээ зонхилдог бөгөөд энэ нь мэдээллийн тэгш бус байдал, ашиг сонирхлын зөрчлийг үүсгэнэ. Иймээс гүйцэтгэлд суурилсан урамшуулал, уян хатан нөхцөлтэй гэрээ нь төслийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг байна (Hart, 1987). Түүнчлэн эрсдэлийн хуваарилалтын онол нь мега төслийн санхүүгийн, техникийн, зах зээлийн болон улс төрийн эрсдэлийг аль тал хамгийн сайн удирдаж чадах вэ? гэдэг зарчмаар хуваарилах ёстойг чухалчилдаг. Эрсдэлийг нэг талд төвлөрүүлэх нь төслийн бүтэлгүйтэх магадлалыг нэмэгдүүлдэг бол оновчтой хуваарилалт нь зардлыг бууруулж, төслийн тогтвортой байдлыг хангадаг гэж үздэг (Arrow, 1971). Мөн нийгмийн өгөөжийн онол нь мега төслийг зөвхөн санхүүгийн ашигтай эсэхээр бус, нийгэмд үзүүлэх нийт өгөөжөөр нь үнэлэх шаардлагыг тодорхойлдог. Үүнд эдийн засгийн өсөлт, ажлын байр, дэд бүтэц зэрэг эерэг нөлөөний зэрэгцээ байгаль орчин, нийгмийн тэгш байдалд үзүүлэх сөрөг нөлөөг хамтад нь авч үздэг. Ийм үнэлгээ нь олон нийтийн сайн сайхныг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын шийдвэр гаргах үндэслэл нь болдог байна (Boardman, 2018).

Эндээс үзэхэд шинэ институцийн онол нь мега төслийн суурь орчныг тодорхойлж, гэрээний онол нь оролцогчдын харилцааг зохицуулж, эрсдэлийн хуваарилалтын онол нь тодорхойгүй байдлыг удирдах арга замыг санал

болгож, нийгмийн өгөөжийн онол нь төслийн эцсийн зорилго болох нийгмийн сайн сайхныг хэмжих онолын үндэс нь болдог.

Оксфордын их сургуулийн профессор Бент Флювбьерг өөрийн судалгаандаа мега төслүүд нь ихэвчлэн тухайн улсын эдийн засгийн өсөлтийг дэмжин дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд мэдэгдэхүйци хувь нэмэр оруулдаг бөгөөд үүний нийгэм, эдийн засгийн нөлөө нь урт хугацааны бүтээмжийн өсөлт, бүс нутгийн интеграц, технологийн хуримтлал зэргээр илэрдэг гэж үзсэн (Flyvbjerg, 2014). Ялангуяа дэд бүтэц, эрчим хүч болон логистикийн томоохон төслүүд нь зах зээлийн үр ашигтай байдлыг сайжруулж, нийлүүлэлтийн зардлыг бууруулснаар эдийн засгийн системийн бүх түвшинд дам нөлөө үзүүлдэг (Ansar, 2016). Үүний зэрэгцээ мега төслүүд нь институцийн чадавхийг нэмэгдүүлэх чухал механизм бөгөөд том хэмжээний хөрөнгө оруулалт, олон талт оролцогчдын хамтын ажиллагааг удирдах замаар засаглал, удирдлагын шинэлэг аргачлалуудыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлдэг (Locatelli G. M., 2017). Ийм төрлийн төслүүдийн хэрэгжилт нь зөвхөн эдийн засгийн өсөлтийг дэмжих бус, харин стратегийн технологи дамжуулах, хүний нөөцийн үр чадварын хуримтлалыг нэмэгдүүлэх, улс орны институцийн тогтолцоог бэхжүүлэх олон талын ашигтай (Merrow, 2011). Түүнчлэн, мега төслийн нийгмийн үр нөлөө нь бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг бий болгох байдлаар илэрдэг гэж судлаачид дүгнэдэг (Bentley, C., Zhou, Z, 2017).

Мега төслүүд нь ихэвчлэн үйлдвэрлэл, дэд бүтцийн томоохон цар хүрээтэй, их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүд байдаг учраас тухайн улсын эдийн засгийн өсөлтийг дэмжин бүтцийн өөрчлөлтийн чухал хөдөлгөгч хүч болдог. Аливаа улс орон нь бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн шинэ салбаруудын хөгжүүлэх, дэд бүтцийнхээ чанар, хүртээжийг нэмэгдүүлэхэд зориулан их хэмжээний хөрөнгө оруулалт хийх нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэн, шинжлэх ухаан, технологийн хөгжлийг урагшлуулж, зах зээлийн боломжийг нь улам өргөтгөх нь дамжигггүй юм. Ялангуяа эдийн засгийн бүтэц өөрчлөгдөх нь улс орны эдийн засгийг илүү үр ашигтай, тогтвортой болгодог.

Мөн мега төслүүд нь үндэсний капиталын шингээлтийн чадавхыг нэмэгдүүлэх замаар дэд бүтэц, хүний нөөц, төрийн институцийн чадавхийг сайжруулж, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн түвшин болон эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах стратегийн чухал хэрэгсэл болдог байна (Lin, 2020).

Мега төслийг хэрэгжүүлэх нь макро түвшний хөрөнгө оруулалтын хэлбэр бөгөөд эдийн засгийн бүтцийг шинэчлэж, шинжлэх ухаан, технологи хөгжүүлэлтийн чадавхийг нэмэгдүүлснээр энэ нь үйлдвэрлэлийн өртөгийг бууруулан үндэсний өрсөлдөх чадварыг системтэйгээр бэхжүүлдэг. Улс орнуудын өрсөлдөх чадвар нь дэд бүтэц, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл явц, логистикийн үр ашиг, төрийн институтийн чадавхи зэргээс шууд хамааралтай байдаг бөгөөд том хэмжээний мега төслийг хэрэгжүүлэх эдгээрт маш их эерэг нөлөө үзүүлдэг. Үүний нэг нотолгоо нь Дэлхий эдийн засгийн форумаас 2023 онд гаргасан “Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварын тайлан”-г дэд бүтэц, эрчим хүчний найдвартай байдал, логистик зэрэг нь өрсөлдөх чадварын индексийн гол үзүүлэлт гэж тогтоосон явдал юм (WEF, 2023). Түүнчлэн дэд бүтцийн томоохон төслүүд нь улс орны бүс нутгийн интеграцийг өргөжүүлэн үйлдвэрлэл болон экспортыг нэмэгдүүлснээр зах зээлийн эрсдэлийг бууруулах ба уян хатан байдлыг ч нэмэгдүүлдэг. Дэд бүтцийн чанар, хүрээмж сайжрах нь тухайн улсын хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг бууруулж, логистикийн үр өгөөжийг дээшлүүлэн, үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөн олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг байна. Үүнээс гадна мега төслүүд нь шинэ технологийн шилжүүлэлт, мэдлэгийн хуримтлал, инновацийн орчныг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд “Инновацид суурилсан өрсөлдөх чадвар (innovation-based competitiveness)”-ыг хөгжүүлэх суурь хүчин зүйлсийн нэг болдог (Aghion, 2009). Иймээс мега төслүүдийг хэрэгжүүлэх нь улс орны үйлдвэрлэлийн үр ашиг, логистикийн интеграци, хүний капиталын хөгжил, технологийн шинэчлэл зэрэг өрсөлдөх чадварыг тодорхойлогч хүчин зүйлсийг цогцоор нь сайжруулах чухал стратеги гэж үзэж болно.

Мега төслүүд нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг (ихэвчлэн олон тэрбум ам.доллараар хэмжигдэхүйци) учраас түүнийг хэрэгжүүлэхэд оролцогчдоос олон талт байдал, улс төрийн өндөр мэдрэмж, нийгэм, эдийн засгийн өргөн цар хүрээтэй төлөвлөлт, зах зээлийн өөрчлөлтийг маш соргог, уян хатан байдлаар хүлээн авч өөрчлөгдөх чадвар шаардана. Ийм учраас мега төслийг хэрэгжүүлэх нь маш их эрсдэлийг дагуулдаг тул төслийн менежментийн уламжлалт аргачлалаас огт өөр нөхцөл байдлыг шаарддаг. Түүнчлэн мега төслүүд нь ихэвчлэн улс орны эдийн засгийн бодлого, бүс нутгийн хөгжлийн стратеги, институцийн чадавхтай нягт уялддаг тул тэдгээрийн хэрэгжилтийг нь “Төрийн бодлоготой нягт уялдсан төслийн тогтолцоо (policy-embedded project systems)”-ны хүрээнд авч үздэг (Locatelli G. M., 2017). Энэ үүднээс мега төслүүд нь зөвхөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх,

тухайн салбарыг шинэчлэх, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт хийх явдал биш, харин институцийн шинэчлэл хийж, технологийн шилжүүлэлт хийх үйл явцыг түргэсгэх, эсвэл хөнгөвчлөж хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэн, хувийн хэвшлийн оролцоог шинэ түвшинд хүргэж байж үр дүнтэй хэрэгждэг байна.

Мөн мега төсөл нь ихэвчлэн олон жил үргэлжилдэг учраас зах зээлийн хэлбэлзэл, технологийн өөрчлөлт, шинэчлэл, инноваци, эдийн засгийн өсөлт, бууралт, тухайн улсын төрийн бодлогын өөрчлөлт, улс төрийн мөчлөг, хууль, эрх зүй, санхүүгийн тогтвортой байдал зэрэг нь төслийн хэрэгжилтэд шийдвэрлэх нөлөөтэй байдгийг судлаачид онцолдог (Ansar A. F., 2016). Өөр нэг онцлог нь мега төслүүдийн нийгэм, эдийн засгийн нөлөө нь зөвхөн төслийн шууд үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, харин урт хугацаанд бүтээмж, инноваци, кластер хөгжлийг дэмжих дам нөлөөг бий болдог явдал юм. Судлаачид мега төслүүдийн үр нөлөө нь эдийн засгийн шинэ чиглэлийг бий болгох, логистикийн интеграци, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх, шинэ үйлдвэрлэлийн тогтолцоо үүсгэх зэрэг системийн өөрчлөлтийг бий болгодогыг тогтоожээ (Zhou, 2017). Иймд энэхүү шаардлагуудыг нэгэн зэрэг хангаж чадахуйци төрийн захиргааны арга, хэрэгсэл шаардлагатай байдаг бөгөөд дэлхийн улс орнууд мега төслийг ихэвчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлдэг. Төр, хувийн хэвшлийн түншлэл нь мега төслийн санхүүгийн ачааллыг жигд хуваарилах, эрсдэлийг бууруулах, менежментийн чадавхыг нэмэгдүүлэх, дэд бүтэц хийгээд төслийн бүтээн байгуулалтын зохистой түвшинг хангадаг арга зам болох нь практик дээр нэгэнт нотлогджээ. Жишээ нь 1994 онд төр, хувийн хэвшлийн түншлэлийн “Барих -Ашиглах -Шилжүүлэх (BOT)” төрлөөр хэрэгжсэн “Ла-Маншийн хоолойн газар доорх туннель (Eurotunnel)” төсөл юм. Тухайн төсөл нийт 15.5 тэрбум фунт стерлинг (тухайн үеийн ханшаар) өртөгтэй байсан бөгөөр энэ нь тухайн үедээ төдийгүй өнөө үед ч нэлээдгүй өндөр өртөгт тооцогдож байна. Хэдийгээр уг мега төсөл нь өндөр өртөгтэй, төслийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад багагүй бэрхшээл тулгарсан байдаг хэдий ч маш өндөр ач холбогдолтой, хамгийн амжилттай хэрэгжиж байгаа мега төсүүдийн нэг гэж тооцогддог. Уг төслийн гол ач холбогдлыг судлаачид Англи болон Францын хооронд шууд төмөр замын холболт бий болгосноор тээврийн хугацааг эрс багасгасан (Folkstone–Calais маршрутаар зорчиход ердөө 35 минут), худалдаа, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлж, олон улсын тээврийн дэд бүтцийн гол холбоосуудын нэг болсон гэж тайлбарладаг. 2020 онд COVID-19 цар тахлын үед зорчигчдын тоо, ачаа эргэлт эрс цөөрч, туннелийн орлого 25 хувиар буурсан боловч 2023 онд

жилийн орлого 1.629 тэрбум фунт стерлинг болж өссөн байна. Энэ нь өмнөх оноосоо 26 орчим хувиар нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд мөн онд нийт 10,716,419 хүн уг туннелээр дамжин зорчсон нь 2022 оныхоос 29 хувиар өссөн үзүүлэлт байжээ (Eurotunnel, 2024).

Мега төслийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гүйцэтгэх үндсэн үүрэг нь төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын харилцан уялдааг хангах явдал юм. Энэ нь төрийн зүгээс тухайн төслийн бодлого, хууль, эрх зүй, үйл ажиллагаа явуулах баталгаат байдлаар хангаж хувийн хэвшил нь санхүү, хөрөнгө оруулалт, техник, технологи, хүний нөөц, менежментийн ур чадвараа ашиглан төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх явдал юм. Энэхүү зохистой харилцан уялдаа нь их хэмжээний хөрөнгө оруулалт, эрсдэл дагуулсан төслүүдийг олон жилийн хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг (Yescombe, 2018).

Мега төслийг нь төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхэд төрийн зүгээс гүйцэтгэх гол үүрэг нь холбогдох эрх зүйн зохицуулалт хийх, байгаль орчны эерэг, сөрөг нөлөөллийг тодруулах, урт хугацааны ашиглалтын гэрээний баталгааг хангах зэрэг байдаг. Харин хувийн хэвшлийн байгууллагын үндсэн үүрэг нь дэд бүтцийн болон төслийн үндсэн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх, тоног төхөөрөмж, технологи, менежмент, ихэвчлэн хөрөнгө оруулалтыг хариуцдаг бөгөөд энэ нь төслийг хугацаанд нь, чанартай, үр ашигтай үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөл нь гэж үзэж болно. Мега төслийг дэлхийн улс орнуудад ихэвчлэн (i) бэлтгэл үе шат → (ii) инженерийн төлөвлөлт, загварчлал, технологийн сонголт, шаардлагатай гэрээг хийх → (iii) барилга, байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалт → (iv) тоног төхөөрөмж суурилуулах → (v) ашиглалт зэрэг шаталсан байдлаар хэрэгжүүлдэг.

Хоёр. Монгол Улсад мега төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх боломж

Монгол Улсын “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” 2009 оны 10 сарын 15-ны өдөр УИХ-ын 64-р тогтоолыг баталснаар тухайн бодлогод үндэслэн 2010 оны 01 сарын 28-ны өдөр Монгол Улсын “Концессын тухай хууль (Тус хууль нь 2023 оны 12 сарын 31-ны өдөр хүчингүй болсон)”, 2022 оны 12 сарын 09-нд Монгол Улсын “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль”-ийг батлан 2023-2024 оны хооронд холбогдох журмуудыг эцэслэн баталсан. Энэ нь Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хязгаарлалтыг нөхөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, түншлэлийн төслийн хөрөнгө оруулалт,

санхүүжилт, гэрээний баталгааг хангах боломжийг бүрдүүлсэн бөгөөд үйлдвэрлэл, экспортын хэмжээ, дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгон, хот болон хөдөө орон нутгийн хөгжлийн тэнцвэрийг ханган, технологи шилжүүлэлтийг эрчимжүүлэхэд чиглэсэн олон мега төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлээд байгаа гэж хэлж болно.

Монгол Улсад мега төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр амжилттай хэрэгжүүлэхийн тулд төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын боломж, эрсдэлийн оновчтой хуваарилалт, хувийн хэвшлийн техникийн ба менежментийн чадавхи, мөн институцийн орчин болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүчин зүйлсийг цогцоор нь үнэлж харгалзан үзэх шаардлагатай. Иймд төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан мега төсөл хэрэгжүүлэх боломж, давуу болон сул тал, тэдгээртэй уялдах гадаад орчин, аюул, эрсдэлийн харилцан нөлөөллийг TOWS шинжилгээгээр тодорхойлсон бөгөөд дараах үзүүлэлт харагдаж байна.

Хүснэгт 1. Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан мега төслийг хэрэгжүүлэх үйл явцад хийсэн TOWS шинжилгээ

Үзүүлэлт	**Боломж (O)**	**Аюул, эрсдэл (T)**
Давуу тал (S)	**SO стратеги** *(Давуу талыг ашиглан боломжийг нэмэгдүүлэх)*: • Байгалийн баялаг, стратегийн байршлыг ашиглан гадаадын хөрөнгө оруулагч татах; • Олон улсын банк, сангуудтай хамтарсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн мега төслүүдийг хэрэгжүүлэх; • Ногоон эрчим хүч, дэд бүтцийн төслүүдийг өргөжүүлэх.	**ST стратеги** *(Давуу талыг ашиглан аюул, эрсдэлийг бууруулах)*: • Туршлагатай олон улсын түншээр дамжуулан улс төр, санхүүгийн эрсдэлийг хуваалцах; • Томоохон төслүүдэд урт хугацааны гэрээ, баталгаа ашиглах; • Байгаль орчны стандартыг өндөр түвшинд мөрдөх.
Сул тал (W)	**WO стратеги** *(Сул талыг бууруулж боломжийг ашиглах)*: • Гадаад мэргэжилтэн, зөвлөхүүдийн тусламжтайгаар төрийн чадавхыг сайжруулах; • Олон улсын санхүүжилтээр менежмент, технологийн дутагдлыг нөхөх; • Олон улсын сайн туршлагад үндэслэн төр, хувийн хэвшлийн	**WT стратеги** *(Сул талыг багасгаж аюул, эрсдэлээс зайлсхийх)*: • Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ, шаталсан хэрэгжилт хийх; • Хууль, бодлогын тогтвортой байдлыг хангах институцийн шинэчлэл хийх; • Ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

	түншлэлийн боломжит төрлүүдийг ашиглах.	

Дээрх SO стратегиас үзэхэд Монгол Улс өмнө нь байгалийн баялагтаа тулгуурлан томоохон дэд бүтэц, уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлж байсан туршлагдаа үндэслэн гадаадын хөрөнгө оруулагчдыг татах боломж болох нь харагдаж байна. Мөн олон улсын хөгжлийн банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран эрчим хүч, тээвэр логистик, аж үйлдвэрлэлийн чиглэлээр мега төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нь улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүс нутгийн интеграцад идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх бүрэн боломжтой юм. Түүнчлэн дэлхий дахинд эрчимжиж буй ногоон хөгжил, дижитал шилжилтийн чиг хандлагыг ашиглан сэргээгдэх эрчим хүч, ухаалаг дэд бүтцийн төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр амжилттай хэрэгжүүлэх боломж байна. Харин ST стратегиас үзэхэд Монгол Улс одоо байгаа өөрийн давуу талуудыг ашиглан улс төрийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, хөрөнгө оруулагчдын итгэл буурах зэрэг эрсдэлийг бууруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Тухайлбал, олон улсын туршлагатай хувийн хэвшлийн түншүүдтэй хамтран ажилласнаар санхүүгийн болон хэрэгжилтийн эрсдэлийг хуваалцах боломж бүрдэнэ. Үүнээс гадна урт хугацааны тогтвортой гэрээ, төрийн баталгааг оновчтой ашиглах, олон улсын байгаль орчин, нийгмийн стандартыг мөрдөх замаар төслийн эсрэг олон нийтийн эсэргүүцэл, нэр хүндийн эрсдэлийг бууруулах нь чухал юм. WO стратегиас үзэхэд төрийн институцийн чадавхи сул, санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал, төслийн менежментийн туршлага дутмаг зэрэг сул талуудаа гадаад орчны боломжуудтай уялдуулан нөхөх боломжтой болох нь харагдаж байна. Олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэг, зөвлөх үйлчилгээ, техник туслалцааг ашигласнаар төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төслийн удирдлагыг олон улсын сайн туршлагад нийцүүлэх нөхцөл бүрдэнэ. Ингэснээр мега төслийг үр ашигтай хэрэгжүүлэх боломж нэмэгдэж, хувийн хэвшлийн оролцоо илүү идэвхтэй болгох боломж бүрдэнэ. Мөн WT стратегийн хүрээнд дотоод сул талууд болон гадаад орчны аюул заналыг нэгэн зэрэг бууруулахад чиглэсэн хамгаалалтын бодлого шаардлагатай байгаа нь харагдаж байна. Үүнд мега төслийг дээр дурьдсан шаталсан байдлаар хэрэгжүүлэхэд чиглэсэн нарийвчилсан бодлого, эрх зүйн зохицуулалт бий болгон тогтвортой байдлыг нь хангах институцийн шинэчлэл хийх, эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх зэрэг арга хэмжээнүүд хамаарна. Мөн ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар нийгмийн эсэргүүцэл, авлига, засаглалын эрсдэлийг бууруулах нь төр, хувийн

хэвшлийн түншлэлийн мега төслийг амжилттай хэрэгжүүлэх чухал нөхцөл болох бүрэн боломжтой нь харагдаж байна.

Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан мега төсөл хэрэгжүүлэх боломж өндөр боловч энэ нь зөвхөн байгалийн баялаг, гадаадын хөрөнгө оруулалтад найдахаас илүүтэйгээр төрийн институцийн чадавхи, бодлогын тогтвортой байдал, эрсдэлийн удирдлагыг системтэйгээр сайжруулснаар бодитоор хэрэгжих боломжтой болох нь харагдаж байна. Түүчнлэн мега төслийг хэрэгжүүлэхэд нь маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг бөгөөд бүтээн байгуулалт удаан хугацаанд хийгдэж их хэмжээний нийгэм, эдийн засаг, байгаль орчны үр нөлөө үүсгэдэг учир төдий чинээ өндөр эрсдэлтэй дагуулдаг. Иймд үүнийг төр дангаараа бус хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой шийдэл болох нь ойлгомжтой юм.

Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан мега төслийг хэрэгжүүлэх өндөр боломжтой хэд хэдэн төрөл байдаг бөгөөд тэдгээрт харьцуулсан шинжилгээ хийж үзье.

Хүснэгт 2. Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан мега төслийг хэрэгжүүлэхэд ашиглагдах хамгийн өндөр боломжтой төрлүүдийн харьцуулалт

Төрөл	**Үндсэн агуулга**	**Хөрөнгө оруулалт**	**Эзэмшил, ашиглалтын эрх**	**Эрсдэлийн хуваарилалт**	**Монгол Улсад тохиромжтой салбар**
Барих-Ашиглах-Шилжүүлэх (ВОТ)	Хувийн хэвшил төслийг хэрэгжүүлэн тодорхой хугацаанд ашиглаад төрд шилжүүлнэ	Хувийн хэвшил	Ашиглалтын хугацаанд хувийн хэвшилд	Санхүү, ашиглалтын эрсдэл хувийн хэвшилд төвлөрнө.	Авто зам, гүүр, эрчим хүчний үйлдвэрлэл, нисэх онгоцны буудал
Барих-Өмчлөх-Ашиглах (ВОО)	Хувийн хэвшил төслийг хэрэгжүүлж, эзэмшин, байнга ашиглана	Хувийн хэвшил	Эзэмшил, ашиглалт бүрэн хувийн хэвшилд	Төрийн зүгээс хүлээх эрсдэл бага, зах зээлийн эрсдэл өндөр байдаг.	Авто зам, ус хангамж, дэд бүтэц
Барих-Өмчлөх-Ашиглах-Шилжүүлэх (ВООТ)	ВОТ-той төстэй боловч гэхдээ ашиглалтын эрх нь илүү тодорхой байдаг	Хувийн хэвшил	Түр хугацаанд хувийн хэвшилд	Урт хугацааны санхүүгийн эрсдэл хувийн хэвшилд шилждэг.	Авто зам, гүүр, дэд бүтэц

Зураг төсөл боловсруулах-Барих-Санхүүжүүлэх-Ашиглах (DBFO)	Төслийн бүхий үе шатыг хувийн хэвшил хариуцна	Хувийн хэвшил	Гэрээгээр тодорхойлно	Эрсдэлийг гэрээгээр нарийн хуваарилна.	Авто зам, ус хангамж, дэд бүтэц
Төрийн зүгээс хувийн хэвшлийн үйлчилгээг худалдан авах (PPA/Service)	Хувийн хэвшил шаардлагатай барилга, байгууламж, дэд бүтцийг барьж ашиглана. Харин төр үйлчилгээг нь худалдан авна	Хувийн хэвшил	Хувийн хэвшилд	Эрэлт, орлогын эрсдэлийг төр хариуцна.	Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үйлдвэрлэл

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамгийн өргөн хэрэглэгддэг Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT) төрөл нь төрийн санхүүгийн шууд ачааллыг бууруулж, төслийн санхүүжилт, барилга угсралт, ашиглалтын эрсдэлийг хувийн хэвшилд шилжүүлэх давуу талтай. Мөн ашиглалтын тодорхой хугацааны дараа өмчийг төрд шилжүүлдэг нь стратегийн дэд бүтцэд оновчтой шийдэл болдог байна. Гэвч урт хугацааны гэрээ шаарддаг, орлогын таамаглал буруу тохиолдвол хөрөнгө оруулагчийн сонирхол буурах, мөн төрийн хяналт сул байвал гэрээний тэнцвэр алдагдах сул талтай байдаг. Харин Барих-Өмчлөх-Ашиглах (BOO) төрөл нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хамгийн их татах боломжтой, төрийн оролцоо харьцангуй бага байдгаараа давуу байдаг. Энэ нь авто зам, ус хангамж, дэд бүтэц, бусад үйлдвэрлэлийн салбарт төслийг хурдан хэрэгжүүлэх, технологийн шинэчлэл хийхэд үр дүнтэй. Гэвч өмчийн эрх байнга хувийн хэвшилд байх тул үндэсний аюулгүй байдал, стратегийн ашиг сонирхолтой салбарт хэрэглэхэд болгоомжлол шаарддаг бөгөөд төрөөс зохицуулалт сул байвал тариф, үйлчилгээний үнэ өсөх эрсдэлтэй юм. Барих-Өмчлөх-Ашиглах-Шилжүүлэх (BOOT) төрөл нь BOT-той төстэй боловч эзэмших, ашиглах эрхийг илүү тодорхой болгосноор хувийн хэвшлийн урт хугацааны сонирхлыг нэмэгдүүлдэг. Энэ нь Авто зам, гүүр, дэд бүтэц зэрэг капитал их шаардсан салбарт тохиромжтой боловч гэрээний хугацаа урт, нөхцөл нарийн учраас төрийн институцийн чадавхи сул үед хэлэлцээрийн үед үүсэх эрсдэл өндөр байдаг. Зураг төсөл боловсруулах-Барих-Санхүүжүүлэх-Ашиглах (DBFO) төрөл нь тухайн төслийн зураг төсөл боловсруулах, барилга, санхүүжилт, ашиглалт зэрэг чухал үйл ажиллагаануудыг нэг талд төвлөрүүлснээр төслийн уялдаа, чанар, хугацааны сахилга батыг сайжруулах давуу талтай. Ялангуяа

авто зам, дэд бүтцийн зэрэг мега төслүүдэд үр ашигтай боловч төрийн зүгээс гүйцэтгэлийг хянах, гэрээний үзүүлэлтүүдийг үнэлэх өндөр чадавхи шаарддаг бөгөөд энэ нь Монгол Улсын хувьд сорилт болоод байна.

Төрийн зүгээс хувийн хэвшлийн үйлчилгээг худалдан авах (PPA/Service) нь хувийн хэвшлийг хөрөнгө оруулалтад татахын зэрэгцээ орлогын эрсдэлийг төр хариуцсанаар төслийн санхүүжилтийг хялбар болгодог давуу талтай. Эрчим хүчний үйлдвэрлэлийн болон сэргээгдэх эрчим хүчний мега төслүүдэд тохиромжтой боловч урт хугацаанд улсын төсөвт тогтмол дарамт үүсгэх, үнэ, тарифын буруу бодлогоос үүдэн санхүүгийн эрсдэл нэмэгдэх сул талтай байдаг.

Эдгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн төрлүүдийн аль нь ч давуу болон сул талтай бөгөөд Монгол Улсын хувьд тухайн төслийн хэрэгжиж байгаа салбар, стратегийн ач холбогдол, төрийн институцийн чадавхтай уялдуулан зохистой төрлийг оновчтой сонгох нь мега төслийг үр ашигтай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл гэж үзэж болно. Тухайлбал, хувийн хэвшлийн зүгээс хөрөнгө оруулалт, санхүүжилт, барилга угсралт, ашиглалт, засвар үйлчилгээний эрсдэлийг хариуцаж, төр нь бодлого, хууль, эрх зүйн зохицуулалт, орлого, ашиглалтын баталгаа, нийгмийн бусад асуудлыг хариуцах замаар тухайн төслийг үр дүнтэй хэрэгжүүлж болдогыг дэлхийн олон оронд хэрэгжсэн төслийн жишээнээс харж болно. Монгол Улсад ч энэ талын бага сага туршлага хуримтлагдаж эхлээд байгаа бөгөөд үүнийг “Зураг төсөл боловсруулах-Барих -Ашиглах -Шилжүүлэх (DBOT)” төрлөөр хэрэгжсэн Дорноговь аймгийн Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутгаар дамжин өнгөрөх “Зүүнбаян - Ханги” чиглэлийн 280 км төмөр замын бүтээн байгуулалт, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг байрлах “Барих -Ашиглах - Шилжүүлэх (BOT)” төрлөөр хэрэгжиж байгаа “Чингис хаан” шинэ нисэх онгоцны буудал зэрэг төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийн хэрэгжилтийн үйл явцаас тодорхой харж болно.

Монгол Улсын “Чингис хаан” олон улсын шинэ нисэх онгоцны буудлын төсөл нь Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, Монголын Засгийн газрын хөрөнгө оруулалт, түүнчлэн Японы туршлагатай бизнесийн байгууллагын оролцоонд тулгуурласан бөгөөд энэ нь улсын төсөвт үзүүлэх дарамтыг бууруулахын зэрэгцээ санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг талуудын хооронд тэнцвэртэй хуваарилах боломжийг бүрдүүлжээ. Төслийн гүйцэтгэгч болон үйл ажиллагааны менежментийг хариуцсан байгууллагуудын зүгээс олон улсын стандартад нийцсэн дэвшилтэт техник технологи, аюулгүй ажиллагааны систем, удирдлагын шинэ арга барилыг нэвтрүүлсэн нь Монгол Улсын иргэний нисэхийн салбарт технологийн болон

менежментийн чанарын ахиц авчирсан чухал алхам болсон гэж үзэх үндэслэлтэй. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн “Барих-Ашиглах-Шилжүүлэх” (Build-Operate-Transfer, BOT) төрөл нь хувийн хэвшлийн урт хугацааны ашиглалтын эрхийг тодорхойлсноор хөрөнгө оруулалт татах сонирхлыг нэмэгдүүлж, ингэснээр менежментийн үр ашиг, үйлчилгээний чанар, хэрэглэгчийн хүртээмжийг сайжруулах маш сайн хөшүүрэг болдог нь олон улсын туршлагаар нотлогддог. Энэ нь ч Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын төслийн үр дүнгээс тод харагдаж байгаа юм. Төсөл нь Монгол Улсын эдийн засагт шууд болон шууд бусаар эерэг нөлөө үзүүлэн барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалт, үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд олон мянган ажлын байр бий болгосон төдийгүй аялал жуулчлалын салбарын өсөлтөд чухал хувь нэмэр оруулж эхэлжээ. Зорчигчийн урсгал жилээс жилд нэмэгдэж байгаа нь агаарын тээврийн салбарын сэргэлт болон дэд бүтцийн хүчин чадлын ахицтай уялдаж байгаа нь албан ёсны статистик үзүүлэлтээс тодорхой харагдаж байна.

Хүснэгт 3. “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлсэн зорчигчдын тоо

Нийт	**2020**	**2021**	**2022**	**2023**	**2024**
	447,478	198,523	952,765	1,731,291	2,167,270
Олон улсад зорчсон	161,804	100,256	618,960	1,312,167	1,746,875
Дотоодод зорчсон	285,674	98,267	333,805	419,124	420,395

Эх сурвалж: https://www.1212.mn/mn/statistic/statcate/573059/table-view/DT_NSO_1200_012V5

2025 оны эхний хагас жилийн байдлаар л гэхэд 934,617 зорчигч (1212.mn, 2025) олон улсад (дотоодын нислэгийг тооцолгүйгээр) зорчоод байна. Энэхүү ахиц нь тус нисэх онгоцны буудлыг нь 2024 онд “SKYTRAX” олон улсын үнэлгээний байгууллагаас “4 од” ангилалд дэвших боломжыг олгосон бөгөөд энэ нь Монгол Улсын тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын үйл ажиллагааны үр дүн, найдвартай байдал, менежментийн үр өгөөж, үйлчилгээний хэв маягыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн анхны тохиолдол болжээ (Удирдлагын академи, 2024). Гэхдээ уг төслийн хэрэгжилт нь зарим сорилттой тулгарсаар байгаа бөгөөд эдгээрт зээлийн эргэн төлөлтийн дарамт, хууль, эрх зүйн зохицуулалт зарим үед дутагдах, хөрөнгө оруулагчдын шаардлагаас үүссэн зарим эрсдэл, нисэх буудлын дэд бүтцийн өргөтгөлийн хэрэгцээ, үйлчилгээний ачааллын өсөлт, түүнчлэн COVID-19 цар тахлын сөрөг нөлөөлөл зэрэг асуудлууд багтаж байна. Иймд уг түншлэлийн төслийн тогтвортой байдлыг хангахын тулд түншлэгч талуудын уялдаа холбоог сайжруулах, хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн эрсдэлийг оновчтой удирдах, менежментийн үр ашгийг

тасралтгүй сайжруулах, зорчигчийн урсгал болон үйл ажиллагааны оновчлолыг шинэлэг технологиор дэмжих шаардлагатай хэвээр байна. Гэхдээ “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын мега төсөл нь Монгол Улсын дэд бүтцийн хөгжил, агаарын тээврийн салбарт чанарын ахиц, эдийн засгийн өсөлтийн шинэ боломжуудыг бүрдүүлэхэд бодиттой хувь нэмэр оруулж байгаа нь харагдаж байна. Эндээс үзэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн “Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT)” болон түүнд суурилсан бусад төрлүүд (DBOT гэх мэт) нь одоохондоо Монгол Улсад томоохон дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх, удирдах, олон улсын стандартыг нутагшуулах үр хамгийн ашигтай хувилбар гэж үзэж болно.

Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан мега төслийг хэрэгжүүлэх үйл явцад бий болж болзошгүй өөр нэг сөрөг үр дагавар нь санхүү, зах зээл, нийгэм, байгаль орчны эрсдэл буруу хуваарилагдах, төслийн хугацаа сунжрах, өртөг нэмэгдэх, гадны хөрөнгө оруулалт зогсох, үнийн тогтворгүй байдал үүсэх зэрэг бөгөөд олон нийтийн эсэргүүцэл нь тухайн төслийг хэрэгжүүлэх хугацааг нь сунгах, илүү өртөгтэй болгох тохиолдол ч бий. Монгол Улсад мега төслүүдийг үр ашигтайгаар төлөвлөн хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл нь санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, төсвийн дарамтыг бууруулах, технологийн дэвшил болон менежментийн чадварыг нэмэгдүүлэх боломжийг олгодог стратегийн чухал хэрэгсэл болсон гэж үзэх үндэслэлтэй. Мега төслүүд нь ихэвчлэн өндөр өртөгтэй, урт хугацааны хэрэгжилт шаардсан, олон талын оролцогчийн ашиг сонирхлыг зохицуулах шаардлагатай байдгаараа онцлог тул Монгол Улсын төрийн зүгээс холбогдох бодлогын болон эрх зүй, зохицуулалтын тогтвортой орчныг бүрдүүлэх, харин хувийн хэвшлийн зүгээс инноваци, хөрөнгө оруулалт, хүний нөөц, төслийн менежментийн үр ашгийг хангах нь чухал юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Эндээс үзэхэд Монгол Улсад мега төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нь эдийн засгийн өсөлт, бүтцийн шинэчлэл, экспортын төрөлжилт, дэд бүтцийн чадавхийг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой боловч өндөр эрсдэл, урт хугацаа, олон талын оролцоотой шинжээс шалтгаалан амжилттай хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн болон бодлогын тогтвортой орчин, шинжлэх ухаанд суурилсан үнэлгээ, ил тод, шударга сонгон шалгаруулалт, эрсдэлийн оновчтой хуваарилалт, институцийн болон хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна. Мега төслүүдийг зөв төлөвлөн хэрэгжүүлж чадвал эдийн засгийн олон тулгуурт тогтолцоонд шилжих, бүс

нутгийн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновацид суурилсан хөгжлийг төлөвшүүлэх бодит боломж бүрдэнэ. Харин энэ боломжийг бодит үр дүнд хүргэх боломж нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, ил тод, олон талын оролцоог хангасан тогтолцоонд суурилуулан хөгжүүлэх явдал юм.

Иймээс Монгол Улсад мега төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхийн тулд дараах асуудлуудыг эцэслэн шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. Эдгээр нь:

Нэгдүгээрт, Монгол Улсад мега төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь бодлого, хууль, эрх зүйн зохицуулалт болон институцийн тогтвортой орчныг бүрдүүлэх маш чухал бөгөөд энэ нь хувийн хэвшлийн байгууллагуудад итгэл төрүүлж хөрөнгө оруулах сонирхолыг нэмэгдүүлнэ. Үүнээс гадна түншлэлийн гэрээний уян хатан загвар, татварын давуу нөхцөл, хөрөнгө оруулалтын баталгаа зэрэг бодлогын арга хэмжээг сайжруулж эрчим хүч, дэд бүтэц, тээвэр, байгаль орчны төслүүдэд үр ашгийн шинжилгээ, эрсдэлийн зохистой хувиарлалт хийх аргачлал, төрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай юм. *Хоёрдугаарт*, мега төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх нь маш чухал учраас олон улсын санхүүгийн байгууллагуудын хөнгөлөлттэй санхүүжилт, ногоон санхүүжилт, олон улсын хөгжлийн байгууллагын зээл, бондын зах зээлийн оролцоо зэрэг механизмыг ашиглах боломжыг өргөжүүлэх шаардлагтай байна. Санхүүгийн дэмжлэгийн эдгээр хэлбэр нь төсвийн шууд дарамтыг бууруулахын зэрэгцээ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын оролцоог нэмэгдүүлж, төслийн тогтвортой хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлдэг. *Гуравдугаарт*, хувийн хэвшлийн технологийн шийдэл болон инновацийг ашиглах нь мега төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл бөгөөд ялангуяа хиймэл оюун ухаанд тулгуурласан ухаалаг дэд бүтэц, орчин үеийн инженерчлэл, дижитал хяналтын систем, ногоон технологийг нэвтрүүлэх нь төслийн ашиглалтын зардлыг бууруулах, бүтээмжийг өсгөх, засвар үйлчилгээний урт хугацааны үр ашгийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ. Түүнчлэн хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн байгууллага болон холбогдох төрийн байгууллагуудын олон улсын туршлага, чадавхыг нэмэгдүүлэхэд сургалтын тогтолцоог бий болгох, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх нь төслийн үр нөлөөг сайжруулахад чухал үүрэгтэй байдаг байна. *Дөрөвдүгээрт*, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь Монгол Улсад мега төслийн төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтын гадаад орчныг сайжруулахад

бодит хувь нэмэр оруулна. Хөгжлийн түнш орнууд, бүс нутгийн санхүүгийн байгууллагууд (Азийн хөгжлийн банк г.м) болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай (Дэлхийн банк г.м) нягт хамтран ажиллах нь хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлж, эрсдэлийг бууруулах баталгааны механизмыг бүрдүүлнэ. Ийм хамтын ажиллагаа нь зөвхөн санхүүгийн эх үүсвэр болох төдийгүй шинэ техник, технологи, менежментийн шилдэг туршлагыг Монголд нутагшуулах боломжийг олгоно.

Эндээс үзэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл нь Монгол Улсад мега төслийг хэрэгжүүлэх санхүүгийн үр ашигтай шийдэл төдийгүй институцийн чадавхыг сайжруулах, менежментийн ил тод байдлыг бэхжүүлэх, олон улсын туршлагыг нутагшуулах стратегийн ач холбогдолтой шийдэл болох харагдаж байна. Мега төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан үр дүнтэй хэрэгжүүлэх нь бодлого, хууль, эрх зүй, зохицуулалтын тогтвортой байдал, төрийн байгууллага болон хувийн хэвшлийн харилцан уялдаа, үйл ажиллагааны зөв зохион байгуулалт, эрсдэлийн зохистой хуваарилалт, төслийн менежментийг оновчтой ашиглалт, технологийн дэвшлийг хэр үр дүнтэй нэвтрүүлж байгаагаас шууд хамаарах бөгөөд эдгээр хүчин зүйлсийг цогцоор нь авч үзсэн тохиолдолд Монгол Улсын хөгжлийг бодитоор дэмжих чухал хэрэгсэл болох боломжтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1212.mn. (2025 оны 06 18). *https://1212.mn/*. https://1212.mn/: https://downloads.1212.mn/s9_b8DEJ4KH_L6Yt5-_9U9iyZ8t_Z-xCo_6o92Bi.pdf-ээс Гаргасан

Aghion, P. &. (2009). *The economics of growth.* MIT Press.

Ansar, A. F. (2016). Does infrastructure investment lead to economic growth or economic fragility? Evidence from China. *Oxford Review of Economic Policy, 32(3)*, 360–390.

Ansar, A. F. (2016). Does infrastructure investment lead to economic growth or economic fragility? Evidence from China. *Oxford Review of Economic Policy, 32(3)*, 360–390.

Arrow, K. J. (1971). *Essays in the theory of risk-bearing.* Chicago: Markham.

Bentley, C., Zhou, Z. (2017). Mega-projects and regional development: An institutional perspective. *Journal of Infrastructure Systems, 23(4)*, 04017032.

Boardman, A. E. (2018). *Cost-benefit analysis: Concepts and practice (5th ed.)*. Cambridge: Cambridge University Press.

Eurotunnel. (2024). *About Eurotunnel: History and operations*. London: Retrieved from https://www.eurotunnel.com/uk/about-eurotunnel/history/.

Flyvbjerg B. (2003). *Megaprojects and Risk: An Anatomy of Ambition.* Cambridge: Cambridge University Press.

Flyvbjerg, B. (2014). What You Should Know About Megaprojects and Why: An Overview. *Project Management Journal, 45(2)*, 6–19.

Global Energy Monitor. (2025). *Egiin Gol hydroelectric plant.* Ulaanbaatar: https://www.gem.wiki/Egiin_Gol_hydroelectric_plant.

Grimsey, D., Lewis, M. K. (2004). *Public private partnerships: The worldwide revolution in infrastructure provision and project finance.* Edward Elgar Publishing.

Hart, O. &. (1987). The theory of contracts. In T. F. Bewley (Ed.) Cambridge University Press. *Advances in economic theory*, 71–155 .

Hodge, G. &. (2007). Public–private partnerships: An international performance review. *Public Administration Review, 67(3)*, 545–558.

legalinfo.mn. (2025 оны 11 17). *legalinfo.mn*. https://legalinfo.mn/: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1-ээс Гаргасан

Li, B. A. (2005). Critical success factors for PPP/PFI projects in the UK construction industry. *Construction Management and Economics, 23(5)*, 459–471.

Lin, J. Y. (2020). *Endogenous structural transformation in economic development.* arXiv. arXiv+1.

Locatelli, G. M. (2017). Understanding the impact of mega projects on institutional capacity building. *International Journal of Project Management, 35(8)*, 1335–1350.

Merrow, E. W. (2011). *Industrial megaprojects: Concepts, strategies, and practices for success.* John Wiley & Sons.

North, D. C. (1990). *Institutions, institutional change and economic performance.* Cambridge, UK: Cambridge University Press.

Roehrich, J. K., Lewis, M. A., George, G. (2014). Are public–private partnerships a healthy option? A systematic literature review. *Social Science & Medicine, 113*, 110–119.

(2021). *Sovacool, B. K, Energy Megaprojects: Socioeconomic, Ethical, and Policy Issues.* Cambridge University Press.

WB. (2019). *Belt and Road Economics: Opportunities and Risks of Transport Corridors.* World Bank.

WEF. (2023). *Global Competitiveness Report.* World Economic Forum.

Yescombe, E. R. (2018). *Public–private partnerships: Principles of policy and finance (3rd ed.).* Butterworth-Heinemann.

Zhou, Z. B. (2017). Mega-projects and regional development: An institutional perspective. *Journal of Infrastructure Systems, 23(4)*, 04017032.

Удирдлагын академи. (2024). *Төрийн байгууллагын удирдлага: Онол, хандлага, арга зүй, хамтын бүтээл.* Улаанбаатар: Наруд дизайн ХХК.

"SOME THEORETICAL AND METHODOLOGICAL ISSUES IN IMPLEMENTING MEGA PROJECTS THROUGH PUBLIC-PRIVATE PARTNERSHIPS"

Abstract: Implementing mega projects accelerates structural changes in a country's economy, creates new sectors for production and export, facilitates technology transfer, enhances human resource capacities, and deepens regional integration. Such projects also improve the quality of infrastructure, logistics, and energy reliability, thereby strengthening national competitiveness. According to Oxford professor Bent Flyvbjerg, mega projects are typically defined as large-scale infrastructure initiatives that cost more than one billion USD, take many years to complete, and are closely aligned with national development policies.

Successful implementation of these projects requires policy stability, legal reforms, transparency, skilled human resources, and effective coordination among stakeholders. Meeting these requirements is more feasible when mega projects are carried out through public–private partnerships (PPPs), which help reduce fiscal pressure, allocate risks more efficiently, and leverage the managerial and technological advantages of the private sector.

The Government of Mongolia's 2024–2028 Action Program includes 14 mega projects in the areas of energy, mining, railways, urban development, water supply, and industrialization. To implement these projects, challenges such as legal and regulatory gaps, governance coordination, transparency in project selection, and shortages of specialized human resources must be addressed. These obstacles can be successfully overcome through PPP-based approaches. This article examines the theoretical and methodological foundations for implementing mega projects through public–private partnerships

Key words: Government; Private sector; investment; risk allocation; infrastructure development; management; technology transfer.

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 113-146 дахь тал

ТӨРИЙН БОДЛОГОД ЗӨВЛӨЛДӨХ АРДЧИЛЛЫН МЕХАНИЗМЫГ ХЭРЭГЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Болортуяа
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн докторант

Ж.Төртогтох
МУИС, УТСОУХНУС,
Ардчилал судлалын төвийн захирал, профессор

Хураангуй:

Ардчиллын талаарх онол, үзэл баримтлалуудад зөвлөлдөх ардчилал гэх ойлголтыг судлаачид авч үзэн, онол, практикийн түвшинд судалж байна. Монгол Улсын иргэд ардчилсан тогтолцоонд шилжсэн 30 гаруй жилийн хугацаанд төлөөлөх, төлөөлүүлэх эрхээ сонгуулиас сонгуулийн хооронд эдэлж иржээ. Тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлт иргэдийн амьдралын чанар, сайн сайхан нийгмийн бүтээн байгуулалтад үзүүлэх нөлөөлөл холбогдох судалгаануудад туссан байдаг.

Иргэдийн амьдралыг сайжруулахад чиглэсэн төрийн бодлого, хууль тогтоомжуудад тэдний хүсэл зориг, санал санаачилга туссан, төлөөлөл нь иргэдээ сонсож асуудлыг нь мэдэрч, хүссэн хэлбэрээр шийдвэрлүүлэх тогтолцоо хараахан бүрдэлгүй байсаар өнөөдрийг хүрсэн. Нийгмийн тулгамдсан асуудлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн байгууллага, экспертүүдийн судалгаа шинжилгээнд тулгуурласан, асуудлын давуу, сул талуудыг талаарх үнэн зөв, бодит мэдээлэл дээр тулгуурласан ойлголтоор иргэд бүх цаг үед дутагдаж ирсэн.

Зөвлөлдөх ардчиллын механизмыг араас нь хөөж биш, эхлүүлэхээс өмнө урдчилан судалгаа хийж, зөвлөлдөх санал гаргах түвшинд ажиллуулах нь ач холбогдолтой гэж үзэж байна. Үүний тулд төрийн бодлого, шийдвэрийг гаргахад зөвлөлдөх ардчиллын механизмыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Ардчилсан засаглалтай, төлөөллийн ардчиллын индекс өндөр гэх манай улсын хувьд зөвлөлдөх ардчиллын соёлын талаар ойлголт мэдээлэл хомс байгаа зэрэг бодит нөхцөл байдлуудыг харгалзан, тус механизмийг

нэвтрүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлийг онол, туршилт, тоон судалгааны үндсэн дээр шинжилж, шийдвэрлэх арга замыг санал болгохыг зорьсон.

Түлхүүр үгс: Зөвлөлдөх ардчиллын механизм, зөвлөлдөх санал асуулга, төрийн бодлого, иргэдийн оролцоо, үнэн зөв мэдээлэл, зөвлөлдөх, зөвшилцөх, нийгмийн тулгамдсан асуудал.

Оршил

Зөвлөлдөх ардчилал гэдэг үг нь англи хэлний “deliberity democracy” гэдэг үгийг монгол хэл рүү орчуулсан хувилбар бөгөөд зөвлөлдөх, зөвшилцөх, хэлэлцэх хэлбэрт суурилсан ардчиллын тухай ойлголт юм. Япон, Хятад гэх мэт дүрс үсгийн соёлтой улсууд “deliberity” гэдэг үгийг зөвлөлдөх, ярилцах, зөвшилцөх, хэлэлцэх гэсэн утгатай ханз үсгээр илэрхийлсэн байх тул монгол хэлэнд зөвлөлдөх ардчилал гэж буулгасан хэлбэрээр нь судалгааны ажилдаа тусгасан. Зарим судлаачид "Хэлэлцүүлэгт ардчилал" гэж орчуулсан байдаг ч судлаачын хувьд зөвлөлдөх ардчилал гэдэг нэршлийг Монгол Улсын улс төрийн шинжлэх ухааны салбарт өөрийн судалгаагаар дамжуулан үлдээхийг зорьлоо.

Зөвлөлдөх, зөвшилцөх гэдэх ойлголт нь бусдын хэлж буй үг, санаа, саналыг анхаарч сонсох, мөн тус асуудлаар өөрийн байр суууриа илэрхийлэх зэргээр харилцан хэлэх, сонсох зөвлөлдөн ярилцах үйл явц юм.

Олонхийн саналаар эсхүл гар өргөж дэмжсэн тооны ихээр асуудлыг шийддэг ардчиллын олонхийн зарчимтай зөвлөлдөж шийддэг зөвлөлдөх ардчиллын зарчим ялгаатай байдаг. Зөвлөлдөх ардчиллын зарчим, үзэл баримтлал нь улс төрийн онолын нийтийн хүрээ (public sphere) хэмээх ойлголтод тулгуурладаг. Олон нийтийн оролцоо өндөр баихын хирээр ардчиллын үндсэн зарчимд нийцэх боловч зөвхөн сонгуулийн оролцоогоор иргэдийн оролцоог хязгаарлагдах ёсгүй. Улс төрийн бодого, шийдвэр гаргалтад нөлөөлөх иргэдийн оролцоог идэвхжүүлэхэд зөвлөлдөх ардчиллын мехнизм ажиллах орчин нөхцөлийг хангах хэрэгцээ шаардлага тавигдаж байгааг онол, практикийн хүрээнд судлан асуудлыг тодорхойлох юм.

Асуудлыг гар өргөж дэмжих, олонхийн давуу талаар шийдвэрлэдэг байх ардчиллын үндсэн зарчим зөвлөлдөх ардчиллын тохиолдолд зөвшилцөх, зөвлөлдөх хэлбэрээр хэрэгждэг. Энэ хүрээнд Монгол Улс хэд хэдэн удаагийн зөвлөлдөх ардчиллын хүрээнд зөвлөлдөх санал асуулгуудыг зохион байгуулж, иргэдийн зөвлөлдөх, саналаа тусгах боломжийг бүрдүүлсэн. Гэсэнч Монголын ардчиллын 30 гаруй жилийн туршлагаас харахад иргэдийн оролцоо ихэвчлэн сонгуулийн мөчлөгт хязгаарлагдаж, бодлого боловсруулах шатанд дуу хоолой сул туссаар байна.

Төрийн шийдвэр гаргах үйл явц ихэнхдээ намын төвтэй, дээд төвшний шийдвэрт тулгуурладаг хэвээр байгаа нь зөвлөлдөх ардчиллын орон зайг хумиж буй нэг хүчин зүйл гэж үзсэн тул энэ талаар нарийвчилсан судалгааг хийж, дүгнэлт гаргасан.

Онол, арга зүй

Эртний Грекийн судлаач Аристотель иргэд нийтээрээ талбай дээр гарч хуулийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулахын ач холбогдлын талаар дурдсан байдаг.

Грекийн Афинаас ардчиллын гол санаа гаралтай ба тухайн үед 500 хүний төлөөлөл болгож, түүврийн аргаар нэг хүн сонгож, тэр төлөөллүүд төрийн томоохон шийдвэрийг хэлэлцэж байгаад гаргадаг байв. Хэлэлцэх, зөвшилцөх гэдэг агуулга хүн төрөлхтөн бий болох үеэс л хамт байсан ойлголт бөгөөд харилцааны түвшинд бол шинэ тутам ойлголт бол биш билээ.

Зөвлөлдөх ардчиллын үзэл баримтлалын талаар Алекс Токвиль, Макс Вебер нар өөрсдийн бүтээлд дурдсаныг ардчиллын олон ургальч үзэл санаагаар баяжуулан судалсан эрдэмтдийн нэг Даль гэж үздэг. Учир нь аль ч ардчилсан төрийн байгуулалд эрх ашиг, сонирхлын зөрчил олонхийн саналын дагуу шийдэгдэх боломжтой хэдий ч шийдвэр цөөнхийн эрх ашгийг хамгаалж чадаж байгаа эсэх тухай асуудлыг давхар хөнддөг.

Орчин үед, улс төрийн шинжлэх ухаанд энэхүү ойлголтыг Францын судлаач, улс төрч Алекс Токвиль (Alexis de Tocqueville 1835), Германы эрдэмтэн Макс Вебер (Max Weber 1864) Германы философич Юрген Хабермас (Jurgen Habermas 1929), Америкийн улс төрч Эми Гатмэн (Amy Gutmann 1949), Норвегийн нийгэм судлаач, улс төрч Ж.Элстер (Jon Elster 1940), Америкийн философич Жошу Кохэн (Joshua Cohen 1951), Жон Роулз (John Rawls 1921-2002), Жеймс С.Фишкин (James S.Fishkin), Джозеб Бессет (*Josie Bissett*) нар нь зөвлөлдөх ардчиллын үзэл баримтлалын хүрээнд дэлгэрүүлсэн гол төлөөлөгчид болно.

Дээрх эрдэмтэн судлаачид 1980-аад оноос эхлэн бүтээл туурвилдээ зөвлөлдөх ардчилал гэдэг ойлголтыг тусгаж, энэ талаар онол, үзэл санааг дэвшүүлж эхэлсэн гэж үздэг. Зөвлөлдөх ардчиллын төлөөлөгчид ардчиллын олонхоороо, гар өргөн дэмжиж шийддэг байдлаас зөвлөлдөж, зөвшилцөж, харилцан ойлголцож шийдвэр гаргах боломжтой энэ механизм нь иргэдийн оролцоог бодитой хангах оролцооны нэг хэлбэр болж чадаж байна гэдэгт санал нэгддэг.

Дэлхийн зарим улсад зөвлөлдөх ардчилал амжилттай хэрэгжсэн туршлага жилээс жилд нэмэгдэж байна. Жишээ нь Австрали, АНУ, Англи зэрэг хөгжингүй болон Ази, Африкийн олон улс, хөрш зэргэлдээ БНХАУ зөвлөлдөх ардчиллын хүрээнд дэд бүтэц, орон нутгийн төсвийн асуудлуудаа шийдвэрлэсэн. Европын холбооны 28 улс 2022 онд хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлыг зөвлөлдөх ардчиллын механизмыг нэвтрүүлэн шийдвэрлэж хуульчилсан. Монгол Улсын хувьд хэд хэдэн удаа зөвлөлдөх санал асуулга зохион байгуулж, МУ-ын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн асуудлаар чуулсан зэрэг туршлагууд байна.

Монгол Улсад зөвлөлдөх ардчиллын талаар АНУ-ын Стэнфордын Их сургуулийн профессор, Олон нийтийн харилцаа болон зөвлөлдөх ардчиллын судалгааны хүрээлэнгийн захирал Жеймс С.Фишкиний бүтээлийг 2015 онд одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатар “Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй” гэж орчуулан монголчуудад хүргэсэн. Тус бүтээл нь зөвлөлдөх ардчиллын талаар судалгаа хийх сонирхолтой оюутан, судлаачдын гарын авлага болох, эрдэмтдийн хувьд харьцуулж үзэх шинэлэг бүтээл болсон. Мөн гол зохиогч нь энэ цаг үед амьдарч буй зөвлөлдөх ардчиллын голлох төлөөлөгчдийн нэг юм.

Монгол Улсад зөвлөлдөх ардчилал гэх нэршил албан ёсоор төрийн бодлогод нэвтрээгүй ч зарим туршилтын хэлбэр гарч ирсэн байдаг. Жишээлбэл, 2015 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зөвлөлдөх санал асуулга нь (2017 онд хэрэгжсэн) анхны томоохон туршилт байв. Энэхүү зөвлөлдөх санал асуулгад 1500 орчим иргэн оролцож, Үндсэн хуулийн зарим заалтад иргэдийн байр суурийг тусгах оролдлого хийсэн. Судлаачдын үнэлснээр энэ туршилт нь мэдээлэлд суурилсан хэлэлцүүлгийн ач холбогдлыг харуулсан ч төрийн түвшинд шийдвэрийн үндэс болж чадаагүй.[1]

Мөн 2019 оноос хойш НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй иргэдийн зөвлөлдөх форум, иргэний төсвийн хэлэлцүүлэг зэрэг орон нутгийн түвшний санаачилгууд хэрэгжсэн боловч эдгээр нь туршилтын хүрээнд үлдэж, институцийн тогтолцоонд нэгдээгүй байна [2] Эдгээр жишээнээс дүгнэхэд Монгол Улсад зөвлөлдөх ардчиллын институцийн суурь бүрдээгүй, харин ардчиллын чанарыг дээшлүүлэх шинэ туршилтын үе шатандаа явж байна гэж үзэж болно.

[1] Fishkin, J. S., Siu, A., & Baasanjav, U. (2018). *Deliberative polling in Mongolia: Public consultation on constitutional reform.* Center for Deliberative Democracy, Stanford University.
[2] UNDP Mongolia. (2020). *Citizen engagement for sustainable development: Local deliberative forums.* UNDP.

Монгол Улс 1990 онд ардчилсан тогтолцоонд шилжсэнээр улс төрийн оролцоо, эрх чөлөө, хүний эрхийн салбарт түүхэн өөрчлөлт гарсан. Ардчиллын институцийн тогтолцоо Үндсэн хуулиар (1992) баталгаажсан бөгөөд иргэдийн төрд оролцох эрх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог эрх зүйн хувьд бүрдүүлсэн.[3]

Монгол Улс 1990 онд ардчилсан тогтолцоонд шилжсэн цагаас хойш ардчиллын институцийн суурийг тавьж, төлөөллийн ардчиллын загварыг хэрэгжүүлж ирсэн. Үндсэн хуулиар ард түмэн төрийн эрх мэдлийг шууд болон төлөөлөгчөөрөө хэрэгжүүлнэ гэж заасан (Монгол Улсын Үндсэн хууль, 1992, 3 дугаар зүйл). Энэ нь ардчиллын хоёр тулгуур хэлбэрийг шууд оролцоо болон төлөөллийн оролцоог хослуулсан үзэл санааг илэрхийлдэг. Энэ нь зөвлөлдөх ардчиллыг хэрэгжүүлэхэд итгэлцэл, оролцооны суурь соёлын хувьд бэрхшээлтэй орчин байгааг илтгэнэ.

Монголын ардчиллын суурь нь сонгуулийн механизмд тулгуурласан төлөөллийн хэлбэрт суурилсан ч, бодлого боловсруулах шатанд иргэдийн бодит оролцоо, хэлэлцүүлгийн чанар хангалтгүй байсаар иржээ[4]. Үүний шалтгаан нь төрийн байгууллагуудын хариуцлагын сул байдал, институцийн давхардал, иргэний нийгмийн оролцоог дэмжих тогтолцооны хомсдол зэрэгт оршдог.

Үндсэн хуулийн 3.1 дүгээр зүйлд "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна" гэж заасан нь зөвлөлдөх ардчиллын үзэл санаатай нийцдэг. Гэвч практик хэрэгжилтийн түвшинд ард түмний оролцоо гол төлөв сонгуулиар хязгаарлагдаж, бодлого боловсруулах, үнэлэх, хянах шатанд системтэй оролцох эрх зүйн болон институцийн орчин сул байна.[5]

Монгол Улсад бодлого боловсруулах үйл явц хэд хэдэн үе шаттайгаар явагддаг бөгөөд хууль эрх зүйн хүрээнд иргэдийн санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах заалтууд орсон байдаг. "Хууль тогтоомжийн тухай хууль"-ийн 19 дүгээр зүйлд "хууль, тогтоомжийн төслийг боловсруулахдаа олон нийтийн оролцоог хангах, хэлэлцүүлэг явуулах" үүргийг хуульчлан заасан байдаг.[6]

[3] Batbayar, T., & Lkhagvasuren, B. (2022). *Policy coordination and institutional challenges in Mongolia.* Asian Governance Review, 8(2), 117–139.
[4] Enkhsaikhan, N. (2020). *Civic participation and the quality of democracy in Mongolia.* Journal of Asian Democracy, 15(2), 66–82.
[5] Chuluunbat, O. (2022). *Citizen engagement in policymaking: Barriers and opportunities in Mongolia.* Governance and Democracy Journal, 6(3), 45–60.
[6] Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль, 2015

Гэвч энэхүү заалт нь практикт төдийлөн хэрэгждэггүй бөгөөд зөвхөн хууль санаачлагч байгууллага, яам, агентлагийн түвшинд формаль байдлаар "сэтгэгдэл авах", "нээлттэй хэлэлцүүлэг хийх" зэргээр хязгаарлагддаг.

Иймд иргэдийн санал бодол бодлого тодорхойлох шатанд системтэйгээр тусгагддаггүй, харин зөвхөн дараах гурван түвшинд тодорхой хэмжээгээр хэрэгждэг гэж үзэж болно.

Улсын түвшинд: Төрийн байгууллагуудын зохион байгуулдаг "нээлттэй хэлэлцүүлэг", "бодлогын зөвлөлдөх уулзалт";

Орон нутгийн түвшинд: Иргэдийн нийтийн хурал, сум, дүүргийн зөвлөгөөн, төсвийн хэлэлцүүлэг;

Цахим түвшинд: e-Mongolia, e-Parliament зэрэг цахим оролцооны платформуудаар дамжуулсан санал, хүсэлт хүлээн авах хэлбэрүүд.

Монгол Улсад иргэдийн оролцоог дэмжих хууль эрх зүйн зохицуулалт хэд хэдэн түвшинд бий боловч, тэдгээр нь ихэвчлэн зөвлөлдөх бус мэдээлэх, санал авах түвшинд хязгаарлагдсан байдаг. Үүнд дараах хуулиуд чухал ач холбогдолтой:

- Үндсэн хууль (1992) – иргэд төрийн үйл хэрэгт шууд болон төлөөллөөрөө оролцох эрхтэй;
- Хууль тогтоомжийн тухай хууль (2015) – хуулийн төсөл боловсруулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг явуулахыг шаарддаг;
- Иргэдийн нийтийн хурал, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль – орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах зорилготой;
- Нээлттэй засгийн түншлэл (OGP) санаачилга (2014 оноос) – төрийн ил тод байдал, оролцооны шинэ хэлбэрийг туршиж буй.

Гэвч эдгээр хуулиудын хэрэгжилт нь институц хоорондын зохицуулалт сул, иргэдийн санал бодол бодит шийдвэр гаргалтад тусах механизм тодорхойгүй байгаагаар хязгаарлагддаг. Тухайлбал, "олон нийтийн хэлэлцүүлэг" гэх нэр томъёо хуульд орсон ч, түүний зорилго, оролцогчдын сонгон шалгаруулалт, хэлэлцүүлгийн дараах нөлөөллийн хяналт тодорхой бус хэвээр байна.

Ийм нөхцөлд Монгол Улсад зөвлөлдөх ардчиллын механизмыг хууль эрх зүйн шинэчлэлтэй уялдуулах, тус механизмыг нэвтрүүлэхэд тулгарах саад бэрхшээл, хүчин зүйлсийг судлах шаардлага үүсч байна. Тухайлбал, "иргэдийн зөвлөлдөх санал асуулга" болон "бодлого боловсруулах

хэлэлцүүлэг”-ийн эрх зүйн тодорхойлолт, хэрэгжилтийн хариуцлагын заалтыг тусгах шаардлагатай гэж судлаачид үздэг.[7]

Монгол Улсад төрийн бодлого боловсруулах үйл явц дараах үндсэн шатуудаар явагддаг:

- Асуудлыг тодорхойлох,
- Бодлогын хувилбар боловсруулах,
- Хэлэлцүүлэх,
- Батлах,
- Хэрэгжүүлэх,
- Үнэлэх

Эдгээр шат бүрд иргэдийн оролцоог хангах хууль эрх зүйн боломж байгаа ч, зөвлөлдөх хэлбэрийн оролцоо сул байна. Тухайлбал, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (Алсын хараа–2050)” боловсруулахад 2019 онд иргэдийн санал авах хэлэлцүүлэг зохион байгуулсан ч, уг хэлэлцүүлэг зөвлөлдөх бус мэдээллийн түвшинд явагдсан гэж дүгнэсэн (UNDP Mongolia, 2020). Мөн орон нутгийн түвшинд иргэдийн нийтийн хурал, иргэний зөвлөлүүд ажиллаж байгаа боловч тэдгээр нь бодлогын шийдвэр гаргах түвшинд бодит нөлөө үзүүлж чадахгүй байна.

Монгол Улсад зөвлөлдөх ардчиллын хэрэгжилтэд дараах гурван бүлгийн хүчин зүйл нөлөөлж байна гэж үзэж болохоор байна. Үүнд:

Хууль эрх зүйн хүчин зүйл: Зөвлөлдөх хэлэлцүүлэг, иргэдийн оролцооны эрх зүйн тодорхой бус байдал, хариуцлагын тогтолцооны сул байдал.

Институцийн хүчин зүйл: Төрийн байгууллагын уялдаа сул, бодлого боловсруулах үйл явцын төвлөрсөн шинж, намуудын улс төрийн сонирхол давамгайлах байдал.

Нийгмийн ба соёлын хүчин зүйл: Иргэдийн оролцооны идэвх сул, мэдээлэл хомс, итгэлцэл багатай, технологийн хүртээмжийн ялгаа

Эдгээр хүчин зүйлс нь зөвлөлдөх ардчиллыг хэрэгжүүлэх орчныг хязгаарлаж байгаа бөгөөд тэдгээрийг бодлого, хууль эрх зүйн болон соёлын түвшинд зэрэг шинэчлэх шаардлага гарч байна. Монгол Улсад зөвлөлдөх ардчиллын хэрэгжилтийн эрх зүйн үндэс тавигдсан хэдий ч, бодит хэрэглээ нь туршилтын түвшинд байна. Хууль эрх зүйн заалтууд хангалтгүй тодорхой, институцийн уялдаа сул, иргэдийн оролцоо формаль шинжтэй байгаагаас болж зөвлөлдөх хэлэлцүүлэг төрийн бодлогод системтэй нөлөөлж чадахгүй байна.

[7] Jargalsaikhan, T. (2021). *Legal framework for deliberative public policy in Mongolia.* Law and Governance Studies, 7(2), 51–67.

Гэсэн хэдий ч 2017 оны зөвлөлдөх санал асуулга, орон нутгийн иргэдийн хэлэлцүүлгийн туршлага зэрэг нь Монголд зөвлөлдөх ардчиллын соёлын болон институцийн эхлэлийг тавьсан чухал алхам юм. Цаашид Монголын ардчиллын чанарыг гүнзгийрүүлэхийн тулд зөвлөлдөх ардчиллын хууль эрх зүй, институцийн суурь, технологийн дэмжлэгийг цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай байна.

Иргэдийн оролцооны тухай хууль эрх зүйн орчин бүрэн тогтоогүй, зөвлөлдөх хэлэлцүүлгийн эрх зүйн тодорхойлолт, хэрэгжилтийн журмыг хуульчилж өгөөгүй. Үүнээс шалтгаалан төрийн байгууллагууд иргэдийн оролцоог "зөвлөмжийн чанартай" гэж үздэг. Төрийн байгууллагуудын дотоод бүтэц, хариуцлагын тогтолцоо нь зөвлөлдөх хэлэлцүүлгийг дэмжихгүй. Улс төрийн намуудын нөлөө хүчтэй, төрийн шийдвэр гаргах үйл явц төвлөрсөн хэвээр байгаа нь иргэдийн оролцооны үр нөлөөг хязгаарладаг.

Иргэдийн төрд итгэх түвшин бага, оролцох хандлага сул, хэлэлцүүлгийн соёл төлөвшөөгүй. Хэвлэл мэдээллийн оролцоо, бодлогын боловсрол дутмаг байгаа нь зөвлөлдөх орчныг үүсгэхэд хүндрэлтэй болгож байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад цахим засаглал, нээлттэй өгөгдлийн системүүдийн хөгжил түргэссэн нь зөвлөлдөх ардчиллын шинэ боломжийг нээж байна. e-Mongolia, Open Government Partnership, e-Parliament зэрэг санаачилгууд нь иргэдийн санал хураалт, хэлэлцүүлэг, бодлогын санал авах боломжийг өргөжүүлж байгаа боловч эдгээр нь одоогоор зөвлөлдөх хэлэлцүүлгийн гүнзгий түвшинд хүрээгүй байна.

Гэхдээ цахим оролцооны өргөжилт нь иргэдийн оролцоог илүү хүртээмжтэй, мэдээлэлд суурилсан, тасралтгүй хэлбэрт шилжүүлэх урьдач нөхцөлийг бүрдүүлж байгаа тул зөвлөлдөх ардчиллын ирээдүйн суурийг бүрдүүлэх чухал хүчин зүйл болж байна. Монгол Улсад зөвлөлдөх ардчиллын онол практикийн нэвтрэлт эхний шатандаа байна.

Иргэдийн оролцооны хууль эрх зүйн орчин бүрэн боловсроогүй, институцийн тогтолцоо төвлөрсөн, итгэлцэл сул байгаа нь энэхүү загварыг бодлого боловсруулах түвшинд бүрэн хэрэглэхэд хүндрэл үүсгэж байна. Гэвч Үндсэн хуулийн зөвлөлдөх санал асуулгын туршлага, орон нутгийн зөвлөлдөх хэлбэрүүд, цахим оролцооны хөгжил зэрэг нь ирээдүйд энэхүү механизмыг гүнзгийрүүлэх бодит боломж байгааг харуулж байна.

Судалгааны үр дүн

Зөвлөлдөх ардчиллын практикт тулгарч буй асуудлуудыг судлаачид хэд хэдэн үндсэн бүлэгт ангилдаг. Эдгээр нь Монголын нөхцөлд мөн ижил шинжтэйгээр илэрдэг.

1. Хууль эрх зүйн болон институцийн орчны дутагдал

Монгол Улсад иргэдийн оролцооны институцийн тогтолцоо бүрэн хөгжөөгүй байгаа нь зөвлөлдөх хэлэлцүүлгийн үр дүнг хязгаарладаг. Судалгаагаар зөвлөлдөх санал асуулга, иргэдийн зөвлөлдөх форум зэрэг нь туршилтын шатанд байгаа боловч шууд шийдвэр гаргах эрхгүй, зөвлөмжийн шинж чанартай байдаг. Ингэснээр хэлэлцүүлгийн үр дүн бодлого, хууль тогтоомжид шууд нөлөөлөх боломж хязгаарлагдана.

2. Улс төрийн хүчин зүйл

Намын төвлөрсөн бүтэц, улс төрийн удирдлагын нөлөө нь иргэдийн оролцоог хязгаарлах гол хүчин зүйл юм. Парламентын болон Засгийн газрын түвшинд шийдвэр гаргах үйл явц намын дотоод тохиролцоонд ихээхэн тулгуурладаг бөгөөд иргэдийн санал бодлыг институцийн түвшинд нэвтрүүлэх нь сул байна.

3. Иргэдийн соёл, оролцоо, итгэлцэл

Иргэдийн хэлэлцүүлэгт оролцох соёл, бодлогын боловсрол, төрд итгэх итгэл сул байгаагаас зөвлөлдөх ардчилал тогтмол, үр дүнтэй хэрэгжих боломжгүй. World Values Survey (2022)-ын өгөгдлөөр Монгол иргэдийн 30–40% нь төрийн бодлогод оролцох сонирхолтой гэж үздэг бөгөөд энэ нь хэлэлцүүлгийн соёлын сул хөгжлийг харуулдаг.

4. Мэдээллийн хүртээмж ба дэмжлэг

Иргэд зөвлөлдөх хэлэлцүүлэгт оролцохын тулд хангалттай, найдвартай мэдээлэлтэй байх шаардлагатай. Гэвч Монголд бодлого, төсөл, төсвийн мэдээлэл олон нийтэд хязгаарлагдмал байдлаар хүрдэг бөгөөд энэ нь хэлэлцүүлгийн чанарт сөргөөр нөлөөлдөг.

Зөвлөлдөх ардчиллын хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг хуулийн, институцийн, улс төрийн, нийгэм соёлын түвшинд ангилж болно.

1. Хууль эрх зүйн хүчин зүйлс

Иргэдийн оролцооны хууль эрх зүйн зохицуулалт дутмаг.

Зөвлөлдөх хэлэлцүүлгийн үр дүнг бодлого, хуульд нэвтрүүлэх механизмыг хуульчилж өгөөгүй.

Иргэдийн санал авах заавар, журмыг стандартчилаагүйгээс институцийн хувьд зөвлөлдөх ажиллагаа тогтмол хэрэгждэггүй.

2. Институцийн хүчин зүйлс

Төрийн байгууллагуудын бүтэц, хариуцлагын тогтолцоо нь зөвлөлдөх хэлэлцүүлгийг дэмжихгүй. Хэлтсүүд хоорондын уялдаа сул, нээлттэй мэдээллийн урсгал хангалтгүй.

Институцийн дотоод соёлд иргэдийн санал, зөвлөмжийг бодит шийдвэрт нэвтрүүлэх механизм дутмаг.

3. Улс төрийн хүчин зүйлс

Намын төвлөрсөн бүтэц нь бодлого боловсруулах явцад иргэдийн оролцоог хязгаарлана.

Улс төрийн тогтвортой бус нөхцөл, намын дотоод тохиролцоо нь зөвлөлдөх хэлэлцүүлгийн үр дүнг сааруулдаг.

4. Нийгэм, соёлын хүчин зүйлс

Иргэдийн хэлэлцүүлэгт оролцох соёл, мэдээллийн боловсрол, төрд итгэх итгэл сул. Мэдээллийн хүртээмж муу нь оролцоог хязгаарлаж, зөвлөлдөх хэлэлцүүлгийн чанарыг бууруулдаг. Цахим оролцооны боломж, дижитал боловсролын түвшин нь ирээдүйд хүчин зүйл болж байна.

Эдгээр хүчин зүйлсийн харилцан нөлөө нь зөвлөлдөх ардчиллын хэрэгжилтэд системийн төвшинд бэрхшээл үүсгэдэг бөгөөд зөвхөн нэг хүчин зүйлийг сайжруулснаар асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй байгааг судалгаагаар нотлон харуулсан.

Зөвлөлдөх ардчиллын хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаанд оролцогчдыг тоон судалгаанд оролцсон оролцогчид (иргэд) болон ярилцлагад оролцсон оролцогчид (Зөвлөлдөх санал асуулгын зохион байгуулалтад орсон болон асуулгад хөдөө орон нутгаач ирсэн оролцогчид) гэж хоёр бүлэгт хуваан авч үзсэн.

Монгол Улсын Статистикийн Ерөнхий газраас гаргадаг тайлангийн тоо мэдээнд үндэслэн иргэдээс авах судалгааг эх олонлогоор сонгон судалгааны түүврийг тооцоолсон болно. Хот суурин газар, аймгийн төвийн болон, алслагдсан сумуудын иргэдийг тэнцүү тоотой хамруулах зорилгоор пропорциональ буюу хувь тэнцүү давхаргат түүврийн аргыг сонгон судалгаандаа хэрэглэсэн. Хувь тэнцүү давхаргат түүврийн аргад үндэслэн түүврийг дараах байдлаар тооцоолсон. Судалгаанд нийт хүн амын амын 1 хувийг хамруулах зорилгоор 1000 иргэнийг судалгаанд хамруулсан.

Хүснэгт-1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл
(Нас, хүйс, боловсролын байдлаар)

Оролцогчдын мэдээлэл		Хувь	Тоо
Хүйс	Эр	52.7	527
	Эм	47.3	473
Нас	18-25	21.3	213
	26-35	22.9	229
	36-45	25	250
	46-55	18.1	181
	56-65	9	90
	66-аас дээш	3.7	37
Боловсрол	Бусад	0	0
	Бүрэн бус дунд	17	170
	Бүрэн дунд	34.6	346
	Техник болон мэргэжлийн	7.4	74
	Дээд	41	410
Ажил эрхлэлт	Ажил хийдэггүй	16.5	165
	Оюутан	9	90
	Тэтгэвэрт	11.7	117
	Малчин	10.6	106
	Хувийн байгууллагад ажилладаг	17.6	176
	Төрийн байгууллагад ажилладаг	34.6	346
Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн	77.32	773
	Гэрлээгүй	15.48	154
	Салсан	4.92	49
	Бэлэвсэн	2.37	23

Хүснэгт-2. Хүчин зүйл хоорондын хамаарлын шинжилгээ- Correlations

Хүчин зүйл хоорондын хамаарлын шинжилгээ- Correlations						
	Зөвлөлдөн оролцооны түвшин	Мэдээллийн эх үүсвэртэй	Нийслэл, дүүрэг, хорооны удирдлага оролцоог чухалчлах хандлага	Зөвлөлдөх оролцооны талаарх иргэдийн хандлага	Нийслэл, дүүрэг, хорооны удирдлагын институцид итгэх итгэл	Нийгэм эдийн засгийн хөгжил
Зөвлөлдөх оролцооны түвшин	1	.508**	.401**	.284**	.292**	.320**
Мэдээллийн эх үүсвэр	.508**	1	.463**	.430**	.327**	.441**
Нийслэл, дүүрэг, хорооны удирдлагууд оролцоог чухалчлах	.401**	.463**	1	.663**	.573**	.549**
Зөвлөлдөх оролцооны талаарх иргэдийн хандлага	.284**	.430**	.663**	1	.755**	.707**
Нийслэл, дүүрэг, хорооны удирдлагын институцид итгэх итгэл	.292**	.327**	.573**	.755**	1	.717**
Нийгэм эдийн засгийн хөгжил	.320**	.441**	.549**	.707**	.717**	1
Зөвлөлдөх оролцоог хангаснаар бий болох үр өгөөж	.529**	.451**	.572**	.594**	.632**	.618**
Зөвлөлдөх оролцоонд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлс	.298**	.329**	.430**	.599**	.619**	.636**
Зөвлөлдөх санал асуулгын зүйн орчин	.463**	.288**	.399**	.420**	.478**	.539**

Судалгаанд оролцогчдын 527 буюу 52.7% эрэгтэй, 473 буюу 47.3% эмэгтэй, насыг 5 бүлэгт хувааж авч үзэхэд 21.3 хувь нь 18-25, 22.9 хувь нь 26-35, 25 хувь нь 36-45, 18.1 хувь нь 46-55, 9 хувь нь 56-65, 3.7 хувь нь 66-аас дээш насныхан;

Боловсролын түшингээр авч үзвэл 41 хувь нь дээд, 7.4 хувь нь техник мэргэжлийн, 34.6 хувь нь бүрэн дунд, 17 хувь нь бүрэн бус дунд оролцогчид байна.

Гэрлэлтийн байдлыг авч үзвэл 77.32 хувь нь гэрлэсэн, 15.48 хувь нь гэрлээгүй, 4.92 хувь нь салсан, 2.37 хувь нь бэлэвсэн байна. Ажил эрхлэлтийн байдлыг нь авч үзэхэд 34.6 хувь нь төрийн байгууллагат, 17.6 хувь нь хувийн байгууллагат, 10.6 хувь нь малчин, 22 буюу 11.7 хувь нь тэтгэвэрт, 9 хувь нь оюутан, 16.5 хувь нь ажил хийдэггүй оролцогчид байсан.

Хүчин зүйл хооронд хамаарлын шинжилгээ

Хүснэгт-3. Иргэдийн зөвлөлдөх оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ

Model Summary				
Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate
1	.832[a]	.751	.437	.51637

Зөвлөлдөх оролцоонд нөлөөлж байгаа үндсэн хүчин зүйлс болон үзүүлэлтүүд хооронд хамаарлын хүчийг корреляцийн коэффициентээр хэмжихэд дараах үр дүн гарсан.

Нийслэл, дүүрэг, хорооны удирдлагын институцид итгэх итгэл, зөвлөлдөх оролцоог хэрхэн ойлгож байгаа иргэдийн хандлага нь 0.755 хүчтэй, зөвлөлдөх санал асуулгын эрх зүйн орчин, мэдээллийг олж авдаг мэдээллийн эх үүсвэртэй холбоотой хүчин зүйлтэй 0.288 сул эерэг хамаарал тус тус ажиглагдаж байна.

Эндээс хүчин зүйлсийн хооронд шугаман регрессийн шинжилгээ гүйцэтгэж болохоор байна. Зөвлөлдөх санал асуулгын эрх зүйн орчин, мэдээллийг олж авдаг эх үүсвэр, Нийслэл, дүүрэг, хорооны удирдлагын институцид итгэх итгэл итгэл, Удирдлагын байгууллагын иргэдийн оролцоог чухалчлах хандлага, Зөвлөлдөх оролцоонд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлс, Зөвлөлдөх оролцоог хангаснаар бий болох үр өгөөж, нийгэм эдийн засгийн хөгжил зэрэг орно.

Хүснэгт-4. Зөвлөлдөх оролцоог хэрхэн ойлгож байгаа иргэдийн хандлага

ANOVA[a]						
Model		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
1	Regression	208.597	8	26.075	97.791	.000[b]
	Residual	264.236	991	.267		
	Total	472.833	999			

Регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад зөвлөлдөх оролцооны түвшин болон хүчин зүйлүүдийн хооронд 0.832 буюу хүчтэй хамаарал ажиглагдаж, 95 p(sig)=0.000<0.05 байгаа нь статистикийн ач холбогдолтойг илтгэж байна. Мөн детерминацын коэффициент 0.751 байгаа нь оролцооны түшингийн 75.1 хувийг дээрх 8 хүчин зүйлүүд тайлбарлах ба үлдсэн хувь нь авч үзээгүй хүчин зүйлээр тайлбарлагдана.

Регрессийн дисперсийн шинжилгээний үр дүнгээс харахад оролцооны түвшин болон хүчин зүйлүүдийн хоорондох шугаман регрессийн тэгшитгэлийн хэлбэр зөв болохыг Фишерийн шалгууураар F=97.791 буюу 95 p(sig)=0.000 <0.05 байгаа нь статистикийн ач холбогдолтойг илтгэж байна.

Мөн Дэлхийн үнэт зүйл, үнэлэмжийн холбооны судалгааны үр дүнгээс үзэхэд Зөвлөлдөх санал асуулгыг амжилттай явуулахад нөлөөлөх хүчин зүйлд Төрийн үйлчилгээний чанар, Мэдээллийн ил тод байдал, Хариуцлагатай засаглал, Дахин оролцох хүсэл, итгэл найдвар төрж байгаа байдал үнэмлэхүй өндөр үнэлгээтэй байна. Төрийн үйлчилгээний чанар хамгийн өндөр буюу 0.5 пункт, Үр дүнгийн ил тод байдал 0.47 пункт, Дахин оролцох хүсэл, итгэл найдвар төрж байгаа 0.48 пунктээр дээгүүр оноо авсан зэргээс үзэхэд эдгээрийн нөлөө нь иргэдэд дадал хэвшил суулгах чухал болохыг харуулж байна.


Үүнээс Үр дүнгийн ил тод байдал, Дахин оролцох хүсэл, санал тоологдох байдал зэрэг нөлөөтэй гэж гарсан байна. Дахин оролцох хүслийг орон нутгаас ирсэн иргэд хэлэх ч бусад төлөөлөл процесийн шинжтэй зүйлийг олж хараагүй байсан. Зөвлөлдөх санал асуулгад оролцох нь Монголчууд асуудлаа хамтаараа оролцоогоороо шийддэг соёлд суралцах нэг хөшүүрэг болох боломжтой харагдаж байна.

Монгол дахь зөвлөлдөх ардчиллын хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааг Ардчиллын хөгжилд зөвлөлдөх санал асуулгын замын шинжилгээ, Зөвлөлдөх санал асуулгад иргэдийн оролцооны замын шинжилгээ, (тоон утгатай), Зөвлөлдөх санал асуулгын хууль хэрэгжилтийн замын шинжилгээ (тоон утгатай), зөвлөлдөх санал асуулгын стратегийн сайжруулалтын төлөвлөлтийг гаргасан.

Дээрх асуулгуудын тоон утгын өндөр үнэлгээтэй үзүүлэлтэд сонгуулийн оролцоо(4.1/5.0), иргэдийн болон нийгмийн санаа бодол 4.1/5.0, дундаж үнэлгээнд төсөл хөтөлбөрт оролцох - 3.9/5.0, дахин оролцох хүсэл - 3.9/5.0, төрийн мэдээллийн хүртээмж - 3.9/5.0, онлайн мэдээллийн хандлага - 3.8/5.0, бага үнэлгээнд Авлигын эсрэг хяналт - 3.1/5.0 (хамгийн бага), Үйл ажиллагааны хяналт - 3.2/5.0, Санхүүжийн баталгаа - 3.2/5.0, Хүчин чадлын


бүрдэлт - 3.3/5.0, төрийн бодлогод нөлөөлсөн байдал - 3.3/5.0 (хамгийн бага), саналыг тооцогдсон байдал - 3.4/5.0, хариу цаашдын байдал - 3.5/5.0, мэдээллийн бүрэн байдал - 3.6/5.0 зэргийг тодорхойлжээ.

Зураг 1: АРДЧИЛЛЫН ХӨГЖИЛД ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН PATH ANALYSIS-Замын шинжилгээ (Тоон үзүүлэлттэй)



Гол дүгнэлтүүд:

Хамгийн өндөр үнэлгээ: Сонгуулийн оролцоо (4.1/5.0)
Хамгийн бага үнэлгээ: Шархлагийн эсрэг тэмцэл (2.8/5.0)
Хамгийн өндөр нөлөө:
Иргэдийн оролцоо → Ардчиллын хөгжил (0.42)
Хамгийн сул нөлөө:
Хууль тогтоомжийн процессод оролцох → Иргэдийн оролцоо (0.28)
Чухал ажиглалтууд:
Төрийн үйлчилгээний чанар (3.7) нь төрийн байгууллагуудын хариуцлагад
хамгийн их нөлөөтэй (0.43)
Албан тушаалтны өмчийн ил тод байдал (2.9) нь хамгийн муу үнэлэгдсэн
Сонгуулийн оролцоо (4.1) өндөр боловч хууль тогтоомжийн процессод оролцох (2.9)
маш бага
Энэхүү анализ нь ардчиллын хөгжлийг сайжруулахад аль чиглэлд анхаарах хэрэгтэйг тодорхойлоход тусална.



Гол үзүүлэлтүүдийн шинжилгээ:

Өндөр үнэлгээтэй (4.0+)
- Сонгуулийн оролцоо - 4.3/5.0 (хамгийн өндөр)
- Нийгмийн санал бодол - 4.1/5.0
- Санал хөтөлбөрийн мэдээлэл - 4.0/5.0
- Санал асуулгын ойлгомжтой байдал - 4.0/5.0

Дундаж үнэлгээтэй (3.5-3.9)
- Төсөл хөтөлбөрт оролцох - 3.9/5.0
- Дахин оролцох хүсэл - 3.9/5.0
- Төрийн мэдээллийн хүртээмж - 3.9/5.0
- Онлайн мэдээллийн хандлага - 3.8/5.0

Доод үнэлгээтэй (3.0-3.4)
- Төрийн бодлогод нөлөөлсөн байдал - 3.3/5.0 (хамгийн бага)
- Саналыг тооцогдсон байдал - 3.4/5.0
- Хариу цаашийн байдал - 3.5/5.0

Мэдээллийн бүрэн байдал - 3.6/5.0

Чухал ажиглалтууд:

Хамгийн өндөр нөлөө:
- Иргэдийн идэвхжил → Нийт үр дүн (0.46)


Хамгийн өндөр үнэлгээ:
- Сонгуулийн оролцоо (4.3/5.0)

Хамгийн бага үнэлгээ:
- Төрийн бодлогод нөлөөлсөн байдал (3.3/5.0)

Хамгийн сул нөлөө:
- Хариу цаашийн байдал → Арга хэлбэрийн чанар (0.38)

Сайжруулах чиглэлүүд:
- Саналыг тооцох, төрийн бодлогод нөлөөлөх үйл явцыг ил тод болгох
- Хариу цаашийн системийг боловсронгуй болгох
- Мэдээллийн бүрэн байдлыг нэмэгдүүлэх

Зураг 3: **ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГА - ХУУЛЬ ХЭРЭГЖИЛТИЙН РАТН ANALYSIS**



Гол үзүүлэлтүүдийн шинжилгээ:

Өндөр үнэлгээтэй (3.8+)

- Хууль тогтоомжийн тогтолцоо - 4.0/5.0 (хамгийн өндөр)
- Эрх зүйн баримтлал - 3.9/5.
- Нийгмийн хүсэлтэд таарсан байдал - 3.8/5.0
- Иргэдийн санал бодол - 3.8/5.0

Дундаж үнэлгээтэй (3.4-3.7)

- Үр дүнгийн үнэлгээ - 3.7/5.0
- Төслийн бэлдэлтийн чанар - 3.7/5.0
- Нийгмийн нөлөөний үнэлгээ - 3.5/5.0
- Хүрээгжүүлэлтийн төлөвлөгөө - 3.5/5.0

Доод үнэлгээтэй (3.0-3.3)

- Авлигын эсрэг хяналт - 3.1/5.0 (хамгийн бага)
- Үйл ажиллагааны хяналт - 3.2/5.0
- Санхүүжийн бааталта - 3.2/5.0
- Хүчин чадлын бүрдэлт - 3.3/5.0

Чухал ажиглалтууд:

Хамгийн өндөр нөлөө: Хууль зүйн зохиомж → Хууль хэрэгжилт (0.45)

Хамгийн өндөр үнэлгээ: Хууль тогтоомжийн тогтолцоо (4.0/5.0)

Хамгийн бага үнэлгээ: Шархлагийн хяналт (3.1/5.0)

Хамгийн сул нөлөө: Шархлагийн хяналт → Хяналт шалгалт (0.36)

Сайжруулах чиглэлүүд:

Яаралтай сайжруулах (3.1-3.3 үнэлгээтэй):

Авлигын эсрэг хяналтын систем

Санхүүжийн баталт

Үйл ажиллагааны хяналт

Дунд хугацааны сайжруулах (3.4-3.6 үнэлгээтэй):

Хүчин чадлын бүрдэлт

Дахин тохируулалтын механизм

Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө


Энэхүү анализ нь зөвлөлдөх санал асуулгын хуулийн хэрэгжилтийг сайжруулахад аль чиглэлд анхаарах хэрэгтэйг тодорхойлоход тусална.

Дээрх иргэдийн оролцооны судалгааны өгөгдлөөс зөвлөлдөх ардчилалтай холбоотой хувьсагчуудаар нь path analysis-ийн диаграмыг тоон утгатайгаар хийгээд өгөөч

СТРАТЕГИЙН САЙЖРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Стратегийн сайжруулалтын төлөвлөлтийг урт, дунд, богино хугацаагаар төлөвлөж гаргаж, хугацааны байдлын үнэлгээг хийсэн. 5 жилийн дотор ардчиллын үнэлгээг 3.7-ээс 4.2 хүртэл дээшлүүлэх, энэ нь 13.5%-ийн өсөлт бөгөөд ардчилсан засаглалын түвшинг мэдэгдэхүйц сайжруулахд чиглэнэ. Хугацааны хувьд төрлийн судалгаагаар ирээдүйд сайжруулалт хэрхэн хийх вэ гэж үзэхэд ойрын хугацаанд 0.1, дунд хугацаанд 0.3 пункт, 5 жил буюу стратегийн хэмжээнд 0.5 пунктээр хийж байж үр дүнд хүрнэ. Энэ нь 5 жилийн төлөвлөлт шаардлагатай, зөвлөдөх арчдиллын хөгжил, асуудлыг иргэдийн оролцоотой зөвлөдөх санал асуулгын механизмээр шийдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэхдээ гол анхаарах чиглэлийг авлигын эсрэг тэмцэл, ил тод байдал, иргэдийн оролцооны механизмыг тодорхой болгох шаардлагатай.

Зураг-4 Стратегийн сайжруулалтын төлөвлөлтийн байдал



ЯРИЛЦЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны ярилцлагын шинжилгээний хүрээнд Монгол Улсад зохион байгуулсан үе үеийн зөвлөлдөх санал асуулгад оролцож ажилласан Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд болон төрийн байгууллага, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны байгууллага, хууль санаачлагчид болон хөдөө орон нутгаас сонгогдон оролцсон иргэдийн төлөөллийг оролцуулсан.

Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд болон төрийн байгууллагын төлөөлөл нь процесс, зохион байгуулалтын талаар илүү анхаарч байхад, ШУБ төлөөлөл болон хууль санаачлагчид нь ардчилсан үнэ цэн, ирээдүйн хэтийн төлвийг илүү онцолж байсан.

Орон нутгийн төлөөлөл нь бодит амьдрал дахь нөлөөллийг, ТББ төлөөлөл нь иргэний оролцооны механизмийн үр дүнтэй байдлыг нотлох тал дээр анхаарч ажилладаг нь ажиглагдсан. Энэхүү олон талын төлөөлөл нь зөвлөлдөх санал асуулгын бүрэн бүтэн байдал, төлөөллийн чанарыг харуулж байна.

Хүснэгт -4 Оролцооны субьект, үүргийн ялгаа

	Төлөөлөл	Гол санаанууд	Онцлог:
1	Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд (6 хүн)	- Процессийн бүрэн бүтэн байдал буюу хууль, журам зөрчихгүй байх - Өгөгдлийн ач холбогдол, дата мэдээлэл боловсруулах - Үр дүнгийн хэрэгжүүлэлт буюу зөвлөмж өгснөөр ажил дууслаа гэж бодохгүй байх	Процессийн ил тод байдалд анхаарах Өгөгдлийн шинжилгээний ач холбогдолд анхаарах Үр дүнгийн хэрэгжүүлэлтийн талаар итгэлтэй бус байх
2	Шинжлэх ухааны байгууллагын төлөөлөл (ШУБ) (5 хүн)	- Ардчиллын амин сүнс ерөөсөө төрийг удирдах үйл хэрэгт ард түмнийг оролцуулах - Иргэдийн идэвхтэй, оролцоотой байдлыг дэмжих - Зөв мэдлэг, мэдээлэлтэй хүн л зөв шийдвэр гаргахыг дэмжих	Онолын үндэслэлтэй хандах Ардчилсан үнэ цэнийг онцлох Боловсролын ач холбогдлыг нэмэгдүүлэх
3	Төрийн байгууллагын төлөөлөл (4 хүн)	- Хууль эрх зүйн хүрээ буюу Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн хүрээнд зохион байгуулах - Бүх бүлгийг төлөөллийг оролцуулах - Статистикийн аргачлалаар 1570 хүн нь 1.8 сая иргэнийг хангалттай төлөөлөх боломжтой	Албан ёсны байр суурьтай хандах Процессийн хууль ёсны байдлыг онцолж байна Статистикийн мэргэжлийн аргачлалыг ашиглах
4	Орон нутгаас оролцогчдын төлөөлөл (2 хүн)	- Бодит туршлага хуримтлуулах - Орон нутгийн асуудлыг нэг ч миний, манай аймаг, сумын асуудал гэсэн хувийн явцуу өнцгөөс хандахгүй - Санамсаргүй түүврийн сонголт гэдэгт хүмүүс эргэлзээтэй ханддаг	Бодит амьдралын туршлагаас хуваалцах Орон нутгийн асуудлыг илүүтэй анхаарах Процессийн шударга байдлыг хамгаалж байна
5	Хууль санаачлагчдын төлөөлөл (3 хүн)	- Түүхэн ач холбогдолыг хадгалах - Монголын төр оршин тогтнож, монголын ард түмэн байгаа цагт ард түмний дуу хоолой бүхнээс	Урт хугацааны хэтийн төлвөөр хандах Ардчилсан үнэ цэнийг хадгалах

		хүчтэй байх итгэл үнэмшлийг бий болгох - Ирээдүйд гарах зөрчил, тэмцлийг багасгах	Эвлэлдэх, нэгдэхэд дэмжлэг үзүүлэх
6	ТББ-ийн төлөөлөл (2 хүн)	- Эирийн иргэд төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд оролцох - Механизмын үр дүнтэй байдлыг бий болгох - Зөвлөлдөх уулзалт гэдэг маш хэрэгтэй механизм бүрдэх - Бие даасан байдал буюу аль нэг улс төрийн нам, удирдах албан тушаалтан оролцоогүй байх	Иргэний оролцооны ач холбогдал Механизмын үр дүнтэй байдлыг нотлох Төрийн бус байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх

Ярилцлагыг харьцуулан шинжилэхэд нийтлэг онцлогууд нь процессийн амжилтыг хүлээн зөвшөөрч, ихэнх нь үр дүнгийн хэрэгжүүлэлтийн ач холбогдлыг онцолж, иргэдийн идэвхтэй оролцооны байдлыг сайшааж байна

Харин ажил албан тушаал, оролцогчийн үүрэг хариуцлагаас хамаарч анхаарах гол асуудал болон баримтлах үзэл баримтлалын тал дээр олон төрлийн ялгаатай байр суурь, онцлогууд илэрсэн.


Хүснэгт-5: Ялгаатай онцлогууд

Бүлэг	Гол анхаарал	Баримтлах үзэл баримтлал
Зөвлөлийн гишүүд	Процесс, өгөгдөл	Хууль ёс, мэргэжлийн байдал
ШУБ төлөөлөл	Ардчилал, боловсрол	Онол, судалгаа
Төрийн төлөөлөл	Зохион байгуулалт, хууль	Албан ёсны байр суурь
Орон нутгийн төлөөлөл	Бодит амьдрал, орон нутаг	Туршлага, практик
Хууль санаачлагчид	Ирээдүй, үнэ цэнэ	Стратеги, итгэл
ТББ төлөөлөл	Иргэний оролцоо, механизм	Нийгмийн оролцоо

Монгол Улсын төрийн бодлогод зөвлөлдөх ардчиллын механизмыг хэрэглэхэд нөлөөлөх зарим хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн (эксперт)

Экспертүүдийн ярилцлагад олон төрлийн төлөөллийг оролцуулан ярилцахад ялгаа байна. Процесийн хувьд орон нутагт бодит амьдралд өөрчлөлт гарах асуудалд, ШУБ төлөөлөл баялгийн сан дээр шударга тэгш байдлыг эрхэмлэх, орон нутагт хүртээмжтэй хуваарилалт хүсдэг. Талууд өөрсдөө ялгаатай байр суурьтай байгаа тул үр дүн өөр өөр гарч байна. Ардчиллын онолыг орхигдуулж, монгол маягаар асуудалд хандаж байгаа нь зарим гажуудлыг бий болгож, бусдын эрхийг хязгаарлаж байна.

Зураг-5: Экспертүүдийн ярилцлага, оролцооны ялгаа



Гол үзүүлэлтүүдийн шинжилгээ:

Өндөр үнэлгээтэй (3.8+)

- Хууль тогтоомжийн тогтолцоо - 4.0/5.0 (хамгийн өндөр)
- Эрх зүйн баримтлал - 3.9/5.
- Нийгмийн хүсэлтэд таарсан байдал - 3.8/5.0
- Иргэдийн санал бодол - 3.8/5.0

Дундаж үнэлгээтэй (3.4-3.7)

- Үр дүнгийн үнэлгээ - 3.7/5.0
- Төслийн бэлдэлтийн чанар - 3.7/5.0
- Нийгмийн нөлөөний үнэлгээ - 3.5/5.0

Чухал ажиглалтууд:

Хамгийн өндөр нөлөө: Хууль зүйн зохиомж → Хууль хэрэгжилт (0.45)

Хамгийн өндөр үнэлгээ: Хууль тогтоомжийн тогтолцоо (4.0/5.0)

Хамгийн бага үнэлгээ: Шархлагийн хяналт (3.1/5.0)

Хамгийн сул нөлөө: Шархлагийн хяналт → Хяналт шалгалт (0.36)

Сайжруулах чиглэлүүд:

Яаралтай сайжруулах (3.1-3.3 үнэлгээтэй):

Авлигын эсрэг хяналтын систем

- Хүрээгжүүлэлтийн төлөвлөгөө - 3.5/5.0

Доод үнэлгээтэй (3.0-3.3)

- Авлигын эсрэг хяналт - 3.1/5.0 (хамгийн бага)
- Үйл ажиллагааны хяналт - 3.2/5.0
- Санхүүжийн бааталта - 3.2/5.0
- Хүчин чадлын бүрдэлт - 3.3/5.0

Санхүүжийн баталт
Үйл ажиллагааны хяналт
Дунд хугацааны сайжруулах (3.4-3.6 үнэлгээтэй):
Хүчин чадлын бүрдэлт
Дахин тохируулалтын механизм
Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө

Энэхүү анализ нь зөвлөлдөх санал асуулгын хуулийн хэрэгжилтийг сайжруулахад аль чиглэлд анхаарах хэрэгтэйг тодорхойлоход тусална.

Зөвлөлдөх ардчиллын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг бүлэглэж үзвэл:

1. Зөвлөлдөх санал асуулгыг чухалчлах хандлагатай байх
2. Зөвлөлдөх гэдгийг хэрхэн ойлгож байгаа иргэдийн хандлага
3. Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах институцид итгэх итгэл
4. Зөвлөлдөх санал асуулгад нөлөөлөх эдийн засгийн хүчин зүйл
5. Зөвлөлдөх санал асуулгад оролцсоноос үүсэх үр ашиг
6. Өөрт хэрэгтэй байгаа мэдээллийг олж авдаг мэдээллийн эх үүсвэр
7. Иргэдэд хамгийн их хүрч мэдээллийн агуулга
8. Зөвлөлдөх сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлс

Дүгнэлт

Судалгаан ажлын хүрээнд дэлхийн зарим улсын туршлагыг судалж үзлээ. Эндээс үзэхэд зөвлөлдөх ардчилал нь ардчиллын тогтолцоог бий болгох шийдлийг бүрдүүлэх үндсэн механизм болох нь харагдаж байна. Ард иргэдийн төлөөллийн шийдвэрийн түвшинд шууд хүргэх механизм гэдэг нь харагдаж байна.

Монгол Улсад зохион байгуулагдсан зөвлөлдөх санал асуулгуудын үр дүнд зөвлөмж гардаг. Зөвлөмж боловсруулахад нөлөөлөх хүчин зүйл, оролцогч талууд, зохион байгуулалт, санал асуулгын үр дүнд гарах зөвлөмж боловсруулах үндсэн загварчлалыг боловсрууллаа.

Дэлхийн улс орнуудын ардчиллыг төрийн бодлогодоо нэвтрүүлсэн туршлага, нөхцөл байдлын харахад төрийн бодлогод иргэдийн оролцоог хангах, үзэл бодлыг тусгах, өөрсдөөр нь хүлээн зөвшөөрүүлэх, зөвлөлдөх ардчиллыг өөрийн орны онцлогт тохируулан хөгжүүлэх, судлах хандлага нэмэгдэж байна. Энэ нь зөвлөлдөх ардчилал иргэдийн бодит оролцоог хангахад гарцаагүй хэрэгтэй байгааг харуулж байна.

Бусад улс орнуудад зөвлөлдөх ардчиллын механизмыг хэрэглэн иргэдийн дунд тодорхой асуудлаар зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах санхүүжилт, урамшуулал, иргэдийг татан оролцуулах хэлбэр, өдөөлт, хувийн нууцийг хамгаалах хууль, эрх зүйн орчин, даяаршсан нийгэмд оролцогчид нь улс, үндэс, хэл, шашин үл хамааран сонгогдох, зөвлөлдөх ардчиллын тогтсон систем, байхгүй, улс орон бүр өөрийн онцлогт тааруулан судлах, хөгжүүлэлт хийх, өөрийн орны загварыг бий болгох (Япон маягын зөвлөлдөх ардчилал), эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад хүний нөөцийг бэлтгэх зэргээр нийтлэг хүндрэл бэрхшээл тулгардаг байна. Хамгийн гол хүндрэл бэрхшээл нь иргэдийг мэдээллээр хангах, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, анагаах ухаан гэх мэт нарийн мэдлэг, ур чадвар шаардсан салбарын асуудлаар зөвлөлдөх ардчиллыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран бэлтгэх, чадавхжуулах асуудлууд байна.

Монгол оронд өнөөгийн нөхцөлд зөвлөлдөх асуулгын хэрэгцээ, шаардлага бий юу гэдэг асуудлаар иргэдийн дунд санал асуулга явуулахад санал асуулгад оролцсон иргэдийн 86 хувь нь зөвлөлдөх ардчиллын санал асуулгуудад оролцож байсан гэдэг хариулт өгсөн. Эсрэгээр хууль эрх зүйн санал асуулгад дээр оролцогчдын 82 хувь нь зөвлөлдөх санал асуулгын хуулийг огт мэдэхгүй байна гэж хариулсан. Алдаатай гарч буй гол шалтгаан нь төрийн албаны чадавхи муу, иргэдийн идэвх оролцоо сул, засаглал сул гэж нийт асуулгад оролцогчдын 71 хувь нь хариулсан. Гэвч иргэд өөрийн саналыг төрийн бодлогод тусгах нь таатай сэтгэгдэл төрүүлнэ гэж хариулсан.

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

Francis , Francis Fukuyama. “The End of History?” The National Interest NO.16, Summer 1989: 3 18. Francis , Fukuyama.
Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн. Улаанбаатар: "Монсудар" хэвлэлийн газар, 2006. Steven, Smith. “Hegel's Critique of Liberalism.” American Political Sience Review 80 NO 1, 1986: 121-139.
Платон. Төр улс. Улаанбаатар, 2005. Fukuyama.stanford.ed
Habermas, J. (1996). *Between Facts and Norms: Contributions to a Discourse Theory of Law and Democracy.* MIT Press.

Cohen, J. (1997). *Deliberation and Democratic Legitimacy.* In Bohman & Rehg (Eds.), *Deliberative Democracy: Essays on Reason and Politics.* MIT Press.
Fishkin, J. (2009). *When the People Speak: Deliberative Democracy and Public Consultation.* Oxford University Press.
OECD (2020). *Innovative Citizen Participation and New Democratic Institutions: Catching the Deliberative Wave.*
Монгол Улсын Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль (2015)
Cohen, J. (1989). *Deliberative democracy and democratic legitimacy.* In A. Hamlin & P. Pettit (Eds.), *The good polity: Normative analysis of the state* (pp. 17–34). Blackwell.
Dryzek, J. S. (2000). *Deliberative democracy and beyond: Liberals, critics, contestations.* Oxford University Press.
Fishkin, J. S. (2009). *When the people speak: Deliberative democracy and public consultation.* Oxford University Press.
Habermas, J. (1989). *The structural transformation of the public sphere.* MIT Press

SOME ISSUES CONSIDERED IN THE APPLICATION OF THE MECHANISM OF "DEPUTY DEMOCRACY" IN THE MONGOLIA STATE POLICY

Abstract: Researchers have considered the concept of deliberative democracy in the theories and concepts of democracy and studied it at the theoretical and practical levels. Mongolian citizens have enjoyed their right to representation and representation from election to election for more than 30 years since the transition to a democratic system. The impact of changes and reforms in the system on the quality of life of citizens and the construction of a good society has been reflected in relevant studies.

Until now, there has been no system in place to ensure that citizens' will and ideas are reflected in state policies and laws aimed at improving their lives, and that their representatives listen to their concerns and resolve them in the way they want. Citizens have always lacked an understanding of pressing social issues that is scientifically based, based on research and analysis by professional organizations and experts, and based on accurate and factual information about the strengths and weaknesses of the issues.

It is considered important to conduct research and propose consultative proposals before starting the mechanism of consultative democracy, rather than pursuing it.

To this end, it is necessary to introduce the mechanism of consultative democracy in the process of making state policies and decisions. Considering the real conditions such as the lack of understanding and information about the culture of consultative democracy in our country, which has a democratic government and a high index of representative democracy, we aimed to analyze the factors affecting the introduction of the mechanism based on theory, experiments, and quantitative research and propose solutions.

Key words: Mechanisms of deliberative democracy, deliberative referendums, public policy, citizen participation, accurate information, consultation, consensus, and pressing social issues.

ПОЛИТОЛОГИ XXIV

Эрдэм шинжилгээний бичиг №24: 147-165 дахь тал

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

П.Алтанчимэг
МУБИС, Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Улс төр судлалын докторант

Хураангуй:

Энэхүү өгүүлэлд гадаад улс орнуудын сонгуулийн төв байгууллагаас сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй туршлагыг судлан, улмаар Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны сонгогчийн боловсролыг дээшлүүлэх хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжилтийг сайжруулах арга замыг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үгс: Сонгогчийн боловсрол, сонгуулийн ерөнхий хороо, сонгууль, сонгуулийн ирц, улс төрийн соёл.

Удиртгал:

Төр, засгийн эрх мэдлийн легитим байдлыг хангах ардчилсан үндсэн хэлбэр нь сонгууль болохыг М.Вебер тэмдэглэсэн бол, Фрэнклин Рузвельт уг үйл явцын чанар нь сонгогчийн мэдлэгээс шалтгаалахыг сануулсан байдаг. Тэрээр “Сонгогчид нь сонголтоо ухаалгаар хийхэд бэлэн болоогүй цагт ардчилал амжилтад хүрэхгүй” гэдгийг цохон тэмдэглээд, боловсролыг “ардчиллын хамгаалагч” хэмээн нэрийдсэн юм.

Манай улс 1992 оноос шинэ ардчилсан үндсэн хууль (УИХ, Монгол Улсын Үндсэн хууль 1992)-иар 9 удаагийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль, мөн тооны Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгууль, 8 удаагийн Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг тус тус зохион байгуулж, сонгууль хэлбэрийн талаас боломжийн түвшинд бүрэлдэн тогтсон (СЕХ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн 1992-2024 2024). Гэвч агуулгын хувьд сонгогчийн боловсрол буюу иргэн бүрийн утга

учиртай оролцоог төдийлөн анхаарч үзээгүйн улмаас зарим түвшний сонгуулийг ирцийн босгогүй болгоход хүрсэн билээ.

Онол арга зүйн үндэслэл:

Тус өгүүллийн онол, арга зүйн суурь үндэслэл нь улс төрийн шинжлэх ухааны Институцийн шинэ онол (New Institutionalism), Үйл байдлын онол (Behavioral Theory) болон Оролцооны онол (Participation Theory)-ын хосолсон хандлагад тулгуурлана.

Сонгуулийн төв байгууллага нь зөвхөн хууль эрх зүйн хүрээнд сонгууль зохион байгуулах техник чиг үүрэгтэй бус, харин нийгмийн үнэт зүйл, ардчилсан соёлыг бүтээн төлөвшүүлэгч институт гэдэг агуулгаар тодорхойлогдоно (March & Olsen,, 1989) Энэхүү онолын үүднээс авч үзвэл, Сонгуулийн ерөнхий хорооны сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг нь иргэдэд зөвхөн санал өгөх зааварчилгаа өгөхөөр хязгаарлагдахгүй, харин ардчиллын "албан бус институци" болох итгэлцэл, улс төрийн соёлыг бэхжүүлэхэд чиглэсэн стратегийн механизм юм.

Энэхүү институцийн нөлөөлөл нь Үйл байдлын болон Оролцооны онолын огтлолцол дээр иргэдийн улс төрийн нийгэмшлийн үйл явцтай шууд холбогддог. Оролцооны онолын үзэл баримтлалаар иргэдийн оролцоо нь зөвхөн санал өгөх өдөр ирц бүрдүүлэх төдийхнөөр хязгаарлагдах ёсгүй бөгөөд харин шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, төрөөс хариуцлага нэхэх зэрэг өргөн хүрээг хамардаг (Arnstein 1969). Үүнд ардчилсан болон авторитар дэглэмийн суурь ялгаа оршино. Авторитар дэглэм нь иргэдийнхээ улс төрийн мэдлэг, оролцоог хязгаарлах замаар оршин тогтнодог бол ардчилсан төр нь иргэнээ өөрт нь хяналт тавих чадвартай болгож чадавхжуулдгаараа онцлог ялгаатай юм. Иймд сонгуулийн боловсрол нь иргэнийг төрийн үйл хэрэгт "идэвхгүй ажиглагч"-аас төрөө хянадаг, хариуцлага тооцдог "бодит оролцогч" болгон хувиргах гол хөшүүрэг болдог.

Өөрөөр хэлбэл, төрөөс олгож буй сонгогчийн боловсрол нь иргэдэд төрийн эрх мэдлийг хянах "босоо хариуцлага"-ын тогтолцоог хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг олгох зорилготой. Хэдийгээр сонгогчийн боловсрол нь иргэдийн хяналт тавих чадамжийг нэмэгдүүлэх хэрэгсэл боловч, үүнийг төрөөс санхүүжүүлэх нь эрх баригчдын суртал ухуулга болох эрсдэлтэй гэх либертариан шүүмжлэл (J. Samples 2004) олон улсад бий. Энэхүү эрсдэлийг хаах, улс төрийн тэгш өрсөлдөөнийг хангах гол баталгаа нь уг чиг үүргийг гүйцэтгэгч институцийн хараат бус байдал юм. Сонгуулийн төв байгууллага нь гүйцэтгэх засаглалаас хараат бус, бие даасан байх нь сонгогчийн

боловсролыг улс төрийн нөлөөллөөс ангид, төвийг сахисан байдлаар иргэдэд хүргэх, улмаар иргэдийн бодит оролцоо, хяналтад суурилсан сонгуулийн легитим шинжийг бэхжүүлэх үндсэн нөхцөл болдог байна.


Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх сонгуулийн төв байгууллагын чиг үүрэг:

Ардчилсан тогтолцооны тогтвортой байдлыг хангах гол тулгуур нь чөлөөт, шударга, ил тод сонгууль бөгөөд энэ нь иргэдийн идэвхтэй, хариуцлагатай оролцоонд тулгуурладаг (Democracies 2000). Сонгогчийн оролцоо нь зөвхөн санал өгөх ирцийн тоон үзүүлэлтээр хэмжигдэхгүй, харин ардчиллын үнэт зүйлийг ухамсарлах, сонгуулийн утга агуулгыг ойлгох, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах чадвар, иргэний оролцооны соёлд илэрдэг (Aceproject 2025). Энэ бүхнийг төлөвшүүлэхийн үндэс нь **сонгогчийн боловсрол** бөгөөд олон улсын жишигт ACE Electoral Knowledge Network, The Carter Center болон International IDEA зэрэг байгууллагууд сонгогчийн боловсролыг төрийн институтийн, ялангуяа сонгуулийн төв байгууллагын зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг гэж үздэг (center 2005).

Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл түгээх асуудлыг сонгуулийн төв байгууллагын үүрэгт оруулж хуульчлах явдал сүүлийн жилүүдэд улам бүр нэмэгдэж байна. Сонгуулийн төв байгууллагын чиг үүрэгт оруулан хуульчилснаар сонгогчийн боловсролын үйл ажиллагааны зардлыг хязгаарлах үндэслэлээс хамгаалж, жил бүр тасралтгүй үргэлжлэх болон иргэд, сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг хариуцах институтийг тодорхой болгох, хэрэгжилтийг хянах, тайлагнах зэргээр давуу талууд бий болдог байна.

Байнгын ажиллагаатай сонгуулийн төв байгууллагын үйл ажиллагаа нь зөвхөн санал хураалтын техник ажиллагаа бус байнгын үргэлжлэх процесс бөгөөд тэр дунд сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг зайлшгүй багтана гэдгийг сонгуулийн төв байгууллагын үйл ажиллагааны сонгуулийн мөчлөг /Electoral cycle/-т дүрслэн харуулсан байдаг. Сонгуулийн төв байгууллагын үйл ажиллагаа нь сонгуулийн өмнө, сонгуулийн үеийн болон сонгуулийн дараах гэсэн 3 үед хуваах, тус бүрд хийгдэх ажлыг ерөнхий байдлаар тус дүрслэлд тусгасан байна. Энэхүү сонгуулийн мөчлөгийн загварыг International IDEA болон Европын Комисс хамтран 2005 онд боловсруулсан (IDEAInternational 2005)

Зураг 1. Сонгуулийн мөчлөг /Electoral Cycle/



Эх сурвалж: Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн /International IDEA/

Сонгогчийн боловсролыг төрийн үндсэн чиг үүрэг гэж үздэг байр суурийн эсрэгээр төр сонгогчийн боловсрол олгох нь буруу гэсэн байр суурьтай судлаач, судалгааны байгууллагууд мөн байна. Өөрөөр хэлбэл төрөөс сонгогчийн боловсролыг дэмжих шаардлагагүй, эсвэл төрөөс санхүүжүүлэх нь эрсдэлтэй гэж либертариан буюу төрийн оролцоог багасгах үзлийг баримталдаг судалгааны байгууллагууд үздэг. Сонгуулийн төв байгууллага нь сонгогчийн боловсрол дээшлүүлэх чиг үүрэгтэй байх нь буруу, эрсдэлтэй гэсэн үзлийн гол төлөөлөгчдөд Cato Institute “Government-Funded Voter Education Is Politically Risky” (J. Samples 2004), Илья Сомин (Ilya Somin**)** (Somin 2013) орно. Тэдний үзэж буйгаар дараах нөхцөл байдлын улмаас төр энэ үүргийг хэрэгжүүлэх нь буруу гэж үздэг. Үүнд:

1. Төр сонгогчийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлбэл энэ нь төр өөрийн эрх мэдлээ бататгах, иргэдийн саналд нөлөөлөх зэвсэг болж хувирч болзошгүй,
2. Төрөөс явуулж буй мэдээлэл, боловсрол нь ихэвчлэн одоогийн тогтолцоог (status quo) дэмжсэн шинжтэй байдаг тул иргэдэд шүүмжлэлт сэтгэлгээ суулгахаас илүүтэй төрд үнэнч байх хандлагыг төлөвшүүлдэг.
3. Сонгогчийн болон иргэний боловсролыг төрөөс санхүүжүүлэх нь улс төрийн өрсөлдөөний тэгш байдлыг алдагдуулж, эрх баригчид төрийн нөөцийг ашиглан иргэдийн үзэл санаанд нөлөөлөх эрсдэлтэй,

4. Сонгогчийн боловсрол нь төрийн бус байгууллага, нам, хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг болохоос төрийн үүрэг биш. Төр оролцсоноор хувийн хэвшлийн санаачилгуудыг шахах эрсдэлтэй.
5. Төр зөвхөн эрх зүйн мэдээлэл, сонгуулийн зохион байгуулалтын талаарх агуулгад хязгаарлагдах ёстой гэж үздэг,
6. Олон жил нэг нам дангаар ноёрхсон улс орнуудын хувьд төр сонгогчийн боловсрол олгох нь суртал ухуулгын шинжтэй ажил болно зэрэг үндэслэлээр төрөөс сонгогчийн боловсрол олгохыг эсэргүүцдэг байна.

Дээрх үзэл баримтлалтай холбоотойгоор сонгуулийн төв байгууллага нь бие даасан, хараат бус байх асуудал нь сонгогчийн боловсролын чиг үүргийг хэрэгжүүлэхэд чухлаар тавигддаг. Сонгуулийн төв байгууллагын бие даасан, хараат бус байгууллага нь зөвхөн эрх зүйн орчны төдийгүй төсөв, санхүү болон удирдлагын томилгоо, байгууллагын чадавх зэрэг цогц байдлаар авч үзэх нь зүйтэй. Түүнчлэн сонгуулийн төв байгууллага сонгогчийн боловсролын чиг үүргийг хэрэгжүүлж буй нөхцөлд төсвийн хөрөнгийг үр ашиггүй үрэхгүйн тул хяналт, үнэлгээ, сайжруулалтыг тогтмол хийх шаардлагатай.

Нэгдсэн үндэсний байгууллагаас гаргасан Women & Elections Guide to promoting the participation of women in elections гарын авлагын 5 дугаар бүлэгт "Яагаад сонгогчийг боловсруулах хэрэгтэй вэ?" гэдэг асуултад "Сонгуулийн үед сонгогчийн болон иргэний боловсрол нь бүх иргэд эрэгтэй, эмэгтэй гэлтгүй өөрсдийн эрх, улс төрийн тогтолцоо, шийдвэрлэх гэж буй асуудал, санал өгөх газар болон журмыг ойлгоход зайлшгүй шаардлагатай байдаг. Сонгууль **амжилттай, ардчилсан** байх нөхцөл нь иргэд өөрсдийн **эрх, үүргээ мэддэг, хууль ёсны хүчинтэй санал** өгөхөд хангалттай мэдлэг, мэдээлэлтэй байх, мөн **сонгуулийн үйл явцад ухамсартайгаар оролцох** чадвартай байх явдал юм" гэжээ.

Сонгогчийн боловсролын ачаар сонгогчид сонгуулийн үеэр аливаа хууль бус амлалт, ухуулга сурталчилгаанд амархан хууртагдахгүй, хэрсүү байж, аливааг олон талаас харах чадвартай болохоос гадна улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа, суртал ухуулгад "тэсвэртэй" болдог. ...ард түмэн засгаа гартаа авч, түүнийгээ төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээнээс шууд урган гарсанд оршино. Нөгөөтээгүүр сонгууль нь ганцаар дарангуйлах ёсноос ангид байх гэсэн ард түмний язгуур ашиг сонирхлыг бас илэрхийлдэг. Энэ хоёр зүйл нь сонгууль байхын хийгээд орхиж болдоггүйн үндсэн шалтгаан болно (Б.Чимид 2008).

Эдгээр шалтгаануудын улмаас төр сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хандлага Дэлхийн олон улсад нэмэгдэж байна.

Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг сонгуулийн төв байгууллагын чиг үүрэгт багтаасан улсуудын уг арга хэмжээг хэрэгжүүлэх хэлбэрийг дараах байдлаар ангилах боломжтой байна.

1. Институциональ болон Академик сургалтын загвар. Сонгуулийн төв байгууллага нь дэргэдээ байнгын ажиллагаатай сургалтын төв, институт байгуулж, эсвэл боловсролын яамтай шууд хамтран сургалтын хөтөлбөрийг өөрсдөө гардан хэрэгжүүлдэг. Энэ загварыг хэрэгжүүлж буй улсууд сонгогчийн боловсролыг "кампанит ажил" биш "тасралтгүй сургалт" гэж үздэг. Энэ загвар нь хамгийн чанартай, цэгцтэй боловсрол олгодог ч санхүүжилт их шаарддаг, төрийн институтийн чадавхаас шууд хамаардаг байна. Үүнд:

БНСУ-ын бие даасан сонгуулийн төв байгууллага нь дэргэдээ сонгуулийн боловсролын хүрээлэн (KOCEI)-тэй. Академик түвшинд тогтмол сургалт, судалгаа явуулдаг.

Гүрж улсын бие даасан сонгуулийн төв байгууллага нь тусгай сургалтын төвтэй, тус төвөөр дамжуулан олон улсын байгууллагууд болон дотоодын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж сонгогчийн боловсролын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Швед улсын сонгуулийн төв байгууллага нь засгийн газрын загвартай. Засгийн газрын загвар бүхий сонгуулийн төв байгууллага тул боловсролын яам, сургуулиудтай шууд захиргааны шугамаар хамтран ажиллаж сургуулийн хөтөлбөрт сонгуулийн агуулгыг тусган, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажилладаг.

Шинэ Зеланд улсын бие даасан загвар бүхий сонгуулийн төв байгууллага нь сургуулийн багш нарт хэрэг болох сургалтын материалуудыг бэлтгэн, сургууль багш нартай хамтран ажиллаж сонгогчийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Энэтхэг улсын бие даасан загвар бүхий сонгуулийн төв байгууллага нь урт хугацааны сонгогчийн боловсролын SVEEP хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба тэр хүрээнд улс даяар маш нарийн бүтэцтэйгээр, сургууль бүрд клуб байгуулах замаар төрөөс шууд удирддаг жишээнүүд багтана.

2. Стратегийн түншлэлийн загвар. Сонгуулийн төв байгууллага нь "Захиалагч"-ийн үүрэг гүйцэтгэж, контент бэлтгэх, сургалт явуулах ажлыг мэргэшсэн ТББ, залуучуудын байгууллагад санхүүжилттэйгээр шилжүүлдэг. Энэ төрлийн загвар нь "Төрийн сурталчилгаа" гэж харагдахаас сэргийлж, зорилтот бүлэгт (залуучуудад) илүү ойр байдаг. Мөн сонгуулийн

төв байгууллага дэргэдээ боловсролын тусдаа төв байгуулан ажиллах зардлыг хэмнэх давуу талтай гэж үздэг байна. Үүнд:

Канад улсын сонгуулийн төв байгууллага CIVIX байгууллага "Student Vote"-ийг гардан хийдэг.

Швейцар улсын сонгуулийн төв байгууллага залуучуудын парламент (DSJ) нь "Easyvote" төслөөр төрийн албаны хэлийг залуусын хэлэнд хөрвүүлдэг.

Эстони улсын сонгуулийн төв байгууллага "Tech + NGO" хоршил буюу технологийн компаниуд кибер боловсролыг, залуучуудын байгууллага иргэний идэвхийг хариуцдаг.

Герман улсын сонгуулийн төв байгууллага нь улс төрийн сангуудад санхүүжилт өгч, олон ургальч үзлээр боловсрол олгодог жишээнүүд багтана.

3. Олон нийт болон сүлжээний загвар. Уламжлалт төвлөрсөн сургалтаас илүүтэй нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа бүхий сүлжээ, олон нийтийн бүлгүүдийг ашиглаж, сайн дурынхан болон нөлөөллийн хүмүүсээр дамжуулан сонгогчийн боловсролын агуулгыг хүргэх хэлбэр. Энэ загвараар хэрэгжүүлэх нь газар зүйн хувьд тархай бутархай, хүн ам ихтэй, эсвэл төрд итгэх итгэл сул улсуудад хамгийн үр дүнтэй. "Хүнээс хүнд" (Peer-to-peer) зарчмаар ажилладаг байна. Үүнд: Филиппин улсын сонгуулийн төв байгууллага"Citizen Arms", Индонез улсад "Ардчиллын сайн дурынхан". Нийгмийг 10-11 бүлэгт хувааж, бүлэг тус бүрээс "агент" тай, АНУ улсад Rock the Vote, League of Women Voters зэрэг иргэний нийгмийн сүлжээнд тулгуурлан сонгогчийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Харин сонгогчийн боловсрол болон сонгогчийн боловсролын төсөл, хөтөлбөрийг үнэлэх тухайд: Улс орнууд сонгогчийн боловсролын төсөл, хөтөлбөр үйл ажиллагааны үр дүнг тараасан гарын авлагын тоогоор биш, харин сонгогчийн зан төлөвийн өөрчлөлтөөр хэмждэг чиглэлд анхаарч байна. Жишээлбэл Их Британи, Канад зэрэг улсуудад KAP (Knowledge, Attitude, Practice) үнэлгээний загварийг ашиглан сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын судалгаа хийн үнэлж, судалгааны үр дүнг парламентад тайлагнан, дараагийн сонгогчийн боловсролын стратеги төлөвлөгөөг дүгнэлтийг үндэслэн сайжруулах байдлаар явагддаг байна. БНСУ-д иргэдийн ардчиллын үнэт зүйлийн талаарх ойлголтыг хэмждэг тусгай индекс боловсруулан ажигладаг. Мөн сургалтад хамрагдсан хүмүүсээс "өмнөх" ба "дараах" сорил авч, мэдлэг нь хэдэн хувиар нэмэгдсэнийг тоон үзүүлэлтээр гаргаж ирдэг. Төсвийн зарцуулалтыг энэ үр дүнтэй харьцуулж үнэлдэг.

Зарим улс иргэдээс асуухаас илүүтэй, тэдний "хийсэн үйлдэл" (Data-driven analysis) дээр дүн шинжилгээ хийдэг. Сонгуулийн оролцоонд үндэслэн сонгуулийн дараах анхаарах шаардлагатай бүлгүүдийг тодорхойлж дараагийн сонгууль хүртэл тэр бүлгүүдэд тохирсон арга хэлбэрээр сонгогчийн боловсролыг хэрэгжүүлдэг байна. Өөр нэг сонирхолтой жишээ нь Австрали улсын сонгуулийн төв байгууллага санал хураалтын дараа хүчингүй болсон саналын хуудсуудыг цуглуулж, *яагаад* хүчингүй болсныг судалдаг. Жишээ нь: Хэрэв олон хүн тоог дарааллаар нь биш, зүгээр "Х" тэмдэглээд хүчингүй болгосон байвал "Аан, бид Preferential voting системийг сайн тайлбарлаж чадаагүй байна" гэж дүгнэдэг.

Дэлхийн улс орнуудын сонгуулийн төв байгууллагууд нь өөрсдийн орны нөхцөл байдалд тохируулан сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргээ дээрх арга хэлбэрүүдээр хэрэгжүүлэх нь түгээмэл байна. Улс орнуудын сонгуулийн төв байгууллагын сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг судлах явцад нийтлэг анзаарагдаж буй байдал нь сонгогчийн боловсролыг зөвхөн сонгуулийн ирц бүрдүүлэх богино хугацааны кампанит ажил гэдгээс сонгуулийн мөчлөг хооронд үргэлжлэх тасралтгүй үйл ажиллагаа болгон авч үзэх хандлага нэмэгдэж байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг, түүний хэрэгжилт

Сонгуулийн ерөнхий хороо нь 1992 онд Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах бүрэн эрхтэйгээр байгуулагдаж, 2006 онд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар бие даасан, хараат бус байдлыг нь баталгаажуулсан байна. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар хорооны үйл ажиллагааны үндсэн чиг, үүрэгт “7.1.6. ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчийн боловсролыг **дээшлүүлэх**, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах” (УИХ, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль 2006) гэж сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг хуульчилсан байна. Өнөөдрийн байдлаар сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын 5 жилийн /2024-2027он/ стратеги төлөвлөгөөнд нийт 4 зорилтын нэг зорилт болгон оруулсан байна. Мөн Хорооны ажлын албаны бүтцийн хувьд Мэдээлэл, сургалт, судалгааны төвийг 2022 оноос 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан

сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мэдээлэл, сургалт, судалгааны төв нь олон улсын байгууллага, ТББ, мэргэжлийн холбоод болон төрийн байгууллагуудтай хамтран сонгогчийн боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд, БНСУ-ын КОЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй "Хариуцлагатай сонгогч" хөтөлбөрийг 2022-2024 онд хэрэгжүүлж, "Сургагч багшийн сургалт"-ыг 5 удаа зохион байгуулж 21 аймаг 9 дүүрэгт 113 сургагч багш бэлтгэж, "Оролцогчийн сургалт"-ыг жилд 2 удаагийн давтамжтай буюу нийт 168 удаа зохион байгуулж, 4114 залуу сонгогчдыг хамруулсан байна. "Хариуцлагатай сонгогч" сургалтын хөтөлбөрийн агуулгын хувьд сонгогчийн боловсролыг өргөн утгаар нь ардчилсан сонгуулийн утга учрыг тайлбарлах, сонгуулиар сонгож буй төлөөллүүдтэй хамтран ажиллах, оролцоотой иргэн байх, мэдээлэлд шүүлтүүртэй хандаж, баримтаар нягтлах зэрэг агуулгууд багтсанаараа зөвхөн сонгуулийн ирцийн нэмэгдүүлэх төдийгүй ардчилсан нийгмийн оролцоотой, шүүмжлэлт сэтгэлгээтэй иргэдийн бэлтгэх чиглэлд анхаарч байна. Түүнчлэн төрийн бус байгууллага, Их дээд сургуулиудтай болон Үндэсний номын сантай хамтран оюутан залуучуудад сонгуулийн үйл ажиллагаа, санал тоолох төхөөрөмжийг танилцуулах сургалтыг жил бүр тодорхой хэмжээнд зохион байгуулж байгаа ч нийт сонгогчдын тоо /2024 оны УИХ-ын сонгуулийн сонгогчдын тоо 2,089,949/ (СЕХ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн 1992-2024 2024)-той харьцуулахад хүртээмжийн хувьд хангалтгүй хэвээр байна. Түүнчлэн сонгуулийн төв байгууллагаас судлаач, эрдэмтэн, оюутнуудад зориулсан сонгуулийн өгөгдлийг нээлттэй өгөгдлийн форматаар www.opendata.gov.mn цахим портал болон хорооны цахим хуудас m-election.mn -д байршуулах, сонгуулийн боловсрол улирал тутмын сэтгүүлийг бэлтгэн цахим, цаасан хэлбэрээр тогтмол гаргаж байна.

Сонгогчийн боловсрол олгох нь сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар СЕХ-ны үндсэн чиг үүрэг боловч төсөв хангалтгүйгээс төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын асуудал учир дутагдалтай, хязгаарлагдмал хэвээр байна. Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зардал нь байгууллагын үйл ажиллагааны зардлын "мэдээлэл, сурталчилгаа"-ны зардалд багтдаг байна. СЕХ-ны мэдээлэл, сурталчилгааны зардал нь 2020 онд 0 төгрөг, 2021 онд 0 төгрөг, 2022 онд 118 сая, 2023 онд 60.5 сая, 2024 онд 33 сая, 2025 онд 70.6 саяас 49,8 сая (төсвийн тодотголоор хасагдсаар 49,8 сая), 2026 онд 9 сая төгрөгийг уг зардалд төсөвлөсөн байна. Байгууллагын мэдээлэл, сурталчилгааны зардал

гэдэг нь зөвхөн сонгогчийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны зардал биш бөгөөд байгууллагын сургалт, мэдээлэл, сурталчилгааны бүхий л ажилд зарцуулагдах нийт зардал юм. Дээрх тоон үзүүлэлтээс бие даасан хараат бус байгууллагын хуулиар тогтоосон үндсэн чиг үүрэгт шаардагдах төсөв засгийн газраас шууд хамааралтай байгааг харах боломжтой юм. V-Dem, ACE, International IDEA зэрэг байгууллагын харьцуулсан үзүүлэлтүүдээс харахад институтийн хууль эрх зүйн (de jure) бие даасан байдал дангаараа хангалтгүй бөгөөд функциональ (de facto) буюу үйл ажиллагааны бодит бие даасан байдал илүү чухал болохыг харуулав. Тухайлбал, санхүү, хүний нөөц, стратегийн шийдвэр гаргах чадавх (Д.Бат-Эрдэнэ 2024) хязгаарлагдмал нөхцөлд сонгогчийн боловсролын бодлого тогтвортой хэрэгжих боломж буурдаг байна.

Одоогоор улс орнууд сонгогчийн боловсролын үр нөлөө, түвшинг үнэлэхдээ ихэвчлэн сонгуулийн ирц, мэдээллийн хүртээмж зэрэг тоон үзүүлэлт ашиглаж байна. Цаашид үнэлгээний аргачлалд сонгогчийн зан төлөв, мэдээлэл боловсруулах чадвар, үнэт зүйлийн өөрчлөлт зэрэг чанарын үзүүлэлтийг хамруулах нь бодлогын үр нөлөөг илүү бодитой дүгнэж, стратегийг нарийвчлан боловсруулах боломж олгоно (IFES 2014).

Монгол Улсын Их хурлын сонгуулийн ирцийг 1992-2024 он (СЕХ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн 2024) хүртэл харьцуулан авч үзье.

Хүснэгт 1. УИХ-ын ээлжит сонгуулийн ирц 1992-2024 он

Сонгууль	Сонгуулийн насны иргэд	Бүртгэгдсэн сонгогчид	Санал өгсөн сонгогч	Ирцийн хувь
1992 УИХ	1,202,704	1,085,129	1,037,392	95,6
1996 УИХ	1,218,549	1,147,260	1,057,182	92,1
2000 УИХ	1,364,862	1,247,033	1,027,985	82,4
2004 УИХ	1,472,372	1,279,516	1,051,812	82,2
2008 УИХ	1,607,825	1,542,617	1,179,448	76,46
2012 УИХ	1,882,035	1,840,824	1,238,537	67,28
2016 УИХ	1,998,823	1,911,047	1,406,123	73,58
2020 УИХ	2,132,294	2,003,969	1,475,780	73,6
2024 УИХ	2,224,233	2,089,949	1,450,037	69,4

Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн 1992-2024 он.

Сүүлийн жилүүдэд зөвхөн Монгол Улсад төдийгүй дэлхий нийтээр залуучуудын сонгуулийн оролцоо буурч байна. Тэр дундаа 18-25 насны залуучуудын ирц өмнөх жилүүдэд тун хангалтгүй байсныг энд дурдах нь

зүйтэй болов уу. Жишээлбэл, 2012 оны УИХ-ын сонгуульд тэдний ердөө 38%, 2016 оны сонгуульд 50% , 2020 оны УИХ-ын сонгуулиар 63% , 2024 онд 48.4%-ийн ирц (СЕХ, Сонгуулийн ерөнхий хороо 2025)-тэй оролцсон байна. Орон нутгийн хурлын сонгуулийн тухайд сонгогчийн оролцоо хуульд заасан ирцийн босго давахгүйн улмаас Орон нутгийн хурлын сонгуулийг 2020 оноос ирцийн босгогүй болгосон зэргээс сонгуулийн оролцоо ямар түвшинд байгаа нь харагдаж байна.


УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд санал өгөөгүй сонгогчдын тоог насны бүлгээр авч үзвэл 18-24 насны залуучууд байгаа бөгөөд энэ бүлгийн 70% нь сонгогчийн боловсролын талаар ямар ч мэдээллийг авч чадаагүй гэж судалгаанд хариулсан байна. (ХЭҮК 2025)

ХЭҮК-ын 24 дэх илтгэлд "..сонгогчийн боловсролын талаар дүгнэхдээ сонгогчийн боловсролд зориулсан үндэсний хөтөлбөр хэрэгждэггүй, сонгуулийн төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулан хуульчилсан нь хангалтгүй гэсэн байна. Түүнчлэн сонгогчдод боловсрол олгох үйл ажиллагаа нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүний нөөц ихээр шаарддаг ажил учир үндэсний хэмжээнд төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтран өргөн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн сонгогчдод бүх талаар ойлгомжтой дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь сонгуулийг зардал багатай, цаг хугацаа хэмнэн явуулахад тустай бөгөөд сонгогчийн боловсрол сайн байх тусам сонгуулийн ирц, оролцоо илүү байдаг болохыг илтгэгч олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлд дурдаж байжээ" гэсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэх, сонгогчийн боловсролын өнөөгийн түвшинг үнэлэх болон цаашид сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох зорилгоор экспертийн ярилцлагыг хийлээ. Тус ярилцлагад улс төрийн намын төлөөлөл-9, бие даасан судлаачид-7, төрийн бус байгууллагын төлөөлөл-7, хэвлэл мэдээллийн салбарын төлөөлөл-8, олон улсын байгууллагад ажиллаж байсан төлөөлөл-5 нийт 36 экспертээс ярилцлага авлаа.

1. Манай улсад сонгогчийн боловсрол ямар түвшинд байгааг экспертүүдээс асуудал 61% нь сонгогчийн боловсролын түвшин "хангалтгүй" гэж үзсэн бол үлдсэн 39% нь "дунд" гэж үнэлсэн байна.

Зураг 2. Манай улсад сонгогчийн боловсролын түвшин



Эх сурвалж: Экспертийн ярилцлага


Сонгогчид санал өгөх техникийн мэдлэгтэй ч (хаана, яаж дугуйлах), *яагаад* санал өгөх, мөрийн хөтөлбөр хэрхэн ялгах, үнэт зүйлийн талаарх мэдлэг дутмаг байна. Түүнчлэн сонгогчид мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар сул, сошиал медиагийн давлагаа, поп амлалтад амархан автах, санал худалдах зэрэг асуудлууд байсаар байна гэж хариулсан байна. 1992 оноос өнөөг хүртэл сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ахиц гаргасан ч энэхүү үйл ажиллагаа кампанит ажлын шинжтэй, зөвхөн сонгуулийн өмнөх богино хугацаанд явагдаж ирсэн байна. Тогтвортой бодлого, судалгаанд суурилсан төлөвлөлт, тусгай бүтэц, төсөвгүй байдал нь сонгогчийн боловсрол хангалтгүй байгаагийн гол хүчин зүйл гэж үзсэн байна.

Түүнчлэн эрх зүйн орчны тогтворгүй байдал нь сонгогчийн боловсролын дорвитой сургалтын бааз, материал бүрдэхгүй байгаатай холбоотойг экспертийн ярилцлагын судалгаагаар судлаачид цохон тэмдэглэж байлаа. Монгол Улс нь парламентын сонгуулийн тогтолцоог нийт найман удаа 1992, 1996, 2005, 2011, 2015, 2016, 2019 болон 2023 онд УИХ-ын сонгуулийн өмнө өөрчилжээ. Сонгуулийн гол дүрэм олон удаа өөрчлөгддөг, улс төрийн орчны тогтворгүй байдал нь урт хугацааны, тогтвортой сонгогчийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэхэд саад болсон гэж үзэж болох талтай.

2. Экспертүүдээс сонгуулийн ерөнхий хорооны сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа дээр үнэлгээ авахад 2021 оноос хойш сайжирч байгаа гэсэн хариултыг өгсөн өгөөд эерэг үнэлж буйн

шалтгааныг СЕХ дангаараа биш сонгогчийн боловсролыг дээшлүүлэх боломжтой бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай гэж дүгнэж байлаа.

Зураг 3. Сонгуулийн ерөнхий хорооны сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийн үнэлгээ



Эх сурвалж: Экспертийн ярилцлага

Түүнчлэн экспертүүдийн үнэлгээгээр сонгогчийн боловсрол нь зөвхөн сонгуулийн үеэр идэвхждэг, кампанит ажил хэлбэртэй байгаа тул цаашид сонгуульгүй жилүүдэд үргэлжлэх тасралтгүй процесс байх, мөн агуулгыг өргөтгөж оролцоотой иргэдийг бэлтгэх чиглэл хандах ёстойг онцолж байв.

3. Экспертийн ярилцлагаар сонгогчийн боловсролыг дээшлүүлэхэд СЕХ-ноос гадна ямар байгууллагууд оролцоо боломжтой талаар тодруулахад Улс төрийн нам, ЕБС, Их дээд сургууль, ТББ, хэвлэл мэдээлэл болон бусад төрийн байгууллагуудыг сонгогчийн боловсролыг дээшлүүлэхэд өөр, өөрсдийн үйл ажиллагаагаар дамжуулан тодорхой үүрэг, хариуцлагатай оролцох боломжтой гэж үзсэн байна.

Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх, мэдээллээр хангах ажил маш чухал бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг хангах асуудал нь ихээхэн цогц шинжтэй учраас гагцхүү СЕХ-д даатган орхих нь учир дутагдалтай юм. 1992 оноос Шинэ Үндсэн хуулиар сонгууль зохион байгуулж эхэлснээс хойш сонгогчийн боловсролын чиглэлд олон улсын байгууллага, дотоодын иргэний нийгмийн байгууллага болон албан бус боловсролын төвүүд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Түүнчлэн ерөнхий боловсролын сургууль (ЕБС), бусад боловсролын байгууллагууд, хэвлэл мэдээллийн

байгууллагууд болон улс төрийн намууд ч мөн сонгогчийн боловсролыг дээшлүүлэх оролцогч талууд болно.

ЕБС: Сонгогчийн боловсролыг олгох өөр нэг томоохон институт бол ЕБС бөгөөд ЕБС-ийн ахлах ангиудад нийгэм судлал хичээлээр сонгогчийн боловсролын агуулгыг 8 дугаар анги /Орон нутгийн нутгийн удирдлага/ 9 дүгээр анги /ардчиллын тухай/,10 дугаар анги /Улс төр, эрх мэдлийн хуваарилалт/, 11 дүгээр анги /Улс төр, сонгууль../-д ангиудад сурагчдад олгож байна. Улсын хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг жилдээ дунджаар 35,000 /2020 онд 34,816 төгсөгч, 2021 онд 31,908 төгсөгч, 2022 онд 33,135 төгсөгч, 2023 онд 35,506 төгсөгч, 2024 онд 42,993 төгсөгч/ (хороо 2025) орчим сурагч төгсдөг байна. Тэгэхээр 4 жилд 140.000 орчим шинэ сонгогчид Ерөнхий боловсролын сургуулиас бэлтгэгдэж байгаа юм. Хэрэв нийгмийн ухааны хичээлээр ардчиллын болон сонгогчийн боловсролын агуулгуудыг хангалттай хэмжээнд олгож чадвал шинэ сонгогчийн боловсролын асуудлыг тодорхой хэмжээнд хангах боломжтой юм.

ТББ болон Олон улсын байгууллага: эдгээр байгууллагууд нь Монгол Улсын иргэний болон сонгогчийн боловсролын гол хөдөлгөгч хүч болдог. Олон улсын байгууллагуудын санхүүжилтээр дотоодын ТББ-ууд сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа залуусын оролцоог сайжруулах болон сонгуулийн процессын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж хамтран ажилладаг. Үүнд, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлсэн “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” (SWYEEPPM) хөтөлбөр (MongoliaU.S. 2023) нь иргэдийн сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх хөтөлбөр багтана. Тус хөтөлбөрийн хүрээнд Монголын ИНБ-уудаар дамжуулан олон тооны төслүүдийг хэрэгжүүлсэн нь сонгогчийн боловсрол төдийгүй сонгуулийн эрх зүйн, зохион байгуулалтын үйл ажиллагааг сайруулахад бодитой нөлөө үзүүлэхүйц үр дүнг авчирсан. Лийд төгсөгчдийн холбооны “Сонгуулийн дата хакатон”төсөл, “Сонгуулийн ирц (сонгогчийн бүртгэл)-ийн мэдээллийг ил тод болгох нь” судалгаа (LEADAA 2021), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийн хэрэгжилт: Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль ажиглалт (2021 он), Бодлогод залуусын хяналт ТББ-ын хэрэгжүүлсэн “Сонгуулийн амлалт дата сан” (ТББ 2022) гэх мэт олон төслүүд нь бодитой үр дүнг авчирсан төслүүд хэрэгжүүлсэн байна.

Түүнчлэн CFLI/FCIL Орон нутгийн санаачилгыг дэмжих Канад сангийн дэмжлэгтэй дотоодын ИНБ-уудын сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиглэлийн хэд хэдэн төсөл хэрэгжсэнээс дурдвал Цогц хөгжлийн үндэсний төв. Сонгогчийн гарын авлага УБ, 2024 он, ЛИЙД төгсөгчдийн холбооны хэрэгжүүлсэн "Сонгуулийн луужин" төслүүд нь СЕХ-ны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвтэй хамтран ТББ-ын хэрэгжүүлсэн үр дүнтэй, бодитой төслүүд болсон. Олон Улсын байгууллагуудын санхүүжилт, хөтөлбөрийн бүрээнд дотоодын ТББ-ын хэрэгжүүлсэн дээрх төсөл, арга хэмжээнүүд нь сонгогчийн боловсролд тодорхой дэмжлэг болсон нь гарцаагүй. Мэдээж эн хамтын ажиллагааг цаашид ч үргэлжлүүлэх нь зүйтэй.
Улс төрийн нам: Ардчилсан улс орнуудад улс төрийн нам нь төлөөллийн ардчилалд онцгой үүрэгтэй оролцогч институт болохын хувьд нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Нам нь улсын хэмжээний бодлогын нам байна гэж зааж, Улс төрийн намын тухай хуулийн 2023 оны шинэчилсэн найруулгад хэд хэдэн чухал заалтаар тусгалаа олсны нэг нь иргэд, намын гишүүдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг билээ. Улс төрийн намын үйл ажиллагааны чиг үүрэгт иргэд, намын гишүүдэд улс төрийн боловсрол олгох мөн ил тод нээлттэй ажиллах зэрэг нийгмийн өмнө хүлээх тодорхой чиг үүргийн агуулгыг нэмж хуульчилсан. Тиймээс Улс төрийн намуудын зүгээс олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хууль, эрх зүйн хүрээнд чанд гүйцэтгэх чадавхтай байх шаардлага зүй ёсоор тавигдана. Тэр дундаа Улсын их хурлын сонгуулийн үр дүнгээр төрийн санхүүжилт авч буй нам, тухайн санхүүжилтийн 15 хувийг иргэдийн улс төрийн боловсролд, 15 хувийг намын гишүүдийн улс төрийн боловсрол, оролцоог дэмжихэд зарцуулахаар зориулалтыг нарийвчлан тодорхойлсон. Хуулийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхээр Сонгуулийн ерөнхий хорооноос Намын гишүүн, иргэдэд улс төрийн боловсрол олгох жишиг хөтөлбөрийг баталж улс төрийн намуудад хүргүүлсэн байна. Сонгуулийн ерөнхий хороо нь төрөөс санхүүжилт авч буй намуудын зардлын зарцуулалтад хяналт тавих замаар хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах юм.
Хэвлэл мэдээлэл: Хэвлэл мэдээллийн салбар нь сонгогчийн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн мэдээлэл түгээх гол оролцогч тал бөгөөд ялангуяа сонгуулийн хугацаанд сонгуулийн байгууллага бөгөөд улс төрийн нам, эвсэл болон нэр дэвшигч нартай хамтран ажилладаг. Сошиал медиагийн хэрэглээ идэвхтэй өргөжиж, сонгуулийн үеийн гүтгэлэг, худал мэдээлэл болон популист амлалтууд хурдтай газар авч буй нийгэмд хэвлэл мэдээллийн салбар сонгогчийн боловсролд ялангуяа баримтад тулгуурласан

(Fact-check) мэдээлэл түгээх, худал мэдээлэлтэй тэмцэх зэргээр сонгуулийн төв байгууллагатай хамтран иргэд, сонгогчидруу хандан ажиллах зайлшгүй шаардлага үүсээд байна. Мэдээж хэрэг төрийн албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ) хуулиар хүлээсэн үүргийнхээ сонгогчийн боловсролын контент бэлтгэн түгээх үүрэгтэй тул сонгогчийн боловсролын цуврал агуулгыг СЕХ-той хамтран бэлтгэн түгээх чиглэлд хамтран ажиллах боломжтой.

4. Экспертийн ярилцлагын сүүлийн хэсэгт сонгуулийн ерөнхий хороо сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргээ цаашид хэрэгжүүлэхдээ арга хэлбэрээр ажиллах нь илүү үр дүнтэй талаар тодруулахад. СЕХ үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж, бусад оролцогч талууд /ЕБС, ИНБ, мэргэжлийн холбоо, төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл болон улс төрийн нам/-ын уялдааг хангах байдлаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Үндэсний хөтөлбөр батлагдсанаар *нэгдүгээрт*: сонгогчийн боловсролын асуудлыг урт хугацааны тасралтгүй үйл явц болгон авч үзэх, *хоёрдугаарт*: оролцогч бүх талуудыг нэгдсэн агуулга, материалаар хангах, *гуравдугаарт*: төсвийн тогтвортой байдал хангагдах боломж бүрдэх юм.

Урт хугацааны үндэсний хөтөлбөр батлуулж, оролцогч байгууллагуудын чиг үүрэг, хариуцлага болон шаардлагатай төсвийн асуудлыг шийдвэрлэн СЕХ-ны ажлын албан Мэдээлэл, сургалт, судалгааны төв оролцогч талууд болох ЕБС, их сургууль бусад боловсролын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллага болон улс төрийн намууд зэрэг олон талын оролцоо /зөвхөн СЕХ -н оролцогч талуудтай хамтран ажилладаг биш оролцогч талууд ч мөн үндэсний хөтөлбөрийн хүрээнд харилцан хамтран ажиллах/-г хангаж, нэгдсэн удирдлага, хяналт, үнэлгээ хийж, хамтран ажиллах шаардлагатай байгаа нь судалгааны явцад харагдлаа. СЕХ нь "Менежер/Зохицуулагч"-ийн үүрэгтэйгээр урт хугацааны үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, харин ТББ, ЕБС, хэвлэл мэдээлэл гэх мэт бусад оролцогч талуудыг шаардлагатай агуулга, санхүүгийн эх үүсвэрээр ханган хамтран ажиллах боломжтойг судлаачид онцолж байлаа.

Зураг 4.Сонгогчийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэхэд санал болгох загвар



Эх сурвалж: Экспертийн ярилцлага

Сонгуулийн төв байгууллага нь ардчиллыг бэхжүүлэх үндсэн институтийн нэг бөгөөд түүний бие даасан байдал, чадавх, үүргийн хүрээнд сонгогчийн боловсролыг тогтвортой, шинжлэх ухааны үндэстэйгээр хэрэгжүүлж чадвал ардчиллын чанарыг хэмжих, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, иргэдийн улс төрийн соёлыг дээшлүүлэх стратегийн чухал механизм болох юм. (академи 2024)

ДҮГНЭЛТ

Сонгууль нь ардчилсан засаглалын легитим чанарыг хангах суурь нөхцөл болохын хувьд сонгогчийн боловсролыг зөвхөн санал хураалтын техник үйл явцаар хязгаарлахгүйгээр сонгуулийн мөчлөг хооронд тасралтгүй үргэлжлэх иргэдийн ухамсарт оролцоо гэж үзэх хандлага олон улсад давамгайлж байна. Дэлхийн улс орнууд сонгогчийн боловсролыг институциональ, стратегийн түншлэл, олон нийтийн сүлжээний гэсэн үндсэн загваруудаар хэрэгжүүлэн, үр дүнгээ иргэдийн зан төлөвийн өөрчлөлтөөр хэмжих чиг хандлага руу шилжиж байгаа юм.

Монгол Улсын хувьд Сонгуулийн Ерөнхий Хороо хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх бүтэц, стратегитай хэдий ч улсын төсвийн дэмжлэг сул, гадаад санхүүжилтээс хамааралтай байгаа нь үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулж байна. Судалгааны үр дүнгээс харахад иргэд санал өгөх техникийн мэдлэгтэй боловч мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийх шүүмжлэлт сэтгэлгээ дутмаг хэвээр байгаа тул экспертүүд

өнөөгийн нөхцөл байдлыг хангалтгүй гэж үнэлжээ. Иймд цаашид төсвийн тогтвортой байдлыг хангаж, ерөнхий боловсролын сургууль, иргэний нийгэм, улс төрийн намуудын оролцоог нэгтгэсэн үндэсний хэмжээний экосистемийг бүрдүүлэх нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх оновчтой арга зам мөн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Aceproject. 2025. *voter education.* https://aceproject.org/main/english/ve/vea02.htm.

Arnstein, S. R. 1969. “A ladder of citizen participation.” *Journal of the American Institute of Planners.*

center, The Carter. 2005. *Election obligations and standards.* Atlanta.

Democracies, Community of. 2000. *Warsaw Declaration* . Warsaw.

IDEA, International. 2005. *International IDEA.*

IFES. 2014. *Civic education for civil society: A guide for technical assistance providers.* https://www.ifes.org/publications/civic-education-civil-society-guide-technical-assistance-providers.

LEADAA. 2021. *Сонгуулийн ирц (сонгогчийн бүртгэл) судалгаа.* Улаанбаатар.

March & Olsen,. 1989. *Rediscovering institutions: The organizational basis of politics.* Free Press.

Mongolia, U.S. Embassy in. 2023. *Монгол Улсад залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх* . https://mn.usembassy.gov/mn/pr-0.

Samples, J. 2004. *Taxpayer-funded voter education: A conflict of interest* . https://www.cato.org/policy-analysis/taxpayer-funded-voter-education-conflict-interest.

Samples, John. 2004. *Three Myths about Voter Turnout in the United States.* Washington, D.C.: Cato Institute.

Somin, I. 2013. *Democracy and political ignorance: Why smaller government is smarter.* Stanford University Press.

академи, Хууль зүйн. 2024. *Гадаад орнуудын үндсэн хууль.* Улаанбаатар.

Б.Чимид. 2008. *Сонгуульд суралцахуй (тогтолцоо, үйл явц, эрх зүй).* Улаанбаатар.

Д.Бат-Эрдэнэ. 2024. *Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг, сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал.* Улаанбаатар: Титанпринт.

Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар. 2025он . *Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй.* Улаанбаатар: Мөнхийн үсэг.

НҮБ, КОЙКА. 2025. “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь төсөл.” Улаанбаатар.

СЕХ. 2024. *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн.* Улаанбаатар .

—. 2024. *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн 1992-2024.* Улаанбаатар хот.

—. 2025. *Сонгуулийн ерөнхий хороо.* m-election.mn.

ТББ, Бодлогод залуусын хяналт. 2022. *Сонгуулийн амлалт.* https://www.policywatch.mn/databankgeneral.html.

УИХ. 1992. *Монгол Улсын Үндсэн хууль.*

УИХ. 2006. *Сонгуулийн төв байгууллагын тухай хууль.* Улаанбаатар.

хороо, Үндэсний статистикийн. 2025. *Ерөнхий боловсролын сургуулийг өдрөөр суралцан төгсөгчдийн тоо.* www.1212.mn .

ХЭҮК. 2025. *Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл.* Улаанбаатар: Адмон принт.

FUNCTIONS OF THE CENTRAL ELECTORAL MANAGEMENT BODY IN ENHANCING VOTER EDUCATION AND THEIR IMPLEMENTATION

Abstract: This article explores the international practices and mechanisms through which central electoral management bodies exercise their functions in enhancing voter education. By synthesizing global experiences, the study aims to define strategic pathways for improving the implementation of the statutory duties mandated to the General Election Commission (GEC) of Mongolia in the realm of voter education and civic engagement.

Key words: Voter education, General Election Commission, election, voter turnout, political culture.

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 167-182 дох тал

PREDICTING VOTER CHOICES: THE CASE OF MONGOLIA

Zolzaya Gungaa
Department of Statistics and Econometrics,
School of Economics and Business, MULS, Mongolia

Usukhbayar Bayarsaikhan
Department of Computer Science,
School of Applied Sciences, MULS, Mongolia

Abstract: In democratic societies, the electoral process constitutes the primary mechanism for the legitimate formation of political authority, with voters' political choices directly influencing socio-economic development and policy outcomes. Research on voter behavior in Mongolia remains limited, with most studies relying on descriptive statistical summaries. This study employs a Multinomial Logistic Regression (MLR) model to analyze the combined effects of demographic characteristics, socio-economic indicators, and party evaluations among voters from two electoral districts. The results indicate that age, education, income, sources of political information, political activism, previous voting behavior, and party evaluations are statistically significant predictors of voter choice ($p < 0.05$). The model accurately predicts support for the Mongolian People's Party (MPP) and Democratic Party (DP) with 84–98% precision, whereas predictions for the 'Other' category are weaker, likely due to heterogeneity and a small number of observations. Model fit indices (Cox & Snell $R^2 = 0.745–0.791$; Nagelkerke $R^2 = 0.803–0.852$) demonstrate a high explanatory capacity. The findings underscore the theoretical and methodological relevance of data-driven electoral forecasting in the Mongolian context and highlight the need for further research into small-party heterogeneity and latent voter structures.

Keywords: Multinomial logistic regression for qualitative data, Electoral forecasting

Introduction

In democratic societies, the electoral process serves as the fundamental mechanism for the legitimate formation of political authority, with voters' political choices directly influencing national development, policymaking, and socio-economic trends (Blais, 2000), (Norris, 2014). Consequently, predicting voter behavior has emerged as a critical research area, not only in political science but also in the fields of information technology, statistics, and data analytics (Gueuwou & Mensah, 2023).


Since Mongolia's transition to a democratic system, multiple parliamentary, presidential, and local elections have been conducted. The outcomes of these elections have varied according to numerous factors, including societal sentiment, economic conditions, political party reputations, mass media, and social networks (Batbold & Tumenjargal, 2018), (Myagmartsooj, 2024). However, scientific studies that systematically analyze and predict actual voter behavior remain relatively scarce in the Mongolian context (Urandelger, Burmaa, & Altan-Od, 2023).

Internationally, studies examining determinants of voter behavior frequently consider variables such as age, gender, education, income, geographic location, and political ideology (Norris, 2014), (Shahi, Basyurt, & Stieglitz, 2025). For instance, research conducted in the United States and Europe has demonstrated that machine learning algorithms—including logistic regression, decision trees, neural networks, and support vector machines (SVMs)—can reliably forecast electoral outcomes (Brito & Adeodato, 2023), (Gueuwou & Mensah, 2023). Furthermore, sentiment analysis of social media data (e.g., Twitter, Facebook) has enabled real-time detection of shifts in voter preferences (Shahi, Basyurt, & Stieglitz, 2025), (Gueuwou & Mensah, 2023).

Global organizations, including the World Bank and the International Foundation for Electoral Systems (IFES), regularly conduct statistical analyses of electoral processes, voter participation, and political behavior, highlighting the importance of data-driven insights (Bank, 2022), (International Foundation for Electoral Systems, 2021). Such studies consistently identify macro-level factors—economic conditions, trust in government, corruption levels, and media influence—as significant determinants of voter choice (Bank, 2022).

Between 2008 and 2024, the number of seats held by political parties fluctuated steadily, with abrupt changes occurring at specific intervals, indicating that the institutional consolidation of parliamentary representation has not yet been fully established. To provide a comprehensive depiction of the evolving dynamics within the party competition landscape, the following graph has been presented.

Figure 1. Seats won by parties, by year




Source: NSO

This graph illustrates the dynamic changes in parliamentary representation of Mongolian political parties between 2008 and 2024. While the Mongolian People's Party (MPP) maintained a stable dominant position, the abrupt fluctuations in the seats of the Democratic Party (DP) reflect institutional instability. During the period under study, newly emerging coalitions and smaller parties began to secure representation to some extent, indicating an increasing level of fragmentation within the party system. The results of 2024 show a sharp departure from previous cycles, revealing new organizational arrangements in political competition and shifts in voter behavior.

Using voter indicators from the parliamentary elections, the graph also depicts trends in voter preferences. It clearly shows the tendency of the electorate to direct support toward either the ruling party or the opposition.

Figure 2. Number of voters, number of citizens who voted, by year
Source: NSO



Over the period under study, the number of citizens registered on the voter lists steadily increased, whereas the growth in actual voters was comparatively slower, resulting in a persistent gap in electoral participation. Accordingly, this graph was developed and utilized to empirically illustrate the structure of voter turnout and its long-term trends.

In Mongolia, sociological studies have addressed aspects of voter behavior and electoral participation. The National Statistics Office regularly publishes reports correlating election-age citizens' participation with socio-economic indicators, while surveys by the Sant Maral Foundation provide insights into voters' political attitudes (National Statistics Office of Mongolia, 2023), (Sant Maral Foundation, 2022). Nevertheless, most of these analyses are descriptive and rely on statistical summaries, with relatively few studies employing predictive models based on machine learning or data mining techniques (Myagmartsooj, 2024).

With recent advancements in Mongolia's information technology sector, attempts to process electoral data algorithmically and generate predictive models have emerged. Yet these efforts remain largely experimental, constrained by limited access to high-quality datasets. Moreover, studies leveraging social media data are still in developmental stages, with ethical and privacy considerations unresolved (Gueuwou & Mensah, 2023).

Overall, while international methodologies for accurately predicting voter choices are relatively mature, Mongolia lacks sufficiently comprehensive official statistical surveys and sample-based studies, highlighting a clear need to advance both theoretical and applied research in this domain (Norris, 2014), (Urandelger, Burmaa, & Altan-Od, 2023).

Materials and method

Numerous theories and models have been developed to understand the factors influencing voter choice, which are crucial for examining the interplay between voter behavior and socio-economic conditions (Blais, 2000). According to Rational Choice Theory, voters determine which party or candidate to support based on the maximization of personal utility (Downs, 1957). This theory conceptualizes voters as deliberate and calculative actors, making it widely applicable in statistical models designed to predict electoral outcomes (Hair & Babin, 2019). Sociological models emphasize that social factors such as age, gender, education, income, occupation, and geographic location significantly shape voting behavior (Myagmartsooj, 2024). These models allow for a nuanced understanding of voters that integrates both social context and cultural environment alongside rational calculation.

Psychological models highlight the influence of attitudinal factors—including party loyalty, political activism, and information-seeking habits—on voter decision-making (Urandelger, Burmaa, & Altan-Od, 2023). Economic-choice theories posit that macroeconomic conditions at the time of elections, such as unemployment, inflation, and living standards, can directly affect voter decisions. In the Mongolian context, these theoretical frameworks collectively indicate that predictive analyses of voter behavior must account simultaneously for social, economic, and informational determinants.

Previous studies in Mongolia have consistently shown that voters' education level, age group, prior voting behavior, and information sources exert notable influence on electoral choices. Building on these insights, the present study integrates the aforementioned theoretical perspectives to develop a model capable of predicting voter choices in Mongolia. The study employs a Multinomial Logistic Regression (MLR) framework, which accommodates dependent variables with multiple categories (Hair & Babin, 2019). Here, the dependent variable is the political party chosen by the voter, while independent variables include age, gender, education, income, information sources, political activism, and prior voting behavior. Regional differences and other potential control variables are also incorporated into the model.

Data collection was conducted through a structured survey designed to capture voters' socio-economic characteristics, political engagement, and information-seeking patterns (National Statistics Office of Mongolia, 2023). Survey items were measured using nominal and ordinal scales, with Likert scales employed where appropriate to quantify attitudinal and behavioral indicators (Hair & Babin, 2019).

For the Multinomial Logistic Regression (MLR) model, the following formulation is employed:

$$Logit\left(\frac{P(Y=i)}{P(Y=bas\ )}\right) = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \cdots \beta_n X_n \qquad (1)$$

In this context, YYY represents the voter's choice, while $X1, \ldots, Xn$ denote the independent variables, and β\betaβ represents the model coefficients. To assess model adequacy, indicators such as the Likelihood Ratio Test, Pseudo R^2, and Classification Accuracy are employed to evaluate the predictive validity of the model. Additionally, checks for multicollinearity and other assumptions necessary for reliable estimation were conducted to ensure the robustness of the results (Hosmer, 2013).

The study sample comprises 138 voters from two electoral districts (Gobi-Altai, Zavkhan, Uvs, and Khovd) and 124 voters from four districts (Bulgan, Orkhon, and Khuvsgul), ensuring representation of major voter populations in Mongolia.

The sample size was determined to be sufficient to provide stable and reliable estimates for the Multinomial Logistic Regression (MLR) model.

The survey encompassed 138 voters from the 2nd electoral district (Gobi-Altai, Zavkhan, Uvs, Khovd) and 124 voters from the 4th electoral district (Bulgan, Orkhon, Khuvsgul), yielding a total sample of 262 respondents. Following established guidelines for multinomial logistic regression (Hosmer, 2013), the required minimum sample size to achieve stable parameter estimates is computed as $N \geq 10 \times (k-1) \times p = 330$, where k is the number of outcome categories and p the number of predictors. Although the total sample slightly undercuts this threshold, the distribution of respondents across major political parties and predictors ensures sufficient data to generate reliable and interpretable MLR estimates.

The primary data for this study were collected to capture voters' socio-economic characteristics, political attitudes, and behavioral patterns. Data collection employed a structured survey designed to be representative of Mongolia's adult voting population. The survey comprised the following sections:

1. **Demographic Information:** Socio-economic variables measured included age, gender, education level, and average monthly household income.

- *Age* was treated as a continuous variable but could also be categorized into age groups for analysis.
- *Gender* was recorded as a binary categorical variable (male, female).
- *Education level* was an ordinal variable with the following categories: Primary, Secondary, Upper Secondary, Diploma, Bachelor, Master, and Doctorate.
- *Average monthly household income* was also treated as an ordinal variable, categorized as: below 1 million MNT, 1–2 million, 2–3 million, 3–5 million, and above 5 million MNT.

2. **Political Participation and Attitudes:** To predict electoral behavior and party choice, the following indicators were employed:

- *Information sources:* Voters were asked where they primarily obtain political information. Categories included television, Facebook, TikTok, news websites, acquaintances/friends, and others. This was treated as a nominal variable.
- *Political activism:* Voters self-assessed their level of political engagement on a 5-point Likert scale, ranging from "Very inactive" to "Very active," treated as an ordinal variable.

- *Previous electoral participation:* Respondents indicated whether they voted in prior parliamentary elections, with response options: Yes, no, or don't remember. This was treated as a nominal variable.
- *Party evaluation:* Voters rated the policies and performance of political parties on a scale from "Very poor" to "Very good," treated as an ordinal variable. Party evaluation was considered a key predictor influencing trust in, and likelihood of supporting, a given party.
- *Current choice:* Respondents indicated which party they would vote for if an election were held today. This categorical (nominal) variable served as the dependent variable in the study and was used in the Multinomial Logistic Regression (MLR) model.

RESULT

The reliability and validity of the survey instruments administered to participants were thoroughly assessed to ensure the accuracy and credibility of the collected data.

Table 1. Results of reliability and plausibility analysis

Test	2nd circle	4th circle
Cronbach's alpha	0.417	0.441
KMO	0.839	0.658

The results indicate that Cronbach's alpha values were 0.417 for the 2nd district and 0.441 for the 4th district, suggesting relatively low internal consistency within these item sets. This implies that some items may not perfectly correlate with one another or fully represent the intended construct, highlighting the need to further assess the extent to which the included items capture coherent concepts and underlying characteristics.

The Kaiser-Meyer-Olkin (KMO) measure of sampling adequacy was 0.839 for the 2nd district and 0.658 for the 4th district, indicating that the sample sizes were sufficient to perform factor analysis. Specifically, a KMO value around 0.8 is generally considered "meritorious," while a value around 0.6 is regarded as "mediocre but adequate."

To evaluate the internal consistency of the measurement scales, item-level analyses based on Corrected Item–Total Correlation (CITC) were conducted. This approach assesses the extent to which each item reflects the overall scale. Items with CITC ≥ 0.30 are deemed consistent with the general structure of the scale,

whereas items with CITC < 0.30 indicate weak structural alignment and may require removal, re-specification, or reassignment to a different factor.

Table 2. Item-Total correlation test results

Variables	2nd circle	4th circle
Age	0.587	0.678
Gender	0.498	0.433
Education	0.853	0.917
Income	0.792	0.798
Source of political information	**-0.248**	-0.315
Political activity	0.765	0.796
Voted in previous elections	**-0.178**	**-0.214**
MPP rating	0.718	0.673
DP rating	0.506	0.529
HUN rating	-0.588	-0.571
Other party ratings	0.346	0.409
Party to vote for today	-0.477	-0.384

The analysis indicates that the internal consistency of the items included in the survey varies across districts. Variables such as Age, Gender, Education (Edu), Income, Political Activism (Activism), and AN_rate exhibited Corrected Item–Total Correlations (CITC) above 0.30 in both districts, suggesting that these items consistently and reliably contribute to the overall measurement structure. Notably, Education and Income demonstrated particularly high CITC values (0.79–0.92), indicating strong alignment with the latent constructs measured in the survey.

Conversely, items such as Information Source (Infosource), Previous Vote (PrevVote), and HUN_rate in the 2nd district, as well as Other_rate and VoteToday in the 2nd district, exhibited CITC values below 0.30, with some instances showing negative correlations. These findings imply that these items may not adequately reflect the intended constructs and may require further examination, potential revision, or reassignment to improve the coherence of the measurement scales.

Table 3. Demographic Characteristics of the Participants

Indicator	2nd circle		4th circle	
	frequency	Percentage	frequency	Percentage
Age				
Up to 30	24	17.4	19	15.3
31-40	54	39.1	49	39.5
41-50	50	36.3	46	37.1
51-60	9	6.5	10	8,1
61 and up	1	0.7	0	0
Total	138	100	124	100
Gender				
Male	69	50	63	50.8
Female	69	50	61	49.2
Total	138	100	124	100
Education				
Primary	15	10.9	12	9.7
Secondary	40	29.0	37	29.8
Diploma	23	16.7	21	16.9
Bachelor	33	23.9	29	23.4
Master	27	19.6	25	20.2
Total	138	100	124	100
Average household income				
Up to 1 million tugrug	6	4.3	4	3.2
1-2 million tugrug	35	25.4	33	26.6
2-3 million tugrug	38	27.5	33	26.6
3-5 million tugrug	40	29.0	38	30.6
More than 5 million tugrug	19	13.8	16	12.9
Total	138	100	124	100

Regarding age, the 31–40 and 41–50 age groups accounted for the largest proportions in both districts, approximately 39% and 36–37%, respectively, while individuals aged 61 and above represented a very small fraction of respondents.

In terms of gender, the distribution of male and female participants was roughly balanced in both districts, each comprising approximately 50% of the sample.

Comparing education levels, respondents with upper secondary and bachelor's degrees constituted the majority, while those holding a master's degree represented about 19–20% of the total participants.

With respect to average household income, households earning 2–5 million MNT per month accounted for the largest share, approximately 55%, whereas households earning below 1 million MNT comprised the smallest proportion.

Overall, these results indicate that the demographic structures of the two districts are largely comparable, demonstrating a balanced composition of the survey's baseline characteristics.

Let Y denote the voter's choice, with "Other" as the reference category. The multinomial logit model is specified as:

$$log\frac{P(Y=j)}{P(Y=other)} = \beta_{0j} + \sum_{i=1}^{11}\beta_{ij}X_i, \quad j = \{MAN, AN, HUN\} \qquad (2)$$

where X_i represents the individual-level predictors including age, gender, education, income, political information source, activism, previous vote, and party evaluations. The estimated coefficients (β_{ij}) and their significance levels are reported in Table 3.

Table 4. Results of Multinomial Logit Model Estimation

Variables	2nd circle		4th circle	
	Choose MPP	Choose DP	Choose MPP	Choose DP
Age	-0.151* (0.124) [0.674^{L}-1.097^{U}]	-0.396* (0.165) [0.487^{L}-0.930^{U}]	-0.178* (0.187) [0.580^{L}-1.207^{U}]	-0.547* (0.259) [0.348^{L}-0.961^{U}]
Gender	0.040* (1.217) [0.096^{L}-11.304^{U}]	-0.993* (1.066) [0.046^{L}-2.995^{U}]	-1.800* (1.422) [0.010^{L}-2.682^{U}]	-1.348* (1.759) [0.008^{L}-8.165^{U}]
Education	0.412* (1.062) [0.188^{L}-12.120^{U}]	1.044* (0.973) [0.422^{L}-19.122^{U}]	-1.271* (1.077) [0.034^{L}-2.319^{U}]	-0.640* (1.121) [0.059^{L}-4.742^{U}]
Income	0.820* (1.248) [0.197^{L}-26.225^{U}]	-2.444* (1.391) [0.006^{L}-1.326^{U}]	2.263* (1.366) [0.660^{L}-139.826^{U}]	1.117* (1.810) [0.088^{L}-106.080]
Source of political information	-0.275* (0.320) [0.406^{L}-1.421^{U}]	1.162* (0.427) [1.385^{L}-7.382^{U}]	-0.728* (0.310) [0.268^{L}-0.872^{U}]	2.097* (0.885) [1.438^{L}-46.124^{U}]
Political activity	-0.636* (1.324) [0.040^{L}-7.098^{U}]	3.889* (1.739) [1.616^{L}-1478.0^{U}]	-0.170* (1.672) [0.032^{L}-22.341^{U}]	3.900* (2.431) [0.421^{L}-5796.3^{U}]

Voted in previous elections	-1.766* (1.287) [0.014^{L}-2.130^{U}]	1.557* (0.769) [1.051^{L}-21.430^{U}]	-0.857* (0.805) [0.088^{L}-2.057^{U}]	1.070* (0.943) [0.460^{L}-18.501^{U}]
MPP rating	1.092* (0.893) [0.518^{L}-17.171^{U}]	-1.545* (0.915) [0.035^{L}-1.281^{U}]	0.968* (0.695) [0.674^{L}-10.283^{U}]	-0.645* (1.195) [0.050^{L}-5.453^{U}]
DP rating	0.596* (0.547) [0.621^{L}-5.302^{U}]	1.720* (0.721) [1.360^{L}-22.922^{U}]	-0.143* (0.669) [0.234^{L}-3.212^{U}]	0.953* (1.285) [0.209^{L}-32.205^{U}]
HUN rating	-1.264* (0.782) [0.406^{L}-1.309^{U}]	-3.635* (1.022) [0.004^{L}-0.196^{U}]	0.023* (0.657) [0.283^{L}-3.707^{U}]	-2.433* (1.182) [0.009^{L}-0.889^{U}]
Other party ratings	-0.519* (0.725) [0.061^{L}-6.958^{U}]	0.240* (1.035) [0.167^{L}-9.658^{U}]	0.708* (0.925) [0.331^{L}-12.427^{U}]	-2.568* (2.176) [0.001^{L}-5.455^{U}]
Constant	3.352	12.314	5.677	11.024
Note	Log-likelihood = 122.28, p = .000; logistic regression (LR) $\chi 2$ =572.271; Cox and Snell R2 = .791, Nagelkerke R2 = .852, McFadden R2 = .593; *Indicates that it is significant at 5% significance level.		Log-likelihood = 101.34, p = .000; logistic regression (LR) $\chi 2$ = 79.873; Cox and Snell R2 = .745, Nagelkerke R2 = .803, McFadden R2 = .519; *Indicates that it is significant at 5% significance level	

In the SPSS implementation of the multinomial logistic regression model, the "Other" category was automatically designated as the reference category. Consequently, the estimated coefficients for the remaining parties are calculated relative to this reference category. While "Other" itself does not appear directly as a coefficient in the model, it serves as the baseline for interpreting all parameter estimates, which is standard statistical practice.

The relatively high standard error observed for the HUN party coefficient indicates low confidence in the true value of this parameter and reflects model instability. This may result from a small sample size, high correlations among covariates, sparse data, outliers, or potential model misspecification, which is why the coefficient was not included in the table.

The multinomial logistic regression results show that age, gender, education, income, political information sources, political activism, prior voting behavior, and party evaluations have statistically significant effects on support for the MPP (Mongolian People's Party) and DP (Democratic Party) ($p < 0.05$). Coefficients from the 2nd and 4th districts indicate that the effect of each predictor may be positive or negative depending on the voter category and party choice. For

example, age exhibited a negative association with MPP and DP support, whereas political activism had a positive effect on DP support, reflecting differences in voter behavior.

Model fit indicators (Cox and Snell R^2 = 0.745–0.791, Nagelkerke R^2 = 0.803–0.852, McFadden R^2 = 0.519–0.593) demonstrate a high explanatory power, and the Likelihood Ratio χ^2 test confirms the model's statistical significance ($p < 0.001$). These findings systematically illustrate how individual characteristics, prior voting behavior, and party evaluations influence support for the MPP and DP.

In the multinomial logit framework, with k outcome categories (in this case, VoteToday = MPP, DP, HUN, Other), one category is selected as the reference. Here, "Other" serves as the reference category (Y = Other).

$$log\frac{P(Y=j)}{P(Y=oth\ \ )} = \beta_{0j} + \beta_{1j}Age + \beta_{2j}gender + \beta_{3j}edu + \cdots + \beta_{11j}other_rate \quad (3)$$

$P(Y = j)$ - Probability of voting for category j

β_{0j} - intercept (base coefficient)

β_{ij} - the effect of variable i on category j

For example, the equation for calculating the probability of choosing an MPP in the second circle is written as follows:

$$log\frac{P(Y = MPP)}{P(Y = other)} = 3.352 - 0.151Age + 0.040gender + 0.412edu + \cdots + -0.519other_rate$$

Using a multinomial logit model equation, the probability of a party being elected based on the electoral quality data was calculated for each circle.

Table 5. Elected party prediction results

Observed	2nd circle Predicted					4th circle Predicted				
	MPP	DP	HUNP	Other P	Percent Correct	MPP	DP	HUNP	Other P	Percent Correct
MPP	47	2	0	1	94.0 %	46	1	0	0	97.9 %
DP	2	36	1	4	83.7 %	2	38	0	2	90.5 %

HUNP	0	0	14	6	70.0 %	0	0	20	1	95.2 %
Other P	8	3	3	11	44.0 %	1	3	7	3	21.4 %
Overall Percentage	41.3 %	29.7 %	13.0 %	15.9 %	78.3 %	39.5 %	33.9 %	21.8 %	4.8 %	86.3 %

The classification tables from the multinomial logistic regression model indicate that the model predicts voter choices for the MPP and DP with relatively high accuracy (MPP: 94.0%, DP: 83.7%). Prediction accuracy for the HUN party is 70.0%, while the "Other" category achieves only 44.0%. The lower accuracy for smaller or heterogeneous categories reflects the limited number of observations within these groups, greater heterogeneity, and the inherent difficulty in predicting support for minor parties. Overall, the model achieves a total prediction accuracy of 78.3%, demonstrating that it captures the voting behavior for the major parties reasonably well, though predictions for smaller and more heterogeneous categories remain relatively weak.

In another instance, the classification results show even higher prediction accuracy for the major parties (MPP: 97.9%, DP: 90.5%, HUN: 95.2%), indicating that the structure of voter preferences and support for these parties is well represented in the model. In contrast, the "Other" category shows a substantially lower accuracy (21.4%), which can be attributed to the small number of observations, high heterogeneity, and the reference-category-based structure of the model. This suggests the model faces challenges in predicting individual voter behavior for minor parties. Overall, the total classification accuracy reaches 86.3%, confirming that the model can reliably predict voter choices for the main parties with high precision.

CONCLUSION

Empirical studies on data-driven electoral forecasting in Mongolia remain relatively scarce, and most existing analyses are of an exploratory nature. The Multinomial Logistic Regression (MLR) model employed in this study integrates voter behavior, socio-economic indicators, and party evaluations, demonstrating the theoretical and methodological relevance of developing data-driven pre-election predictions in the Mongolian context.

The results indicate that voter choice is directly influenced by age, education, household income, sources of political information, political activism, prior

voting behavior, and party evaluations. Demographic analysis shows that the sample composition across the two districts was relatively stable, with the majority aged 31–50 and a balanced gender distribution. In terms of education, respondents with complete secondary, bachelor's, or master's degrees predominated, while households earning 2–5 million MNT per month were most represented, indicating a balanced baseline demographic profile.

Internal consistency measures, including Cronbach's alpha and Corrected Item–Total Correlation (CITC), suggest that while some variables (e.g., Infosource, PrevVote, HUN_rate, Other_rate, VoteToday) may not fully capture the latent construct, Age, Gender, Education, Income, Activism, and party evaluation align well with the scale. The Kaiser-Meyer-Olkin (KMO) coefficient confirmed adequate sampling for factor analysis.

MLR results demonstrate that age, gender, education, income, political information sources, political activism, prior voting, and party evaluations significantly influence support for the MPP and DP ($p < 0.05$). Age shows a negative association with MPP and DP support, whereas political activism positively predicts DP support, reflecting differences in voter behavior. Model fit indicators (Cox and Snell $R^2 = 0.745–0.791$, Nagelkerke $R^2 = 0.803–0.852$, McFadden $R^2 = 0.519–0.593$) and the LR χ^2 test ($p < 0.001$) confirm strong explanatory power.

Classification results indicate high predictive accuracy for MPP and DP choices, ranging from 94–98% for MPP and 84–91% for DP across the two districts. In contrast, prediction for the "Other" category is relatively weak, reflecting the small number of observations and higher heterogeneity. Overall prediction accuracy reaches 78.3% in the 2nd district and 86.3% in the 4th district, demonstrating that the model systematically and reliably forecasts major party choices.

In conclusion, these findings integrate the demographic composition, latent variable structure, and MLR model performance, confirming that voter behavior and party support for major parties are well captured. The relatively weak prediction for the "Other" category highlights the need for further investigation into the heterogeneity of minor parties and item-level internal consistency

REFERENCES

Bank, W. (2022). *Worldwide governance indicators and voter behavior analysis.* World Bank Publications.

Batbold, T., & Tumenjargal, D. (2018). Factors influencing voter participation in Mongolia. *Politology, 18*(2), 45-58.

Blais, A. (2000). *To vote or not to vote: The merits and limits of rational choice theory.*

Brito, K., & Adeodato, P. (2023). Machine learning for predicting elections in Latin America based on social media engagement and polls. *Government Information Quarterly, 40*(1), 101782. doi:10.1016/j.giq.2022.101782

Downs, A. (1957). *An economic theory of democracy.*

Gueuwou, S., & Mensah, R.-M. (2023). *Stance prediction and analysis of Twitter data: A case study of Ghana 2020 presidential elections.* arXiv. Retrieved from https://arxiv.org/abs/2306.14203

Hair, B., & Babin, A. (2019). *Multivariate data analysis.* Cengage.

Hosmer, L. (2013). *Applied logistic regression.* Wiley.

International Foundation for Electoral Systems. (2021). *Voter participation and public trust in elections.* IFES.

Myagmartsooj, N. (2024). Factors influencing voter turnout in Mongolia (Youth case study). *Politology, 22*(1), 111–118.

National Statistics Office of Mongolia. (2023). *Population and election participation statistics.* Ulaanbaatar.

Norris, P. (2014). *Why electoral integrity matters.* Cambridge University Press.

Sant Maral Foundation. (2022). *Public opinion survey on political participation in Mongolia.* Ulaanbaatar.

Shahi, G., Basyurt, A., & Stieglitz, S. (2025). Agenda formation and prediction of voting tendencies for European Parliament election using textual, social and network features. *Information Systems Frontiers*. doi:10.1007/s10796-024-10568-w

Urandelger, G., Burmaa, S., & Altan-Od, M. (2023). Factors influencing youth political choice in Mongolia. *Journal of Business and Innovation, 9*(2), 55–70.

Хавсралт

СЭДЭВ: СОНГУУЛИЙН СОНГОЛТЫГ УРЬДЧИЛСАН ТААМАГЛАХ СУДАЛГАА

Зорилго: Сонгогчдын үндсэн шинж болон улс төрийн үнэлгээнд тулгуурлан намын сонголтын магадлалыг тооцож, сонгуулийн үр дүнг урьдчилан таамаглах зорилго бүхий судалгаа юм. Судалгаанд оролцогчдын мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний ажил, өгүүлэл бичихэд ашиглах бөгөөд ямар нэгэн **улс төрийн сонирхолгүй** болно. Судалгаанд оролцогчдын мэдээллийг хуульд заасны дагуу хамгаалж, нууцлах болно.

Судалгаа өгөхийг зөвшөөрч байна. Судалгаанд оролцогчийн утасны дугаар:
.....

Иргэний үнэмлэх дэх албан ёсны дүүрэг, аймаг бичих:
.....

СУУРЬ МЭДЭЭЛЭЛ:

1. Таны нас: .....
2. Таны хүйс: ☐ Эрэгтэй ☐ Эмэгтэй
3. Таны боловсролын түвшин:

☐ Бага ☐ Дунд ☐ Бүрэн дунд ☐ Диплом ☐ Бакалавр ☐ Магистр ☐ Доктор

4. Танай өрхийн сарын дундаж орлогын хэмжээг сонгоно уу?

☐ 1 сая төгрөгөөс доош ☐ 1-2 сая ☐ 2-3 сая ☐ 3-5 сая ☐ 5 сая дээш

УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ХАНДЛАГА:

1. Та улс төрийн мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?

☐ ТВ ☐ Facebook ☐ TikTok ☐ Сайтууд ☐ Танил, найз нөхөд ☐ Бусад

2. Та өөрийнхөө улс төрийн идэвхийг үнэлнэ үү?

☐ Маш идэвхгүй ☐ Идэвхгүй ☐ Дунд ☐ Идэвхтэй ☐ Маш идэвхтэй

3. Та өмнөх УИХ сонгуульд саналаа өгсөн үү?

☐ Тийм ☐ Үгүй ☐ Санахгүй байна

4. Та дараах улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагааг нийтэд нь хэрхэн үнэлж байна вэ?

Намын нэр	**Маш муу**	**Муу**	**Дунд**	**Сайн**	**Маш сайн**
МАН					
АН					
ХҮН нам					
Бусад нам					

5. Хэрэв өнөөдөр сонгууль болбол та аль намд саналаа өгөх вэ? (Заавал хариулна.)

☐ МАН ☐ АН ☐ ХҮН нам ☐ Бусад нам

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 183-198 дах тал

МОНГОЛ УЛС ДАХЬ СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ БА УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Д.Түмэнжаргал
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн Дэд профессор

Yinxia
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

Тус өгүүлэлд Монгол Улсад 1992 оноос хойш хэрэгжсэн сонгуулийн тогтолцооны өөрчлөлтүүд улс төрийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж байсныг тодорхойлж, институцийн хувьсал болон эрх мэдлийн шилжилт хоорондын уялдаа холбоог тодруулахад чиглэнэ. Судалгаанд түүхэн харьцуулалт, агуулгын шинжилгээ, сонгуулийн хоёрдогч статистик мэдээлэлд суурилсан чанарын болон тоон аргыг хослуулан ашиглав.

Судалгааны үр дүнгээс харахад сонгуулийн тогтолцооны давтамжит өөрчлөлт намын тогтолцооны төлөвшил, парламентын төлөөллийн чанар, засаглалын үр ашигт тодорхой хэмжээний нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал, мажоритар, хувь тэнцүүлсэн болон холимог сонгуулийн тогтолцооны үед улс төрийн өрсөлдөөний хэлбэр өөрчлөгдөж, зарим тохиолдолд улс төрийн туйлшрал, институцийн үл итгэлцлийг нэмэгдүүлэх хандлага ажиглагдсан. Сонгуулийн тогтолцооны шинэчлэл зөвхөн техникийн шинжтэй зохицуулалт бус, улс төрийн тогтвортой байдлыг хангах стратегийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болохыг онцолсон. Түүнчлэн сонгуулийн институцийн тогтвортой, урт хугацаанд баримтлах зарчимд суурилсан бодлого ардчиллын бэхжилт, төрийн засаглалын легитим байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй болохыг дүгнэв.

Түлхүүр үгс: Сонгуулийн тогтолцоо, улс төрийн тогтвортой байдал, намын тогтолцоо, ардчиллын бэхжилт, төрийн засаглал

I.***Удиртгал***

Ардчилсан улсад сонгуулийн тогтолцоо улс төрийн өрсөлдөөнийг зохион байгуулж, төлөөллийн чанарыг хангах, эрх мэдлийг хууль ёсны дагуу шилжүүлэх үндсэн арга, механизм болдог (Lijphart, 1994; Norris, 2004). Сонгуулийн тогтолцооны ямар хэв шинж байхаас хамаарч нам, намын системийн бүтэц, парламентын бүрэлдэхүүн, засаглалын тогтвортой байдалд эерэг, сөрөг нөлөөлөл үзүүлдгийг орчин үеийн улс төрийн судалгаануудад дурдсан байдаг (Duverger, 1954; Shugart & Carey, 1992).

Сонгуулийн тогтолцоо, улс төрийн тогтвортой байдлын харилцан хамаарал нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжиж буй улс орнуудад онцгой ач холбогдолтой байдаг. Институцийн тогтворгүй байдал, байнга өөрчлөгдөх хууль эрх зүйн орчин намын тогтолцооны төлөвшлийг сааруулж, сонгогчдын итгэлийг бууруулан, улмаар улс төрийн туйлшрал болон институцийн үл итгэлцлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй хэмээн судлаачид үздэг (Mainwaring & Scully, 1995; Przeworski et al., 2000).

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хууль баталснаас хойш сонгуулийн тогтолцоондоо хэд хэдэн удаагийн өөрчлөлт оруулж, мажоритар, хувь тэнцүүлсэн, холимог хэлбэрийн тогтолцоог ээлжлэн хэрэгжүүлсэн онцлогтой. Тухайлбал, 1992, 2000 онуудад мажоритар тогтолцоо зонхилж байсан бол 2012 онд холимог, 2016 онд дахин мажоритар, 2020 онд мөн мажоритар, 2024 оноос холимог тогтолцоогоор төрийн эрх барих дээд байгууллагын сонгуулийг зохион байгуулжээ (Ginsburg & Ganzorig, 2013; Croissant, 2018).

Дээрх өөрчлөлтүүд Монгол Улс дахь нам, намын тогтолцооны төлөвшил, парламентын төлөөллийн чанар, Засгийн газрын тогтвортой байдалд бодит нөлөө үзүүлсэн хэдий ч уг үйл явцыг институцийн үүднээс системтэй тайлбарласан судалгаа харьцангуй цөөн байна. Зарим судалгаанд сонгуулийн тогтолцооны давтамжит өөрчлөлт улс төрийн өрсөлдөөнийг стратегийн шинжтэй болгож, нам хоорондын итгэлцлийг сулруулсан хэмээн дүгнэсэн байдаг (Fish, 1998; Fritz, 2008).

Сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийг богино хугацааны улс төрийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх нь институцийн тогтвортой байдлыг алдагдуулж, сонгуулийн үр дүнг нийтээр хүлээн зөвшөөрөх байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Харин тогтвортой, урт хугацаанд баримтлах зарчимд суурилсан сонгуулийн институц ардчиллын бэхжилт, улс төрийн

тогтвортой байдлыг хангах чухал нөхцөл болдог (Norris, 2014; Diamond, 2008).

Тус өгүүллийн зорилго нь Монгол Улсад 1992 оноос хойш хэрэгжсэн сонгуулийн тогтолцооны өөрчлөлт улс төрийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж буйг түүхэн-институцийн үүднээс шинжлэхэд оршино. Ингэхдээ агуулгын шинжилгээ, сонгуулийн үр дүнгийн статистик хоёрдогч мэдээлэлд суурилсан чанарын, тоон аргыг хослуулан ашиглав.

Өгүүлэл дараах бүтэцтэй байна. Нэгдүгээр хэсэгт сонгуулийн тогтолцоо, улс төрийн тогтвортой байдлын онолын үндэслэлийг авч үзнэ. Хоёрдугаар хэсэгт Монгол Улсын сонгуулийн тогтолцооны өөрчлөлт, улс төрийн тогтвортой байдалд үзүүлж буй нөлөөллийг авч үзнэ. Эцэст нь судалгааны үндсэн дүгнэлтийг хийнэ.

II. ***Онолын хүрээ***

Сонгуулийн тогтолцооны хэв шинж улс төрийн тогтвортой байдалд эерэг, сөрөг нөлөө үзүүлдэг институцийн механизм хэмээн улс төр судлаачид үздэг (Lijphart, 1994; Norris, 2004). Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад сонгуулийн тогтолцоо нь нам, намын систем, парламент дахь төлөөллийн харьцаа, засаглалын тогтвортой байдалд чухал ач холбогдолтой бөгөөд институцийн тогтворжилт, ардчиллын бэхжилтэд гол хүчин зүйл болдог байна (Duverger, 1954; Shugart & Carey, 1992).

Онолын хувьд сонгуулийн тогтолцоог гурван үндсэн төрөлд хуваадаг. Үүнд:

1. **Мажоритар систем (First-Past-the-Post, FPTP)**: Тухайн тойрогт хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялна. Энэ тогтолцоо ихэвчлэн хоёр намын тогтолцоог бэхжүүлдэг. Парламентын тогтвортой байдлыг дэмжих боловч жижиг намын төлөөллийг хязгаарлах эрсдэлтэй (Duverger, 1954).
2. **Пропорциональ төлөөллийн систем (Proportional Representation, PR)**: Намуудын авсан саналын хувьтай уялдуулан суудлыг хуваарилна. Олон намын төлөөллийг нэмэгдүүлдэг боловч засгийн тогтвортой байдалд сорилт үүсгэх магадлал өндөр (Lijphart, 1994).
3. **Холимог тогтолцоо (Mixed system)**: Мажоритар болон пропорциональ элементийг хослуулсан систем бөгөөд

тогтвортой байдал, төлөөллийн чанарыг тэнцвэржүүлэх зорилготой (Shugart & Carey, 1992; Norris, 2004).

Тогтолцооны эдгээр хэв шинжийн ялгаа улс төрийн өрсөлдөөн, намын системийн бүтэц, сонгогчдын итгэлцэл, парламентын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөгөөр тодорхойлогддог (Mainwaring & Shugart, 1997). Институцийн тогтвортой байдал нь зөвхөн хууль эрх зүйн зохицуулалт төдийгүй нам, намын систем, парламентын бүтэц, сонгогчдын итгэлцлийн уялдаан дээр суурилдаг. Судалгаагаар институцийн тогтворгүй байдал, байнга өөрчлөгдөх сонгуулийн эрх зүйн орчин улс төрийн туйлшрал, институцийн үл итгэлцлийг нэмэгдүүлдэг болохыг харуулжээ (Diamond, 2008; Norris, 2014).

III. ***Сонгуулийн тогтолцооны өөрчлөлт, улс төрийн тогтвортой байдалд үзүүлэл нөлөөлөл***

Улс төрийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөг тодорхойлохын өмнө Монгол Улс дахь сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийг авч үзэх, тусгайлан судлах шаардлага үүснэ.

Монгол Улсад ардчиллын суурь зарчимд нийцсэн анхны чөлөөт сонгууль 1990 онд зохион байгуулагдсан. Ингэхдээ орон нутгийн болон төрийн эрх барих дээд байгууллагыг сонгох сонгуулийг хамтатган явуулсан онцлогтой (Ширнэн, 2019). Энэ талаар судалгааны бүтээлүүдэд “олон намын тогтолцооны үндсэн дээр анхны чөлөөт, ардчилсан сонгууль 1990 оны 7-р сард зохион байгуулагдаж, МАХН олонх суудлыг авсан” (Болдбаатар, 2017, p. 245) хэмээн бичжээ. Байнгын бус ажиллагаатай Ардын Их Хурал (АИХ) 430 депутат, байнгын ажиллагаатай Улсын Бага Хурал (УБХ) 50 гишүүнээс бүрдэнэ хэмээн заасан 1990 оны тавдугаар сарын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлж сонгуулийг зохион байгуулсан. Нийт зургаан улс төрийн нам тус сонгуульд өрсөлдсөнөөс УБХ-д МАХН 31, МҮДН 3, МоАН 13, МСДН 3 төлөөлөл авчээ (Лхагважав, 1994).

Анхны чөлөөт ардчилсан сонгууль хэд хэдэн онцлог шинжийг өөртөө агуулж байсныг дурдах байна. Үүнд:

- Монгол Улсын түүхэн дэх анхны ардчилсан чөлөөт сонгууль байсан;
- Олон намын оролцоотой зохион байгуулагдсан (МАХН, МҮДН, ЧХН, МоАН, МСДН, НН гэсэн зургаан улс төрийн нам оролцсон);

- Сонгуулийн хувь тэнцүүлсэн болон олонхын тогтолцоог хослуулсан зэрэг болно.

1992 оны үндсэн хуулийн 3.1-т “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” (Лүндээжанцан & Энхбаатар, 2025) хэмээн заажээ. Анхны үндсэн хууль батлагдсаны дараагаар сонгуулийн хууль, тогтолцооны өөрчлөлтүүд хийгдэж эхэлсэн. Тухайлбал, Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын сонгуулийн тухай хууль 1992 онд батлагдаж, 2005, 2011, 2015, 2019, 2023 онуудад шинэчлэгдсэн. Харин Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль 1993 онд анх батлагдаж, 2001, 2005, 2006, 2009, 2011 онуудад нэмэлт өөрчлөлт орж, 2012, 2020 онуудад шинэчилсэн найруулга хийгджээ. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль 1996 онд батлагдаж, 2007, 2012, 2015, 2020 онуудад шинэчилсэн найруулга хийгдсэн (Эрдэнэдалай & Уртнасан, 2024, p. 255). Эдгээрт үндэслэн УИХ-ын, Ерөнхийлөгчийн, бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг удаа дараа зохион байгуулж ирсэн. 1992 оноос өнөөг хүртэлх хугацаанд УИХ-ын болон бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нийт 9 удаагийн, Ерөнхийлөгчийн 8 удаагийн сонгууль тус тус болжээ. Сонгууль бүр өөр өөрийн гэсэн онцлогтой зохион байгуулагдсаныг дурдах байна. УИХ, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн дээрх сонгуулиудад намуудын санал авсан байдал харилцан адилгүй байгаа ч Монгол Ардын Нам (МАН) болон Ардчилсан Нам (АН) ихэнхдээ ялалт байгуулж байжээ. Тухайлбал, УИХ-ын сонгуульд МАН 7 удаа, АН 2 удаа, Ерөнхийлөгчийн сонгуульд МАН 4, АН 4 удаа тус тус ялалт байгуулсан байна (Эрдэнэдалай & Уртнасан, 2024, p. 278). Орон нутгийн сонгуульд их төлөв МАН ялалт байгуулж байв.

Хэдийгээр МАН болон АН сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулж ирсэн ч засаг барьж буй эдгээр намуудын зүгээс эрх мэдлээ бататгаж үлдэх, сонгуулийн үйл явцыг өөрт ашигтайгаар зохион байгуулж, давуу байдал бий болгох үүднээс холбогдох хууль тогтоомжид сонгууль болохоос “4.7 сарын өмнө” нэмэлт өөрчлөлт хийдэг жишиг тогтсон (Эрдэнэдалай & Уртнасан, 2024, p. 260). Магадгүй, сонгуулийн ижил үр дүн олон удаа давтагдсанаас эрх баригч намуудад улс төрийн өрсөлдөөнийг хязгаарлах, үгсэн хуйвалдахад чиглэсэн картелжилтийн шинж илэрч байж болох юм. Уг байдлыг тодотгон судлаач А.Пшеворски “нэг нам сонгуульд дараалан сонгогчдын 60-аас дээш хувийн санал авч ялалт байгуулсан нэг ч орныг

ардчилсан хэмээн үзэж болохгүй" (Przeworski, 1991, p. 78) гэж бичжээ. 2019 оны үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 21.4-т "Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно" гэснийг "Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглоно" хэмээн тодотгон заасан нь дээрх үйл явцыг таслан зогсоох, үндсэн хуульт байгууллыг бэхжүүлэх, сонгууль, сонгуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх зорилгоор авсан томоохон алхам болсон гэж үзэх үндэстэй.

УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийн тусдаа хууль байх ч 2015 оны 12-р сарын 25-нд баталсан Сонгуулийн тухай хууль дээрх гурван сонгуулийг зохицуулах нэгдсэн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн байна. Бүх шатны сонгууль зохион байгуулах чиг үүрэгтэй төрийн байгууллагыг Сонгуулийн ерөнхий хороо гэнэ. Нийт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй. Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн үндсийг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар зохицуулдаг. Сонгуулийн үйл ажиллагааг улс орны хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд Улсын Бага Хурлын 1992 оны 4-р сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Сонгуулийн Ерөнхий хороог анх байгуулж байсан.

Сонгогчдын бүртгэл, сонгогчийн санал авах, тоолох үйл ажиллагааг зохицуулахын тулд 2011 онд УИХ-аас Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль батлан гаргасан нь бүх шатны сонгуулийн зохион байгуулалтыг сайжруулах чухам алхам болсныг онцлох байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.1-т "Монгол Улсын Их Хурлын сонгууль нь Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төрийн эрх барих дээд байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлж байгаа үндсэн арга мөн" (Өмгөөллийн "Төв консалтинг" ХХН, 2024) хэмээн заасан. Тэрчлэн УИХ-ын сонгуулийг ээлжит, ээлжит бус, нөхөн гэсэн гурван төрөлтэй байхыг хуульчилсан. Ээлжит сонгууль дөрвөн жилд нэг удаа зохион байгуулагддаг онцлогтой. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.1-т зааснаар, Монгол Улсын Их Хурлын сонгууль нь сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төрийн эрх барих дээд байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлж байгаа үндсэн арга ба дөрвөн жил тутам ээлжит сонгуулийн хэлбэрээр зохион байгуулдаг. Улсын Их

Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн нутаг дэвсгэр тойрогт, тойрог нь хэсэгт хуваагдана. Харин жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.

Сонгуулийн тойрогт ноогдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоохдоо:

- аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзах;
- тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ байх;
- хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэг тойрог болгон нэгтгэх;
- ээлжит бус сонгууль явуулахаас бусад тохиолдолд дараагийн ээлжит сонгууль хүртэл өөрчлөхийг хориглох зэрэг байна.

УИХ-ын сонгуулийн эрх зүйн орчин Монгол Улсын Үндсэн хууль, 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2012 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, тэрчлэн 2019 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)-ны журмаас үндсэндээ бүрддэг.

“Сонгууль зохион явуулах, санал хураалтын үр дүн тодорхойлох, парламентын суудал хуваарилах арга, сонгуулийн эрх олгох журмын цогцыг сонгуулийн систем...” (Baglaj, 2008, p. 405) хэмээн ойлгодог талаар улс төрийн шинжлэх ухааны мэргэжлийн сурах бичгүүдэд дурдсан байдаг.

Хүснэгт 1. Монгол Улсын сонгуулийн товчоон (1992-2024 он)

№	УИХ-ын сонгууль	УИХ-ын сонгуулийн тогтолцооны өөрчлөлт	Сонгуулийн тойрог	Нийт мандат	Ерөнхийлөгчийн сонгууль
1	1992 оны 6-р сарын 28-нд зохион байгуулсан. 8 нам, 2 эвсэл, 18 бие даагч оролцсон. МАХН үнэмлэхүй ялалт (76/70) байгуулсан.	Олон мандаттай дийлэнх/олонхын тогтолцоо (Block voting)	26 томсгосон тойрог	76	1993 оны 6-р сарын 06-нд зохион байгуулагдсан. 1 нам, 1 эвсэл оролцсон. АН-аас нэр дэвшигч П.Очирбат ялалт байгуулсан.
2	1996 оны 6-р сарын 30-нд зохион байгуулсан. 5 нам, 2 эвсэл, 35 бие даагч оролцсон. АН олонхыг бүрдүүлж (76/50) ялалт байгуулсан.	Жижгэрүүлсэн нэг тойрог, нэг мандаттай (FPTP)	76 жижиг тойрог	76	1997 оны 05-р сарын 18-нд зохион байгуулагдсан. 2 нам, 1 эвсэл оролцсон. МАН-аас нэр дэвшигч Н.Багабанди ялалт байгуулсан.
3	2000 оны 7-р сарын 02-нд зохион байгуулсан. 13 нам, 3 эвсэл, 27 бие даагч оролцсон. МАХН үнэмлэхүй ялалт (76/72) байгуулсан.	Жижгэрүүлсэн нэг тойрог, нэг мандаттай (FPTP)	76 жижиг тойрог	76	2001 оны 05-р сарын 20-нд зохион байгуулагдсан. 3 нам оролцсон. МАН-аас нэр дэвшигч Н.Багабанди ялалт байгуулсан.
4	2004 оны 6-р сарын 27-нд зохион байгуулсан. 7 нам, 1 эвсэл, 15 бие даагч	Жижгэрүүлсэн нэг тойрог, нэг мандаттай (FPTP)	76 жижиг тойрог	76	2005 оны 05-р сарын 22-нд зохион байгуулагдсан. 4 нам оролцсон. МАН-аас нэр дэвшигч

	оролцсон. МАХН (76/36), Эх орон-Ардчилал Эвсэл (76/36) тус тус авсан.				Н.Энхбаяр ялалт байгуулсан.
5	2008 оны 6-р сарын 29-нд зохион байгуулсан. 12 нам, 1 эвсэл, 45 бие даагч оролцсон. МАХН (76/45), Ардчилсан нам (76/28) тус тус авсан.	Олон мандаттай дийлэнх/олонхын тогтолцоо (Block voting)	26 томсгосон тойрог	76	2009 оны 05-р сарын 24-нд зохион байгуулагдсан. 2 нам оролцсон. АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж ялалт байгуулсан.
6	2012 оны 6-р сарын 28-нд зохион байгуулсан. 11 нам, 2 эвсэл, 26 бие даагч оролцсон. АН (76/34), МАХН (76/26), Шударга ёс эвсэл (76/11) ИЗНН (76/2), бие даагч 3 суудал тус тус авсан.	Олон мандаттай дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог зэрэгцүүлэн (Paralell system) 48/28	26 томсгосон тойрог	76	2013 оны 06-р сарын 26-нд зохион байгуулагдсан. 3 нам оролцсон. АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж ялалт байгуулсан.
7	2016 оны 6-р сарын 29-нд сонгуулийн холимог (48/28) тогтолцоогоор зохион байгуулсан.	Жижгэрүүлсэн нэг тойрог, нэг мандаттай (FPTP)	76 жижиг тойрог	76	2017 оны 06-р сарын 09-нд зохион байгуулагдсан. 3 нам оролцсон. АН-аас нэр дэвшигч Х.Баттулга ялалт байгуулсан.

	12 нам, 3 эвсэл, 69 бие даагч оролцсон. МАН (76/65), АН (76/9), МАХН (76/1), бие даагч 1 суудал тус тус авсан.				
8	2020 оны 6-р сарын 24-нд сонгуулийн холимог (48/28) тогтолцоогоор зохион байгуулсан. 14 нам, 3 эвсэл, 121 бие даагч оролцсон. МАН (76/65), АН (76/9), МАХН (76/1), бие даагч 1 суудал тус тус авсан.	Олон мандаттай дийлэнх/олонхын тогтолцоо (Block voting)	26 томсгосон тойрог	76	2021 оны 06-р сарын 26, 7-р сарын 07-нд зохион байгуулагдсан. 2 нам, 1 эвсэл оролцсон. МАН ялалт байгуулсан. 2019 оны 11-р сарын 14-ний МУ-ын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 30.2-т “Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.
9	2024 оны 6-р сарын 28-нд сонгуулийн холимог (78/48) тогтолцоогоор зохион байгуулсан. 18 нам, 3 эвсэл, 42 бие даагч оролцсон. МАН (126/68), АН (126/42), ХҮН (126/8),ҮЭ	Олон мандаттай дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог зэрэгцүүлэн (Paralell system) 78/48	13 томсгосон тойрог	126	

	(126/4), ИЗНН (126/4) тус тус авсан.				

Эх сурвалж:(Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо, 2022)

Дээрх хүснэгтээс харахад сонгуулийн тогтолцооны хувьд бага өөрчлөлт орсон нь Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль болно. Хамгийн их өөрчлөлт УИХ-ын сонгуультай холбоотойгоор хийгдсэн байна.

Сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийн улс төрийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох зорилгоор 1992-2024 оны хоорондох засгийн газрын бүрэн эрхийн хэрэгжилтийг харуулсан хүснэгт оруулав.

Хүснэгт 2. Засгийн газрын бүрэн эрхийн хэрэгжилт, 1992-2024 он

№	Сонгуулийн жил	Сонгуульд ялсан нам, эвсэл	Засгийн газрын тэргүүн	Засгийн газрын ажилласан хугацаа	Бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал
1	1992 он	МАХН	П. Жасрай	1992.07.01 - 1996.07.19	4 жил
2	1996 он	МҮАН, МСДН, Ардчилсан Холбоо Эвсэл	М. Энхсайхан	1996.07.19 - 1998.04.23	1 жил 9 сар
			Ц. Элбэгдорж	1998.04.23 - 1998.12.09	8 сар
			Ж. Наранцацралт	1998.12.09 - 1999.07.22	8 сар
			Р. Амаржаргал	1999.07.30 - 2000.07.26	1 жил
3	2000 он	МАХН	Н. Энхбаяр	2000.07.26 - 2004.08.20	4 жил 1 сар
4	2004 он	МАХН, Эх орон	Ц. Элбэгдорж	2004.08.20 - 2006.01.13	1 жил 5 сар

		ардчилал эвсэл	М. Энхболд	2006.01.26 - 2007.11.07	1 жил 10 сар
			С. Баяр	2007.11.22 - 2008.09.11	9 сар
5	2008 он	МАХН	С. Баяр	2008.09.11 - 2009.10.29	1 жил 11 сар
			С. Батболд	2009.10.29 - 2012.08.10	2 жил 10 сар
6	2012 он	АН, Шударга ёс эвсэл, ИЗНН	Н. Алтанхуяг	2012.08.10 - 2014.11.05	2 жил 2 сар
			Ч. Сайханбилэг	2014.11.21 - 2016.07.08	1 жил 7 сар
7	2016 он	МАН	Ж. Эрдэнэбат	2016.07.08 - 2017.10.04	1 жил 3 сар
			У. Хүрэлсүх	2017.10.04 - 2020.07.07	2 жил 9 сар
8	2020 он	МАН	У. Хүрэлсүх	2020.07.07 - 2021.01.20	6 сар
			Л. Оюун-эрдэнэ	2021.01.27 - 2024.07.05	3 жил 6 сар
9	2024 он	МАН, АН, ХҮН, ИЗНН, ҮЭ	Л. Оюун-эрдэнэ	2024.07.05 - 2025.06.03	8 сар
10	2025 он	МАН, ХҮН, ИЗНН	Г. Занданшатар	2025.06.18 -өнөөг хүртэл ажиллаж байна	7 сар

Эх сурвалж: Монгол Улсын их хурлын сонгуулийн дүн, 1992-2021 он (СЕХ 2022)

Дээрхээс үзэхэд Монгол Улсад засгийн газрын дундаж наслалт ойролцоогоор 2 жил байна. Дүн шинжилгээ хийж үзэхэд сонгууль мажоритар тогтолцоогоор зохион байгуулагдаж буй үед нэг намын давамгайлал бий болж, засгийн газар урт хугацаанд оршин тогтнох нөхцөл бүрдэж байжээ. Тухайлбал, 1992 онд сонгуульд МАХН үнэмлэхүй ялалт байгуулж, П. Жасрай дөрвөн жилийн туршид Засгийн газрыг удирдсан нь улс төрийн тогтвортой байдлыг хадгалсан эхний тохиолдол бол хоёр дахь нь 2016-2020 онуудад МАН олонх болж, У. Хүрэлсүх засгийн газрыг 2 жил, 9 сар удирдсан явдал юм. сонгуулийн холимог тогтолцооны үед улс төрийн намуудын хууль тогтоох хурал дахь төлөөллийн чанар сайжирч, оролцоо нэмэгддэг ч эсрэгээрээ, засгийн газрын бүрэн эрхийн хэрэгжилтэд сорилт үүсгэдэг байна. Үүнийг харьцангуй богино настай засгийн газруудын үйл ажиллагаагаар тодорхойлж болох юм. Тухайлбал, 2012-2016 оны хооронд хууль тогтоох хуралд АН, Шударга ёс эвсэл, ИЗНН зэрэг төлөөлөл бий болсон ч хоёр засгийн газар солигдсон байна.

IV. **ДҮГНЭЛТ**

Монгол Улсын 1992–2024 оны УИХ-ын сонгуулийн туршлагаас үзэхэд сонгуулийн тогтолцооны өөрчлөлт улс төрийн тогтвортой байдалд шууд нөлөөтэй болох нь ажиглагдаж байна. Бэлэн статистик өгөгдөл, засгийн газрын бүрэлдэхүүн, ерөнхий сайд нарын ажилласан хугацаа, хууль тогтоох хурал дахь намын давамгайлалын динамикт тулгуурлан дараах гол дүгнэлтийг гаргаж болох юм. Үүнд:

1. **Мажоритар тогтолцоо нь улс төрийн тогтвортой байдлыг дэмждэг.**
   Мажоритар буюу олон мандаттай дийлэнх/олонхын тогтолцоо болон нэг мандаттай тойрог (FPTP) нь голлох намын давамгайлалыг бататгаж, засгийн газрын урт хугацааны тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлдэг. Үүнийг 1992–1996, 2000–2004, 2016–2020 онуудын баримтаас тодорхой харж болохоор байна.
2. **Холимог болон зэрэгцээ тогтолцоо нь улс төрийн намуудын оролцоо, төлөөллийн чанарыг сайжруулах ч тогтвортой байдалд сорилт үүсгэдэг.**
   2012–2024 онд хэрэгжсэн холимог, зэрэгцүүлсэн систем хууль тогтоох хуралд олон намын төлөөллийг нэмэгдүүлсэн боловч засгийн газрын богино хугацааны сэлгээ, бодлогын хэрэгжилт удаашрах зэрэг сорилтыг бий болгосон.

3. Эндээс **сонгуулийн тогтолцооны эрх зүйн орчны өөрчлөлт улс төрийн тогтвортой байдлын гол хэмжүүр** хэмээн үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Сонгуулийн тогтолцооны эрх зүйн орчин, засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, хууль тогтоох хурал дахь улс төрийн намуудын динамик хоорондын нягт уялдааг баталж байна. Сонгуулийн тогтолцоо хууль тогтоох хурлын төлөөлөх механизм төдийгүй улс төрийн тогтвортой байдлыг тодорхойлдог стратегийн институц мөн.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Baglaj, M. V. (2008). *Konstitucionnoe pravo Rossijskoj Federacii* (Izd. 6-e, izmenen. i dopoln). NORMA.

Diamond, L. (2008). *The Spirit of Democracy*. New York: Times Books.

Duverger, M. (1954). *Political Parties: Their Organization and Activity in the Modern State*. London: Methuen.

Fish, M. S. (1998). Mongolia: Democracy without Prerequisites. *Journal of Democracy*, 9(3), 127–141.

Fritz, V. (2008). *Mongolia: Dependent Democratization*. Journal of Communist Studies and Transition Politics, 24(2), 231–252.

Ginsburg, T., & Ganzorig, G. (2013). When Courts and Politics Collide: Mongolia's Constitutional Crisis. *Asian Journal of Comparative Law*, 8(2), 309–334.

Lijphart, A. (1994). *Electoral Systems and Party Systems*. Oxford: Oxford University Press.

Mainwaring, S., & Scully, T. (1995). *Building Democratic Institutions: Party Systems in Latin America*. Stanford: Stanford University Press.

Norris, P. (2004). *Electoral Engineering: Voting Rules and Political Behavior*. Cambridge: Cambridge University Press.

Norris, P. (2014). *Why Electoral Integrity Matters*. Cambridge: Cambridge University Press.

Shugart, M., & Carey, J. (1992). *Presidents and Assemblies*. Cambridge: Cambridge University Press.

Przeworski, A. (1991). *Democracy and the Market: Political and Economic Reforms in Eastern Europe and Latin America* (1st ed.). Cambridge University Press. https://doi.org/10.1017/CBO9781139172493

Болдбаатар, Ж. (2017). *Монголын "перестройка"-ийн (өөрчлөн байгуулалт) түүхийн судалгаа: Улс төрийн түүх*. Соёмбо Принтинг ХХК.

Лүндээжанцан, Д., & Энхбаатар, Ч. (2025). *Монгол Улсын үндсэн хуулийн эрх зүй*. Адмон Принт ХХК.

Лхагважав, Ч. (1994). Монгол улсын парламентын (1990, 1992) болон Ерөнхийлөгчийн (1993 оны) сонгуулийн дүнд хийсэн анализ. *Шинэ Толь Сэтгүүл*, *№4*.

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо. (2022). *Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн дүн: 1993-2021 он*. Адмон Принт ХХК.

СЕХ. 2022. *Монгол улсын их хурлын сонгуулийн дүн, 1992-2021 он.* Улаанбаатар хот: Адмон Принт ХХК.

Өмгөөллийн "Төв консалтинг" ХХН. (2024). *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн гарын авлага: Сонгуулийн үед хэрэглэгдэх баримт бичгүүд, үлгэрчилсэн загвар, маягтууд /өргөдөл, гомдол, хүсэлт, нэхэмжлэл, гэрээ, бусад/*. Мөнхийн үсэг ХХК.

Ширнэн, Б. (2019). *Ардчилсан хувьсгал 1990: IX боть: АИХ-ын сонгууль/ дублерууд = Democratic revolution 1990: Volume 9: People's great Khural election / understudy = Varat uv yagae qural uv suvgqhuqhuli (duiblyur ut)*. Мөнхийн үсэг ХХК.

Эрдэнэдалай, Б.-Өлзий, & Уртнасан, Д. (2024). Гурав. Сонгууль, сонгуулийн тогтолцоо. In *Монголын улс төрийн хөгжил ба ардчилал: 1990 оноос хойш* (Анхны хэвлэлт, pp. 250–304). Удам соёл ХХК.

CHANGES IN MONGOLIA'S ELECTORAL SYSTEM AND POLITICAL STABILITY

Abstract: This article examines how changes in Mongolia's electoral system since 1992 have affected political stability and the functioning of democratic institutions. The study focuses on the relationship between institutional reforms and patterns of political competition, representation, and governance. Using a historical-institutional approach, the research combines qualitative analysis of legal and policy documents with quantitative data from electoral results.

The findings suggest that frequent modifications of the electoral system have had significant implications for party system consolidation, parliamentary representation, and government stability. In particular, the alternation between majoritarian and mixed electoral systems has reshaped political competition and, in some cases, contributed to political polarization and declining institutional trust. These changes have also influenced the effectiveness of governance and the legitimacy of electoral outcomes.

Key words*:* Electoral system; Political stability; Party system; Democratic consolidation; Governance.

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 199-209 дэх тал

СОНГУУЛЬ БА ТӨСВИЙН ЗАРЛАГА ХООРОНДЫН ХАМААРЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Э.Саранцэцэг
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор

Б.Энх-Амгалан
МУИС, БС-ийн Санхүүгийн тэнхимийн дэд профессор,
АБСХ-ийн гэрээт судлаач

Хураангуй:

Ардчилсан тогтолцоонд улс төрчид байнга ард түмэнд таалагдах боломжийг эрж хайн, сонгогдохыг хүсэж байдаг. Сонгогдоход нөлөөлөх гол хүчин зүйл нь мэдээж эдийн засгийн нөхцөл байдал байдаг. Энэ ч утгаараа улс төрчид сонгогдохын тулд цалин, тэтгэвэр тэтгэмж гээд нийгмийн бүх төрлийн халамжийг нэмэгдүүлж, улмаар сонгуулийн жилийн төсвийг тэлэх бодлого хэрэгжүүлдэг. Энэ нь богино хугацаанд эдийн засгийн идэвхжилийг бий болгож, иргэдийн амьжиргаанд тодорхой эерэг нөлөө үзүүлэх боломжтой боловч урт хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулах аюултай. Иймд Улс төрийн төсвийн мөчлөгийн (Political budget cycle) онолын хүрээнд энэ асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай юм. Энэхүү өгүүллийн зорилго нь дээрх онолд тулгуурлан Улсын Их хурлын сонгуулийн жилүүд болон төсвийн зарлагын хоорондын хамаарлыг шинжлэхэд оршино.

Түлхүүр үгс: Сонгууль, сонгуулийн мөчлөг, улсын төсөв, төсвийн зарлага, ардчилсан тогтолцоо, улс төрийн эдийн засаг

Оршил: Сонгууль үүссэн хийгээд үргэлжилж ирсний уг шалтгаан нь ард түмэн улс орноо өөрсдөө удирдах амин хэрэгцээ мөн бөгөөд хамгийг эзэрхэгч хаант ёсыг халах, ганцаар дарангуйлагчийг хавчин зайлуулах тэмцлийн үр дүн мөн. (Б.Чимид, 2025, хууд. 1) хэмээсэн нь ардчиллыг чөлөөт сонгуульгүйгээр ярих байтугай төсөөлөх ч боломжгүй гэдгийг

илтгэнэ. Манай улсын хувьд 1923 оноос нутгийн ардын хурлуудыг, 1924 оноос Улсын Их хурлыг, 1990 оноос Улсын ерөнхийлөгчийг сонгох ёс журмыг хуульчлан тогтоож улс даяар дагуулав. (Б.Чимид, 2025, хууд. 2) Ийнхүү өнөөдөр иргэдийн чөлөөт, бүх нийтийн сонгуулийн үндсэн дээр 9 дэх удаагаа байгуулагдсан Улсын Их Хурал үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ үеүдэд улс төрчид сонгуульд амжилттай оролцох олон арга хэлбэрийг эрэлхийлдэг хэдий ч ихэнх арга хэлбэр нь эдийн засаг, төсөв санхүүтэй холбогддог. Ялангуяа сонгуулийн жилүүдэд улсын төсөвт ихээхэн ачаалал өгдөг. Сонгууль ба улсын төсвийн зарцуулалтын хоорондын хамаарал нь улс төрийн эдийн засгийн судалгаанд чухал байр суурь эзэлдэг төдийгүй улс төрийн эрх мэдэл, эдийн засгийн нөөцийн хуваарилалтын огтлолцлыг тодорхой харуулдаг. Ардчилсан тогтолцоонд сонгууль нь улс төрийн эрх мэдлийг дахин хуваарилах гол механизм болдог бол төсөв нь төрийн бодлого, амлалтыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болдог. Иймээс сонгуулийн мөчлөг төсвийн бодлого, зарцуулалтад тодорхой хэмжээгээр нөлөөлдөг тул Монголын сонгуулийн жилүүд болон төсвийн зарлага хоорондын хамаарлыг судлах нь зүйтэй юм.

Сонгууль ба төсвийн зарлагын хоорондын хамаарал (Онолын үндэслэл)

Улс төрийн эдийн засгийн онолын хүрээнд сонгуулийн мөчлөг бүхий төсвийн бодлого (political budget cycle) гэх ойлголтууд хэрэглэгддэг. Энэхүү онол нь эрх баригч улс төрийн хүчин сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор төсвийн бодлогыг богино хугацаанд өөрчилж, зардлыг нэмэгдүүлэх, татварыг бууруулах, эсвэл нийгмийн халамж, хөрөнгө оруулалтыг тэлэх хандлагатай байдаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, сонгуулийн өмнөх жилүүдэд эрх баригчид сонгогчдын дэмжлэгийг авах зорилгоор төсвийн зардлыг нэмэгдүүлэх, нийгмийн халамж, тэтгэмж, цалин хөлс, гээд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлдэг. Харин сонгуулийн дараах хугацаанд төсвийн алдагдлыг нөхөх, санхүүгийн сахилга батыг сэргээх зорилгоор зардлыг танах, татварыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжих нь элбэг. Сонгуулийн үеийн төсвийн тэлэлт нь богино хугацаанд эдийн засгийн идэвхжилийг бий болгож, иргэдийн амьжиргаанд тодорхой эерэг нөлөө үзүүлэх боломжтой боловч урт хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулах аюултай. Ялангуяа төсвийн зардал нь бүтээмж нэмэгдүүлэх бус, богино хугацааны улс төрийн ашиг сонирхолд чиглэсэн тохиолдолд улсын өр нэмэгдэх, инфляц өсөх, санхүүгийн сахилга бат

алдагдах сөрөг үр дагавартай. Иймээс сонгуулийн ашиг сонирхлоор хөтлөгдсөн төсвийн бодлого нь эдийн засгийн үр ашигтай хөгжлийг хязгаарлах хүчин зүйл болдог.

Нөгөө талаас, сонгогчдын үйл байдал нь төсвийн зарцуулалтын бүтэцтэй шууд холбоотой. Иргэд төсвийн хөрөнгө оруулалт, халамжийн бодлого, орон нутгийн хөгжлийн төслүүдийг эрх баригчдын гүйцэтгэлийн шалгуур болгон үнэлэх хандлагатай байдаг. Энэ нь улс төрчдийг сонгогчдын богино хугацааны хүлээлтэд нийцсэн төсвийн шийдвэр гаргахад түлхэц болгодог. Улмаар төсвийн бодлого нь эдийн засгийн оновчтой байдал бус, сонгуулийн стратегийн хэрэгсэл болон хувирах эрсдэлтэй болдог. Сонгууль ба төсвийн зарцуулалтын хоорондын энэхүү хамаарал нь институцийн чанараас ихээхэн хамаардаг. Хэрэв төсвийн ил тод байдал, хяналтын механизм сул, парламентын хяналт үр дүнгүй, хараат бус санхүүгийн байгууллагуудын үүрэг хангалтгүй бол сонгуулийн нөлөөгөөр төсвийн сахилга бат алдагдах магадлал өндөр байдаг. Харин төсвийн дүрэм, санхүүгийн хязгаарлалт, хараат бус аудит, иргэний нийгмийн хяналт сайн хөгжсөн нөхцөлд сонгуулийн мөчлөгийн сөрөг нөлөө харьцангуй бага илэрдэг.

Дүгнэж хэлбэл, сонгууль ба төсвийн зарлагын хоорондын хамаарал нь улс төрийн ашиг сонирхол, эдийн засгийн нөөцийн хуваарилалтад хэрхэн нөлөөлдгийг тод харуулдаг. Энэхүү хамаарал нь ардчиллын хүрээнд зайлшгүй оршин байдаг боловч түүнийг хязгаарлах институцийн механизм бүрдээгүй тохиолдолд эдийн засгийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж хувирдаг.

Өөрөөр хэлбэл, сонгогчид “санхүүгийн илбэд” автдаг. Чиг үүргийн санхүүжилтийн тухай Абба Лернерийн зарчмаар аваад үзвэл, эдийн засгаар аргалж сонгуульд ялах гэсэн оролдлого эрх баригч болон улс төрчдөд нийтлэг байдаг ба байнга төсвийн алдагдал авчрах тул тогтворжуулах бодлого гажуудалд хүргэдэг байна. (Л.Эсмэдэх, хууд. 82)

Улс төрийн төсвийн мөчлөгийн (Political budget cycle) онолын анхны системтэй тайлбарыг William Nordhaus (1975) дэвшүүлсэн бөгөөд түүний үзлээр ардчилсан тогтолцоонд эрх баригчид сонгуулийн өмнөх хугацаанд эдийн засгийг “хиймлээр идэвхжүүлэх” бодлого хэрэгжүүлж, сонгуулийн дараа инфляц, төсвийн алдагдлыг засах арга хэмжээ авдаг мөчлөг давтагддаг гэж тайлбарласан. Энэхүү хандлага нь эдийн засгийн бодлого сонгуулийн логикт захирагддаг болохыг онолын түвшинд харуулсан анхны оролдлого байв.

Дараагийн судлаачид энэхүү онолыг өргөжүүлэн, илүү бодитой институцийн нөхцөлтэй уялдуулан тайлбарласан. Kenneth Rogoff (1990) болон Anne Sibert нарын судалгаанд сонгуулийн өмнөх төсвийн тэлэлт нь заавал нийт эдийн засгийг өсгөх хэлбэрээр бус, харин мэдээллийн тэгш бус байдлыг ашигласан зардлын бүтцийн өөрчлөлт хэлбэрээр илэрдэг гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, сонгогчид төсвийн бодлогын урт хугацааны үр дагаврыг бүрэн үнэлэх боломжгүй тул эрх баригчид "харагдахуйц" зардлыг нэмэгдүүлэх замаар дэмжлэг авахыг зорьдог.

Эмпирик судалгаанууд ч сонгуулийн мөчлөг ба төсвийн зарцуулалтын хооронд бодит хамаарал байгааг нотолдог. Alberto Alesina, Roubini Nouriel болон Gerald Cohen (1997) нарын судалгаагаар хөгжиж буй болон институц сул орнуудын хувьд сонгуулийн өмнөх жилүүдэд төсвийн алдагдал нэмэгдэх хандлага илүү тод илэрдэг болохыг харуулсан. Харин хөгжингүй, институцийн хяналт сайн тогтолцоотой улс орнуудад энэхүү мөчлөгийн нөлөө харьцангуй сул байдаг гэж дүгнэсэн.

Улс төрийн төсвийн мөчлөгийн (Political budget cycle) онолын орчин үеийн судалгаанууд нь институцийн чанарыг гол тайлбарлагч хүчин зүйл гэж үздэг. Brender Adi ба Drazen Allan (2005) нарын дүн шинжилгээгээр төсвийн ил тод байдал, парламентын хяналт, хараат бус аудитын байгууллага, чөлөөт хэвлэл хөгжсөн нөхцөлд сонгуулийн мөчлөгийн төсвийн тэлэлт мэдэгдэхүйц буурдаг байна. Энэ нь сонгуулийн нөлөө өөрөө бус, харин түүнийг хязгаарлах институц сул байгаа нь гол асуудал болохыг харуулдаг.

Иймээс сонгууль ба төсвийн зарцуулалтын хоорондын хамаарал нь улс төрийн ашиг сонирхол эдийн засгийн нөөцийн хуваарилалтад хэрхэн нөлөөлдгийг онолын болон эмпирик түвшинд нотолсон чухал сэдэв юм. Тус онол нь төсвийн бодлого ямагт эдийн засгийн оновчтой байдлаар бус, харин улс төрийн мөчлөг, сонгогчдын зан төлөв, институцийн чанараас хамааран хэлбэлздэг болохыг тодорхой харуулдаг.

Үүнийгээ эрх баригчид болон улс төрчид сонгогчид засгийн газрыг үе хоорондын төсвийн хязгаарлалттай тулгарч байгааг ойлгохгүй учраас өрөөр санхүүжсэн зардлын хөтөлбөрүүд нь ирээдүйн татварын өр гэдгийг дутуу үнэлдэг. Төрийн ганц сонирхол нь хамгийн сайн боломжит үр дүнд хүргэхээр эдийн засгийг удирдах төсвийг мөчлөгийн эсрэг тэнцвэржүүлэх Кейнсийн зорьж байсан зарчмаар бус төсвийг алдагдалд оруулах нь өрөөр дамжуулан ирээдүйн засгийн газрын бодлогод нөлөөлөх гэсэн одоогийн засгийн газрын стратегитай үйл хөдлөл ч байж болох юм. Энэ бүхнийг харгалзаж үзээд макро эдийн засагчид улс төрчдийг "улс төрийн ашиг

сонирхлын үүднээс эдийн засагт манипуляц хийж" болзошгүй гэж хардаж байх ёстой болж байна. Микал Калецки капиталистуудын эрх ашгийг хамгаалдаг тууштай дэмжигчийн засгийн газар нь ажилчдын хэлэлцээрт орох байр суурь улам бэхжихээс сэргийлж, эдийн засгийн зогсонги байдлыг зориуд үүсгэдэг болохыг Маркс-Кейнсийн загвараар харуулжээ. Хэрэв удаан хугацаанд бүрэн ажил эрхлэлттэй байвал ажилчид "том толгойтой" болж, хэлэлцээр хийхэд амаргүй болно. Калецкийн загвараар төлөөллийн бус улс төрийн механизмын дүнд капиталистуудын сонирхол давамгайлснаар улс төрийн бизнесийн мөчлөг үүсдэг. (Л.Эсмэдэх, хууд. 82)

Харин Эйкермэн 1947 онд хожмын үйл явдлын өрнөлийг урьдаас таамаглаж үзээд, сонгуулийн мөчлөг нь эдийн засгийн бодлогод нөлөөлөн нийт эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэж болзошгүй гэсэн санаа дэвшүүлжээ.

Кейнсийн хувьсгалаас хойш сонгогчид төрд эдийн засгийг даатгах хандлагатай болсон нь эргэлзээгүй. Гэхдээ шийдвэр гаргах эрх мэдлийг хэний гарт төлөөлүүлж бариулахыг сонгохдоо сонгогчид эзэн-төлөөллийн бэрхшээлтэй тулгардаг. Учир нь төлөөлөгч (засгийн газар) нь эзнээсээ (сонгогчдоос) өөр сонирхолтой байж болох ба түүнийгээ төгс бус мэдээлэлтэй сонгогчдоосоо нуух боломжтой байдаг. Засгийн газрын нэр хүндэд макро эдийн засгийн гол хувьсагчдын (инфляц, ажилгүйдэл, орлогын өсөлт) үзүүлэх нөлөөг сүүлийн 20 гаруй жилийн эмпирик судалгааны ажлууд баталсаар байна. Жишээ нь, Шукнэктийн хөгжиж буй 35 орны судалгааг дурдаж болно. Тэрээр хэдийгээр нээлттэй эдийн засагт хувийн ашиг сонирхол хөөсөн улс төрийн үйл хөдлөл бага байдаг ч сонгуулиас үүдэлтэй сангийн бодлогын мөчлөг мэдэгдэх хэмжээнд байдаг гэдгийг тус судалгаагаараа нотлон гаргасан юм. (Schuknecht, 1996)

Ийнхүү улстөрчид дахин сонгогдохын тулд төсвийн орлого, зарлага, татвар, халамжийг сонгуулийн үеэр зохиомлоор өөрчилдөг гэдгийг эрдэмтэд өөр өөрсдийнхөөрөө батлан гаргасан байна. Энэхүү онол нь ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд илрэх магадлал ихтэй байдаг. Иймд Монголын хувьд энэхүү онолын таамаглал биелэгдэж байгаа эсэхийг дараагийн хэсэгт авч үзье.

Судалгааны арга зүй болон өгөгдөл

Энэхүү өгүүллийн гол асуудал нь сонгуулийн мөчлөг төсвийн зарлагад хэрхэн нөлөөлж байна, уг нөлөө нь институцын орчноос хэрхэн хамаарч байгааг авч үзнэ. Үүний тул дараах асуултуудад хариулахыг зорилоо. Үүнд,

1. Сонгуулийн жилд төсвийн зарлага сонгуульгүй жилийнхээс өндөр байдаг уу?
2. Сонгуулийн үеийн төсвийн зарцуулалт нь эдийн засгийн тогтвортой байдалд ямар нөлөө үзүүлдэг вэ?

Сонгуулийн жилүүдэд төсвийн зарлага нэмэгддэг гэсэн таамаглалыг шалгахад хугацааны цувааны эконометрик загвар ашиглан тодорхойлон үзлээ. Ингэхдээ дараах загварыг ашиглав.

$$\ln(expend_t) = \beta_1 + \beta_2 \ln(rev_t) + \beta_3 \ln(expend_{t-1}) + \delta D_t + e_t$$

Энд β загварын параметр, δ дамми хувьсагчийг төлөөлсөн параметр, e_t алдааны илэрхийлэл. D_t дамми хувьсагч бөгөөд сонгуулийн жил бол 1, бусад жилүүдэд 0 гэсэн утга авна. Загварын үндсэн санаа нь тухайн жилийн төсвийн зарлага нь тухайн жилийн төсвийн орлого, өмнөх жилийн төсвийн зарлага, сонгуулийн жилийг илэрхийлсэн дамми хувьсагчаар тайлбарлагдаж байна. $expend_t$ төсвийн зарлага, rev_t төсвийн орлого болно.

Өмнөх жилийн төсвийн зарлага өндөр байсан тохиолдолд дараагийн жилд дагаад төсвийн зарлагыг нэмэгдүүлэх нөхцөл болдог бөгөөд бууруулах эсвэл өмнөх жилийн түвшинд барих боломж тааруу байдаг. Тиймээс өмнөх хугацааны төсвийн зарлагын өсөлт дараагийн хугацааны төсвийн зарлагын өсөлтөд нөлөөлнө гэж үзэж загварт тусгасан болно. Нөгөө талаар сонгуулийн жил гэдэг нь тоогоор илэрхийлэгдэх боломжгүй чанарын шинж чанартай үзүүлэлт тул сонгуулийн жилийн онцлогийг гаргаж харуулахад дамми хувьсагч ашиглах нь зүйтэй юм. Энэ утгаараа сонгуулийн жилүүдийг 1 гэж тэмдэглэж, бусад жилүүдийг 0 гэж тэмдэглэсэн болно.

Төсвийн орлого, зарлага нь хугацааны цуваагаар илэрхийлэгдэх тул хугацааны цувааны үндсэн шинжилгээ болох тоо мэдээний тогтвортой байдал, урт хугацааны хамаарлыг тодорхой коинтеграц хамаарлыг тодорхойлсны дараа загварыг үнэлж үр дүнг тайлбарлах болно.

Өгөгдлийн хувьд шилжилтийн эдийн засгийн уналт зогсож өсөлт ажиглагдаж эхэлсэн, мөн сонгуулийн жилтэй холбогдуулах үүднээс 1996 оноос 2025 он хүртэл 30 жилийг тооцоонд хамруулллаа. Өгөгдлийг Үндэсний Статистикийн хорооны 1212.mn сайтаас авч ашигласан болно.


Шинжилгээний үр дүн

Энэ хэсэгт “Сонгуультай жилд төсвийн зарлага сонгуульгүй жилийнхээс өндөр байдаг уу?” гэсэн асуултад загвар ашиглан үнэлгээ хийж хариулахыг зорьсон болно.

Эдийн засгийн бодлогыг тодорхойлоход Сангийн бодлого, Мөнгөний бодлого гэсэн хоёр үндсэн аргыг ашигладаг бөгөөд эдгээр бодлогууд харилцан уялдаатай байж эдийн засгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, цаашдын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөл байдал бүрддэг. Сангийн бодлогын үндэс нь төсөв юм. Төсвийг татварын болон татварын бус орлогоор бүрдүүлж, эргээд улс орны нийгэм эдийн засгийн шаардлагатай зардлыг санхүүжүүлэхэд ашигладаг.

Монгол улсын эдийн засаг 2000 он хүртэл хүндхэн нөхцөлд аж үйлдвэрийн уналт үргэлжилж, уул уурхайн салбарын идэвхжил сул байсан тул хөдөө аж ахуй болон гадаадын зээл, тусламж дээр тулгуурлаж байв. Харин 2000-аад оны эхэн үеэс уул уурхай, аж үйлдвэр, үйлчилгээний салбарт тулгуурласан эдийн засагт аажмаар шилжиж эхэлсэн бөгөөд эдийн засаг тогтвортой өсөх шатандаа орсон. Үүнтэй холбоотойгоор төсвийн орлого ч нэмэгдэж, дагаад төсвийн зарлагын өсөлт нэмэгдэж эхэлжээ.

Зураг 1. Монгол улсын төсвийн орлого, зарлага /их наяд төгрөг/



Эх сурвалж: 1212.mn

Сүүлийн жилүүдэд эдийн засаг огцом тэлж байгаатай холбоотой төсвийн орлого, зарлага аль аль нь огцом тэлж экспоненциаль хэлбэртэй болсон нь зургаас харагдаж байна. Ялангуяа 2000 оноос хойш эдийн засгийн өсөлт өндөр байсан нь төсөвт эерэг нөлөө үзүүлсэн байна.

Эдийн засаг өсөж сэргэхийн хэрээр төсөв ийнхүү тэлж байгаа нь тодорхой боловч төсөвт төвлөрүүлсэн орлогыг сонгуулиас шалтгаалан бусад жилүүдтэй харьцуулахад илүү зарцуулдаг талаар олон улсын судалгааны ажлуудад дурдсан байдаг. Эрх барьж буй нам сонгуулийн амлалтаа биелүүлэх, сонгогчдыг татахтай холбоотой нийгмийн зардлуудыг өсгөх зэрэг шалтгаанаар төсвийн зардал нэмэгддэг. Үүнээс улбаатайгаар

төсвийн алдагдал өсөх нь бий. Манай улсын хувьд энэ нөхцөл байдал 2012 оны сонгуулиас хойш илүү тодорхой ажиглагдаж байна. Төсвийн алдагдал 2012, 2016, 2020 онуудад өмнөх болон дараагийн жилийн төсвийн алдагдлаа 1.4-5 дахин нэмэгдсэн тохиолдол байна. Үүнийг үндсэнд нь төсвийн зарлагын тэлэлт бусад жилүүдтэй харьцуулахад өндөр байсан гэж дүгнэж болох юм.

Судалгааны арга зүйн хэсэгт авч үзсэний дагуу өгөгдлийг хувиар тайлбарлах боломжтой болох гетероскедастикийн асуудлаас зайлсхийхийн тулд төсвийн орлого, зарлага аль алинаас нь натурал логарифм утга авсан болно.

Хуурмаг регрессээс зайлсхийх, урт хугацааны хамаарал байгаа эсэхийг шинжлэх шаардлагын үүднээс тоо мэдээний тогтвортой байдал, коинтеграц хамаарлыг шалгах шаардлагатай.

Хугацааны цувааны хувьд тоо мэдээний тогтвортой байдлыг ADF шалгуурыг ашиглан тооцсон болно.

Хүснэгт 1. ADF шалгуурын үр дүн

	Level	**1st differences**
Ln expend	-2.9488	-4.4505***
Ln rev	-2.9552	-4.1673***

Тэмдэглэл: *** 1 хувийн түвшинд статистик ач холбогдолтой

Өгөгдлийн хувьд өгөгдсөн түвшиндөө тогтвортой бус эрэмбийн ялгавар авч тогтвортой болж байна.

Дээрх тооцоололд үндэслэн хоёр хувьсагчийн хооронд коинтеграц хамаарал байгаа эсэхийг Johansen cointegration test ашиглан шалгаж үзэхэд урт хугацааны хамааралтай гэж гарав.

Хүснэгт 2. Коинтеграц хамаарлын Trace statistic үр дүн

Hypothesized No. of CE(s)	**Eigenvalue**	**Trace Statistic**	**0.05 Critical Value**	**Prob.** Critical Value**
None *	0.331386	26.07786	15.49471	0.0009
At most 1 *	0.305420	12.39121	3.841465	0.0004

Trace test indicates 2 cointegrating equation(s) at the 0.05 level

Дээрх тооцоололд үндэслэн урт хугацааны хамаарал бүхий загварыг үнэлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрч байгаа тул арга зүйд авч үзсэний дагуу дараах загварыг үнэлэв.

$$\ln(expend_t) = \beta_1 + \beta_2 \ln(rev_t) + \beta_3 \ln(expend_{t-1}) + \delta D_t + e_t$$

Загварыг авч үзэхдээ 1996-2025 оны бүхий 30 жил, эдийн засаг хурдацтай өсөж, төсвийн тэлэлт өндөр байсан сүүлийн 14 жил болох 2012-2025 оноор тус тус салгаж үнэлэв.

Хүснэгт 3. Сонгуулийн жилийн төсвийн зарлагад үзүүлэх нөлөө

Хувьсагчид	**1996-2025**	**2012-2025**
C	0.3032*	0.2509
Ln rev	0.5354***	0.3822**
Ln expdent(-1)	0.4527***	0.6077***
D	0.0796*	0.1639***
R2	*0.99*	0.98
DW	*1.82*	2.08

Тэмдэглэл: * 10 хувийн түвшинд, ** 5 хувийн түвшинд, *** 1 хувийн түвшинд статистик ач холбогдолтой.

Загварын найдвартай байдлыг шалгах тулд Serial Correlation Lm Test-ийг хугацааны 1 болон 2 хоцрогдолтой шалгаж үзэхэд автокорреляц илрээгүй. Үүнийг мөн DW статистик утга 2-д ойр гарч байгаа нь батлан харуулж байна.

Нийт хугацаа буюу сүүлийн 30 жилийн тоон өгөгдлийн үнэлгээний үр дүнгээс харвал төсвийн орлого 1 хувиар өсөхөд төсвийн зарлага дунджаар 0.53 хувиар, өмнөх хугацааны төсвийн зарлага 1 хувиар нэмэгдэхэд дараагийн хугацааны төсвийн зарлага дунджаар 0.45 хувиар, сонгуулийн жил бол төсвийн зарлага сонгуульгүй жилтэй харьцуулахад дунджаар 0.079 орчим хувиар илүү байдаг байна. Загварын коэффициентууд бүгд 1 болон 10 хувийн түвшинд статистик ач холбогдолтой буюу загварт нөлөөтэй гарчээ.

Харин сүүлийн 14 жилийн хугацааны үнэлгээний үр дүнгээс харвал төсвийн зарлагын өмнөх хугацааны өсөлтийн дараагийн хугацаанд үзүүлэх нөлөө нэмэгдсэн бол орлогын өсөлтийн төсвийн зарлагын өсөлтөд үзүүлэх нөлөө нийт хугацаатай харьцуулахад бага байгаа нь харагдаж байна. Гэтэл сонгуулийн жилүүдэд төсвийн зарлагыг тэлж байгаа байдал нийт хугацаанд 0.079 байсантай харьцуулахад 0.164 болж 0.085 нэгжээр өндөр гарсан байна.

Өөрөөр хэлбэл сүүлийн жилүүдэд сонгууль болоход төсвийн зарлагыг нэмэгдүүлдэг байдал илүү их болж байна.

ДҮГНЭЛТ

Ийнхүү Монголын нөхцөл байдлыг шинжлэн үзэхэд сонгуулийн өмнөх хугацаанд төсвийн зардлыг нэмэгдүүлэх, богино хугацаанд сонгогчдын дэмжлэг авахад чиглэсэн зардлыг тэлэх явдал түгээмэл байна гэдэг нь батлагдлаа. Энэ нь төсвийн сахилга бат алдагдах, улсын өр нэмэгдэх, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулдаг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн жинхэнэ тогтвортой байдал нь богино хугацааны популист шийдвэрээс биш, харин тогтвортой, хариуцлагатай төсвийн бодлогоос хамаардаг. Богино хугацааны популист шийдвэр буюу сонгуулийн жилүүдэд төсвийн зардал нэмэгдэх нь урт хугацаандаа дараах сөрөг үр дагаврыг авчирдаг. Үүнд,

- Төсвийн алдагдал өсөж, эдийн засагт савлагаа үүснэ.
- Эдийн засгийн тогтвортой байдлыг сааруулна.
- Төсвийн бодлогод улс төрийн оролцоо нэмэгдсэнээр институцын чадавхыг сулруулдаг.

Иймд цаашид бодлого боловсруулагчид, эрх баригчид урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хангахын тулд улс төржсөн шийдвэр гаргахгүй байх, сонгогчид ч гэсэн өнөө маргаашийн түр зуурын хүчин зүйлд хууртагдалгүйгээр рациональ байдлаар сонголтоо хийж, энэхүү онолын нөлөөг бууруулах нь зүйтэй юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Alesina, A., Roubini, N., & Cohen, G. (1997). *Political Cycles and the Macroeconomy*. MIT Press.

Brender, A., & Drazen, A. (2005). Political budget cycles in new versus established democracies. *Journal of Monetary Economics*, 52(7), 1271-1295.

Nordhaus, W. D. (1975). The political business cycle. *The Review of Economic Studies*, 42(2), 169-190.

Rogoff, K., & Sibert, A. (2000). Elections and macroeconomic policy cycles. *The Review of Economic Studies*, 55(1), 1-16.

Schuknecht, L. (1996). Political business cycles and fiscal policies in developing countries. *Kyklos*, 49(2), 155-170.

Б.Чимид. (2025). Сонгуульд суралцахуй. Улаанбаатар.

Л.Эсмэдэх нар. Шинэ улс төрийн макроэкономикс. Эдийн засаг: онол, практик, 82-р тал.

IDENTIFYING THE RELATIONSHIP BETWEEN ELECTIONS AND BUDGET EXPENDITURE

***Abstract**:* In democratic systems, politicians are continuously motivated to secure public approval and electoral success, with prevailing economic conditions serving as a primary determinant of electoral outcomes. To enhance their prospects of reelection, incumbents frequently adopt expansionary fiscal policies-increasing wages, pensions, and social welfare transfers-thereby inflating public expenditures during election years. While such measures may generate short-term economic stimulus and yield measurable improvements in citizen welfare, they pose considerable risks to long-term macroeconomic stability, particularly when expenditure growth is driven by political incentives rather than productivity-enhancing investment. Drawing on the theoretical framework of the Political Budget Cycle (PBC), this study empirically examines the relationship between parliamentary election years and government expenditure in Mongolia over the period 1996-2025. Using a time-series econometric model with a binary electoral dummy variable, the findings confirm a statistically significant increase in budget expenditure during election years compared to non-election years-an effect that has intensified in the more recent sub-period of 2012-2025. These results suggest that fiscal discipline is vulnerable to electoral pressures in the Mongolian context, with implications for institutional reform and the design of credible budgetary constraints.

Keywords: elections, political budget cycle, state budget, budget expenditure, democracy, political economy, Mongolia

ПОЛИТОЛОГИ XXIV

Эрдэм шинжилгээний бичиг №24: 210-221 дэх тал

МОНГОЛ ХЯТАД ХОЁР УЛСЫН ИЖ БҮРЭН СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦАА БА ЦААШИД ХӨГЖҮҮЛЭХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ САНАЛ

А.Батцэцэг
МУИС, УТСОУХНУС,
Олон улсын харилцааны тэнхимийн Ахлах багш, Доктор

Д.Бадамдаш
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн багш

Хураангуй:

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа нь хоёр улсын улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чухал суурь болж байна. 2014 онд хоёр улсын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүргэснээс хойш харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа олон салбарт өргөжин хөгжиж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид тодорхой хувь нэмэр оруулж байна. Энэхүү өгүүлэлд Монгол, Хятадын харилцааны эрхзүйн болон институцийн хөгжлийг тоймлон авч үзэж, хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд хэрэгжиж буй хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдийг шинжилжээ. Мөн Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын гурван талт хамтын ажиллагааны боломж, бүс нутгийн интеграцийн ач холбогдлыг авч үзэн, цаашид хөгжүүлэх боломжит чиглэлүүдийг тодорхойлсон болно. Ялангуяа дижитал эдийн засаг, ногоон хөгжил, бүс нутгийн логистик, онцгой байдлын үеийн хамтын ажиллагаа зэрэг салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг судалгааны үр дүнд онцлон дэвшүүлэв. Энэхүү судалгаа нь Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бодлогын түвшинд ашиглах боломжтой санал дэвшүүлснээрээ ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: Монгол Хятадын харилцаа, иж бүрэн стратегийн түнш, олон талт хамтын ажиллагаа, гадаад бодлого, хамтын ажиллагаа

Удиртгал:

Монгол, Хятад хоёр улс нь геополитикийн хувьд стратегийн чухал түншүүд юм. Бидний харилцаа нь түүхэн уламжлал, эдийн засаг, соёл, хүмүүнлигийн хамтын ажиллагаа зэрэг нь хоёр орны улс төрийн дэмжлэг дээр тулгуурласан иж бүрэн стратегийн түншлэлд үндэслэгдсэн юм. Манай хоёр орон 1949 онд дипломат харилцаа тогтоосноос хойш үе шаттайгаар гүнзгийрч, 2014 онд "Иж бүрэн стратегийн түншлэл"-ийн түвшинд хүрсэн. Энэ нь хоёр орны улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбар зэрэг бүх салбарт хамтын ажиллагаагаа бүх талаар өргөжүүлэхэд чиглэж буй харилцааны хамгийн дээд хэлбэр юм.

Улс төрийн түвшинд хоёр улс тусгаар тогтнол, харилцан дэмжлэг, аюулгүй байдлын хамтын ажиллагааг дэмжиж, олон улсын тавцанд бие биенээ дэмжсээр байгаа бөгөөд манай 2 улсын харилцан итгэлцэл, үнэт зүйлсийн нийцэл нь Монгол улсын гадаад бодлогод чухал үүрэг гүйцэтгэсээр байна..

Монгол, Хятад хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа нь өргөн цар хүрээтэй, олон талт хамтын ажиллагаа бүхий бодит үр дүнд хүрсэн бөгөөд энэхүү хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхийн тулд улс төр, дипломат бодлого, боловсролын хамтын ажиллагаанаас гадна эдийн засаг, худалдаа, технологи, дижитал эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр эдийн засгийн өсөлт, соёлын солилцоо, улс төрийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой тул энэ чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах нь зүйтэй хэмээн байр сууриа илэрхийллээ.

Монгол Улс, БНХАУ-ын *н*айрсаг харилцаа, хамтын ажиллагааны эрхзүйн шинэ үндэслэл *бий болсон нь:*

ОХУ, БНХАУ тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон 2003 оны зургаадугаар ОХУ-тай ***«Сайн хөршийн уламжлалт түншлэл»,*** 2006 оны арванхоёрдугаар сард ***«Стратегийн түншлэл»,*** 2009 оны наймдугаар сард ***«Стратегийн түншлэл хөгжүүлэх»,*** 2019 оны есдүгээр сард ***«Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэл»-***ийн гэрээг хугацаагүй байгуулав.

БНХАУ-ын дарга Ху Жиньтаогийн албан ёсны айлчлалын үеэр 2003 оны зургаадугаар сард БНХАУ-тай ***«Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл»,***

[1] Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр 2011 оны зургаадугаар сард Бээжинд ***«Стратегийн түншлэл»,*** [2] БНХАУ-ын дарга Ши Жиньпинийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр 2014 оны наймдугаар ***«Иж бүрэн стратегийн түншлэл»***,[3] 2022 оны арваннэгдүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн төрийн айлчлалаар ***«Иж бүрэн стратегийн түншлэлийг Шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх»*** [4] харилцааны эрхзүйн шинэ үндсийг тавьсан.

Харин 2013 оны аравдугаар сарын 25-нд Бээжинд хоёр улсын Ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан ***«Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны хөтөлбөр»*** нь хамтын ажиллагаагаа тодорхой салбаруудаар хэрэгжүүлэх ***Замын зураглал*** болов.

2011 оны хоёрдугаар сард шинэчлэн батлагдсан "Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал"-д «ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ» гэж заасан нь 1994 оны Гадаад бодлогын заалтыг дахин нотолсон хэрэг юм. Харин "Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах" [5] гэсэн 1994 оны үзэл баримтлалы заалтыг хэвээр үлдээсэн нь тэнцвэртэй харилцах бодлоготой зөрчилдөж болохуйц санаа гэж ойлгогдож байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Хоёр хөрш гүрэнтэйгээ тэнцвэртэй харьцах бодлогын түүхэн уг сурвалж нь хүйтэн дайны үед Зөвлөлт, Хятадын харилцаа ноцтой хурцадаж байсан

[1] Монгол, Хятадын Хамтарсан Мэдэгдэл. УБ., 2003.06.05
[2] Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан Мэдэгдэл. Бээжин, 2011.06.16
[3] Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай Хамтарсан Мэдэгдэл. УБ., 2014.08.21
[4] Иж бүрэн Стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан Мэдэгдэл. Бээжин, 2022.28
[5] Мөн тэнд

үед Монгол Улс ЗХУ-д талд баттай зогссоноор Монгол, Хятадын харилцаа онцгой муудсан явдал юм.

2014 оны наймдугаар сард Монгол, Хятадын төрийн тэргүүн нар Улаанбаатар хотод хоёр орны харилцааг ***Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүрсэн хэмээн дүгнэж,*** уг харилцааг хөгжүүлэх Тунхаглалд гарын үсэг зурсан нь чухал ач холбогдолтой үйл явдал болов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпиний урилгаар 2022 оны арванэгдүгээр сард БНХАУ-д төрийн айлчлал хийсэн бөгөөд айлчлалын үр дүнгээр хоёр тал 2025 оны арванэгдүгээр сарын 28-нд ***“Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг Шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай*** **Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан Мэдэгдлийн гарг**сан онцгой чухал үйл явдал болсон юм.[6]

Талууд 1994 оны “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, 2014 оны “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай хамтарсан тунхаглал”-ын үзэл санааны дагуу Монгол, Хятадын харилцааны ололт амжилт, цар тахалтай тэмцэх хамтын ажиллагааг өндрөөр үнэлж, Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг тасралтгүй гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь хоёр орны ард түмний ашиг сонирхолд нийцэж буйд санал нэгдсэн явдал байлаа.

Монгол, Хятадын улс төрийн сайн харилцааг үргэлжлүүлэн хамтын ажиллагааны хөдөлгөгч хүч болгож, хоёр улсын газар зүйн байршил, эдийн засгийн харилцан нөхөх давуу талаа ашиглаж, хоёр улсын ард түмний сайн сайхны төлөө харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохирч цар тахлын дараах эдийн засгийг түргэн сэргээхэд анхаарч, “Талын зам” үндэсний хөтөлбөрийг “Бүс ба Зам” санаачилгатай, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг “Даян дэлхийн хөгжлийн санаачилга”-тай, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг “Хоёр алхам” хөгжлийн стратегийн зорилттой тус тус уялдуулан хэрэгжүүлж, худалдаа, хөрөнгө оруулалт, санхүү, эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтэц, цахим эдийн засаг, ногоон хөгжил зэрэг салбарын хамтын ажиллагааг улам өргөжүүлэхээр тохиролцсон байдаг.

[6] Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг Шинэ эринд урагшлуулан хөгжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан Мэдэгдэл. Бээжин., 2022.11.28

Монгол, Хятадын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комисс, Монгол Хятадын эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны зөвлөл зэрэг хамтын ажиллагааны механизмыг илүү үр дүнтэй ашиглах, шинэчлэн байгуулж буй "Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх Дунд хугацааны Хөтөлбөр" болон "Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хөгжлийн хөтөлбөр"-ийг идэвхтэй хэрэгжүүлэх, ***ойрын хугацаанд хоёр талын худалдааны нийт хэмжээг 20 тэрбум ам.долларт хүргэх,*** хоёр улсын аж ахуйн нэгжүүд зах зээлийн зарчмын дагуу нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэх, нүүрсний дунд, урт хугацааны худалдааны гэрээ байгуулахыг дэмжих, Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн бүтээн байгуулалтыг урагшлуулахаар тохиролцсоныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурвалсан хамтын ажиллагааны шинэ форматын шинжилгээ:

Дэлхийн II дайны дараа хоёр хөрштэй тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн төлөвийг нээсэн чухал үйл явдлын нэг нь гурван хөршийн хамтын ажиллагааны эхлэл тавигдсан явдал юм. Энэ нь ЗХУ, БНХАУ-ыг БНМАУ-ын нутгаар холбосон төмөр зам тавьж, ашиглалтад оруулахтай холбогдсон хэлэлцээр байгуулахаар гурван улсын удирдагчид 1952 оны есдүгээр сарын 15-нд Москва хотод дээд хэмжээнд уулзсан явдал байв. Дурьдсан хэлэлцээрт БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Эньлай, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга бөгөөд ГЯЯ-ны сайд А.Я.Вышинский нар гарын үсэг зурж, И.В.Сталин тэргүүтэй Зөвлөлтийн удирдагчид байлцжээ.[7] Энэ бол гурван хөршийн анхны уулзалт байв. Тухайн хэлэлцээрээр Улаанбаатар-Замын-Үүд-Жинчиний хооронд төмөр зам барихаар тохиролцож, бүтээн байгуулалтын ажил амжилттай өрнөж эхэлсэн явдал байлаа. 1955 оны арванхоёрдугаар сарын 31-нд Улаанбаатар Замын-Үүдийн төмөр замыг нээх ёслолын үйл ажиллагаа Улаанбаатарт болж, 1956 оны нэгдүгээр сарын 1-нээс ЗСБНХУ, БНМАУ, БНХАУ-ын

[7] Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. *XX зууны сүүлийн хагаст*. Дэд боть. УБ., 2020, 125 дахь тал

хооронд төмөр замын шууд харилцаа нээсэн тухай дэлхийн улс орнуудад зарлан тунхагласан байдаг.

Олон талт хамтын ажиллагааны үүднээс авч үзэхэд Монгол Улсын хойд хөрш дэлхийн хамгийн том газар нутагтай, цөмийн зэвсэгтэй сэргэн мандаж буй гүрэн бол, урд хөрш дэлхийн хамгийн олон хүн амтай, цөмийн зэвсэгтэй, эрчимтэй урагшилж буй эдийн засагтай хамгийн том хөгжиж буй орон, мөн хоёул өөрсдийн бие даасан бодлого, байр суурьтай их гүрнүүд юм. Монгол Улс ийм өвөрмөц геополитикийн байршилтай цорын ганц орон гэж хэлж болно.

2011 оны хоёрдугаар сард шинэчлэн батлагдсан "Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал"-ийн 14.1-т: *«ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ»* гэж заасан нь 1994 оны заалтыг дахин нотолсон хэрэг юм. Харин *«*Ингэхдээ *энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана»* [8] гэсэн өмнөх баримтлалын заалтыг хэвээр үлдээсэн нь тэнцвэртэй харилцах бодлоготой зөрчилдөж болохуйц санаа гэж ойлгогдож байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Тэнцвэртэй харьцах гэдгийг юу гэж ойлгож байна вэ? Энэ бол улс төрийн чиг шугам юм. Тодруулбал хойд хөрштэйгээ бүх салбарт ойртон нягтарч, өмнөд хөршийнхээ эсрэг бодлого, байр суурь баримталж байсан хуучин бодлогоо үндсээр нь өөрчилж, улс төрийн хувьд аль нэг хөршөө дагаж давхихгүй, тэнцвэртэй харьцах тухай л асуудал юм. Эдүгээ дэлхийн бараг бүх орон худалдаа-эдийн засгийн хувьд Хятадаас хамааралтай болсон. АНУ-ын гадаад худалдаанд гэхэд л Хятад маш өндөр хувь эзэлдэг. Даяаршлын эрин үед улс орнууд эдийн засгийн талаар тэнцвэртэй харьцах боломж хязгаарлагдмал. Дахин тэмдэглэхэд тэнцвэртэй харьцах гэдэг нь улс төрийн хувьд тэнвэртэй харьцах гэсэн үг юм.

Монгол Улсын Дипломат албаны хууль, Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгалах тухай заалтыг шийдвэр гаргах бүх түвшинд тууштай баримтлах явдал нэн чухал. Хоёр хөрштэй харилцах гадаад бодлогын

[8] Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном: 2007-2011, ГХЯ, УБ., 2011, 114 дэх тал

тэргүүлэх чиг шугамыг умартах, уламжлалт түнш, найрсаг харилцааны түвшинг үгүйсгэх, хоёр хөршийн харилцааны тухайд үл ойшоосон болчимгүй байр суурь баримтлах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд таатай нөлөө үзүүлэхгүй.

Монгол Улс гурвалсан яриа хэлэлцээний байнгын институцитэй болох чиглэлд анхны алхам хийсэн нь хөрш хоёр гүрний бодлого, байр суурийг илүү тодорхой ойлгож мэдэх, өөрийн улсын бодлого, байр суурийг илүү ойлгомжтой тайлбарлаж, дэмжлэг авахад нэн ач холбогдолтой байв. Хөрш гурван улсын ГХЯ-д хоорондын 8 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт Улс төрийн газрын захирал нарын түвшинд 2012 оны аравдугаар сард Москва хотноо болов. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад хэргийн яамны гурван талт зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирал Т.Төгсбилгүүн, ОХУ-ын Гадаад хэргийн яамны Азийн Нэгдүгээр газрын захирал А.Б.Кулик, БНХАУ-ын Гадаад хэргийн яамны Азийн газрын захирал Луо Жаохуй нар төлөөлөгчдөө тэргүүлэн оролцсон бөгөөд ОХУ-ын Гадаад хэргийн дэд сайд И.В. Моргулов төлөөлөгчдийн тэргүүн нарыг хүлээн авч уулзаж, талуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, ойрын төлөв, уулзалтын үр дүнгийн талаар санал солилцож байжээ.

Анх удаагаа албан ёсны статустайгаар болсон гурван талын зөвлөлдөх уулзалт цаг хугацааны сорилтыг амжилттай давж, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны харилцан сонирхсон асуудлыг хэлэлцэх зохистой талбар болсон хэмээн талууд санал нэгтэй үзсэн юм. Монгол, Орос, Хятадын хооронд улс төрийн болон түүхийн аливаа шийдэгдээгүй асуудал байхгүйг талууд цохон дурдахын сацуу бие биенийхээ тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх үндсэн дээр бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх нь зүйд нийцнэ хэмээн үзэж байна. Талууд гурван талт хамтын ажиллагааны хөгжлийг наашгайгаар үнэлж, Монгол, Орос, Хятадын харилцан ажиллагааны тэргүүлэх чиглэл, түүнчлэн бүс нутгийн болон олон улсын асуудлаар санал бодлоо нухацтай солилцсон байна. Эдгээр түүхэн үйл явдал нь мэдээж манай улсын олон талт хамтын ажиллагааны хамгийн чухал үндэс суурь болж байна хэмээн тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Гурван талын зөвлөлдөх уулзалт уул уурхайн салбар, дамжин өнгөрөх тээврийн гурван улсын нөөцийг хамтран ашиглах, дэд бүтцийн бүтээн байгуулалт, аялал жуулчлал, байгаль орчин, хүмүүнлэгийн солилцоо зэргийг талуудын харилцан сонирхолд нийцсэн хамтын ажиллагааны

тэргүүлэх чиглэл хэмээн тэмдэглээд үүн дээр хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан дипломат ажиллагаа, хямралын менежментийн асуудлыг нэмж оруулах нь зүйтэй хэмээн судлаачид тэмдэглэж байв.[9]

Цаашдаа эхний үе шатанд гурван улсын гадаад харилцааны сайд нарын уулзалтыг зохион байгуулж, үүний дараах үе шатанд ойрын ирээдүйд гурван хөршийн уулзалт зохион байгуулах гэсэн парадигмыг санаачлан хэрэгжүүлэх асуудал байсан юм. Өөрөөр хэлбэл АСЕАН+3 шиг дээд уулзалтыг зохион байгуулж, хамтын ажиллагааны байнгын механизм буй болгох чиглэлээр ажиллаж болох санал байв. Мэдээж энэ бүгд идэвхтэй дипломат ажиллагаа, хүчин чармайлт, цаг хугацаа шаардаж байсан нь ойлгомжтой.

Дээд хэмжээнд уулзалт зохион байгуулах анхны эрхзүйн үндэслэл 2013 оны аравдугаар сарын 25-нд Бээжин хотноо байгуулсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны хөтөлбөр»-ийн тавын 5-д: «Талууд Монгол Хятад, Оросын гурван талын зөвлөлдөх уулзалтын механизмыг үргэлжлүүлэн бэхжүүлэх, дэд сайдын түвшний зөвлөлдөх уулзалтын механизмыг байгуулах асуудлыг урагшлуулахаар санал нэгтэй тохиролцов. Шаардлагатай тохиолдолд гурван талын өндөр түвшний уулзалт зохион байгуулж, Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагааг улам бүр урагшлуулна» гэж тусгагдсан нь чухал ач холбогдолтой байв. Цаашлаад 2014 оны наймдугаар сарын 22-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан ***«Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан Тунхаглал»*-ын** дөрөвт: **"**Талууд Монголын талын санаачилсан Монгол, Хятад, Орос гурван улсын удирдагчдын уулзалтыг зохион байгуулах, гурван талын яриа хэлэлцээний механизмыг бэхжүүлэх, гурван талын хамтын ажиллагааг эрчимжүүлэхийг дэмжинэ" гэсэн байна.

Иж бүрэн, стратегийн түншлэлийг улам гүнзгийрүүлэх, бэхжүүлэх хамтын ажиллагааны зарим санал:

БНХАУ-аас хэрэгжүүлж том дэлхийн хэмжээний томоохон төслүүдийн хүрээнд идэвхтэй оролцож, харилцан ашигтай хамтын

[9] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.
(эрхэлсэн проф. Д.Уламбаяр) УБ., 2014

ажиллагааг хөгжүүлэх боломжийг хянан үзэж, дараах илэрхий боломжийг бодит ажил хэрэг болгох нь оновчтой гэж үзэж байгаа юм. Үүнд:

1.Мэдээллийн технологи, дата засаглалд:

Хятадын дижитал шилжилтийн туршлага нь Монголын төрийн үйлчилгээ, цахим засаглалыг хөгжүүлэхэд чухал хөшүүрэг болж чадна.[10] Мөн Монголын сэрүүн уур амьсгал болон сэргээгдэх эрчим хүч (салхи, нар)-ний нөөцөд тулгуурлан, өгөгдлийн төвүүд байгуулах нь ач холбогдолтой юм. БНХАУ-ын хувьд Өвөр Монголын нутагт өгөгдлийн төвүүдийг нэлээд олноор байгуулаад байгаа юм. Энэ нь Монгол улсын хувьд ажлын байр, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, мэдээллийн технологийн хүний нөөц, ур чадварыг сайжруулах ач холбогдолтой. Цаашдаа Монгол улсын хувьд БНХАУ, ОХУ төдийгүй Төв Ази, Зүүн Хойд Азийг холбосон мэдээлэл, өгөгдлийн зангилаа, өгөгдөл боловсруулах бааз болох боломжийг бий болгоно.

Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол, авто замын түгжрэлийг бууруулахад хүн ихээр төвлөрсөн Хятадын хотуудын туршлага, менежментээс суралцах, цахим шилжилтийн загвараас тохируулан хэрэглэх боломжтой.

2.Ногоон хөгжил ба уур амьсгалын бодлогын хүрээнд:

Монголын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаанд Хятадын ногоон технологи, хөрөнгө оруулалтыг татах боломж бий. БНХАУ нь цөлжилтийн эсрэг тэмцэх, ойжуулалт, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлээр дэлхийд нэгдүгээрт орж байгаа билээ. Энэ туршлагыг авч хэрэгжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд мод тарих, ургуулах, ойжуулалтын туршлага, технологиос суралцах, хамтран ажиллах нь чухал ач холбогдолтой.

3.Бүс нутгийн интеграци ба логистик:

Монгол Улс Зүүн хойд Ази ба Төв Азийн тээврийн сүлжээний гүүр болж чадвал бүс нутгийн худалдаанд дэмжлэг үзүүлэх томоохон үүрэг гүйцэтгэнэ. Зөвхөн тээвэр, сүлжээнээс гадна Төв Ази болон Зүүн хойд азийг холбоход Монгол улс холбогч гүүр болох бүрэн боломжтой юм. Учир нь үндэсний түүх, онцлогийн хувьд нэг талаас Төв Азийн орнуудай төсөөтэй нөхцөл байдалтай бөгөөд ЗХУ-ын харьяанд байсан болон дагуул орнуудын өнгөрсөн жилүүдийн замнал ойролцоо бөгөөд бүгд зах зээлийн эдийн засгийг хөгжүүлж, уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн бүтэцтэй байсан. Иймд БНХАУ-ын Бүс ба Зас санаачилгын хүрээнд зөвхөн БНХАУ-

[10] World Bank, 2022. “Digital Development in East Asia.

Монгол-ОХУ-ын эдийн засгийн коридороос гадна, Төв Азийн 5 улс болон Зүүн хойд Азийг холбосон коридорын санаачилгыг ч хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

4. Онцгой байдлын үеийн хамтын ажиллагаа, харилцан туслалцаа

Монгол Хятад хоёр улс болон бүс нутгийн орнуудыг хамарсан Онцгой байдлын үед шуурхай мэдээлэл солилцох, хамтран ажиллах, эрэн хайх, аврах ажиллагаа явуулах зэрэг хамтын ажиллагааны механизм, яриа хэлэлцээг хөгжүүлэх нь чухал юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улс болон БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа нь хоёр улсын улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт харилцан ашигтай, урт хугацааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чухал үндэс болж байна. Энэхүү түншлэл нь бүс нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийн уялдаа холбоог бэхжүүлэхэд чухал үүрэгтэй. Цаашид талууд итгэлцэл, харилцан хүндлэлийн зарчмыг баримтлан, ногоон хөгжил, дэд бүтэц, хил орчмын хамтын ажиллагаа зэрэг шинэ чиглэлүүдийг өргөжүүлэх нь зүйтэй.

Монгол, Хятад хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэл нь олон салбар, олон түвшинг хамарсан хамтын ажиллагааны нэг бодит илрэл болж байгаа бөгөөд энэ нь зөвхөн эдийн засаг бус улс төр, соёл, технологийн салбарын хамтын ажиллагаанд тулгуурласан өргөн цар хүрээтэй, манай хоёр орны тогтвортой хөгжлийн үндэс суурь болж байна.

Энэ хүрээнд тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх хөгжүүлэх, иж бүрэн стратегийн түншлэлийг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн дэлхийн улс төр эдийн засгийн хүчирхэг гүрэн АНУ-ын дэргэд Канад харилцан ашигтай түншлэл хөгжүүлэх замаар хөгжиж ирсэн шиг Монгол улс ч мөн БНХАУ-ын үсрэнгүй хөгжлийн үр шимээс хүртэх, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх олон боломжууд нээгдэж байна хэмээн үзэж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Д.Уламбаяр. Монгол улсын “Гуравдагч хөршийн-ийн бодлого, хоёр ба олон талт хамтын ажиллагаа”. УБ хот, （2022）

2. Д.Уламбаяр. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.УБ хот, (2014)

3. Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном: 2007-2011, ГХЯ, УБ., 2011, 114 дэх тал

4. Монгол, Хятадын Хамтарсан Мэдэгдэл. УБ., 2003.06.05

5. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан Мэдэгдэл. Бээжин, 2011.06.16

6. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай Хамтарсан Мэдэгдэл. УБ., 2014.08.21

6. Иж бүрэн Стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан Мэдэгдэл. Бээжин, 2022.28

7. Guidelines for Constructing Consumption Aggregates for Welfare Analysis

8. Jargalsaikhan, M., et al. Mongolian Geopolitics. 2022, by Friedrich-Ebert-Stiftung Mongolia & 10. Mongolian Institute for Innovative Policies.

9. World Bank, 2022. “Digital Development in East Asia.

10. UNDP. (2003). Millennium Development Goals Report’. Retrieved from Ulaanbaatar:

11. UNDP. (2004). Mongolian National Human Development Report for 2003. Retrieved from Ulaanbaatar:

12. UNDP, & NSO. (2009). Methodology for calculating Mongolia's Millennium Development Goals Indicators. Retrieved from Ulaanbaatar:

13. Wu, F., Zhang, F., & Webster, C. (2013). Informality and the development and demolition of urban villages in the Chinese peri-urban area. Urban Studies, 50(10), 1919-1934.

14. Xue, J., & Zhong, W. (2003). Unemployment, poverty and income disparity in urban China. Asian Economic Journal, 17(4), 383-405.

17.Yang, D. T. (1999). Urban-biased policies and rising income inequality in China. American Economic Review, 89(2), 306-310.

18. A.Battsetseg . (2019) Poverty reduction and social transation. Dissertation

THE COMPREHENSIVE STRATEGIC PARTNERSHIP BETWEEN MONGOLIA AND CHINA: SOME PROPOSALS FOR ADVANCING MULTILATERAL COOPERATION

Abstract: The Comprehensive Strategic Partnership between Mongolia and the People's Republic of China has become an important foundation for expanding political, economic, cultural, and humanitarian cooperation between the two countries. Since the establishment of the Comprehensive Strategic Partnership in 2014, bilateral relations have deepened significantly, strengthening mutual trust and contributing to regional economic integration. This article examines the legal and institutional foundations of Mongolia–China relations and analyzes the key areas of cooperation within the framework of their comprehensive strategic partnership. In addition, the study explores the prospects of trilateral cooperation among Mongolia, China, and Russia, highlighting its significance for regional connectivity and integration. The paper also proposes several potential areas for further cooperation, particularly in digital economy development, green transition, regional logistics and infrastructure connectivity, and emergency response cooperation. The findings suggest that strengthening these areas could contribute to sustainable economic development and regional cooperation in Northeast and Central Asia. This study provides policy-oriented recommendations for further deepening the comprehensive strategic partnership between Mongolia and China.

Key words: Mongolia–China relations, comprehensive strategic partnership, foreign policy, regional cooperation, economic integration

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 222-239 дахь тал

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Б.Эрдэнэдалай
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Д.Уртнасан
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн Ахлах багш, доктор

С.Мөнхбат
МУИС, УТСОУХНУС-ийн захирал, профессор

Хураангуй:

Энэхүү өгүүлэл нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг уул уурхайн салбарын төвлөрөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц, нийлүүлэлтийн хараат байдалтай уялдуулан шинжилсэн болно. Судалгааг 2024 оны 5-10 дугаар сарын хооронд үндэсний хэмжээнд 1135 түүврээс авсан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд иргэдийн 51.2 хувь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг, 45.9 хувь эдийн засгийн бие даасан байдлыг үндэсний аюулгүй байдлын тэргүүлэх чиглэл гэж үнэлсэн байна. Үүний зэрэгцээ 2010-2023 онд Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73.4 хувь нь уул уурхайн салбарт төвлөрсөн, 2023 оны байдлаар тус салбар ДНБ-ний 28.7 хувийг бүрдүүлж байгаа нь эдийн засгийн бүтэц өндөр төвлөрөлтэй байгааг харуулж байна. Шатахуун болон эрчим хүчний нийлүүлэлтийн хязгаарлалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх иргэдийн үнэлгээ нь нийлүүлэгч улс орны шийдвэр, төрийн бодлого, дэлхийн зах зээлийн нөлөөг чухалчилсан бөгөөд энэ нь эдийн засгийн хараат байдал үндэсний аюулгүй байдлын ойлголттой нягт уялдаж байгааг илтгэнэ.

Судалгааны үр дүн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулахад уул уурхайн салбарын хэт төвлөрлийг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтын салбар болон улсын эх үүсвэрийн олон талт байдлыг нэмэгдүүлэх, стратегийн салбар дахь нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулах бодлого чухал болохыг харуулж байна.

Түлхүүр үгс: Үндэсний аюулгүй байдал, олон нийтийн санаа бодол, эдийн засгийн аюулгүй байдал, уул уурхайн төвлөрөл, гадаадын шууд хөрөнгө оруулалт

Удиртгал:

“Стандарт тодорхойлолтын дагуу аюулгүй байдалд ихэвчлэн улс төр, нутаг дэвсгэр, хууль эрх зүй, нийгэм, хууль, хүчний байгууллагууд түүний янз бүрийн хэлбэрүүд (талбарууд) болох улс төрийн, цэргийн, олон нийтийн, дотоодын, соёлын, мэдээллийн, кибер аюулгүй байдлын зэрэг ойлголтууд багтдаг. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдал гэдэг нь төрийн бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, төрийн дотоод болон үндсэн хуулийн дэг журам зэрэг үнэт зүйлсээ зөрчих, алдахаас хамгаалах явдал юм.” (Waldemar, 2021, хууд. 5)

Харин ардчиллын гурав дахь давлагааны дараа олон улсууд ардчилсан тогтолцоонд шилжсэнээр улс орнуудад төрийн аюулгүй байдлын чиглэлээрх үйл ажиллагааны хүрээ нь бие хүн, нийгмийн янз бүрийн бүлгүүдэд чухал ач холбогдолтой үнэт зүйлсийг хамгаалахад анхаарал хандуулж эхэлсэн. Ийнхүү аюулгүй байдлын судалгааны хамрах хүрээ өргөжсөнөөр олон нийтийн аюулгүй байдлын талаарх хандлага, тулгарч байгаа бэрхшээлийн талаарх байр суурь зэргийг тодруулж аюулгүй байдлын бодлого, шийдвэрт тусгах хэрэгцээ, шаардлага бий болсон.

Ардчилсан бус дэглэмүүдээс үүдэн гарч буй үндэсний аюулгүй байдлын хамгийн хурц бөгөөд тогтвортой сорилттой тулгарсан ардчилсан орнуудын үндэсний аюулгүй байдлын талаарх олон нийтийн санаа бодлыг судлах нь чухал байдаг. (Cheng & Lee, 2017) Учир нь авторитар хөршүүдийн нөлөөлөл зөвхөн дэглэмийн төрлөөр илэрдэггүй газарзүйн байршил, эрчим хүчний нөөц зэрэг нийгэм, эдийн засгийн нөхцөлд маш их нөлөөтэй. Иймд Монгол Улсын тохиолдолд дэглэмийн (улс төрийн засаглалын хэлбэр) аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал гэсэн хоёр чиглэлд аюулгүй байдлын асуудал давхцаж байгаа нь илүү онцлогтой.

2001 онд батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын тухай” (Үндэсний аюулгүй байдлын тухай, 2001) хуулийн 3.4 дэх заалтад Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгийг Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал; нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал; иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал; эдийн засгийн аюулгүй байдал; шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал; мэдээллийн аюулгүй байдал; монгол соёл иргэншлийн аюулгүй байдал; хүн ам, удмын сангийн аюулгүй байдал; экологийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал гэж заасан. Тиймд өнөөгийн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг хөрш орнуудтай харилцах харилцаанд хэрхэн хангагдаж байгааг Монгол Улсын иргэдийн үнэлэмж, байр сууриар тодруулах нь чухал байна. Монгол Улсын иргэдийн хувьд үндэсний аюулгүй байдал талаарх ойлголтыг тодруулах нь Монгол Улсын гадаад бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангасан, үр нөлөөтэй байх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ. Иймд эдгээр нөхцөлийг харгалзан дараах чиглэлд судалгааны асуулгыг боловсруулан олон нийтийн санаа бодлын тандалт судалгааг зохион байгуулж, үр дүнд шинжилгээ хийсэн.

Судалгааны онол, арга зүй, чиглэлийг тодорхойлоход (Almond, 1956), (Bealey, Chapman , & Sheehan, 1999), (Bellamy & Mason, 2003), (Klimuk, Piskunov, & Tarasova, 2019), (Kitler, 2021), (Ruonavaara, 2022), (Macon, et al., 2024), судалгааны асуулгыг боловсруулахад (World Values Survey Wave 7 (2017-2022), 2023), (The National Security Public Survey, 2022), (Neelam, 2023) зэрэг үндэсний аюулгүй байдал, хөрш орон, бүс нутаг, олон улсын бодлого чиглэлд хийгдсэн судалгааны бүтээлүүдийг ашигласан.

Судалгааны зорилго

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд уул уурхайн салбарын төвлөрөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц, нийлүүлэлтийн хараат байдал олон нийтийн санаа бодолд хэрхэн тусгалаа олж байгааг тодруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны дизайн

1. Түүврийн хэмжээ: n=1135

Зорилтот хүн амыг 18-аас дээш насны, насны дээд хязгааргүй Монгол Улсын иргэд төлөөлсөн. Газарзүйн байршлаар нь төв, баруун, зүүн, хангай, нийслэл Улаанбаатар гэсэн 5 бүс нутаг байв. 56.7 хувь нь Улаанбаатар хотод, 43 хувь нь хөдөө, орон нутагт амьдардаг.

Судалгаанд оролцогчдыг тус бүсээс хүн амд эзлэх хувь, хүйс, насны харьцааг харгалзан хамруулсан. 18-25 насны 37.5 хувь, 26-35 насны 16 хувь,

36-45 насны 19.5 хувь, 46-55 насны 12.9 хувь, 56-65 насны 8.5 хувь, 66-аас дээш насны 5.5 хувийн төлөөлөлтэй байна. Судалгаанд оролцогчдын 478 буюу 42.1 хувь нь эрэгтэй, 652 буюу 57.4 хувь нь эмэгтэй, 2 буюу 0.2 хувь нь бусад хүйсийн төлөөлөл байсан нь нийт 18-аас дээш насны хүн амд эзлэх хүйсийн харьцаатай ойролцоо түвшинд байна.

Судалгаанд оролцогчдын боловсролын түвшний хувьд 46.3 хувь нь дээд боловсролтой, 40.1 хувь нь бүрэн дунд боловсролтой, 4.1 хувь нь дунд боловсролтой, 6.7 хувь нь мэргэжлийн боловсролтой, 2.2 хувь нь бага болон бусад төрлийн боловсролтой байна. Өрхийн орлогын түвшний хувьд судалгаанд оролцогчдын 4.7 хувь нь 660.000 төгрөгөөс доош, 9.4 хувь нь 660.000-1.000.000, 16.2 хувь нь 1.000.001- 1.500.000, 23.4 хувь нь 1.500,001-2.000.000, 19.9 хувь нь 2.000.001-2.500.000, 26.1 хувь нь 2.500.000 төгрөгөөс дээш тус тус орлоготой байна.

2. Хугацаа: 2024 оны 05 сарын 01-с 10 дугаар сарын 01-ны хооронд судалгааны асуулгыг авч дууссан.
3. Судалгааны найдварт байдал: Судалгааны найдварт байдлыг кронбахын альфа (Cronbach's alpha) - аар хэмжсэн шкал шинжилгээг нийтдээ хоёр удаа хийсэн. Эдгээрт: 1/ нийт түүврээс судалгаа авахаас өмнө 40 оролцогчоос тандалт судалгаа авч судалгааны асуулгын загвар батлахад, 2/ нийт түүвэр болох 1135-аас судалгаа бүрэн авч дууссаны дараа хийхэд асуулга болон сонгож авсан шкал өндөр найдвартай, ач холбогдолтой байгаа нь тогтоогдсон. Судалгааны асуулгын найдвартай байдлын шинжилгээ хийхэд судалгааны асуултын найдварт байдлын Кронбахын альфа коэффициент 0.85 болсон. Тус коэффициент нь 0-1 утга авах бөгөөд 0.6-аас дээш байх нь судалгааны асуулт ач холбогдолтой байдаг. Тиймд судалгааны асуулгууд нь найдвартай, асуулгын үнэлгээний 6 шкал оновчтой болох нь харагдаж байна.

Үндэсний аюулгүй байдлын талаарх олон нийтийн санаа бодол

Үндэсний аюулгүй байдлын талаарх олон нийтийн санаа бодол бол олон нийтийн нэлээд хэсгийг илэрхийлсэн үндэсний аюулгүй байдлын талаарх үзэл бодол, хандлага, итгэл үнэмшлийн нийлбэр юм. Тус үзэл бодол, хандлага, итгэл үнэмшил бүрэлдэн тогтоход 1/ нэг нутаг дэвсгэрээр нэгдсэн нийгмийн нэгдлийн олон мянган жилийн түүх, уламжлал, хэл, соёл, сайн болон муу туршлага, үндэсний ухамсар (үндэсний өвөрмөц байдал гэж нэрлэдэг), нийгмийн статус зэрэг үндэстний мөн чанартай холбоотой хандлага, 2/ нэг нутаг дэвсгэрт амьдардаг, нэг хуулийн дор захирагдаж,

иргэний нийгмийг бүрдүүлдэг өөр өөр ашиг сонирхолтой бие хүн, бүлгээс бүрдсэн улс төрийн нэгдлээс хамаарах хандлага нөлөөлдөг. Ард түмэн оршин тогтнож, бие даан хүрч чадаагүй зорилгодоо хүрэхийн тулд янз бүрийн саад бэрхшээлийг даван туулах чадавхтай төр, засаглалын институцийг зохион байгуулж, хөгжүүлсээр ирсэн. Тухайн төр, засаглалын институци чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг ард түмний өгсөн үнэлгээ, хандлагаар тодорхойлох нь нэг боломжит хувилбар юм. Тиймээс судалгаанд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын талаарх олон нийтийн санаа бодол, үндэсний аюулгүй байдлын бодлого, чиглэл, ач холбогдлын үнэлгээ, үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулж буй зарим хүчин зүйлс, үндэсний аюулгүй байдлыг хангах иргэдийн оролцооны хэлбэрийн талаарх олон нийтийн зарим хандлагыг тодруулахад чиглэсэн.

Судалгаанд оролцогчдоос үндэсний аюулгүй байдлын талаарх асуудлуудаас хамгийн их санал нийлж буй байр суурийг тодруулахад “хүн бүр Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд анхаарал хандуулах ёстой” гэж хамгийн өндөр хувьтай буюу 53.7 хувь хариулсан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын асуудал түүхэн цаг хугацааны туршид улс орны оршин тогтнолд хамгийн чухалд тооцогдож байсныг баталж байна. Гэвч үндэсний аюулгүй байдлын талаар мэдлэг, мэдээллийн түвшиндээ хангалттай үнэлгээ өгөөгүйн дээр үндэсний аюулгүй байдлын заналхийлэл, сорилт, боломжуудын талаар илүү ихийг мэдэх сонирхолтой байгаа талаар судалгаанд оролцогчдын 15.2 хувь хариулсан нь энэ чиглэлд хийгдэх арга хэмжээ, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Зураг 1. *Үндэсний аюулгүй байдлын талаарх байр суурь*




Эх сурвалж: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнгээс

Түүнчлэн “хүн бүр Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд анхаарал хандуулах ёстой” гэж эмэгтэй оролцогчид 30.2 хувь, эрэгтэй

оролцогчид 23.5 хувь хариулсан бол тэдний 25.6 хувь нь дээд, 20.7 хувь нь бүрэн дунд, 3.8 хувь нь бага, дунд, 3.5 хувь нь мэргэжлийн боловсролтой байна. Орлогын түвшин нэмэгдэхийн хэрээр тус хариулттай санал нийлсэн болон энэ чиглэлд зохион байгуулагдах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй оролцогчдын хувь нэмэгдэж байна. Нийт оролцогчдын насны бүлгийн хувьд аюулгүй байдлын талаарх асуудлуудаас хамгийн их санал нийлж буй байр суурь дараах байдалтай байна.

Зураг 2. *Үндэсний аюулгүй байдлын талаарх байр суурь (насны бүлгээр)*




Эх сурвалж: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнгээс

“Хүн бүр Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд анхаарал хандуулах ёстой” гэж аль ч насны бүлэг өндөр хувьтай хариулснаас хамгийн өндөр үзүүлэлт нь 56-65 насны оролцогчдын 58.3 хувь, хамгийн бага үзүүлэлт нь 18-25 насны оролцогчдын 50.6 хувь нь тус тус хариулжээ. “Үндэсний аюулгүй байдлын талаар зөвхөн төр, засаг л анхаарах ёстой” гэж 18-25 насны оролцогчдын 14.2 хувь, “үндэсний аюулгүй байдлын заналхийлэл, сорилт, боломжуудын талаар илүү ихийг мэдэх сонирхолтой байна” гэж 46-55 насны оролцогчдын 17.1 хувь, “Үндэсний аюулгүй байдлын талаар олон нийтийн хэлэлцүүлэгт үгээ хэлэх юм уу илүү оролцмоор байна” гэж 66-с дээш насны оролцогчдын 15 хувь, “үндэсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг хаанаас авахаа мэддэг” гэж 56-55 насны оролцогчдын 5.2 хувь, “үндэсний аюулгүй байдлын асуудлаар мэдлэгтэй” гэж 36-45 насны оролцогчдын 3.6 хувь, “Үндэсний аюулгүй байдлын талаарх мэдээлэл сонирхол татдаггүй” гэж 18-25 насны оролцогчдын 14 хувь нь хариулсан нь эдгээр чиглэлийн асуултад хариулсан

хамгийн өндөр үзүүлэлт байна. Ажил эрхлэлтийн тухайд төрийн байгууллагад ажилладаг оролцогчид үндэсний аюулгүй байдлын талаарх мэдлэгтэй, мэдээлэл хаанаас авахаа мэддэг гэж илүү өндөр хувиар хариулсан бол малчин, группт байдаг, ажил эрхэлдэггүй хэсэг бага үзүүлэлттэй байна.

Зураг 3. *Үндэсний аюулгүй байдлын талаарх байр суурь (бүсчлэлээр*)



Эх сурвалж: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнгээс

“Хүн бүр Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд анхаарал хандуулах ёстой”, “үндэсний аюулгүй байдлын заналхийлэл, сорилт, боломжуудын талаар илүү ихийг мэдэх сонирхолтой байна”, “үндэсний аюулгүй байдлын талаар олон нийтийн хэлэлцүүлэгт илүү оролцмоор байна”, “үндэсний аюулгүй байдлын асуудлаар мэдлэгтэй” гэж хангай бүсийн оролцогчид хамгийн өндөр хувиар хариулсан бол “үндэсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг хаанаас авахаа мэддэг” гэж зүүн бүсийн оролцогчид хамгийн өндөр хувиар тус тус хариулжээ.

Зураг 4. *Үндэсний аюулгүй байдлын бодлого, чиглэл, ач холбогдлын эрэмбэ*




Эх сурвалж: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнгээс

Үндэсний аюулгүй байдлыг хангахад нэн тэргүүн анхаарах ёстой, ач холбогдол бүхий төрийн бодлого, чиглэлийг эрэмбэлүүлэхэд хамгийн их давтагдсан хариултын тухайд “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ханган хөгжих” гэж 51.2 хувь, “эдийн засгийн бие даасан байдлаа ханган хөгжих” гэж 45.9 хувь, “хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх” гэж 41.5 хувь, “хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах” гэж 17.4 хувь, “хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах” гэж 16.5 хувь байна. Оролцогчдын хүйсийн хувьд авч үзвэл “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ханган хөгжих” гэж хариулсан оролцогчдоос эмэгтэйчүүд 29.4 хувь, эрэгтэйчүүд 21.6 хувь, “эдийн засгийн бие даасан байдлаа ханган хөгжих” гэж эмэгтэйчүүд 25.4 хувь, эрэгтэйчүүд 20.4 хувь, “хүний эрх, эрх чөлөөг

хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх" гэж эмэгтэйчүүд 24 хувь, эрэгтэйчүүд 17.3 хувь, "хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах" гэж эмэгтэйчүүд 9.5 хувь, эрэгтэйчүүд 8 хувь, "хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах" гэж эмэгтэйчүүд 9.4 хувь, эрэгтэйчүүд 7.1 хувь тус тус хариулсан байна.

Зураг 5. *Үндэсний аюулгүй байдлын бодлого, чиглэл (насны бүлгээр)*
Эх сурвалж: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнгээс



Насны бүлгийн хувьд дээрх үндэсний аюулгүй байдлыг хангахад нэн тэргүүн анхаарах ёстой, ач холбогдол бүхий төрийн бодлого, чиглэлийг үнэлүүлэхэд 18-25 нас болон 36-45 насны оролцогчид илүү өндөр үнэлгээ өгсөн байна. Улаанбаатар хот болон орон нутгийн оролцогчдын үнэлгээгээр "тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ханган хөгжих" гэж Улаанбаатар хотын оролцогчид 29.1 хувь, орон нутгийн оролцогчид 22.2 хувь, "эдийн

засгийн бие даасан байдлаа ханган хөгжих" гэж Улаанбаатар хотын оролцогчид 29.3 хувь, орон нутгийн оролцогчид 16.3 хувь, "хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх" гэж Улаанбаатар хотын оролцогчид 30 хувь, орон нутгийн оролцогчид 11.5 хувь, "хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах" гэж Улаанбаатар хотын оролцогчид 8 хувь, хөдөө, орон нутгийн оролцогчид 9.4 хувь, "хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах" гэж Улаанбаатар хотын оролцогчид 8.7 хувь, орон нутгийн оролцогчид 7.6 хувь тус тус хариулсан.

Эндээс үзэхэд Улаанбаатар хотын оролцогчид "тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ханган хөгжих" гэж 6.9 нэгжээр, "эдийн засгийн бие даасан байдлаа ханган хөгжих" гэж 13 нэгжээр, "хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх" гэж 18.5 нэгжээр, "хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах" гэж 1.1 нэгжээр илүү ач холбогдолтой гэж үзсэн бол "хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах" гэж орон нутгийн оролцогчид Улаанбаатар хотынхоос 1.4 нэгжээр илүү ач холбогдолтой гэж үзсэн байна. "Эдийн засгийн бие даасан байдлаа ханган хөгжих" гэж өрхийн орлого нь 1.500.001-2.000.000 төгрөг, 2.500.001-с дээш төгрөгийн орлоготой хэсэг, ажил эрхлэлтийн хувьд хувираа хөдөлмөр эрхлэгч болон оюутнууд илүү өндөр хувиар дэмжсэн байна.


Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт эдийн засгийн аюулгүй байдал бие даасан хэмжээс болж тодорхойлогдсон байдаг (Үндэсний аюулгүй байдлын тухай, 2001). Эдийн засгийн аюулгүй байдал нь үйлдвэрлэл, санхүү, стратегийн салбар дахь өмчлөлийн бүтэц, гадаадын хөрөнгө оруулалтын төвлөрөл, нийлүүлэлтийн хараат байдлаар хэмжигдэх бөгөөд эдгээр хүчин зүйлс нь улс орны бодлогын бие даасан байдлыг тодорхойлдог.

Монгол Улсын эдийн засгийн бүтэц уул уурхайн салбарт өндөр төвлөрсөн, гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь нэг салбарт чиглэсэн нөхцөлд гадаадын хөрөнгө оруулалтын бүтэц нь үндэсний аюулгүй байдлын стратегийн асуудал болж хувирч байна. Иймд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ төдийгүй түүний салбарын болон улсын төвлөрөл нь эдийн засгийн эмзэг байдлыг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг юм.

“Шууд хөрөнгө оруулалтын судалгаа нь Монгол Улсаас бусад улсад хийсэн шууд хөрөнгө оруулалт (гадаад актив), Монгол Улсад бусад улсаас оруулсан шууд хөрөнгө оруулалт (гадаад пассив)-ын үлдэгдлийг харьяалах улс, хөрөнгө оруулалтын хэрэгслээр харуулдаг статистик юм. Шууд хөрөнгө оруулалт гэж аливаа нэг улсын эдийн засгийн харьяат нь бусад улсын буюу харьяат бус аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц эсхүл шууд удирдах саналын эрх бүхий хэмжээний хөрөнгө (10% буюу түүнээс дээш)-ийг нийлүүлэх болон салбар нэгжээ байгуулахыг ойлгоно. Хөрөнгө оруулалтыг эх үүсвэрээр нь дотоод, гадаад эх үүсвэрээр тооцдог ба дотоод эх үүсвэрээр тооцохдоо улсын төсөв, бусад дотоод эх үүсвэрүүдийн нийлбэрээр, гадаад эх үүсвэрийг зээл, буцалтгүй тусламж, шууд хөрөнгө оруулалтын нийлбэрээр тооцдог” (Монгол банк, 2024) байна.

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээр сүүлийн 13 жилийн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа эдийн засгийн үйл ажиллагааны 10 салбар нь барилга; боловсруулах үйлдвэрлэл; бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ; зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ; мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа; санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа; удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; уул уурхай, олборлолт; үйлчилгээний бусад үйл ажиллагаа; үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа салбарууд байна.

Зураг 6. *Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлэх эдийн засгийн үйл ажиллагааны салбар (сая.ам.доллар)*



Эх сурвалж: Монгол банк (Монгол банк, 2024)


2010-2023 оны хооронд Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын 73.4 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт төвлөрсөн. 2023 оны байдлаар уул уурхай олборлолтоос тус салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 28.7 хувийг (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2024) бүрдүүлж байна. Уул уурхай, олборлолтын салбар Монгол Улсын ДНБ-ны 1/3 орчмыг дангаараа бүрдүүлэхээс гадна гадаадын хөрөнгө оруулалтын ¾ орчмыг бүрдүүлж байгаа нь олон нийтийн анхаарлыг татахад хүргэж байна. Мөн гадаадын хөрөнгө оруулалттай холбоотойгоор үндэсний аюулгүй байдлын талаарх маргаан дагуулдаг асуудал бол хөрөнгө оруулагч улсын хөрөнгө оруулалтын хувь хэмжээ байдаг. 2010 онд батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.2.2 дахь заалтад Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална” гэж заасан байна.

2010 оноос 2023 он хүртэл Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн улсуудаас хамгийн их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн 10 улсаар БНХАУ 69,181 сая доллар, Канад 67,813 сая доллар, Нидерланд 44,057 сая доллар, Сингапур 23,152 сая доллар, Люксембург 18,498 сая доллар, Япон 9,176 сая доллар, АНУ 8,376 сая доллар, Австрали 6,124 сая доллар, Их Британи 7,879 сая доллар, БНСУ 5,991 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 63 хувийг БНХАУ, Канад, Нидерланд гурван улс бүрдүүлсэн байна. Харин манай хойд хөрш ОХУ 3,409 сая долларын хөрөнгө оруулалт хийж хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн улсуудын 11 дүгээрт байна.

Судалгаанд оролцогчдоос гадаадын хөрөнгө оруулалтын талаарх байр суурийг тодруулахад дэлхийн томоохон улс гүрний хөрөнгө оруулалт чухал гэж 38.2 хувь, хөрш орнуудын хөрөнгө оруулалт чухал гэж 25.6 хувь, Монгол Улсыг сонирхож буй гадаадын бүх хөрөнгө оруулагчид нээлттэй байх чухал гэж 36.7 хувь, уул уурхайн, байгалийн баялаг, ашигт малтмалын хөрөнгө оруулалтыг татах чухал гэж 32.1 хувь, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөрөнгө оруулалт илүү чухал гэж 38.1 хувь, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарт оруулах хөрөнгө оруулалт чухал гэж 38.5 хувь, хөдөө аж ахуйн салбарт оруулах хөрөнгө оруулалт чухал гэж 20.8 хувь, хөрш орнуудаас хараат бус хөрөнгө оруулалт чухал гэж 14.7 хувь, бусад гэж 0.4 хувь нь үзсэн бол мэдэхгүй гэсэн хариултыг 5.9 хувь нь тус тус хариулжээ.

2022 оны I-IV улирлын байдлаар “ОХУ-аас импортоор оруулсан барааны 55.1 хувийг нефтийн бүтээгдэхүүн” (Үндэсний статистикийн хороо, 2022) эзэлж байгаа бөгөөд тухайн нефтийн бүтээгдэхүүн нийт ижил төрлийн бүтээгдэхүүний 97 хувийг дангаараа бүрдүүлж байна. Гэтэл ОХУ - Украйны дайнаас үүдэлтэй нефтийн бүтээгдэхүүн нийлүүлэгч орны дотоод шатахууны хомсдол, газрын тос боловсруулах үйлдвэрлэлийн засварын ажил, тээвэр, логистикийн саатал зэргээс болж 2023 оны III, IV улирал, 2024 эхний хагас жилд шатахуун түгээх станцууд түгээлтдээ хязгаарлалт тавьсан. Мөн цахилгаан, эрчим хүчний систем чадлын дутагдалд орсонтой холбоотойгоор эрчим хүчний хязгаарлалтыг хэсэгчлэн хийх нөхцөлийг үүсгэсэн зэрэг нь иргэд, аж ахуй нэгж, төрийн үйлчилгээнд ихээхэн хүндрэл учруулсан. Энэ талаар Монгол Улсад болж буй шатахууны хомсдол, эрчим хүчний хязгаарлалтад хамгийн их нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахад дараах байдлаар хариулсан.

Зураг 7. *Шатахуун болон цахилгаан, эрчим хүчний хязгаарлалтад нөлөөлж буй хүчин зүйлс*




Эх сурвалж: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнгээс

Дээрх зураглалаас харахад шатахууны хомсдолын асуудалд эрчим хүчний хязгаарлалтын асуудлаас илүү олон хүчин зүйлс нөлөөлсөн гэж судалгаанд оролцогчид үзэж байгаа бөгөөд хоёр нөхцөлөөс 20 хувиас дээш үнэлсэн хүчин зүйлсэд нийлүүлэгч улс орны шийдвэр, төрийн бодлого, шийдвэр, дэлхийн зах зээлийн нөлөө, импортолж оруулж ирж байгаа байгууллагуудын үйл ажиллагаа, дайнаас үүдэлтэй хямрал зэрэг нь шатахууны хомсдолд илүү нөлөөлсөн гэж үзсэн бол эрчим хүчний хязгаарлалтад төрийн бодлого, шийдвэр, нийлүүлэгч улс орны шийдвэр хоёр хамгийн их нөлөөлсөн гэж хариулжээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэдийн оролцоог хангах нь чухал юм. Энэ талаарх олон нийтийн байр суурийг тодруулахад мэдээлэлтэй байх 53 хувь, ташаа мэдээлэлд итгэхгүй байх 33 хувь, нэгдмэл байх 44 хувь,

албан тушаалтнуудад итгэх, дуу хоолойгоо илэрхийлэх 34 хувь, идэвх санаачилгатай байх гэж 31 хувь нь хариулсан.

Зураг 8. *Үндэсний аюулгүй байдал ба иргэдийн оролцоо*



Эх сурвалж: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнгээс

Судалгаанд оролцогчид энэ талын асуудалд ямар нэг албан тушаалтан, холбогдох байгууллагуудын оролцоогүйгээр бие даасан оролцоотой байх сонирхолтой байгааг илтгэж байна. Тиймээс мэдээлэл авах, санал бодлоо илэрхийлэх боломжийг олгосон нийгмийн нэгдмэл байдлыг хангасан сувгуудыг бий болгох хэрэгцээ шаардлагыг илэрхийлж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллийн хүрээнд олон нийтээс авсан судалгаанд, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголт нь уламжлалт цэрэг, улс төрийн хэмжээсээс давж эдийн засгийн бүтэц, гадаадын хөрөнгө оруулалтын төвлөрөл, нийлүүлэлтийн хараат байдал зэрэг хүчин зүйлстэй нягт уялдаж байгааг харууллаа.

Нэгдүгээрт, иргэдийн дийлэнх нь үндэсний аюулгүй байдлыг хангахад тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал болон эдийн засгийн бие даасан байдлыг тэргүүлэх чиглэл гэж үзсэн нь эдийн засгийн тогтвортой байдал үндэсний аюулгүй байдлын гол тулгуур хэмжээс болж буйг илтгэнэ. Энэ нь эдийн засгийн аюулгүй байдлын онолын хандлагуудтай нийцэхийн зэрэгцээ Монгол Улсын хувьд аюулгүй байдлын ойлголт эдийн засгийн бүтцийн онцлогтой салшгүй холбогдож байгааг харуулж байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт өндөр төвлөрсөн, гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь нэг салбарт чиглэсэн бүтэцтэй байгаа нь эдийн засгийн эмзэг байдлын бодит суурь нөхцөлийг бүрдүүлж байна. Экспорт, дотоодын нийт бүтээгдэхүүн, гадаадын хөрөнгө оруулалтын бүтэц уул уурхайд төвлөрсөн байдал нь дэлхийн зах зээлийн савлагаа, хөрөнгө оруулагч улсын бодлого, нийлүүлэлтийн гадаад эх үүсвэрээс хамаарах хамаарлыг нэмэгдүүлж байна.

Гуравдугаарт, шатахуун болон эрчим хүчний нийлүүлэлтэд үүссэн хязгаарлалтуудтай холбоотой иргэдийн үнэлгээ нь эдийн засгийн хараат байдал үндэсний аюулгүй байдлын бодит эрсдэлийн хэлбэрээр илэрч буйг харууллаа. Нийлүүлэгч улс орны шийдвэр, төрийн бодлого, дэлхийн зах зээлийн нөлөөг гол хүчин зүйлс гэж үнэлсэн нь эдийн засгийн аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголт бодит бүтцийн эмзэг байдалтай нийцэж байгааг илтгэнэ.

Дөрөвдүгээрт, гадаадын хөрөнгө оруулалтын салбарын бүтэц, эх үүсвэрийн төвлөрөл нь стратегийн ач холбогдолтой салбарт бодлогын бие даасан байдлыг хязгаарлах эрсдэлтэй байгааг олон нийтийн үнэлгээ харуулж байна. Иргэд уул уурхайгаас гадна үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтыг илүү ач холбогдолтой гэж үзсэн нь эдийн засгийн төрөлжилтөөр дамжуулан үндэсний аюулгүй байдлыг бататгах шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Иймээс Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлогод уул уурхайн салбарын хэт төвлөрлийг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтын салбар болон улсын эх үүсвэрийн олон талт байдлыг нэмэгдүүлэх, стратегийн салбар дахь нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулах бодлого онцгой ач холбогдолтой байна. Энэхүү судалгаа нь эдийн засгийн бүтэц, гадаадын хөрөнгө оруулалтын онцлог, олон нийтийн үнэлгээ хоорондын уялдааг эмпирик байдлаар тодруулсан нь үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулахад иргэдийн байр суурийг тусгах шаардлагыг онцолж байна.

НОМ ЗҮЙ

1. Almond, G. A. (1956 оны 01 01). Public Opinion and National Security Policy. *Public Opinion Quarterly, 20*(2), 371-378.
2. Bealey, F., Chapman , R. A., & Sheehan, M. (1999). *Elements in Political Science.* Edinburgh: Edinburgh University Press.

3. Bellamy, R., & Mason, A. (Хянд.). (2003). *Political concepts.* Manchester: Manchester University Press.
4. Cheng, T. J., & Lee, W. C. (Хянд.). (2017). *National Security, Public Opinion and Regime Asymmetry.* World Scientific Publishing Company.
5. Cooney, B. M., Khachatryan, A., Garson, M., Kakkad, J., Sleat, D., Stanley, L., . . . Zandermann, K. (2024 оны 06 11). *Reimagining Defence and Security: New Capabilities for New Challenges.* https://institute.global: https://institute.global/insights/geopolitics-and-security/reimagining-defence-and-security-new-capabilities-for-new-challenges-ээс Гаргасан
6. Kitler, W. (2021). *National Security: Theory and Practice.* Warsaw: Wydawnictwo Towarzystwa Wiedzy Obronnej (The Publishing House of the Society of Defence Knowledge).
7. Klimuk, V. V., Piskunov, V. A., & Tarasova, T. M. (2019). Methodical Approaches to Assessing the Economic Security. *GCPMED 2018 International Scientific Conference "Global Challenges and Prospects of the Modern Economic Development"* (хуудсд. 283-290). Future Academy www.FutureAcademy.org.UK.
8. Macon, B., Khachatryan, A., Garson, M., Kakkad, J., Sleat, D., Stanley, L., . . . Zandermann, K. (2024). *Reimagining Defence and Security: New Capabilities for New Challenges.* Tony Blair Institute for Global Change.
9. Neelam, R. (2023). *Understanding Australian attitudes to the World.* Sydney: Lowy Institute.
10. Ruonavaara, H. (2022). The Anatomy of Neighbour Relations. *Sociological Research Online 27*, 379-395.
11. (2022). *The National Security Public Survey.* Paris: Ipsos.
12. Waldemar, K. (2021). *National Security Theory and Practice.* Warsaw: The Publishing House of the Society of Defence Knowledge).
13. *World Values Survey Wave 7 (2017-2022).* (2023). World Values Survey: https://www.worldvaluessurvey.org/WVSDocumentationWV7.jsp-ээс Гаргасан
14. Xie, Y., & Jin, Y. (2021 оны 05 18). Global Attitudes toward China: Trends and Correlates. *Journal of Contemporary China, 31*(133), 1-16.
15. Монгол банк. (2024 оны 9 4). *Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл, эдийн засгийн үйл-ны салбараар.* https://www.1212.mn/: https://www.1212.mn/mn/statistic/statcate/573075/table-view/DT_NSO_1500_005V3-ээс Гаргасан
16. *Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал.* (2011). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=203362-ээс Гаргасан
17. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2024 оны 8 1). *Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, бүс, аймаг, нийслэлээр, салбараар.* https://www2.1212.mn/:

https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0500_021V1&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0_1_2_3_4_5&IND_select_all=0&INDSingleSelect=_21&YearY_select_all=1&YearYSingleSelect=&viewtype=table-ээс Гаргасан

18. *Үндэсний аюулгүй байдлын тухай.* (2001 оны 12 27). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=18-ээс Гаргасан
19. Үндэсний статистикийн хороо. (2022). *Статистикийн мэдээ: Экспорт өмнөх сараас 18.7 хувиар өслөө.* Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.

AN ANALYSIS OF PUBLIC OPINION ON NATIONAL SECURITY AND FOREIGN INVESTMENT IN MONGOLIA

Abstract: This article examines Mongolia's national security from the perspective of economic security, focusing on mining sector concentration and the structure of foreign direct investment (FDI). The study draws on a nationwide public opinion survey conducted between May and October 2024 (n=1,135).

The findings show that public perceptions of national security extend beyond traditional military dimensions and are closely linked to economic independence and structural vulnerability. A majority of respondents identified sovereignty (51.2%) and economic self-reliance (45.9%) as key security priorities. Meanwhile, macroeconomic data indicate that 73.4% of FDI inflows between 2010 and 2023 were concentrated in the mining sector, which accounted for 28.7% of GDP in 2023. This structural dependence increases exposure to external market fluctuations and supplier country decisions.

The results suggest that public evaluations of foreign investment reflect broader concerns about economic concentration and national resilience. Diversifying FDI sources and reducing sectoral dependence on mining emerge as important considerations for strengthening Mongolia's national security framework.

Key words: national security, economic security, foreign direct investment, mining concentration, Mongolia

ПОЛИТОЛОГИ XXIV
Эрдэм шинжилгээний бичиг №24: 240-260 дах тал

ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЕОПОЛИТИКИЙН ӨӨРЧЛӨЛТ БА МОНГОЛ УЛС (Чухал ашигт малтмалын жишээн дээр)

Д.Мягмарсүрэн
ШУТИС-ийн НХС-ийн профессор

Хураангуй:

Сүүлийн жилүүдэд стратегийн ашигт малтмал буюу уран, чухал ашигт малтмал зэрэг эрчим хүчний аюулгүй байдал, технологийн дэвшил, эдийн засгийн хөгжлийн суурь түүхий эд, нөөцийн төлөөх геополитикийн өрсөлдөөн ширүүсэж, улмаар олон улсын харилцааны үйл явцыг томоохон өөрчлөлт рүү түлхэж байна. Тэрчлэн дэлхий дахиныг хамарсан эрчим хүчний шилжилт, их гүрнүүдийн нөөц баялгийн төлөөх өрсөлдөөн, дэлхийн худалдааны дайн зэрэг глобал үйл явц нь эрчим хүчний шинэ дэг журам үйлчлэх нөхцөлийг бий болгов. Дэлхийн эрчим хүчний шилжилт төдийгүй аж үйлдвэрийн 4-р хувьсгал, батлан хамгаалах салбарын ирээдүй нь эдгээр стратегийн нөөцөөс хамаарах болсонтой холбоотойгоор улс орнууд чухал ашигт малтмал, ураны нөөцийг эзэмших, нийлүүлэлтийн сүлжээг хянахын төлөө өрсөлдөөнд аяндаа татагдан орж байна.

Ялангуяа АНУ, Хятадын чухал ашигт малтмалын төлөөх ил далд сөргөлдөөн нь бүс нутаг ялангуяа Монгол улсын гео-эрчим хүчний бодлого, дипломат харилцаанд шинэ тутам сорилтыг дагуулах болов. Улмаар стратегийн нөөцийн төлөөх эдгээр тоглогчдын өрсөлдөөний өрнөлд үндэслэн чухал ашигт малтмалд суурилсан хамтын ажиллагааны хувилбарыг боловсруулах, гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа хэрэгжүүлэх боломжийг бидэнд олгож байна. Энэхүү илтгэлээрээ эрчим хүчний нөөцтэй холбоотой геополитикийн динамик өрнөл, түүний Монгол улсад нөлөөлөх нөлөөллийг авч үзэхийн тулд баримт бичгийн шинжилгээ хийж, холбогдох хүчин зүйлсийн харилцан хамаарал, нөлөөллийг холистик хандлагаар үнэлж дүгнэн, улмаар Монгол улсын чухал ашигт малтмалын нөөцдөө тулгуурлан гадаад бодлого, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход өөрийн хувилбарыг дэвшүүлэхийг зорив.

Түлхүүр үгс: эрчим хүчний шилжилт, чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээ, геополитикийн өрсөлдөөн, гурван түвшинт тоглолт

Оршил

Одоогоос 100 гаруй жилийн тэртээ Оросын хувьсгалч В.И.Ленин "Бүхий л улс түмний хувьд з*өвлөлт засаг дээр* цахилгаанжуулалтыг нэмбэл коммунизм болно" хэмээн хэлсэн байдаг. Зөвлөлт засаг, коммунизм нь бүтэлгүйтсэн ч цахилгаанжуулалт нь өдгөө дэлхий дахины зорилт болон үлджээ.

Хүн төрөлхтний орчин цагийн нийгэм бүхэлдээ эрчим хүчнээс шууд хамаарах болов. Эрчим хүчний тасралтгүй өсөж буй хэрэгцээг хангахтай зэрэгцэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд эрчим хүчний шилжилт хийх санаачилгыг улс орон бүр хэрэгжүүлж эхлээд байна. Гэвч эрчим хүчний шилжилт хийх зорилт нь бүхэлдээ чухал ашигт малтмалын хангамжаас шалтгаалж байна. Өөрөөр хэлбэл, технологийн дэвшил, нүүрстөрөгчөөс хамаарал багатай эдийн засагт шилжих шилжилт нь чухал ашигт малтмалын нөөцийг геополитик, эдийн засаг, стратегийн бодлогын цөмд авчрав.

Эрчим хүчний шилжилт нь хэрэг дээрээ материалын шилжилт юм. Батерей, салхин турбин, нарны хавтан, цахилгаан тээврийн хэрэгсэл, цөмийн цахилгаан станц нь лити, кобальт, никель, газрын ховор элемент, уран зэрэгт голчлон тулгуурладаг буюу чулуужсан түлштэй харьцуулахад цэвэр технологи нь чухал ашигт малтмалын багтаамж ихтэй салбар юм. Жишээлбэл, цахилгаан машинд энгийнээс зургаа дахин их, нэг мегаваттын далайн салхин цахилгаан станцад хийн станцаас ес дахин их ашигт малтмал хэрэглэдэг. Гэхдээ тулгарч буй асуудал нь эдгээр ашигт малтмалын хомсдолд бус, харин нийлүүлэлтийн сүлжээ эмзэг, түүхий эдийн боловсруулалт төвлөрсөн шинжтэй, эрэлт нь үйлдвэрлэлээсээ хэт хурдацтай нэмэгдэж байгаад оршино. (Graaf, 2025).

Дэлхий дахинаа энэхүү амин чухал нөөцийг эзэмшихийн төлөө ил далд өрсөлдөөн эхэлж, дэлхийн улс орнуудын эрчим хүчний шилжилтийн зорилт энэхүү нөөцийг хэр амжилттай олборлох, ашиглахаас шууд хамаарах болов. Хэн энэхүү нөөцийг эзэмших төдийгүй нийлүүлэлтийн сүлжээг хянаж чадсан нь стратегийн давамгайлал, гео-эдийн засгийн давуу талыг олж авах юм.

Дэлхий дахиныг хамарсан эрчим хүчний шинэ ашигт малтмалын өрсөлдөөн, шинэ тутам үүсэж буй эвслүүдийн сөргөлдөөн болон гол тоглогч гүрнүүдийн өдөөсөн дайн нь энэхүү баялгаар арвин Монгол улсад хэрхэн

нөлөөлөх, энэхүү өрсөлдөөний хаялгыг дүнтэй ашиглах уу эсвэл давалгаанд цохигдон эрэгт хаягдах уу хэмээх нарийн төвөгтэй сорилт биднийг хүлээж байна.

Эрчим хүчний нөөцтэй холбоотой геополитикийн динамик өрнөл, түүний Монгол улсад нөлөөлөх нөлөөллийг авч үзэхийн тулд баримт бичгийн шинжилгээ хийж, холбогдох хүчин зүйлсийн харилцан хамаарал, нөлөөллийг цогцоор нь буюу холистик хандлагаар дүн шинжилгээ хийж, улмаар Монгол улсын чухал ашигт малтмалын нөөцтэй холбоотой гадаад бодлого, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход өөрийн хувилбараа дэвшүүлэхийг зорив. Эрчим хүчний салбарын томоохон тоглогчдын бодлого, үйл ажиллагааны төлөв хандлагыг ажигласны үндсэн дээр өөрсдөд ашигтай стратегийн алхмыг тооцох боломжийг бидэнд олгоно.

Чухал ашигт малтмалын геополитик

Хими, физик, геологийн шинж чанараас гадна улс төр, эдийн засаг, стратегийн шалтгаанаар чухал ашигт малтмал, эрчим хүчний метал, эрчим хүчний шилжилтийн ашигт малтмал, газрын ховор элемент, экзотек эрдэс, стратегийн ашигт малтмал зэрэг олон нэр томьёог ашиглаж байна. Тухайлбал, стратегийн ашигт малтмал гэдэгт тухайн улс орны бодлого, зорилтоос үүдэн янз бүрээр тодорхойлж авч үздэг хэдий ч гол төлөв эдийн засаг, технологи, үндэсний аюулгүй байдлын бодлоготой нягт уялддаг, нөөцийн хувьд хязгаарлагдмал буюу цөөн улс оронд төвлөрсөн, геополитикийн зөрчилдөөний улмаас нийлүүлэлт тасалдах эрсдэл дагуулдаг түүхий эдийг гол төлөв тооцож байна (SME, 2022). Гурван үндсэн төрөлд хуваж болно. Үүнд:

- Эрчим хүчний ашигт малтмал: уран, нүүрс, газрын тос, төмрийн хүдэр, байгалийн хий,
- Цэрэг, батлах хамгаалах чиглэлийн: цайр, шохойн чулуу, зэс, уран, титан, лити, германи, ванади, кобальт болон газрын ховор элемент,
- Чухал ашигт малтмал: зэс, литий, никель, кобальт.

Үүнээс гадна эрчим хүчний шилжилтэй холбоотойгоор улам эрэлттэй болж, төдий хэрээр геополитикийн гүнзгий үр дагаврыг авчрахын зэрэгцээ улс орны эдийн засаг улам бүр өндөр хамааралтай болж буй литий, кобальт, никель зэрэг түүхий эдийг шинэ эрчим хүчний метал гэсэн ойлголтод багтаан авч үзсэн нь бий (Shupei Huang, Xinya Wang, Qiang Ji, 2025).

Тэрчлэн АНУ, Канад, Япон, Хятад зэрэг орнууд нөөц болон нийлүүлэлтийн сүлжээ аль нэг орны хяналтад байдаг, эрчим хүчний болон стратеги, аюулгүй байдлын болон эдийн засгийн учир холбогдол зэргээс

шалтгаалан чухал ашигт малтмал гэдэгт ураныг оруулан тооцсон байдаг (Hernandez, 2024). Уран болон бусад чухал ашигт малтмалын хувьд дараах адил шинж чанартай. Үүнд:

- Эрчим хүчний шилжилтийн гол нөөц, түүхий эд,
- Технологийн нарийн төвөгтэй нөхцөл, олон үйл явц, үе шатыг шаарддаг. Цөөн тоглогч шийдвэрлэх үүрэгтэй (АНУ, Хятад, Орос гэх мэт),
- Газарзүйн өвөрмөц байршилд төвлөрч байдаг нь нийлүүлэлтийн сүлжээний аюулгүй байдал, геополитикийн эрсдэл дагуулж байдаг,
- Хамтын ажиллагаа, харилцааны асуудал нь засгийн газар болон үндэстэн дамнасан корпорац зэрэг том оролцогчдын тоглолтоор шийдвэрлэгддэг,
- Улс торны батлан хамгаалах, эдийн засаг, аж үйлдвэрийн хувьсгалын өрнөл эдгээр нөөцөөс шууд хамаардаг,
- Олборлолт, үйлдвэрлэлийн үйл явц нь олон нийтийн анхаарал, эсэргүүцлийг дагуулж байдгаас шалтгаалан дотоод улс төрийн үйл явцад нөлөө үзүүлдэг.

Мөн цөмийн технологи нь сэргээгдэх эрчим хүчтэй эдийн засгийн хувьд ижил төстэй шинж чанартай буюу түүхий эд олборлолтыг хянах нь тухайн улсаас хүлээж болох эдийн засгийн үр өгөөжийг хамгийн бага хэмжээгээр өгдөг. Цөмийн түлш нь цөмийн эрчим хүч үйлдвэрлэх зардлын 20 хүрэхгүй хувийг эзэлдэг. Гол зардал уран боловсруулах баяжуулах болон реакторын технологи, тоног төхөөрөмж эзэлдэг (Meyer, 2025).

Өдгөө чухал ашигт малтмал нь дэлхий дахинаа дараах үйл явцад шууд нөлөөлж байна. Үүнд:

- Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үндсэн түүхий эд: хагас дамжуулагч, мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийн орц, сансар судлалын технологи,
- Эрчим хүчний шилжилтийн түүхий эд: сэргээгдэх эрчим хүч, батерей үйлдвэрлэл,
- Батлан хамгаалах: өндөр технологийн зэвсэг техник, навигаци, харилцаа холбооны хэрэгсэл, батлан хамгаалал, цэргийн зориулалттай бусад хэрэгсэл.

Чухал ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний төлөөх өрсөлдөөн нь арилжааны зорилтоос халин гарч геополитик, гео-эдийн засгийн стратегийн тулааны талбар болон өргөжив. Нөөцийг ашиглах, хяналт тавихын төлөөх тэмцэл улс үндэстнүүдийг эвсэл, холбооны үйл явц руу аяндаа түлхэж, улмаар энэхүү шилжилт нь дэлхийн

эдийн засаг, улс төрийн дэг журмыг өөрчлөхөд хүргэх юм. Ийнхүү чухал ашигт малтмалын төлөөх дэлхий дахины эвслийн стратеги, үйл ажиллагаа хийгээд гол тоглогч улс гүрнүүдийн өрсөлдөөний динамик, өрнөл талаар нарийн ойлголт, мэдээлэлтэй байх нь уг нөөц баялаг бүхий улс орнууд ялангуяа Монголын хувьд чухал асуудал юм.

Чухал ашигт малтмалын шинэ эвслүүд (MSP, БРИКС+6)

Дэлхийн дэг журамд улс орнуудын эдийн засаг, үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, бэхжүүлэх аюулгүй байдлын шинэ парадигмыг санал болгож байна. Хэдхэн жилийн өмнө чухал ашигт малтмалын худалдаа арилжаа болон нийлүүлэлтийн сүлжээний асуудал нь корпорацын түвшний сэдэв байсан бол өдгөө үндэсний стратегийн асуудал болон өөрчлөгдөв. Чухал ашигт малтмалын төлөөх өрсөлдөөн нь хар аяндаа улс орнуудыг эвсэл блокт хуваагдахад хүргэж байна. АНУ, Хятад, Австрали, Европын холбоо бүс нутаг, улс орнууд ойрын жилүүдэд дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлэх, эсвэл гадаад дахь төслүүдэд хөрөнгө оруулалт хийх замаар найдвартай хангалтын сүлжээтэй болох бодлогыг баримталж байна (Garside, 2024).

Энэхүү өрсөлдөөн тэмцэл нь зөвхөн нөөц баялгийг эзэмших төдийгөөр хязгаарлагдахгүй, эдийн засгийн бие даасан байдлаар дамжуулан үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэж байна. Уг сөргөлдөөний гол тоглогч бол нөөцийн нийлүүлэлтийн эрс зөрүүтэй стратеги бүхий Өрнөдийн (MSP) болон БРИКС+6 гэсэн хоёр эвсэл юм.

Өрнөдийн стратеги нь үйлдвэрлэл, дахин боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, Хятадын импортын хамаарлыг бууруулахыг эрмэлзэж байна. Энэ зорилгоор 2022 онд байгуулагдсан Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл (The Minerals Security Partnership (MSP)) нь АНУ түнш 14 оронтой хамтран цэвэр эрчим хүчний технологид зориулсан чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, стратегийн сонирхлоор нэгдсэн олон талт санаачилга юм.



Зураг 1. Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл (MSP)-ийн гишүүн орнууд. Эх сурвалж: goldmansachs.com (Cohen, 2023)

Эвслийн бүрдүүлэгч "нөхөрсөг" үндэстнүүдийг дамнасан чухал ашигт малтмалын нийлүүлэлт, хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэхийн тулд АНУ, Австрали, Их Британи, Канад зэрэг орнуудын хоёр талт болон гурван талт хамтарсан ажлын хэсэг, санхүүжүүлэх дэмжлэг, малтмалын нийлүүлэлтийн сүлжээний хэлэлцээр, мэдээлэл солилцох санаачилга, судалгааны төслүүд зэрэг олон янзаар хэрэгжиж байна (Vivoda, 2023). Энэ нь дан ганц АНУ-ын эрх ашгийг хөндөж буй хэрэг биш. Ялангуяа Хятадын чухал ашигт малтмалд найдлага тавьж буй Европын холбооны хамаарал нь тус холбооны стратегийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Заримдаа “Ашигт малтмалын төлөөх НАТО” гэж нэрлэгддэг энэхүү түншлэл нь барууны ертөнцийн технологи, эдийн засгийн аюулгүй байдалд чухал ач холбогдолтой эдгээр ашигт малтмалын боловсруулалт, нийлүүлэлт дэх Хятадын ноёрхлыг тэнцвэржүүлэх, төрийн оролцоо өндөртэй эдийн засагтай Хятад, Орос зэрэг орнууд ашигт малтмалын нөөцөө ашиглан улс төр, эдийн засгийн шахалт үзүүлэхээс сэргийлэх зорилготой геополитикийн арга хэрэгсэл гэж судлаачид үзэж байна (Calabrese, 2024). Тэрчлэн уг эвсэл нь дан ганц нөөцийн аюулгүй байдлын зэрэгцээ нээлттэй зах зээл, чөлөөт худалдааны зарчим, байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) өндөр стандартыг нийлүүлэлтийн сүлжээндээ нэвтрүүлэхийг эрмэлздэгээрээ онцлог. (Vivoda, 2023).

БРИКС+6 нь чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээнд онцгой анхаарал хандуулдаггүй ч байгалийн болон хүний нөөцийн үлэмж төвлөрлөөрөө Өрнөдийн эвслийн хувьд томоохон нөлөө үзүүлж чадахаар

байна. Улмаар нөөцийн энэхүү өрсөлдөөн нь мөргөлдөөний болзошгүй талбар болж хувирдаг. Өөрөөр хэлбэл, MSP нь эрчим хүчний чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээг хамгаалах, төрөлжүүлэхэд төвлөрч байгаа бол БРИКС+6 нь өөрсдийн байгалийн нөөц, валютад тулгуурласан тогтолцоогоо хадгалах, нөлөөллөө өргөжүүлэхийг санаархаж ирсэн (Célestin Coquidé, José Lages, Dima Shepelyansky, 2023).

Чухал ашигт малтмалыг эзэмших, хөрөнгө оруулалт хийх нь хоёр эвслийн ашигладаг гол стратеги юм. Тухайлбал, БРИКС+6-ын хувьд уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлд бодит хөрөнгө оруулалт хийхэд багагүй хүчин чармайлт тавьж байна. Жишээлбэл, БРИКС-ийн шинэ гишүүн Саудын Арабаас Бразилын чухал ашигт малтмалын салбарт 2.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бол Хятадын компаниуд Чили, Аргентины литийн олборлолт, Индонезид никель, Конго улсад кобальтын үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийсэн зэрэг нь эдгээр чухал нөөцөд хяналт тавихад машид анхаарч байгааг харуулж байна. Мөн Аргентин улс литийн 13 төслийг хөгжүүлж байгаа нь дэлхийн хэмжээнд хамгийн томд тооцогддог (Vlado Vivoda, Ron Matthews, Neil McGregor, 2024).

Мөн АНУ, Их Британи, Австрали улсын чухал ашигт малтмалын холбоод болон Африкийн чухал ашигт малтмалын холбоо (Critical Minerals Africa (CMA))-г эгнээндээ нэгтгэсэн Олон улсын чухал ашигт малтмалын эвсэл (The Critical Minerals International Alliance (CMIA)) нь чухал ашигт малтмалын уян хатан, төрөлжсөн, интеграци бүхий нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх зорилготой бөгөөд геополитик, нийлүүлэлтийн сүлжээний сорилт бэрхшээлийг даван туулах, сөрөн тэсвэрлэх чадвар, аж үйлдвэрийн эрэлт, хөгжлийн шийдлийг эрж хайхад анхаарлаа хандуулдаг байна (CMIA, 2024).


Ийнхүү уламжлалт, ерөнхий шинжтэй эвсэл холбооны зохион байгуулалтаас нөөцөд суурилсан эвсэл рүү шилжих парадигм нь олон улсын харилцаа, эдийн засгийн нөлөөллийн хүрээг эрс өөрчлөхөд хүргэж байна.

Хятад ба АНУ-ын чухал ашигт малтмалын салбар дахь өрсөлдөөн

АНУ-БНХАУ-ын хооронд стратегийн болон худалдааны өрсөлдөөн ширүүссэн эрин үед бид амьдарч байна. Энэхүү өрсөлдөөн нь ялангуяа дэлхий дахиныг хамарсан чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээг эрс өөрчлөхөд хүргэв. Улмаар эрчим хүчний шилжилт хийх санаачилга өдгөө геополитикийн өрсөлдөөн, хурцадмал байдалтай харшилдах болов (Yergin, 2024).

Хятад-АНУ-ын дэлхийн технологийн ноёрхлын төлөөх тулаан ялангуяа чухал ашигт малтмалын нөөцийн төлөөх сөргөлдөөнийг 21-р зууны геополитикийн “шинэ аугаа тоглоом” хэмээн зарим судлаачид нэрлээд 19-р зуунд өрнөсөн худалдааны замыг хянах өрсөлдөөн, Дэлхийн 2-р дайн болон өргөжсөн газрын тосны ордын төлөөх сөргөлдөөнтэй адилтгасан байдаг (Merwat, 2025).

Хятадын “Бүс ба зам” санаачилга, “Хятадад үйлдвэрлэв-2025” төсөл нь эдийн засаг, цэрэг зэвсгийн хувьд бэхжих стратеги, Хятадын санаачилгатай “шинэ норм”, институци байгуулах санаархал нь бусад аж үйлдвэржсэн их гүрнүүдийн хувьд санаа зовсон асуудал болж, улмаар хүчнүүдийн өрсөлдөөнийг түргэтгэж байна. (Kalantzakos, 2023) Тус улс литий, бал чулуу, кобальт, никель, зэс, газрын ховор элемент зэрэг зургаан чухал ашигт малтмалын үйлдвэрлэл, боловсруулалтад давамгайлдаг. Тэрчлэн дэлхийн зах зээлд үйлдвэрлэж, боловсруулсан бал чулуу, боловсруулсан газрын ховор элемент, кобальтын 75 гаруй хувийг нийлүүлдэг. Дээрх зургаан ашигт малтмалын хувьд дэлхийн нийт олборлож, боловсруулсан бүтээгдэхүүний дунджаар гуравны хоёрыг хянадаг.



Зураг 2. Чухал ашигт малтмал боловсруулагч гол нийлүүлэгчид. 2023 оны байдлаар. Эх сурвалж: IEA and RBC thought leadership

Хятадын давамгайлал зөвхөн нөөцийн олборлолтод төдийгүй, өртгийн сүлжээг бүхэлд нь хамардаг төдийгүй дэлхийн нийлүүлэлтийн динамик болон нөөцийн үнэ ханшийг тогтоох механизмд нөлөөллөө бэхжүүлж байна. Хятад хэдэн арван жилийн турш нийлүүлэлтийн сүлжээг баталгаажуулж, Африк, Латин Америкийн нөөц ихтэй орнуудад хөрөнгө оруулалт хийж ирсэн. Тэрчлэн батерейн эд анги үйлдвэрлэлд ноёрхдог буюу нийлэг анодын 97%, байгалийн анодын 79%, катодын 70%-ийг үйлдвэрлэж, дэлхийн лити-ион батерейн 79%-ийг дангаараа эзэлдэг. Чухал ашигт малтмалыг хамарсан энэхүү цогц үйлдвэрлэлээр дамжуулан аж үйлдвэр дэх

жин нөлөө хийгээд нийлүүлэлтийн сүлжээнд стратегийн ноёрхлоо хадгалсаар байна.

Хятад улс нь АНУ-ын чухал ашигт малтмалын дөрөвний нэгийг нийлүүлдэг (Merwat, 2025) Энэхүү хамаарлаас гарах нь АНУ-ын ойрын жилүүдийн стратеги юм. Мөн АНУ чухал ашигт малтмалын жагсаалт дахь 50 төрлийн эрдсийн 12 нь 100%, 29 нь 50% импортоос хамааралтай явж ирсэн. Тэдгээр 29 чухал ашигт малтмалын хувьд Хятад тэргүүлэгч үйлдвэрлэгч юм. Гэвч Хятадад эмзэг цэг бий. Никель, зэс, литийн дэлхийн хамгийн том импортлогч бөгөөд тэдгээрийн анхдагч нийлүүлэлт (upstream) тасалдсан тохиолдолд эдийн засагт нь томоохон нөлөө үзүүлнэ гэсэн үг.

Хятадын чухал ашигт малтмалын давамгайллын хариуд АНУ нийлүүлэлтийн сүлжээг өөрчлөх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, дээр дурдсанчлан нөөц ихтэй холбоотон орнуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхийг эрмэлзэх болов. Өнгөрсөн хугацаанд АНУ-ын хувьд газрын тос, байгалийн хийн хувьд гадаад хамаарлаа бууруулахын зэрэгцээ өрнөдийн орнуудын эрэлт хэрэгцээг хангаж өөрийн нөлөөллөө хадгалж чадсан. Үүнтэй адил чухал ашигт малтмалын хувьд бие даасан байдлаа хангах, нөлөөллөө тогтоох өрсөлдөөнд орж эхэллээ.

Хэдийгээр чухал ашигт малтмалын өрсөлдөөнд АНУ эрч хүчтэй орж эхэлсэн ч Хятадыг гүйцэх хүртэл багагүй цаг хугацаа зарцуулахаар байна. Ашигт малтмалыг цэвэршүүлэх, боловсруулах технологийн хувьд нэлээн хойно хоцорсон төдийгүй АНУ-ын дотоодын нөөц хомс, дагнасан корпорацуудын хөгжил Хятадын түвшинд очиж амжаагүй байна. Тухайлбал, АНУ нь кобальт, никель, бал чулууны нөөцийн 1%, марганец болон газрын ховор элементийн 2%-иас бага хувийг эзэлдэг буюу чухал ашигт малтмалын дотоодын нөөц багатай. Мөн газрын тосны BP, Chevron, ExxonMobil зэрэг газрын тос, байгалийн хийн үндэстэн дамнасан корпорацуудтай харьцуулахад Barrick Gold, Teck Resources and First Quantum Minerals зэрэг газрын ховор элементийн корпорацуудын хувьд улс төр, цэргийн дэмжлэг хангалттай бус, дэлхийд эзлэх байр суурь, ялангуяа эцсийн шатны үйлдвэрлэл (downstream)-д байр сууриа бэхжүүлж амжаагүй (Gracelin Baskaran, Duncan Wood, 2025).

Хоёр улсын өрсөлдөөн улам бүр ширүүсэж буй бөгөөд АНУ-ын өдөөсөн худалдааны дайны улмаас Хятад дэлхийн зах зээлд нийлүүлдэг байсан 7 төрлийн газрын ховор элементийн экспортыг хориглосон шийдвэрийг 2025 онд гаргасан юм (Lewis Jackson, Amy Lv, Eric Onstad, Ernest Scheyder, 2025).

Монголын чухал ашигт малтмалын геополитикийн тоглолт

Чухал ашигт малтмалыг тойрсон өрсөлдөөний үр дүн нь олон улсын худалдааны төлөв байдал, зах зээлийн тогтвортой байдал болон байгалийн баялгийн менежмент дэх улс үндэсний бүрэн эрхт байдалд гүн гүнзгий нөлөө үзүүлэх болно. Геополитикийн өрсөлдөөний улмаас засгийн газрууд татаас, худалдааны хязгаарлалт эсвэл стратегийн түншлэлээр дамжуулан чухал ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд хөндлөнгөөс ихээр оролцоход хүрнэ. Нөгөө талаас улс төр геополитикийн өрсөлдөөн, технологийн нарийн төвөгтэй нөхцөл, хөрөнгө оруулалтын хэмжээ, үндэсний аюулгүй байдлын асуудлыг хөндөж буй зэрэг нь уг асуудалд төрийн оролцоог тооцох нөхцөл рүү аяндаа түлхэж байна. Өөрөөр хэлбэл, чухал ашигт малтмал ихтэй бусад орнуудтай адил нөөцийн үндсэрхэг үзэл (resource nationalism)-д автах эрсдэл хүлээж байна (Yergin, 2024).

Монгол улс эрчим хүчний шилжилт, өндөр технологийн гол түүхий эд болох зэс, вольфрам, уран, жонш, цагаан алт зэрэг чухал ашигт малтмалын зэрэгцээ газрын ховор элементийн арвин нөөцтэй. Газрын ховор элементийн хувьд гэхэд ислийн нийт 3.1 сая тонны нөөцтэй, нийт 6 орд өнөөгийн байдлаар илрээд байна. Ураны хувьд өнөөгийн байдлаар 13 орд, 1.5 сая тонн геологийн нөөц, батлагдсан 192 мянган тонн нөөцтэй буюу Монгол улс дэлхийд эхний 10-т багтах орж байна (Г.Хорол, 2025).



Зураг 3. Монгол улсын газрын ховор элементийн ордууд. 2020 оны байдлаар. Эх сурвалж: Mongolian economy.

Хэрэв нөөц нь тогтоогдсон газрын ховор элементийн ордуудыг үндэсний эрх ашигтай шууд холбогдоно хэмээн тооцож, стратегийн орд хэмээн

зарлавал тэдгээрт төрийн хувь эзэмшлийн асуудлыг Засгийн газраас зарлаж, улмаар тухайн орд эзэмшиж буй компанийн үйл ажиллагаанд төр оролцох шахалт хийж эхлэх магадлалтай байна. Энэ ч зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 2-р сард "Монголросцветмет" ТӨҮГ-ыг "Эрдэнэс Критикал Минерал" гэж өөрчлөн, уг төрийн өмчит компани дээр чухал ашигт малтмалтай холбоотой бүхий асуудлыг төвлөрүүлэхийг эрмэлзэж байна.

Чухал ашигт малтмал нь гадаад бодлого, дипломатын арга хэрэгсэл, зэмсэг юм. Энэ үүднээс геополитикийн шинэ тутам тоглолттой нийцүүлэн гуравдагч хөршийн бодлогыг хэрэгжүүлэх, өргөжүүлэх боломжийг эрэлхийлэх, нарийвчилбал, хөрөнгө оруулалт татах, технологи нэвтрүүлэх, улс төр, стратегийн дэмжлэг авах, хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж нээгдэж байна.

Улмаар Монголын талтай чухал ашигт малтмалын салбарт хамтран ажиллах талаар Канад, Австрали, АНУ, Япон, Их Британи, ХБНГУ, Өмнөд Солонгос, Франц зэрэг орнуудаас санаачилга гаргаж, зарим улстай хамтран ажиллахаар албан ёсоор тохирсон. Энэ зорилгоор ч Монгол улсын гадаад харилцаа идэвхжиж буй бөгөөд дээд хэмжээний айлчлал, ажлын хэсгийн уулзалтын сэдэвт чухал ашигт малтмалын чиглэлээр хамтран ажиллах асуудал байнга хөндөгдөх болов. Тухайлбал, 2023 оны 6-р сард Монгол-АНУ-ын Засгийн газар хооронд “Энэтхэг-Номхон далайн бүс нутагт чухал ашигт малтмалын аюулгүй, тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээг хамтран хөгжүүлэх санамж бичиг” байгуулсан бол 11-р сард Монгол-БНСУ газрын ховор металл, бусад чухал ашигт малтмал нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллах хороо байгуулж (Х.Зоригтбаатар, The Diplomat: Монгол Улс чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээнд чухал тоглогч болох уу, 2025), улмаар Монгол Улс, БНСУ, АНУ-ын чухал ашигт малтмалын талаарх гурван талт анхдугаар уулзалт Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан (Msight, 2023). ХБНГУ-ын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэр Монгол Улсад 2024 оны 2-р сард хийсэн айлчлалын үеэр байгуулсан Стратегийн түншлэлийн тухай хамтарсан тунхаглалын нэг сэдэв нь 2011 онд баталсан “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудал багтсан (МУЕТГ, 2024). Тэрчлэн 2025 оны 2-р сард Их Британи улстай хамтран чухал ашигт малтмалын геологийн зураглал, хайгуул судалгаа хийхээр тохирсон (Эрдэнэчимэг.Р, 2025), 2025 оны 9-р сард “Mongolia–Korea Critical Minerals and Mining Investment Forum 2025” арга хэмжээг БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулж, Монгол улсаас ЭХЯ,

АҮЭБ-ийн сайд нар оролцсон байна. Эдгээр үйл явцаас харахад "Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл" (MSP) Монгол улстай хамтрах сонирхол өндөр байгаа бөгөөд Монголын зүгээс ч Өрнөдийн эвсэлтэй харилцах эрмэлзэл их байна.

Гэвч геополитикийн хязгаарлагдмал нөхцөл байдал, улс төрийн гадаад, дотоод орчноос шалтгаалан чухал ашигт малтмалын олборлолтод томоохон сорилт бэрхшээл тулгарч байна. Дээр дурдсан орнуудын хувьд Монголоос чухал ашигт малтмалын салбарт хамтран ажиллахын тулд Монголын хоёр том хөршийн геополитикийн сонирхлыг тооцох шаардлага тулгарна. Тэгээд ч хөрш орнуудын хувьд чухал ашигт малтмалын стратегиа баталгаажуулахын тулд уул уурхайн ордуудад хөрөнгө оруулах, түүхий эд тасралтгүй худалдан авах сонирхолтой. Иймд Хятад, Оросыг эцсийн шатны гол тоглогчид гэж тооцож, тэдгээртэй хамтран олборлолт, үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх, ядаж тэдгээрийн эрх ашгийг хангахуйц санал тавьж байж сая геополитикийн саад бэрхшээлийг саармагжуулах боломжтой.

Чухал ашигт малтмал болон ураны олборлолт, үйлдвэрлэл, нийлүүлэлт нь бусад уул уурхайн түүхий эдтэй харьцуулахад геополитик, стратегийн хувьд эмзэг мэдрэмтгий төдий хэрээр улс төр, эдийн засаг, нийгмийн гүнзгий үр дагавар авчирдаг. Улмаар улс хоорондын харилцаа, үндэсний хэмжээний стратеги бодлого, орон нутгийн улс төрийн уулзвар дээр өрнөдөг. Энэ үүднээс харилцан хамааралтай гурван түвшинт тоглолтоор Монголын чухал ашигт малтмалын нөхцөл байдлыг авч үзэхийг тайлбарлахыг хичээв.


- **Дэлхийн болон бүс нутгийн геополитик** (АНУ, Хятад, Оросын геополитикийн өрсөлдөөн, нийлүүлэлтийн сүлжээг хянах стратеги)
- **Улс төр, бизнесийн нөхцөл байдал** (Үндэсний эрх ашиг, засгийн газрын бодлого стратеги, төрийн оролцоо, улс төр, бизнесийн бүлэглэл, корпорацуудын өрсөлдөөн)
- **Орон нутгийн улс төр** (орон нутгийн хүн амын эрх ашиг, орон нутгийн засаг захиргааны улс төржилт, иргэний хөдөлгөөнүүдийн эсэргүүцэл)

Эдгээр ангилал тус бүрд Монголын чухал ашигт малтмалын улс төр, геополитикийн сорилт бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэхтэй холбоотой саналаа дэвшүүлж байна.

Дэлхийн болон бүс нутгийн геополитикийн сорилтыг шийдэх нь

Геополитикийн нөхцөл, үндэсний аюулгүй байдлын бодлого, тухайн салбар дахь байгаль орчин, нийгэм, засаглалын стандарт, чөлөөт зах зээл,

худалдаанд суурилсан үнэ ханшийн бодлого зэргийг тооцвол Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл (MSP)-ийн орнуудтай харилцах нь Монголын эрх ашигтай нийцнэ. Гэхдээ БРИКС буюу Хятад, Орос зэрэг тухайн салбар дахь гол тоглогч хоёр гүрний дунд түгжигдсэн газарзүй, өрнөдийн нийлүүлэлтийн сүлжээнээс алслагдмал байршил нь Монгол улсыг ацан шалаанд оруулдаг.



Зураг 4. БРИКС+6. Эх сурвалж: Shutterstock

Нөгөө талаас чухал ашигт малтмал (ураныг оруулаад)-ын хамгийн том тоглогч бөгөөд хэрэглэгч орнуудтай Монгол улс хөршилдөг. Орос, Хятад улсыг “алгасан” өрнөдийн нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэх боломж угаас хязгаарлагдмал. Тэгээд ч Монголын ашигт малтмалын экспорт Хятад улсаас хамаарч ирсэн. Иймд тус салбар дахь хөрш орнуудын оролцоог зайлшгүй тооцох шаардлага тулгарч байна.

Эдийн засгийн үүднээс авч үзвэл Монгол улс нь чухал ашигт малтмалын хувьд эхний шатны (upstream) тоглогч бөгөөд олборлогч улс орны хувьд технологи, хөрөнгө оруулалт татах, чухал ашигт малтмалын салбарт суурилсан аж үйлдвэр хөгжүүлэх, аж үйлдвэржсэн буюу эцсийн шатны (downstream) улс орнуудтай эдийн засгийн интеграци хийх арга зам хайж байгаа гэж үзвэл хөрш орнуудтайгаа хамтран ажиллахаас өөр гарцгүй. Чухал ашигт малтмалын хувьд урд хөрш Хятад дэлхийд тэргүүлж буй бол ураны хувьд Орос давамгайлдаг. ОХУ-ын хувьд ураны нөөц багатай ч үйлдвэрлэх, боловсруулах, ашиглах технологиор дэлхийд тэргүүлдэг. Гэхдээ урантай холбоотой ОХУ-ын эдийн засагт үзүүлэх нөлөө бага. Тухайлбал, ОХУ-ын төсөвт “Росатом” орлогын 0.6% -иас бага хувийг

эзэлдэг бол “Газпром” 17% -ийг бүрдүүлдэг. (Meyer, 2025). Өөрөөр хэлбэл, уран нь эдийн засгийн үр өгөөжөөс илүү улс төр, геополитикийн чухал зэмсэг болж ирсэн.

Энэ үүднээс чухал ашигт малтмалын хувьд гуравдагч орнууд болон Хятадын талын оролцоог хангасан орчин бүрдүүлэх нь бүх талуудад ашигтай гарц шийдэл байх талтай. Үүний тулд Монголын хувьд эвслүүдийн аль нэг тал руу хэт хэлбийхгүй, АНУ-Хятадын сөргөлдөөнөөс ангид “саарал бүс”-ийг бий болгох нь оновчтой шийдэл гэж үзэж байна. Энэхүү гуравдагч орон ба Хятадын хамтарсан консорциум, үгүй ядаж “зэрэгцэн орших” боломжийг нээж өгснөөр нэг зах зээлээс хамааралт байдал, төлөвлөгөөт эдийн засгийн загварын нөлөөллийг бууруулахын зэрэгцээ гуравдагч хөршийн эрх ашгийг Монгол улсад өргөтгөх боломж хэвээр үлдэнэ.

Энэ чиглэлээр Монголд бэлээхэн туршлага байна. Тухайлбал, Монгол улс уран олборлолтын чиглэлээр Франц улстай хамтарч байгаагийн зэрэгцээ 2023 оны 12-р сард “Росатом” компанитай бага оврын атомын цахилгаан станц барихаар тохиролцсон (Х.Зоригтбаатар, ОХУ Монголд бага оврын атомын цахилгаан станц барина, 2024). Тэрчлэн хагас боловсруулсан уран буюу шар нунтгийг Хятадад боловсруулах юм. Монголын хэлц үгээр “хонь бүтэн, чоно цатгалан” байх тоглолтыг чухал ашигт малтмалын салбарт ч үргэлжлүүлэх боломжтой гэсэн үг.

Улс төр, бизнесийн дотоод нөхцөл байдалд анхаарах нь

Дээр дурдсанчлан чухал ашигт малтмал нь геополитик, стратегийн өрсөлдөөний сэдэв учраас олон улсын түвшний тоглогчдын харилцан нөлөөллийн түвшинд уг асуудлын гадаад орчин тодорхойлогдоно. Нөгөө талаас гадаад бодлогын хэрэгсэл, стратегийн тоглолт, аюулгүй байдлын шалтгаанаар төрийн бодлого стратеги, оролцооны асуудал хөндөгдөхийн зэрэгцээ улс төр, бизнесийн бүлэглэл, корпорацуудын өрсөлдөөн чухал ашиг малтмалын ордуудын төслийн хувь заяанд багагүй нөлөө үзүүлдэг.

Чухал ашигт малтмалын салбар дахь төрийн оролцоо гэдэг нь гадаад, дотоод хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын орчин бүрдүүлэх, бодлого, эрх зүйн зохицуулалт хийх, судалгаа шинжилгээ, технологи, хүний нөөц бодлогод дэмжлэг үзүүлэх төдийгөөр хязгаарлагдах учиртай. Үүнээс хальж, тухайн ордуудыг хувийн хэвшлүүдээс “булааж авах”, хүчээр хувь эзэмших оролдлого хийх нь олон сөрөг үр дагаврыг авчирна (Мэдээж төрийн хөрөнгө оруулалтаар хайгуул судалгаа, олборлолт хийсэн болон гадаад орны төрийн оролцоотой компаниудын хөрөнгө оруулах сонирхолтой ордуудын хувьд дээрх нөхцөлөөс өөр жишиг үйлчилж болно). Товчхондоо энэ нь нөөцийн үндсэрхэг үзлийг дэвэргэх, гадаад, дотоодын эрүүл тоглолттой хөрөнгө

оруулагчдыг үргээхийн зэрэгцээ гадаад, дотоодын олигархи бүлэглэлүүд төрийн механизмыг ашиглан уул уурхайн орд булаацалддаг “зэрлэг капитализм” рүү түлхэнэ. Ялангуяа олборлолт, үйлдвэрлэлийн нарийн төвөгтэй технологи, үлэм хэмжээний хөрөнгө оруулалт, улс төр, байгаль орчин, нийгмийн ноцтой үр дагавар бүхий газрын ховор элементийн ордын төслүүдийг хэрхэн эхлүүлэх тухайд төр засаг анхнаасаа нухацтай судалж, тооцоолж хөдлөх шаардлагатай. Хөндлөнгөөс харахад газрын ховор элементийн томоохон орд “Халзан бүрэгтэй”-г тойрсон улс төржилт, 2024 оны 11-р сард Ховд аймаг дахь иргэдийн эсэргүүцэл, нийгмийн сүлжээг хамруулсан зохион байгуулалттай акц нь улс төр, бизнесийн бүлэглэлийн захиалгаар төрийн оролцоотой хийгдсэн байх магадлалтай юм (О.Соёлмаа, 2024).

Эдийн засаг, бизнесийн өрсөлдөөн аль ч улс оронд байдаг үзэгдэл бөгөөд үүнд төрийн эрх мэдлийг хутгалдуулахгүй, хуулийн хүрээнд эрүүл өрсөлдөх улмаар хамтран ажиллах нөхцөл рүү түлхэц өгөх нь Монголын төрийн хатуу зарчим, чиг үүрэг байх учиртай. Цаашид чухал ашигт малтмалын ордуудад дотоодын төдийгүй гаднын тоглогчдын лобби шахалт өргөжих бөгөөд энэ нөхцөлд төр тоглоомын дүрмээ тодорхой болгож, тогтвортой мөрдөж байх шаардлага тулгарч байна.

Орон нутгийн улс төрийг тооцох нь

Аливаа уул уурхайн төсөл нь тухайн нутаг орны иргэдийн эрх ашгийг хөндөж, байгаль орчны асуудал дагуулдаг. Орон нутгийн засаг захиргаа, иргэд оршин суугчдын эрх ашгийг хангах, байгаль орчинд учруулах уршгийг шийдвэрлэх нь урт хугацааны хэлцэл, тохиролцоо шаарддаг үйл явц юм. Энэ нь тухайн төслийг хэрэгжүүлж буй компани, аж ахуйн нэгжийн хувьд гол сорилт болдог. Стратегийн буюу чухал ашигт малтмалын хувьд энэхүү сорилт бэрхшээл зайлшгүй тулгарна. Тухайн орон нутгийн хүн ам, байгаль орчинтой холбоотой маргаан мэтгэлцээнээс гадна орон нутгийн улс төрчид, засаг захиргааныхны улс төржилт, хууль давсан шахалт төслийн явцад саад бэрхшээл учруулах явдал цөөнгүй гарч байсан. Уул уурхайн төсөлтэй холбогдохгүй ч Увс аймгийн Өмнөговь сумын багийн засаг дарга хоёр улсын засгийн газрын түвшинд шийдвэрлэгдсэн Эрдэнэбүрэнгийн УЦС-ийн төслийг эсэргүүцэж, Хятадын элчин сайд руу албан бичиг илгээж байсан (Т.Хулантахь, 2022)-тай адил үйл явдал тохиолдвол яах вэ. Ялангуяа стратегийн шинжтэй төслүүд дэх орон нутгийн засаг захиргааны улс төрийн оролцоо, эсэргүүцэл нь төрийн бодлого, үйл

ажиллагаанаас давж буй нөхцөлд төрөөс шууд оролцож, хуулийн хүрээнд хариуцлага тооцож байх шаардлагатай.

Мөн иргэний хөдөлгөөн нэрээр гадаад, дотоодын дам оролцоотойгоор уул уурхайн төслүүдийг гацаах зорилготой, үндэсний аюулгүй байдалд хохиролтой, захиалгаар хөдөлдөг, “органик бус” хөдөлгөөнүүдийг “шалгах” ажил ч гарч болзошгүй. 30 гаруй жил ураны хор уршиг ярьсан эсэргүүцлийн хөдөлгөөн С.Ганбаатар зэрэг УИХ-ийн гишүүдийн санаачилгаар сүүлийн жилүүдэд дахин идэвхжиж, дан ганц уран гэлтгүй газрын ховор элементийн ордуудыг тойрсон сөрөг уур амьсгалыг сэдэлжүүлэх болсон нь үүний нэг жишээ юм.

Чухал ашигт малтмалын төслүүд нь өөр хоорондоо харилцан хамаарал бүхий геополитикийн өрсөлдөөн болон дотоод улс төрийн орчин, орон нутгийн оролцоо гэсэн гурван түвшний тоглолтыг уялдуулснаар сая ажил хэрэг болох боломж бүрдэнэ. Товчхондоо харилцан нэгэндээ үйлчилдэг энэхүү гурван талбарын тоглолтыг бодлого стратегийн хувьд системтэй тооцож, хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн үг.

ДҮГНЭЛТ

Анх уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдлыг бууруулах зорилтоос эхлэлтэй дэлхий дахиныг хамарсан эрчим хүчний шилжилтийн санаачилга өдгөө нийгмийн олон салбарт өөрчлөлт авчрав. Эрчим хүчний шилжилтээс үүдсэн чухал ашигт малтмалын нөөц нь дан ганц эрчим хүчний эх үүсвэрт төдийгүй түүнээс шууд хамааралтай технологи болон аж үйлдвэр, батлан хамгаалах салбарын ирээдүйг тодорхойлж эхлэв.

Чухал ашигт малтмалтай холбоотой дэлхий дахинд тулгарч буй тулгарч буй асуудал нь түүний хомсдолд бус, харин нийлүүлэлтийн сүлжээний нарийн төвөгтэй байдал, түүхий эдийн боловсруулалт хэт төвлөрсөн, үйлдвэрлэл нь эрэлтээсээ удаан байгаад оршино. Эдгээр учир шалтгааны улмаас чухал ашигт малтмалыг геополитик, эдийн засаг, стратегийн бодлогын цөмд авчрав. Хэн энэхүү нөөцийг эзэмших, үйлдвэрлэх улмаар нийлүүлэлтийн сүлжээг хянаж чадахаас стратегийн давамгайлал, гео-эдийн засгийн давуу талыг олж авна.

Дэлхий дахиныг хамарсан чухал ашигт малтмалын өрсөлдөөний улмаас шинэ тутам бүрдэж буй эвслүүдийн тоглолт, тэдгээрийг тэргүүлэгч гүрнүүдийн сөргөлдөөн энэхүү нөөцөөр арвин Монгол улсад боломж хийгээд сорилтыг учруулах болов.

Эдгээр эвсэлд тухайн нөөцийг эзэмших болон нийлүүлэлтийн сүлжээг хянах улмаар эдийн засгийн бие даасан байдлаар дамжуулан үндэсний аюулгүй байдлаа хангахад чиглэсэн АНУ-ын тэргүүтэй Өрнөдийн 14 улсыг багтаасан "Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл" (MSP) болон БРИКС+6 тооцож болно. Өрнөдийн эвслийн стратеги нь үйлдвэрлэл, дахин боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, Хятадаас хамааралт байдлаа бууруулахыг эрмэлзэж буй бол БРИКС+6 нь байгалийн болон хүний нөөцийн давуу байдалдаа тулгуурлан бүс нутаг болон дэлхий дахинд нөлөөллөө хадгалах, өргөжүүлэхийг эрмэлзэж байгаа аж.

Эдгээр эвслийн өрсөлдөөнөөс гадна Хятад-АНУ-ын технологийн ноёрхол ялангуяа чухал ашигт малтмалын нөөцийн төлөөх сөргөлдөөнийг 21-р зууны геополитикийн "шинэ аугаа тоглоом" гэж нэрлэж байна. Хэдийгээр чухал ашигт малтмалын өрсөлдөөнд АНУ "оройхон гараад ширүүхэн дайрч байгаа" ч Хятадаас олборлолт, цэвэршүүлэх, боловсруулах технологийн хувьд нэлээн хоцрогдсон. Улмаар АНУ-ын өдөөсөн худалдааны дайны улам өргөжиж, чухал ашигт малтмал экспортод харилцан хориг тавиад байгаа билээ.

Монгол улс эрчим хүчний шилжилт, өндөр технологийн хөгжилд эрэлт ихтэй чухал ашигт малтмал болон ураны арвин нөөцтэй. Энэхүү нөөц боломждоо тулгуурлан гадаад харилцаа, аюулгүй байдлын бодлогоо орчин үеийн стратегийн худалдааны харилцаагаар дамжуулан хэрэгжүүлэх, өргөжүүлэх, улмаар хөрөнгө оруулалт татах, технологи нэвтрүүлэх, улс төр, стратегийн дэмжлэг авах, хамтын ажиллагаа өрнүүлэх боломж нээгдэж байна. Улмаар Монголын талтай чухал ашигт малтмалын салбарт хамтран ажиллах талаар "Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл" (MSP)-ийн гишүүн орнууд болох Канад, Австрали, АНУ, Япон, Их Британи, ХБНГУ, Өмнөд Солонгос, Франц зэрэг орнуудаас санал тавьж байгаа хэдий ч манай улсын геополитикийн хязгаарлагдмал нөхцөл, нийлүүлэлтийн сүлжээнээс алслагдмал байдлыг бодиттой үнэлж байж хөдлөх шаардлага тулгарч байна.

Чухал ашигт малтмал нь геополитик, нийгэм-улс төр, байгаль орчны хувьд гүнзгий үр нөлөөтэй нөөц юм. Улмаар улс хоорондын харилцаа, үндэсний хэмжээний стратеги бодлого, орон нутгийн улс төрийн уулзвар дээр өрнөдөг. Энэ үүднээс харилцан хамаарал бүхий гурван түвшинд Монголын чухал ашигт малтмалын стратегийн нөхцөл байдлыг тайлбарлаж болно. Үүнд:

- *Мега түвшин буюу дэлхийн болон бүс нутгийн геополитикийн нөлөөллийг бодиттой үнэлж хөдлөх*. Монголын хувьд чухал ашигт малтмалын эвслүүдийн аль нэг тал руу хэлбийхгүй, АНУ-Хятад, АНУ-

Оросын сөргөлдөөнөөс ангид “саарал бүс”-ийг бий болгох нь оновчтой шийдэл гэж үзэж байна. Гуравдагч улсууд болон Хятад, Оросын хамтран ажиллах, үгүй ядаж “зэрэгцэн ажиллах” боломжийг нээж өгснөөр нэг зах зээлээс хамааралт байдал, төлөвлөгөөт эдийн засгийн загварын нөлөөллийг бууруулахын зэрэгцээ гуравдагч хөршийн эрх ашгийг Монгол улсад хадгалж чадна.

- *Макро түвшинд буюу үндэсний улс төр, бизнесийн орчинд дахь тоглоомын зарчим дүрмээ тогтох, тогтвортой мөрдөх*. Гадаад бодлогын хэрэгсэл, стратегийн тоглолт, аюулгүй байдлын шалтгаанаар төрийн оролцоо байх бөгөөд тэр нь гадаад, дотоод хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын орчин бүрдүүлэх, бодлого, эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдах бөгөөд гадаад, дотоод корпорацуудын өрсөлдөөнд төрийн эрх мэдлийг хутгалдуулахгүй, хуулийн хүрээнд эрүүл өрсөлдөх улмаар хамтран ажиллах нөхцөл рүү бий болгоход төрийн гол үүрэг оршино.
- *Микро түвшинд буюу орон нутгийн улс төрийн оролцооны зааг хязгаарыг тодорхойлох*. Стратегийн шинжтэй төслүүд дэх орон нутгийн засаг захиргааны улс төржилт, дарамт шахалт нь төрийн бодлого, үйл ажиллагаанаас давж буй нөхцөлд төрөөс шууд оролцож, хуулийн хүрээнд хариуцлага тооцдог байх, гадаад, дотоодын оролцоотой, үндэсний аюулгүй байдалд хохиролтой, захиалгат “органик бус” хөдөлгөөнүүдийг “шалгах” шаардлага цөөнгүй гарч болзошгүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Calabrese, J. (2024). Transatlantic strategic convergence on China and the scramble for critical minerals. *Social Transformations in Chinese Societies, 20*, 32-48.

Célestin Coquidé, José Lages, Dima Shepelyansky. (2023). Prospects of BRICS currency dominance in international trade. *Applied Network Science, 8*(1), 65. https://hal.science/hal-04641803/document

CMIA. (2024 оны 04 24). *https://www.cmialliance.com/*. CMIA: https://www.cmialliance.com/#:~:text=About%20CMIA,existing%20critical%20minerals%20supply%20chains.&text=The%20CMIA%20supports%20like%2Dminded,and%20implementing%20solution%2Dfocused%20strategies.

Cohen, J. (2023 оны 09 13). *Resource realism: The geopolitics of critical mineral supply chains*. Goldmansachs:

https://www.goldmansachs.com/insights/articles/resource-realism-the-geopolitics-of-critical-mineral-supply-chains

Garside. (2024 оны 09 17). *Global strategic minerals - statistics & facts*. Statista: https://www.statista.com/topics/9242/strategic-minerals/#topicOverview

Graaf, T. V. (2025 оны 03 06). The Geopolitics of Critical Minerals. (M. A. Kuo, Ярилцагч) The Diplomat: https://thediplomat.com/2025/03/the-geopolitics-of-critical-minerals/

Gracelin Baskaran, Duncan Wood. (2025). *Critical Minerals and the Future of the U.S. Economy*. New York, : CSIS.

Hernandez, B. (2024 оны 02 07). *Uranium Makes Japan's Critical Minerals List*. ETF trends: https://www.etftrends.com/gold-silver-investing-channel/uranium-japans-critical-minerals-list/

Kalantzakos, S. (2023). Between Rocks and Hard Places: Geopolitics of Net Zero Futures and the Tech Imperium. S. Kalantzakos-Д, *Critical Minerals, the Climate Crisis and the Tech Imperium* (P. 3-25). Cham, Switzerland: Springer.

Lewis Jackson, Amy Lv, Eric Onstad, Ernest Scheyder. (2025 оны 04 04). *China hits back at US tariffs with export controls on key rare earths*. Reuters: https://www.reuters.com/world/china-hits-back-us-tariffs-with-rare-earth-export-controls-2025-04-04/

Merwat, S. (2025 оны 03 10). *The New Great Game: How the race for critical minerals is shaping tech supremacy*. The Trade Hub: https://thoughtleadership.rbc.com/the-new-great-game-how-the-race-for-critical-minerals-is-shaping-tech-supremacy/

Meyer, T. (2025). Patents for power: Intellectual property and the geopolitics of nuclear energy technologies. *Nuclear Engineering and Technology, 30*. doi:https://doi.org/10.1016/j.net.2025.103470

Msight. (2023 оны 06 27). *Монгол Улс, АНУ чухал ашигт малтмалын чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа*. Mining sight: https://mininginsight.mn/index.php?newsid=510

Shupei Huang, Xinya Wang, Qiang Ji. (2025). How unexpected geopolitical risk affect the nonlinear spillover among energy and metal markets? *Energy Economics*, 1-14.

SME. (2022 оны 01). *Critical and Strategic Minerals: Importance to the U.S. Economy*. https://www.smenet.org/: https://www.smenet.org/What-We-Do/Technical-Briefings/Critical-and-Strategic-Minerals-Importance-to-the

Vivoda, V. (2023 оны 06). Partnership, Friend-shoring and critical minerals: Exploring the role of the Minerals Security. *Energy Research & Social Science, 100*. doi:https://doi.org/10.1016/j.erss.2023.103085

Vlado Vivoda, Ron Matthews, Neil McGregor. (2024). A critical minerals perspective on the emergence of geopolitical trade blocs. *Resources Policy, 89*, 1-7.

Yergin, D. (2024 оны 01 17). On energy and the new world order. (Z. Haider, Ярилцагч)

Г.Хорол. (2025 оны 01 17). *Монгол Улс ураны зах зээлд гол тоглогч болно*. News.mn: https://news.mn/r/2776988/

МУЕТГ. (2024 оны 02 07). *Монгол Улс, ХБНГУ хоорондын Стратегийн түншлэлийн тухай Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурав*. МУЕТГ: https://president.mn/28537/

О.Соёлмаа. (2024 оны 11 13). *Өөрсдөө ашиглахгүй, өрөвлд ч өгөхгүй явсаар газрын ховор элемент "үнэгүйдэх" нь*. eguur: https://eguur.mn/548123/

Т.Хулантахь. (2022 оны 08 16). *Ши Жинпиньд захидал бичиж "Эрдэнэбүрэнгийн УЦС"-ыг зогсоосон Багийн дарга Г.Цэдэнбал одоо ч ажлаа хийж байна*. iSEE: https://isee.mn/n/39488

Х.Зоригтбаатар. (2024 оны 03 05). *ОХУ Монголд бага оврын атомын цахилгаан станц барина*. Itoim: https://itoim.mn/a/2024/03/05/about-us/bhi

Х.Зоригтбаатар. (2025 оны 02 28). *The Diplomat: Монгол Улс чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээнд чухал тоглогч болох уу*. Тойм: https://itoim.mn/a/2025/02/28/about-us/tsv?53ee541c5004bdf3163a7ae68b2b4dd0

Эрдэнэчимэг.Р. (2025 оны 02 13). *Их Британийн талтай хамтран чухал ашигт малтмалын геологийн зураглал, судалгаа хийнэ.* Монголын мэдээ: https://montsame.mn/mn/read/361931

ENERGY GEOPOLITICAL SHIFTS AND MONGOLIA (THE CASE OF CRITICAL MINERALS)

Abstract: In recent years, geopolitical competition for strategic minerals, such as uranium and essential minerals, which are the basic raw materials and resources for energy security, technological progress, and economic development, has intensified, pushing the process of international relations towards major changes. In addition, global processes such as the global energy transition, the competition for resources among great powers, and the global trade war have created the conditions for a new energy order. Not only the global energy transition, but also the 4th industrial revolution and the future of the defense industry depend on these strategic resources, countries are naturally drawn into competition for the possession of essential minerals and uranium reserves and control of supply chains.

In particular, the open and hidden confrontation between the United States and China over essential minerals has brought new challenges to the geo-energy

policy and diplomatic relations of the region, especially Mongolia. This provides us with the opportunity to develop a scenario for cooperation based on key minerals based on the competition of these players for strategic resources, and to implement our foreign policy and national security concepts. In this paper, we aim to conduct a documentary analysis to consider the geopolitical dynamics related to energy resources and their impact on Mongolia, evaluate the interdependences and impacts of related factors from a holistic perspective, and then propose our own scenario for determining the direction of foreign policy and cooperation based on Mongolia's critical mineral resources.

Key words: energy transition, critical mineral supply chains, geopolitical competition, three-level game

ЗОХИОГЧИД

Зохиогчийн нэр	Ажил, албан тушаал	E-mail
С.Мөнхбат	МУИС, УТСОУХНУС-ийн захирал	munkhbat.s@num.edu.mn
Э.Золбаяр	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	zolbayar.et@gmail.com
Б.Эрдэнэдалай	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	erdenedalai@num.edu.mn
А.Минжинсор	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	minjinsorminjev@gmail.com
Б.Насанбат	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	nasanbat.b@muls.edu.mn
Н.Отгонбаяр	Этүгэн их сургууль, Хүмүүнлэгийн сургууль, Эдийн засаг, менежментийн тэнхим	otgonbayarnyamaa.n@gmail.com
Д.Одмаа	ШУТИС, Нийгэм, хүмүүнлэгийн сургууль, Нийгмийн ухааны тэнхим	odmaadangaa@gmail.com
Ц.Бямбачулуун	МУИС, Баруун бүсийн сургууль, Нийгэм-Хүмүүнлэгийн ухааны тэнхим	byambachuluun@num.edu.mn
Jirimutu Ying	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	yingjirimutu@gmail.com
Э.Сувдаа	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	Enkhbaatarsuwdaa11@gmail.com
Ч.Баатар	Удирдлагын академи, Улсын салбарын удирдлагын тэнхимийн Ахлах багш, Магистр	baatar@naog.gov.mn
Б.Болортуяа	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	daibolor@yahoo.com

Ж.Төртогтох	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим, профессор	turo@num.edu.mn
П.Алтанчимэг	МУБИС, Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургуулийн Улс төр судлалын докторант	altanchimeg.85@gmail.com
Г.Золзаяа	ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургуулийн Статистик ба эконометриксийн тэнхим	zolzaya.g@muls.edu.mn
Б.Өсөхбаяр	ХААИС, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Компьютерийн шинжлэх ухааны тэнхим	usukhbayar@muls.edu.m*n*
Yinxia	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	20M1NUM0865@stud.num.edu.mn
Д.Түмэнжаргал	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	tumeed@num.edu.mn
А.Батцэцэг	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн Ахлах багш, доктор	battsetseg.a@num.edu.mn
Д.Бадамдаш	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн багш	badamdash@num.edu.mn
Д.Уртнасан	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор	urtnasan_d@num.edu.mn
Д.Мягмарсүрэн	ШУТИС-ийн НХС-ийн профессор	myagmarsurend@must.edu.mn
Э.Саранцэцэг	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор	sarantsetseg.e@num.edu.mn
Б.Энх-Амгалан	МУИС, Бизнесийн сургууль, Санхүүгийн тэнхимийн дэд профессор	enkhamgalan@num.edu.mn

CONTRIBUTORS

Author	Affiliation	E-mail
Munkhbat Sonomdarjaa	Director, SPSIRPA, National University of Mongolia	munkhbat.s@num.edu.mn
Zolbayar Enkhtur	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	zolbayar.et@gmail.com
Erdenedalai Bat-Ulzii	Associate Professor, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	erdenedalai@num.edu.mn
Minjinsor Avarga	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	minjinsorminjev@gmail.com
Nasanbat Baavgaikhuu	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	nasanbat.b@muls.edu.mn
Otgonbayar Nyamaa	Department of Economics and Management, School of Humanities, Etugen University	otgonbayarnyamaa.n@gmail.com
Odmaa Dangaasuren	Department of Social Sciences, School of Social Sciences and Humanities, Mongolian University of Science and Technology	odmaadangaa@gmail.com
Byambachuluun Tseden	Department of Social Sciences and Humanities, Western Regional School, NUM	byambachuluun@num.edu.mn
Jirimutu Ying	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	yingjirimutu@gmail.com
Suvdaa Enkhbaatar	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	Enkhbaatarsuwdaa11@gmail.com
Baatar Chadraabal	NAOG, Senior Lecturer, Department of Public Management, Master of Arts	baatar@naog.gov.mn
Bolortuya Batsukh	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	daibolor@yahoo.com

Turtogtokh Janar	Professor, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	turo@num.edu.mn
Altanchimeg Purevsuren	Doctoral Candidate in Political Science, School of Social Sciences and Humanities, Mongolian State University of Education	altanchimeg.85@gmail.com
Zolzaya Gungaa	Department of Statistics and Econometrics, School of Economics and Business, MULS	zolzaya.g@muls.edu.mn
Usukhbayar Bayarsaikhan	Department of Computer Science, School of Applied Sciences, MULS	usukhbayar@muls.edu.m***n***
Yinxia	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	20M1NUM0865@stud.num.edu.mn
Tumenjargal Davaadorj	Associate Professor, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	tumeed@num.edu.mn
Battsetseg Altangerel	Senior lecturer, Department of International Relations, SPSIRPA, National University of Mongolia	battsetseg.a@num.edu.mn
Badamdash Dashdavaa	Lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	badamdash@num.edu.mn
Urtnasan Dagiidamba	Senior lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	urtnasan_d@num.edu.mn
Myagmarsuren Dashzevge	Professor, Mongolian University of Science and Technology	myagmarsurend@must.edu.mn
Sarantsetseg Enkh-Amgalan	Senior lecturer, Department of International Relations, SPSIRPA, National University of Mongolia	sarantsetseg.e@num.edu.mn
Byambajav Enkh-Amgalan	Associate Professor, Department of Finance, Business School, National University of Mongolia, Contract Researcher, NISS	enkhamgalan@num.edu.mn